



НЭЭЛТТЭЙ
НИЙГЭМ
ФОРУМ



ШҮҮХИЙН ШИЙДВЭРИЙН СУДАЛГАА

ЦУВРАЛ 17



НЭЭЛТТЭЙ
НИЙГЭМ
ФОРУМ

ШҮҮХИЙН ШИЙДВЭРИЙН СУДАЛГАА

ЦУВРАЛ 17

Улаанбаатар, 2024

ННА 67
ДАА 340
Ш-978



ШҮҮХИЙН ШИЙДВЭРИЙН СУДАЛГАА ЦУВРАЛ 17

СУДЛААЧИД:

Б.Оюунжаргал
Б.Баялагмаа
Б.Буянхишиг
Б.Цэвээндэмбэрэл
Ч.Баянжаргал
Ц.Оюунаа
Г.Сувд-Эрдэнэ

Дугаар хариуцсан редактор: С.Билгүүн

© Нээлттэй Нийгэм Форум, 2024

Энэхүү цувралд багтсан судалгаануудын дүгнэлт, санал нь судалгааг хийж гүйцэтгэсэн судлаачдын байр суурь, үзэл бодол бөгөөд Нээлттэй Нийгэм Форумын албан ёсны байр суурийг илэрхийлэхгүй болно.

ISBN 978-9919-9136-6-3

Шүүхийн шийдвэрийн судалгаа

ЦУВРАЛ 17



1

ХАРИУЦАГЧ КОМПАНИЙГ «ДАМПУУРСАНД ТООЦОХ ТУХАЙ ХҮСЭЛТ»-ИЙГ ХЭРЭГСЭХГҮЙ БОЛГОСОН ШҮҮХИЙН ШИЙДВЭРТ ХИЙСЭН ДҮН ШИНЖИЛГЭЭ

7

2

ШААРДАХ ЭРХ ШИЛЖҮҮЛЭХ ГЭРЭЭТЭЙ ХОЛБООТОЙ МАРГААН ШИЙДВЭРЛЭСЭН ШҮҮХИЙН ШИЙДВЭРТ ХИЙСЭН ДҮН ШИНЖИЛГЭЭ

97

3

ӨВ ЗАЛГАМЖЛАЛТАЙ ХОЛБООТОЙ ИРГЭНИЙ ХЭРЭГ МАРГААН ХЯНАН ШИЙДВЭРЛЭСЭН ШҮҮХИЙН ШИЙДВЭРИЙН СУДАЛГАА

183

ӨМНӨХ ҮГ

Иргэний хууль, Иргэний хэрэг хянан шийдвэрлэх хууль болон иргэний хэрэг хянан шийдвэрлэхэд ашиглагдаж буй хууль тогтоомжийн хэрэглээ хуульчид, судлаачдын анхаарлыг татсан, нухацтай авч үзэх шаардлагатай асуудлын нэг болж байна. Нээлттэй нийгэм форумас сүүлийн 5 жилийн хугацаанд иргэний шүүхийн шийдвэрийн судалгааны 30 гаруй төслийг санхүүжүүлэн тайланг хэвлэн нийтэлж шүүгч, хуульчдын хүртээл болгосон билээ. Энэхүү хүрээнд нэмж хийгдсэн гурван судалгааны тайланг бид “Шүүхийн шийдвэр судалгаа”-ны цувралын 17 дох дугаартаа танилцуулж байна.

Судлаач Б.Оюунжаргал, Б.Баялагмаа нар дампуурсанд тооцох хүсэлтийг шүүх хэрхэн шийдвэрлэж байгааг гүнзгийрүүлэн судалсан бол доктор Б.Буянхишигийн ахалсан баг шаардах эрх шилжүүлэх гэрээний маргааныг иргэний харилцааны олон талаас авч үзэж хуулийн болон онолын хэрэглээг үнэлсэн юм. Монголын Нотариатчидын танхимын тэргүүн Ч.Баянжаргал ахлагчтай баг өв залгамжлалын асуудлыг шүүхэд хэрхэн шийдвэрлэж байгааг гурван шатны шүүхийн шийдвэрээс түүвэрлэн шинжилсэн болно. Судалгаа шинжилгээний ажлын арвин туршлагатай хууль зүйн их дээд сургуулийн эрдэмтэн, багш нар шүүхийн практикт эрх зүйн онолын үүднээс хуулийг хэрхэн тайлбарлан хэрэглэх талаар түлхүү анхаарсан нь энэ удаагийн судалгааны онцлог байлаа.

Шүүхийн шийдвэр судалгааны энэ дугаарыг эрхэлж, боловсронгуй болгоход чухал хувь нэмэр оруулсан редактор С.Билгүүн, судалгааны тайланд шүүмж өгсөн Н.Батчимэг нотариатч, Улсын Дээд шүүхийн Иргэний танхимын шүүгч Н.Баярмаа, Нийслэлийн иргэний хэргийн давж заалдах шатны шүүгч Э.Энэбиш нарт гүн талархал илэрхийлж, нийт судлаачдад цаашдын эрдэм шинжилгээний үйлсэд нь өндөр амжилт хүсье.

Уншигч та бүхэн санал шүүмжээ манай байгууллагын www.fogim.mn цахим хуудас болон нийгмийн сүлжээний хаягт хандан ирүүлснээр бид өөрсдийн үйл ажиллагааг улам бүр сайжруулах боломж бүрдэх юм.

*П.Эрдэнэжаргал
Гүйцэтгэх захирал*

РЕДАКТОРЫН ЗУРВАС

“Шүүхийн шийдвэрийн судалгаа” цувралын энэ удаагийн дугаарт шаардах эрх шилжүүлэх гэрээ, өв залгамжлалтай холбоотой маргааныг хянан шийдвэрлэсэн, хариуцагч компанийг төлбөрийн чадваргүй болох нь нотлогдоогүй үндэслэлээр дампуурсанд тооцох тухай хүсэлтийг хэрэгсэхгүй болгосон шүүхийн шийдвэрт хийсэн судалгааг эмхэтгэн уншигч танд толилуулж байна.

Эдгээр судалгаанд шүүхийн практикт тодорхой хэмжээгээр шийдвэрлэгддэг боловч хууль тогтоомжийн зохицуулалтын болон хэрэглээний хувьд тулгамдсан асуудал дагуулдаг, цаашид санхүү, зах зээл, нийгмийн харилцааны явцад шинэ тутам гарч буй үзэгдэл, өөрчлөлт шинэчлэлийн үйл явцтай уялдуулан боловсронгуй болгох шаардлагатай асуудлуудыг хөндөн судалсан байна.

Тухайлбал, судлаач, хууль зүйн ухааны доктор Б.Буянхишиг ахлагчтай багийн судалгаанд зах зээлийн эдийн засгийн харилцааны нэг хэрэгсэл болох шаардах эрхийг шилжүүлэх гэрээтэй холбоотой маргааныг хянан шийдвэрлэсэн шүүхийн шийдвэрүүдийг судалж, хууль хэрэглээний хувьд залруулах шаардлагатай байгаа асуудлуудыг тодорхойлсноос гадна Иргэний хуулийн холбогдох зохицуулалтыг боловсронгуй болгох тодорхой санал дэвшүүлсэн байна. Судлаач, хууль зүйн ухааны доктор Б.Оюунжаргал нарын гүйцэтгэсэн судалгаанд хариуцагч компани төлбөрийн чадваргүй болсныг тогтоох, төлбөрийн чадваргүй нь нотлогдоогүй гэж үзэн дампуурсанд тооцох тухай хүсэлтийг хэрэгсэхгүй болгож буй практик, түүний шалтгаан, үүсгэж үр дагавар зэргийг судалж, цаашид боловсронгуй болгох ёстой асуудлуудыг томъёолсон байна.

Түүнчлэн Монголын Нотариатчидын танхимаас хуульчидтай хамтран гүйцэтгэсэн судалгаанд өв залгамжлалтай холбоотой маргааныг хянан шийдвэрлэсэн шүүхийн шийдвэрүүдийг тухайлан судалж, хууль хэрэглээний болон зохицуулалтын хувьд цаашид анхаарах, боловсронгуй болгох тодорхой саналыг дэвшүүлжээ.

Иргэний эрх зүйн чиглэлээр эрдэм шинжилгээ, судалгааны болон практик ажил дагнан эрхэлдэг судлаач, хуульчдын гүйцэтгэсэн эдгээр судалгааны үр дүн, санал, зөвлөмж нь хувийн эрх зүйн хууль тогтоомжийг боловсронгуй болгох ажилд тусгалаа олж, бодитой хувь нэмэр оруулна гэдэгт эргэлзэхгүй байна. Эдгээр судалгааны ажлыг сайжруулах, тулгамдсан асуудал, түүний гарц шийдлийг оновчтой тодорхойлох, чиглүүлэх тал дээр өөрийн мэдлэг, ур чадвар, цаг заваа харамгүй зориулж, санал зөвлөмжөө өгсөн Монгол Улсын Дээд шүүхийн шүүгч, Хууль зүйн ухааны доктор Н.Баярмаа, Нийслэлийн Иргэний хэргийн давж заалдах шатны шүүхийн шүүгч Э.Энэбиш нарт талархаж байна.

Мөн шүүхийн шийдвэрт дүн шинжилгээ хийх арга зүйг боловсронгуй болгох, шүүхийн практик судлалыг дэмжих, энэ чиглэлийн судалгаа хийх эрмэлзэл, чармайлтыг судлаач, хуульчдын дунд нэмэгдүүлэх, тэднийг чадавхжуулах, хууль тогтоомжийн зохицуулалт, түүний хэрэглээг боловсронгуй болгоход чиглэсэн олон чухал санал санаачилга гаргах нөхцөл боломжийг бүрдүүлж ирсэн Нээлттэй нийгэм форумд онцлон талархал илэрхийлье.

С.Билгүүн
Дугаар эрхэлсэн редактор

1

ХАРИУЦАГЧ КОМПАНИЙГ “ДАМПУУРСАНД ТООЦОХ ТУХАЙ ХҮСЭЛТ”-ИЙГ ХЭРЭГСЭХГҮЙ БОЛГОСОН ШҮҮХИЙН ШИЙДВЭРТ ХИЙСЭН ДҮН ШИНЖИЛГЭЭ

СУДЛААЧДЫН ТАНИЛЦУУЛГА



БААТАРЫН ОЮУНЖАРГАЛ (PH.D)

Б.Оюунжаргал нь БНСУ-ын Чонбук Үндэсний их сургуульд Хууль зүйн докторын зэрэг 2021 онд хамгаалсан.

2021 оноос одоог хүртэл МУИС-ийн Хууль зүйн сургуулийн Хувийн эрх зүйн тэнхимийн ахлах багшаар ажиллаж, компанийн засаглал, бизнесийн эрх зүйн чиглэлээр хамтарсан судалгааны төсөлд ахлагч судлаачаар оролцож байна.



БАЯРААГИЙН БАЯЛАГМАА (LL.M)

Б.Баялагмаа нь О.Е.Кутафины нэрэмжит Москвагийн хуулийн их сургуульд эрх зүйн магистрын зэрэг 2020 онд хамгаалсан.

2021 оноос одоог хүртэл МУИС-ийн Хууль зүйн сургуулийн Хувийн эрх зүйн тэнхимийн багшаар ажиллаж, иргэний процессын эрх зүй, хууль ба технологи чиглэлээр сургалт, судалгааны ажлыг гүйцэтгэж байна.

Судлаачид

Ахлагч:
Б.Оюунжаргал

Багийн гишүүн:
Б.Баялагмаа

ГАРЧИГ

ХҮСНЭГТ, ЗУРГИЙН ЖАГСААЛТ	12
УДИРТГАЛ.....	13

НЭГ. ХУУЛИЙН ЭТГЭЭДИЙГ ДАМПУУРСАНД ТООЦОЖ, ТАТАН БУУЛГАХ АЖИЛЛАГААНЫ ОНЦЛОГ	16
--	----

1.1 Нийтлэг эрх зүйн зохицуулалт, түүний зорилго	16
1.2 Тусгай төрлийн процесс ажиллагаа: Дампуурлын хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа	22
1.3 Компани дампуурсанд тооцож, татан буулгах ажиллагаа	25

ХОЁР. ШҮҮХИЙН ШИЙДВЭРИЙН ДҮН ШИНЖИЛГЭЭ	28
--	----

2.1 Компанийг дампуурсанд тооцох хүсэлтийг хянан шийдвэрлэхдээ төлбөрийн чадваргүй болсон тухай захирамж гаргасан байдал	28
--	----

2.1.1 Анхан шатны шүүхийн “Төлбөрийн чадваргүй болсон тухай” захирамж хүчин төгөлдөр болсон боловч давж заалдах болон хяналтын шатны шүүхээс дахин хянаж дүгнэлт өгсөн байдал	34
--	----

2.1.2 “Төлбөрийн чадваргүй болсон тухай” шүүгчийн захирамж хүчинтэй боловч шүүхээс дампуурлын хэргийг хэрэгсэхгүй болгож шийдвэрлэх эрх зүйн үндэслэл байгаа эсэх	37
--	----

2.1.3 Төлбөрийн чадваргүйд тооцсон шүүгчийн захирамжийг хүчингүй болгох замаар хүсэлтийг хэрэгсэхгүй болгож шийдвэрлэх боломж байгаа эсэх	46
---	----

2.2 Төлбөрийн чадваргүйг нотлох үүрэг бүхий субъектийг тодорхойлох асуудал	49
---	----

2.2.1	Онцгой ажиллагааны журмаар дампуурсанд тооцох хүсэлтийг шийдвэрлэхэд нотлох үүргийн хуваарилалт.....	53
2.2.2	Шүүхээс мөрдөн шалгах зарчмыг хэрэгжүүлэх хүрээнд хийгдэх ажиллагаа.....	57
2.3	Компанийг төлбөрийн чадваргүй болоход хүргэсэн буруутай этгээдийг тогтоосны эрх зүйн үр дагавар.....	61
2.3.1	Санаатай дампуурлын шинжтэй хувьцаа эзэмшигч болон үүсгэн байгуулагчийн үйлдэлд хийсэн дүгнэлт...64	
2.3.2	Компани нь хамаарал бүхий этгээдээс авах ёстой авлагыг авч чадахгүй нөхцөлд хийсэн дүгнэлт	65
2.3.3	Толгой компанитай нэг этгээд буюу толгой компани дампуураагүй, буруутай байгаа нөхцөлд хийсэн дүгнэлт	66
2.3.4	Хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр албан татвараа төлөхгүй байгаа компанийн удирдлагын буруутай үйлдэл, түүний эрх зүйн үр дагавар.....	69
2.3.5	Нягтлан бодох бүртгэлийн анхан шатны баримт дутуу байгаа хариуцагчийн буруутай үйлдэл.....	74
2.4.	Шүүх хүсэлтийг хэрэгсэхгүй болгох хууль зүйн үндэслэл ба оролцогчдын ашиг сонирхол.....	76
2.4.1	Дампуурлын тухай хуульд заасан дампуурсанд тооцох хүсэлтийг татгалзах, хэрэгсэхгүй болгох үндэслэл ба шүүхийн хууль хэрэглээний асуудал	79
2.4.2	Дампуурсанд тооцож, татан буулгах хүсэлтийг хэрэгсэхгүй болгох шийдвэр гаргахдаа Дампуурлын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.1-ийг баримталж буй асуудал.....	82
2.4.3	Дампуурсанд тооцож, татан буулгах хүсэлтийг хэрэгсэхгүй болгох шийдвэрийг гаргахдаа Дампуурлын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1 дэх хэсгийг баримталж буй асуудал.....	84
	ДҮГНЭЛТ.....	85
	САНАЛ.....	90
	АШИГЛАСАН ЭХ СУРВАЛЖ.....	94

ХҮСНЭГТ, ЗУРГИЙН ЖАГСААЛТ

Хүснэгт 1. Анхан шатны шүүхийн “Төлбөр чадвартай эсэх”-ийг тогтоосон захирамж түүний эрх зүйн үр дагавар	29
Хүснэгт 2. Монгол Улс болон ОХУ-ын дампуурлын хэргийг шүүхээр хянан шийдвэрлэх ажиллагааны нийтлэг болон ялгаатай тал	42
Хүснэгт 3. Хүсэлт гаргагчид нотлох үүргийг хуваарилсан байдал	49
Хүснэгт 4. Компанийг төлбөрийн чадваргүй болсон буруутай этгээдийг тодорхойлсон байдал	62
Хүснэгт 5. Дампуурсанд тооцох хүсэлтийг хэрэгсэхгүй болгосон үндэслэл	77
Зураг 1. Дампуурлын хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны дараалал.....	38

УДИРТГАЛ

Монгол Улсын шүүхийн шүүн таслах ажиллагааны нэгдсэн дүн мэдээлэлд дурдсанаар 2020 оноос 2023 оны эхний хагас жил хүртэлх хугацаанд шүүх нийт 62 дампуурлын хэргийг¹ анхан шатны журмаар шийдвэрлэжээ. Тус судалгаагаар иргэний хэргийн шүүхээс хуулийн этгээдийг дампуурсанд тооцох хүсэлтийг хэрэгсэхгүй болгож шийдвэрлэхдээ Дампуурлын тухай хууль, Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийг хэрэглэж буй практик, шүүхээс хуулийг нэгдмэл байдлаар хэрэглэж буй эсэх, дампуурлын хэргийг онцгой ажиллагааны журмаар шийдвэрлэхэд хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд тулгамдаж буй асуудлуудад дүн шинжилгээ хийж, тодорхой асуудлуудыг шийдвэрлэх санал дэвшүүлэхийг зорилоо. Энэ хүрээнд хуулийн этгээдийг дампуурсанд тооцох хүсэлтийг шийдвэрлэсэн шийдвэрийг сонгохдоо зөвхөн анхан шатны шүүхээр хязгаарлаагүй бөгөөд ингэснээр шүүх хоорондын хууль хэрэглээний практик, шийдвэрийн үндэслэл, хяналтын шатны шүүхээс тухайлан анхаарч буй асуудал зэргийг судлах зорилт тавьсан болно.

Шүүхийн шийдвэрийн www.shuukh.mn цахим санд 2002 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс 2023 оны 06 дугаар сарын 11-ний өдөр хүртэлх хугацаагаар хайж үзэхэд иргэний хэргийн анхан шатны шүүхээр шийдвэрлэгдсэн 48 дампуурлын хэргийн шийдвэр², мөн

¹ Шүүхийн Ерөнхий зөвлөлөөс гаргадаг Монгол Улсын шүүхийн 2021 он, 2022 он, 2023 оны эхний хагас жилийн шүүн таслах ажиллагааны нэгдсэн дүн мэдээ, <https://www.judcouncil.mn/site/news/7>

² https://shuukh.mn/cases/1/1?item_id=9

дампуурлын хэргийг хянасан 18 магадлал³, 7 тогтоол⁴ илэрсэн. Судалгааны зорилгод нийцүүлж, дампуурлын хэргийг хяналтын шатны шүүхээр эцэслэн шийдвэрлэгдсэн 7 тогтоолыг сонгон авч, шүүхийн шийдвэрийн дүн шинжилгээг гүйцэтгэлээ.

Хууль зүйн практикт энэ төрлийн маргааныг “дампуурлын хэрэг”, “компанийг төлбөрийн чадваргүй болгох”, “төлбөрийн чадваргүй болохыг тогтоолгох маргаан”, “компанийг дампууруулах”, “дампуурлын хэрэг гүйцэтгэх ажиллагаа”, “компанийг дампуурсанд тооцож, татан буулгах” нэхэмжлэл, хүсэлт гаргах зэргээр олон янзаар томьёолдог. Үүнээс гадна иргэний хэргийн шүүхэд дампуурлын хэрэгт холбогдох нэхэмжлэл, хүсэлт гаргах, иргэний хэргийг ердийн журмаар шийдвэрлэхэд баримтлах зарчмыг удирдлага болгох эсэх, онцгой ажиллагааны журмаар буюу “дампуурсанд тооцох хүсэлт”-ийг шийдвэрлэхэд нотлох үүргийг хүсэлт гаргагч хүлээх эсэх, шүүгчээс мөрдөн шалгах зарчмыг хэрхэн хэрэгжүүлж буй талаар судалж, шүүхийн шийдвэрийн хууль хэрэглээ, зохицуулалтын дүн шинжилгээ хийж гүйцэтгэсэн нь практикт хууль хэрэглээний нэгдмэл байдлыг хангах, эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгоход чухал ач холбогдолтой юм.

Түүнчлэн компанийг дампуурсанд тооцох хүсэлтийг онцгой ажиллагааны журмаар шийдвэрлэж буй байдал, Дампуурлын тухай хуулийг шүүхээс ялгамжтай хэрэглэж буй асуудлаас гадна компанийг төлбөрийн чадваргүй болгосон буруутай этгээдийн хүлээх хамтын хариуцлага, хүсэлт гаргагчийн үүрэг, нэхэмжлэгч болон гуравдагч этгээдийн эрх зүйн байдал, эдгээртэй холбоотой эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгох үүднээс гадаадын зарим улсын эрх зүйн зохицуулалтыг судлах шаардлагатай. Энэ

³ <https://shuukh.mn/cases/1/2>

⁴ <https://shuukh.mn/cases/1/3>

хүрээнд БНСУ,⁵ ОХУ-ын⁶ компанийг дампуурсанд тооцож, татан буулгах ажиллагааг зохицуулж буй хууль тогтоомж, шүүхийн практикийг судлан холбогдох хууль тогтоомжийг боловсронгуй болгох талаарх саналаа боловсруулсан болно.

Эдгээр санал нь цаашид арилжааны эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгох ажлын хүрээнд энэ төрлийн харилцааг тухайлан зохицуулж буй Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль, Дампуурлын тухай хууль, Компанийн тухай хуульд практикт шинэ тутам тулгамдсан асуудлуудыг хуульчлан оруулахад дөхөм болох болов уу.

⁵ Тус улсын дампуурлын эрх зүйн зохицуулалттай харьцуулан судлах шалтгаан нь хоёр улс эх газрын эрх зүйн тогтолцоотой бөгөөд эдийн засгийн хөгжлийн явцад ижил төстэй сорилтуудтай тулгардагтай холбоотой. Мөн дампуурлын тухай хууль нь ил тод, үр ашигтай байдлыг баталгаажуулж, шүүхийн шийдвэрийн практик сайтай. Тухайлбал, шүүх санхүүгийн баланс, орлогын тайлан, мөнгөн гүйлгээний тайланд иж бүрэн дүн шинжилгээ хийх замаар төлбөрийн чадваргүй байдал, өрийн хэт өсөлтийг бодитой үнэлдэг. Эдгээр хүчин зүйлс нь Монгол Улс хууль эрх зүйн тогтолцоогоо олон улсын жишигт нийцүүлэн боловсронгуй болгоход хэрэгтэй жишиг болж чадна. Солонгосын хууль эрх зүйн тогтолцоо нь аж ахуйн нэгжийн дахин хөрөнгөжилт, зээлдүүлэгчийг хамгаалахад нэгэн зэрэг чиглэдэг бөгөөд энэ нь Монгол Улсад дампуурлын хэрэг хянан шийдвэрлэх тогтоолцоог илүү үр ашигтай, шударга тогтооход хувь нэмрээ оруулна гэж үзэж байна.

⁶ Тус улсыг пост-социалист эрх зүйн тогтолцоотой улсуудыг төлөөлөн болгож сонгосон ба тус улсын Төлбөрийн чадваргүйдлийн тухай хуулийн зорилго, бүтэц, агуулга үзэл санаа нь манай улсын Дампуурлын тухай хууль тогтоомжтой төсөөтэй байх тул дампуурсанд тооцож, татан буулгах ажиллагааны үе шатыг харьцуулан судлахад тус улсын зохицуулалтыг судлах шаардлага үүссэн болно.

НЭГ. ХУУЛИЙН ЭТГЭЭДИЙГ ДАМПУУРСАНД ТООЦОЖ, ТАТАН БУУЛГАХ АЖИЛЛАГААНЫ ОНЦЛОГ

1.1 НИЙТЛЭГ ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТ, ТҮҮНИЙ ЗОРИЛГО

Дампуурлын хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны зорилго нь компанийн нийт төлбөрийн үүргийг бүрэн арилгах, бүх нэхэмжлэгчид (үүрэг гүйцэтгүүлэгч)-ийн шаардлагыг нэгэн зэрэг тэнцүү хэмжээгээр хангах, тус ажиллагааг нэхэмжлэгчид өөрсдөө удирдах нөхцөлийг бүрдүүлэхэд чиглэдэг.⁷ Хуулийг этгээдийг дампуурсанд тооцох урьдчилсан нөхцөл нь “төлбөрийн чадваргүй байдал” юм. Дампуурлын тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1-д зааснаар хуулийн этгээд өөрийн хөрөнгийн 10-аас доошгүй хувьтай тэнцэх хэмжээний үүргээ хууль буюу гэрээнд заасан хугацаанд биелүүлэхгүй бол төлбөрийг чадваргүйд тооцох нөхцөл бүрдэнэ. Улмаар уг компанийг төлбөрийн чадваргүй болсон үндэслэлээр дампуурсанд тооцох эсэхийг зөвхөн иргэний хэргийн шүүх шийдвэрлэнэ. Өөрөөр хэлбэл, дампуурлын хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа нь хуулийн этгээдийг санаатайгаар төлбөрийн чадваргүйдэлд хүргэж дампууруулах, өр төлбөрөөс зайлсхийх боломжийг олгохгүй байхад чиглэгдэх учир шүүхийн оролцоо илүү байж хуулийн этгээдийн төлбөрийн чадваргүй болсон шалтгааныг зайлшгүй тогтоодог.

⁷ Шүүхийн сургалт, судалгаа, мэдээллийн хүрээлэн “Иргэний хэргийн шүүхийн шүүгчдийн сургалтын гарын авлагын эмхэтгэл”, УБ, 2022, 865-р тал

Харин компани нь бусдын өмнө хүлээсэн үүргээ биелүүлэх боломжтой байх үедээ шүүхийн бус журмаар татан буугдаж болно. Дотоодын хууль тогтоомжид зааснаар⁸ компанийг татан буулгах эрх бүхий этгээд нь компанийг дараах үндэслэлээр татан буулгана. Үүнд:

- 1) Хувьцаа эзэмшигчдийн шийдвэрээр татан буугдах үндэслэл⁹;
- 2) Шүүхийн шийдвэрээр татан буугдах үндэслэл¹⁰;
 - а) дампуурсан;¹¹
 - б) нэг ч гишүүн үлдээгүй;¹²

⁸ Иргэний хуулийн 32 дугаар зүйлийн 32.1, , Компанийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1

⁹ Иргэний хуулийн 32 дугаар зүйлийн 32.1.1-д энэхүү зохицуулалтын суурь үндэслэлийг гаргасан байдаг бөгөөд хувьцаа эзэмшигчид өөрсдөө компанийг татан буулгах шийдвэр гаргах замаар компанийг татан буулгаж болох бөгөөд энэ нь ихэвчлэн компани ашиг олохгүй байх, санхүүгийн хувьд хүнд байдалд орох эсхүл хүнд байдалд орох нь тодорхой болох, хувьцаа эзэмшигчид хоорондоо таарамжгүй болох, компани байгуулсан зорилгодоо хүрэх, цаашид үйл ажиллагаа явуулах шаардлагагүй болох гэх мэт шалтгаантай байдаг. Үүнээс гадна татан буугдах үндэслэлийг компанийн дүрэмд зааж өгсөн тохиолдолд тухайн нөхцөл бүрдсэнээр хувьцаа эзэмшигчдийн хурал татан буулгах шийдвэр гаргах шаардлага үүсдэг. Бизнес эрхлэх эсэх нь тухайн этгээдийн эрх чөлөө байдаг тул хуулиар компани байгуулахад тусгай шаардлага тавьдаггүй бөгөөд татан буулгахад ч мөн ялгаагүй хувьцаа эзэмшигч нар нь чөлөөтэйгөөр шийдвэрлэх боломжтой байхаар зохицуулсан.

¹⁰ Компанийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.2 дах хэсэг.

¹¹ Дампуурлын тухай хуулийн 32.1-д зааснаар 1. Дахин хөрөнгөжүүлэх тухай хүсэлт ирээгүй, 2. Шүүх төлөвлөгөөг батлаагүй, 3. Шүүхэд төлөвлөгөөг ирүүлээгүй, 4. Төлөвлөгөөг биелүүлэх боломжгүй болсон үндэслэлээр шүүх хариуцагчийг дампуурсанд тооцож, татан буулгах шийдвэр гаргадаг.

¹² Компанид нэг ч хувьцаа эзэмшигч үлдэхгүй байж болох бөгөөд энэ нь ихэвчлэн хувьцаа эзэмшигч нь нас барах, дампуурах эсхүл бүх хувьцаагаа компанидаа шилжүүлэх гэх мэт шалтгаантай байж болно. Нэг ч хувьцаа эзэмшигч үлдээгүй компани үйл ажиллагаа явуулж байж болох боловч компанийн тогтвортой байдал алдагдах, зээлдүүлэгч, 3 дагч этгээдийн эрх ашиг хөндөгдөх зэрэг асуудлаас гадна компани нь сонгодог утгаараа хувьцаа эзэмшигчийн хувь нийлүүлсэн хөрөнгө дээр тулгуурлаж үйл ажиллагаагаа явуулж, ашиг сонирхлоо илэрхийлэх, ногдол ашиг тараах гэх мэт ашиг олох зорилготой байдаг учраас зорилго, агуулгын хувьд зохимжгүй болдог. Компанийн тухай хуулиар шүүхээс “нэг ч гишүүн үлдээгүй” үндэслэлээр татан буулгаж болохоор зохицуулсан байгаа боловч нэхэмжлэл, хүсэлт, гомдол гаргах этгээд хэн байх, татан буулгах ажиллагаа ямар процессоор явагдах талаар нарийн зохицуулалт байхгүй байна.

- в) хуульд заасан бусад үндэслэл (КтХ 26.2),¹³
- 3) Хуульд заасан бусад үндэслэл (тухайн үндэслэлд заасан этгээд);
 - а) Компанийг байгуулсан хугацаа дуусах (Иргэний хууль 32.1.3)¹⁴

Дээр дурдсанчлан, компанийг дампуурсанд тооцох эрх бүхий субъект нь зөвхөн шүүх байх бөгөөд компанийг төлбөрийн чадваргүй үндэслэлээр дампуурсанд тооцох хүсэлтийг шийдвэрлэхдээ Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 155¹ дүгээр зүйлээс гадна Дампуурлын тухай хуулийг баримтална.¹⁵ Дампуурлын тухай хуулиар дампуурлын хэрэг үүсгэх, хянан шийдвэрлэх, төлбөрийн чадваргүй аж ахуйн нэгжийг дахин хөрөнгөжүүлж, татан буулгах ажиллагааг¹⁶ дараах байдлаар зохицуулжээ. Үүнд:

- 1) Дампуурлын хэрэг үүсгэх үндэслэл:
 - а) Үүргийн гүйцэтгэлийг шаардах эрх бүхий харилцагч тал дампуурлын хэрэг үүсгэх тухай **нэхэмжлэл** гаргасан (ДтХ 5.1.1);

¹³ Иргэний хуулийн 32.1.2-т зааснаар шүүх нь хуулийн этгээдэд дампуурсанд тооцож татан буулгахаас гадна **хуулийг удаа дараа** буюу **ноцтой зөрчсөн** үндэслэлээр татан буулгаж болохоор зохицуулсан. Өөрөөр хэлбэл, Эрүүгийн хууль болон Зөрчлийн тухай хуулийн дагуу хэрэг үүсгэгдэж **хуулийг зөрчсөн** үйлдэл нь тогтоогдсоны үндсэн дээр **удаа дараа эсвэл ноцтой зөрчил** байгаа тохиолдолд шүүх компанийг татан буулгаж болох бөгөөд татан буулгах нэхэмжлэл, хүсэлт, гомдол гаргах эрх бүхий субъект болон татан буулгах үйл ажиллагааг нарийвчлан зохицуулсан зохицуулалт байхгүй байна.

¹⁴ Компанийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.5 дах хэсэгт зааснаар компанийн дүрэмд тодорхой хугацаатай заах байдлаар компанийг үүсгэн байгуулж болох бөгөөд энэ тохиолдолд дүрэмд заасан хугацаа дууссанаар компани татан буугдана. Гэхдээ хэрэв тухайн компанийг үргэлжлүүлэн үйл ажиллагааг нь явуулахыг хүсвэл хувьцаа эзэмшигчдийн хурлаас “компанийн үйл ажиллагааг үргэлжлүүлэх” шийдвэр гаргах замаар үргэлжлүүлэх боломжтой бөгөөд компанийг татан буулгах эсэх шийдвэр нь Компанийн тухай хуулийн 63 дугаар зүйлийн 63.1-т зааснаар саналын эрхтэй хувьцаа эзэмшигчдийн дийлэнх олонхын саналаар шийдэгддэг тул “үйл ажиллагааг нь үргэлжлүүлэх” тухай шийдвэр ч мөн ижил саналаар шийдвэрлэгдэнэ.

¹⁵ ХБНГУ-ын Ханнс-Зайделийн сангийн Монгол дах төлөөлөгчийн газар, Эрх зүйн боловсрол академи “Монгол Улсын Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн хялбаршуулсан тайлбар”, УБ, 2013,169-р тал

¹⁶ Дампуурлын тухай хуулийн 1 дүгээр зүйлийн 1.1 дэх хэсэг.

- б) Хариуцагч үүргээ биелүүлж чадахгүй болсныг өөрөө мэдэгдэж, дампуурлын хэрэг үүсгэх **хүсэлт** гаргасан (ДтХ 5.1.2)
- 2) Дампуурлын хэрэг хэрэгсэхгүй болгох үндэслэл:
 - а) Төлбөрийн чадвартай байх
- 3) Дахин хөрөнгөжүүлэх үндэслэл:
 - а) Төлөвлөгөөг нэхэмжлэгчдийн 2-оос доошгүй хэсэг дэмжсэн бол¹⁷ (ДтХ 28.2.1)
 - б) Нэхэмжлэлийн шаардлагыг хариуцагч татан буугдсанаас илүү хангаж чадахаар байвал¹⁸ (ДтХ 28.2.2)
- 4) Дампуурсанд тооцож, татан буулгах үндэслэл:
 - а) Дахин хөрөнгөжүүлэх тухай хүсэлтийг шүүхэд ирүүлээгүй¹⁹ (ДтХ 33.1.1);
 - б) Дахин хөрөнгөжүүлэх төлөвлөгөөг шүүх батлаагүй²⁰ (ДтХ 33.1.1)

¹⁷ Нэхэмжлэгчийн хувьд хариуцагч хуулийн этгээдийг дампууруулах нь түүний хөрөнгөөс өөрийн нэхэмжлэлийн тодорхой хэсгийг хангуулах арга болж байдаг. Иймд өөрийн нэхэмжилж буй дүнг аль болох бүрэн хангуулах ашиг сонирхолтой учраас нэхэмжлэгчдэд хариуцагч компанийг дахин хөрөнгөжүүлэх төлөвлөгөөг баталж боломжийг хууль тогтоогч олгосон. Нэхэмжлэгчид олон байгаа тохиолдолд 1) нэхэмжилсэн үнийн дүнгийн 10 буюу түүнээс дээш хувийг эзлэх барьцаат нэхэмжлэгч 2) бусад барьцаат нэхэмжлэгчид 3) хариуцагчтай хөдөлмөрийн гэрээгээр ажиллагчид 4) бусад гэсэн шалгуураар ангилж, бүлэг тус бүрээр санал хураалтыг явуулдаг/ДтХ 27/.

¹⁸ Компанийн эргэлтийн хөрөнгийн хэмжээ, борлуулалтын ашиг, цэвэр ашиг, өрийн харьцаа зэргийг анхаарч, санхүүгийн тайланд дүн шинжилгээ хийх, мөн дахин хөрөнгөжүүлэх төлөвлөгөө нь бодит байдалд биелэгдэх боломжтой эсэх гэх мэт нарийн шинжилгээний дүнд нэхэмжлэгчийн шаардлагыг хариуцагч компани дампуурснаар сайн хангаж байна уу эсвэл дахин хөрөнгөжүүлснээр сайн хангаж байна уу гэдэгт шүүх шийдвэр гаргадаг.

¹⁹ 1)хариуцагч өөрөө 2)хариуцагчаас нэхэмжилсэн нийт төлбөрийн гуравны нэг буюу түүнээс дээш хувийг нэхэмжилж байгаа нэхэмжлэгчид 3)хэрэг гүйцэтгэгч нь татан буулгаснаас нэхэмжлэгчдийн нэхэмжлэлийн шаардлагыг илүү хэмжээгээр хангах боломжтой гэж үзвэл дахин хөрөнгөжүүлэх хүсэлт гаргадаг /ДтХ 23.1/.

²⁰ Дахин хөрөнгөжүүлэх төлөвлөгөөг хүлээж авсан шүүх 1) төлөвлөгөөг нэхэмжлэгчдийн 2-оос доошгүй хэсэг дэмжсэн 2) нэхэмжлэлийн шаардлагыг хариуцагч татан буугдсанаас илүү хангаж чадахаар байвал баталдаг /ДтХ 28.2/. Энэ төлөвлөгөөг батлахдаа шүүхийн анхаарах гол асуудал нь уг төлөвлөгөө хууль тогтоомжтой нийцэж байгаа эсэх, талуудын эрх ашиг тэгш, шударга хангагдаж байгаа эсэхийг сайтар нягтлахаас гадна тухайн компанийн үйл ажиллагаа болон санхүүгийн байдал нь сайжрах боломжтой эсэхэд дүгнэлт өгөх зэрэг юм. Шүүхийн зүгээс нэлээд мэргэжлийн шийдвэр гаргахыг шаарддаг учраас шүүхэд мэргэшсэн этгээдүүдийн туслалцааг авах шаардлага үүсэх боломжтой.

- с) Дахин хөрөнгөжүүлэх төлөвлөгөөг шүүхэд ирүүлээгүй²¹
(ДтХ 33.1.1)
- д) Дахин хөрөнгөжүүлэх төлөвлөгөөг биелүүлэх боломжгүй
болсон²² (ДтХ 33.1.1)

Дампуурсанд тооцож, татан буулгах ажиллагаатай холбоотой харилцааг ОХУ-д Төлбөрийн чадваргүйдлийн (дампуурал) тухай хуулийн зохицуулдаг. Тус зохицуулалтын агуулгатай харьцуулж үзэхэд, Монгол Улсын Дампуурлын тухай хуульд дампуурлаас урьдчилан сэргийлэх хүрээнд авах арга хэмжээ, компанийн эрх бүхий албан тушаалтан эсхүл удирдлагын хүлээх хамтын хариуцлага, үйл ажиллагаа явуулж буй салбарын онцлогтой холбоотой нэмэлт зохицуулалт тусгагдаагүй байгааг дурдах нь зүйтэй.

Хуулийн этгээдийг дампуурсанд тооцож, татан буулгах ажиллагаа гурван үе шатад хувааж болно. Үүнд:

I. Хэрэг үүсгэх ажиллагаа. Сонирхогч этгээдийн хүсэлтийг хүлээн авч Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 62, Дампуурлын тухай хуулийн 7 дугаар зүйлд заасан шаардлагыг хангасан эсэхийг судалж, дампуурлын хэрэг үүсгэх эсэхийг шийдвэрлэнэ. Энэ үе шат нь шүүхэд хүсэлт гаргаснаар эхэлж, шүүгчээс дампуурлын хэрэг үүсгэх тухай захирамж гаргаснаар дуусгавар болно.

II. Төлбөрийг чадваргүйд тооцож, дампуурлын ажиллагааг эхлүүлэх. Энэ үе шат нь төлбөрийн чадваргүй болохыг тогтоож, дампуурлын ажиллагааг эхлүүлэх шийдвэр гаргаснаас эсхүл тус шийдвэр хүчин төгөлдөр болсноор

²¹ Дахин хөрөнгөжүүлэх хүсэлтийг шүүхэд өгснийхөө дараа дахин хөрөнгөжүүлэх төлөвлөгөөг нэхэмжлэгчдийн хурлаар батлуулж шүүхэд хуульд заасан хугацаанд өгдөг./ДтХ 24-27/

²² Дахин хөрөнгөжүүлэх төлөвлөгөөнд тусгагдсан үүргийн гүйцэтгэлийг хангах төлөвлөгөөнд шаардагдах хөрөнгө хуримтлагдахгүй байх, үйл ажиллагааны зорилго, стратеги өөрчлөгдөх эсвэл уг төлөвлөгөөнд тусгагдсан нөхцөл, болзлыг зөрчих, дампуурлын шинэ шалтгаан, нөхцөл байдал бий болох зэргээр төлөвлөгөөг биелүүлэх боломжгүй болж болно.

эхэлж, нэхэмжлэгчдийн анхны хурлыг товлосноор дуусгавар болно.

III. Татан буугдах эсхүл дампуурлын ажиллагааг дуусгавар болгох ажиллагаа. Энэ үе шат нь 2 үндсэн хэлбэртэй байж болно. Үүнд:

- а. Тогтоосон хугацаанд гаргасан нэхэмжлэгчдийн шаардлагыг хариуцагчийн хөрөнгийг худалдан борлуулах замаар орлогыг нэхэмжлэгчид хуваарилах; эсхүл
- б. Дахин хөрөнгөжүүлэх төлөвлөгөөгөөр эсхүл нэхэмжлэгчдийн хурлаар шийдвэрлэсний дагуу ажиллагааг түдгэлзүүлэх эсхүл дуусгавар болгох;

Дампуурлын хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг Монгол Улсын Дампуурлын тухай хуулиар зохицуулдаг ч тус хуульд дээр дурдсан дампуурлын хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны 2, 3 дугаар үе шатыг ялган зааглаж, тухайн үе шатанд хамаарах ажиллагааг тодорхойлоогүй. Үүний улмаас төлбөрийн чадваргүй болохыг тогтоосон үндэслэлээр дампуурлын ажиллагааг шууд эхлүүлж, дампуурлын ажиллагааг нэгдмэл байдлаар үргэлжлүүлэн гүйцэтгэж, дуусгавар болгох боловч давж заалдах болон хяналтын шатны шүүхээс анхан шатны шүүхийн “төлбөрийн чадваргүй”-д тооцож, дампуурлын ажиллагааг эхлүүлсэн нь үндэслэлгүй гэж үзсэнээр дампууруулахтай холбоотой анхан шатны шүүх дээр хийгдсэн бүх ажиллагаа үр дүнгүй болох, хүсэлт гаргагч, нэхэмжлэгч, шүүгчийн үйл ажиллагаа удаашрах нөхцөлийг үүсгэж байна.

1.2 ТУСГАЙ ТӨРЛИЙН ПРОЦЕСС АЖИЛЛАГАА: ДАМПУУРЛЫН ХЭРЭГ ХЯНАН ШИЙДВЭРЛЭХ АЖИЛЛАГАА

Компанийг дампуурсанд тооцох хүсэлтийг онцгой ажиллагааны журмаар шийдвэрлэх бөгөөд тусгай төрлийн процесс ажиллагаанд хамаардаг. Хэрэг хянан шийдвэрлэх онцгой ажиллагаа гэдэг нь эрх зүйн үйл явдал болон үйлдлийг шүүхээс тогтооход чиглэх ба холбогдох этгээдийн хүсэлтээр үүсдэг.²³

Эхний ээлжид сонирхогч этгээд²⁴ нь компанийг дампуурсанд тооцох тухай хүсэлтийг тухайн компанийн оршин байгаа газрын шүүхэд гаргана. Дампуурлын тухай хуульд 5 дугаар зүйлийн 1-д зааснаар сонирхогч этгээд гэдэгт (1) компаниас үүргийн гүйцэтгэлийг шаардах эрх бүхий харилцагч, (2) үүргээ биелүүлж чадахгүй болсон компанийг ойлгоно.

Шүүхэд гаргах хүсэлт²⁵ нь хуульд заасан шаардлагыг хангасан байхаас гадна Дампуурлын тухай хуулийн 7 дугаар зүйлд зааснаар дараах баримт мэдээллийг хавсаргана. Үүнд:²⁶

- 1) Үүргээ биелүүлж чадахгүй болсон компанийн хувьд:
 - а) Хүсэлтдээ төлбөрийн чадваргүй болсон гэх үндэслэл, дахин хөрөнгөжүүлэх эсхүл дампуурсанд тооцож татан буулгах тухай санал;
 - б) Компаниас үүргийн гүйцэтгэлийг шаардах эрх бүхий харилцагчдын нэр, хаяг, харилцагч тус бүрийн авлага буюу гаргуулах төлбөрийн хэмжээ;
 - в) Сүүлийн гурван жилийн санхүүгийн тайлан тэнцэл;

²³ Б.Буянхишиг “Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх эрх зүй”, УБ, 2021, 204-р тал

²⁴ Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1.3 дах хэсэг.

²⁵ Дампуурлын тухай хуулийн 5 дугаар зүйлд шүүхэд харилцагчийн гаргасан хүсэлтийг “нэхэмжлэл”, компаниас гаргасан хүсэлтийг “хүсэлт” гэж томьёолсон бөгөөд аль аль нэр томьёо нь хэргийг онцгой ажиллагааны журмаар шийдвэрлэх хүсэлтэд хамаарах тул судалгаанд “хүсэлт” гэсэн нэр томьёог ашигласан болно.

²⁶ Дампуурлын тухай хуулийн 7 дугаар зүйл.

- г) Өмчлөлдөө байгаа, эсхүл итгэмжлэн өмчилсөн хөрөнгийн жагсаалт, тэдгээрийн үнэлгээний талаарх санал;
 - д) Компанид төлбөртэй этгээдийн нэр, хаяг, төлбөрийн хэмжээ;
- 2) Үүргийн гүйцэтгэлийг шаардах эрх бүхий харилцагчийн хувьд:
- а) Хүсэлтдээ компанийг төлбөрийн чадваргүйд тооцуулах, төлбөрийн чадваргүй болсон гэж үзэх үндэслэл, түүний хүлээсэн үүрэг, төлбөрийн хэмжээ, үүрэг гүйцэтгэх хугацаа;
 - б) Компанийг дахин хөрөнгөжүүлэх, эсхүл дампуурсанд тооцож, татан буулгах тухай санал, түүнд холбогдох нотлох баримтууд;

Шүүх хүсэлтийг хүлээн авснаас хойш 5 хоногийн дотор шийдвэрлэх бөгөөд дээр дурдсан шаардлагыг хангасан тохиолдолд дампуурлын хэрэг үүсгэх тухай шүүгчийн захирамж гарна. Харин хуульд заасан шаардлагыг хангаагүй бол шүүх хүсэлтийг хүлээн авахаас татгалзана. Дампуурлын тухай хуулийн дагуу хэрэг үүсгэсэн шүүгч нь үүргийн гүйцэтгэлийг шаардах эрх бүхий харилцагчийн гаргасан хүсэлтийг 5 хоногийн дотор компанид гардуулж, компанийг **“төлбөрийн чадвартай эсэх”**-ийг 30 хоногийн дотор тогтооно. Монгол Улсын Дээд шүүхийн 2000 оны 01 дүгээр сарын 19-ний өдрийн “Дампуурлын тухай хуулийн зарим зүйл, хэсэг, заалтыг тайлбарлах тухай”²⁷ тогтоолд зааснаар **“төлбөрийн чадваргүйд тооцно”** гэдэгт компанийн банкин дах харилцах болон тооцооны хадгаламжийн данс, түүнчлэн өөрийн кассад бэлэн мөнгөний хүрэлцээгүйгээс нэхэмжлэгчээс нийлүүлсэн буюу худалдсан бараа, бүтээгдэхүүн гүйцэтгэсэн ажил, үзүүлсэн үйлчилгээний үнэ хөлс, мөн банк болон бусдаас олгосон зээлийг төлөх зэрэг зээл тооцооны харилцаанд хүлээсэн, өөрийн хөрөнгийн 10-аас доошгүй хувьтай тэнцэх үүргээ хууль буюу гэрээнд

²⁷ <https://legalinfo.mn/mn/detail?lawId=300071&showType=1>

заасан хугацаанд биелүүлж чадахгүй байгааг ойлгодог. Шүүхийн практикт дампуурлын хэрэг үүсгэсний дараа компанийг “төлбөрийн чадвартай эсэхийг тогтоох” хугацаанд түр хэрэг гүйцэтгэгчийн томилох нь түгээмэл байх²⁸ бөгөөд түүний гаргасан дүгнэлтийг үндэслэн шүүгч төлбөрийн чадваргүйд тооцсон тухай захирамж гаргадаг. Дампуурлын тухай хуулийн 5.5-д дурдсанаар Компанийг төлбөрийн чадваргүй болсныг тогтоосноос хойш 7 хоногийн дотор шүүх энэ тухай хэвлэл мэдээллийн хэрэгслээр нийтэд мэдээлж, нэхэмжлэгчдийн анхны хурлыг товлох дампуурлын хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг эхлүүлнэ. Төлбөрийн чадваргүйд тооцсон тухай захирамж гарсан өдрөөс хойш 5 хоногийн дотор оролцогчид тухайн хэргийг шийдвэрлэж буй шүүхэд гомдол гаргах эрхтэй.

Төлбөрийн чадваргүйд тооцсон захирамж гарснаар дампуурлын хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа шууд эхэлдэг. Тодруулбал, нэхэмжлэгчдийн хурал хуралдаж, Дампуурлын тухай хуулийн 8.3-д заасан асуудлыг хэлэлцэн шийдвэр гаргах, хэрэг гүйцэтгэгч томилогдож, эрх, үүргээ хэрэгжүүлэх замаар дүгнэлт танилцуулж, нэхэмжлэл гаргах, шүүхийн шийдвэрийн биелэлтийг баталгаажуулах арга хэмжээг авах, дахин хөрөнгөжүүлэх хүсэлт гаргах, түүнийг шийдвэрлэх, төлөвлөгөө батлагдсан тохиолдолд хэрэгжүүлэх зэргээр дампуурлын хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа хийгддэг. Уг ажиллагааны үр дүнд (1) дахин хөрөнгөжүүлэх хүсэлтийг шүүхэд гаргаагүй, (2) шүүх дахин хөрөнгөжүүлэх төлөвлөгөөг батлаагүй, эсхүл төлөвлөгөөг шүүхэд ирүүлээгүй, эсхүл (3) төлөвлөгөөг биелүүлэх боломжгүй болсон гэх үндэслэлээр хариуцагчийг **дампуурсанд тооцож, татан буулгах шийдвэрийг** анхан шатны шүүхээс гаргахаар зохицуулсан. Ийнхүү дампуурсанд тооцох хүсэлтийг анхан шатны журмаар шийдвэрлэхэд шүүгч нь дампуурлын хэрэг үүсгэх тухай захирамж, төлбөрийн чадваргүй болсон тухай захирамж, дампуурсанд тооцож, татан буулгах шийдвэр гаргана. Дампуурлын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д зөвхөн оролцогч этгээдүүд

²⁸ https://shuukh.mn/cases/1/1?item_id=9

нь дампуурлын хэргийг хянан шийдвэрлэхтэй холбогдуулан гаргасан шүүгчийн захирамжид гомдол гаргах эрхтэй. Хэрэв оролцогч этгээдүүд нь дампуурлын хэрэг үүсгэх тухай, төлбөрийн чадваргүй болсон тухай захирамжид гомдол гаргаагүй бол тухайн шүүгчийн захирамж хууль зүйн хувьд хүчин төгөлдөр болох бөгөөд уг захирамжаар баталсан шийдвэрийг үл харгалзан, анхан, давж заалдах, хяналтын шатны шүүхээс “төлбөрийн чадвартай эсэх”-д дахин дүгнэлт гаргах шүүхийн практик²⁹ байна.

1.3 КОМПАНИ ДАМПУУРСАНД ТООЦОЖ, ТАТАН БУУЛГАХ АЖИЛЛАГАА

Иргэний хуулийн 26 дугаар зүйлийн 26.1-д зааснаар хуулийн этгээдийн эрх зүйн чадвар нь хуульд заасан журмын дагуу татан буугдаж, улсын бүртгэлээс хасагдсанаар дуусгавар болдог. Дампуурсанд тооцож, татан буулгах ажиллагааг эхлүүлснээр зарчмын хувьд хариуцагч нь өөрийн бүх хөрөнгийн талаарх удирдах, захиран зарцуулах эрхээ алддаг.³⁰ Үүнээс гадна дампуурлын хэрэг үүсгэх үед хариуцагчийн өмчлөлд байсан бүх хөрөнгө болон татан буугдаж улсын бүртгэлээс хасах хүртэлх хугацаанд шинээр бий болсон өмчлөлийн зүйлс, ашиг орлого нь хуваарилагдах эд хөрөнгөд хамаардаг (ДтХ-ийн 17).³¹ Татан буулгах ажиллагааг эрт эхлүүлэх

²⁹ Монгол Улсын Шүүхийн шийдвэрийн цахим сан (shuukh.mn)

³⁰ 김경욱 (2010) 파산신청의 원인으로서의 채무초과 - 2008년 독일의 채무초과 규정의 개정내용을 중심으로 -, 민사집행법연구, 제6권, 468-494, 470면.

³¹ Монгол улс нь дампуурлын хэрэг үүсгэсэн үе буюу нэхэмжлэл, хүсэлтийг хүлээж авсан шүүгч дампуурлын хэрэг үүсгэх захирамж гаргах үед хариуцагчийн өмчлөлд байсан хөрөнгийг хуваарилагдах хөрөнгөд хамруулдаг байдлаараа нилээн өргөн агуулгатай. Өөрөөр хэлбэл төлбөрийн чадвартай эсэх тогтоогдоогүй, дампуурлах эсхүл дахин хөрөнгөжүүлэх тодорхой болоогүй байгад тухайн үед хариуцагчийн өмчлөлд байгаа хөрөнгө нэхэмжлэлийн шаардлагыг хангах ёстой хуваарилагдах хөрөнгөд хамаарч байна. Энэ нь хариуцагч өөрийн хөрөнгөө захиран зарцуулах боломжгүй болох, захиран зарцуулсан үед хүчин төгөлдөр бус болох гэх мэт хариуцагчийн эдийн засгийн эрх чөлөөнд хурцаар халдаж байгаа хэрэг юм. Гадны улс орнуудын хувьд дампуурсан тооцох шийдвэр гарах үед үүрэг гүйцэтгэгч буюу хариуцагчийн өмчлөлд байсан хөрөнгийг хуваарилагдах хөрөнгөд тооцдог жишиг байна. Жишээ нь, БНСУ-ын хувьд Үүрэг гүйцэтгэгчийн дахин хөрөнгөжүүлэлт ба дампуурлын тухай хуулийн 382 дугаар зүйлд заасны дагуу дампуурсанд тооцож, татан буулгах шийдвэр гаргах үед үүрэг гүйцэтгэгчийн өмчлөлд байсан бүх хөрөнгө хуваарилагдах хөрөнгөд хамаарна

нь нэхэмжлэгчдийн нэхэмжлэлийн шаардлагаа хангуулж чадахгүй байх нөхцөл байдалд³² хүргэж болзошгүй байдаг бол оройтуулах нь татан буугдах тухай шийдвэр гаргах хүртэлх хариуцагч буюу дампуурч байгаа этгээдийн хөрөнгөө захиран зарцуулах эрхийг хязгаарлах боломжгүй болдог. Иймд татан буулгах ажиллагааг ямар үндэслэлээр хэзээ эхлүүлэх вэ гэдэг нь хариуцагч болон нэхэмжлэгчийн аль алины ашиг сонирхлыг хөндсөн чухал асуудал байдаг тул дампуурсанд тооцож, татан буулгах үндэслэлийг хуульд тодорхой тусгаж өгөх шаардлага байдаг.

Дампуурлын тухай хуулийн 33 дугаар зүйлд зааснаар анхан шатны шүүхээс хариуцагчийг дампуурсанд тооцож, татан буулгах шийдвэр гарган хэрэг гүйцэтгэгчээс мөнгөн хөрөнгийг хуваарилах ажиллагааг хуулийн дагуу зохион байгуулж, холбогдох тайлангаа шүүхэд танилцуулна. Мөн хуулийн 36 дугаар зүйлд заасныг үндэслэн шүүгч нь хэрэг гүйцэтгэгчийн тайлантай танилцаж, (1) нэхэмжлэгчдийн нэхэмжлэлийг бүрэн, эсхүл хариуцагчийн өмчлөлд байгаа эд хөрөнгийн хэмжээнд хангасан бөгөөд цаашид хуваарилагдах эд хөрөнгө үлдээгүй, (2) эд хөрөнгийг бүрэн худалдаагүй боловч худалдсан хэсгээс нь нэхэмжлэлийн шаардлагыг бүрэн хангасан тохиолдолд татан буулгах ажиллагааг дуусгавар болгоно. Хэрэг гүйцэтгэгч нь татан буулгах ажиллагаа дуусмагц хэрэг гүйцэтгэгч нь энэ тухай бүртгэх байгууллагад мэдэгдэж, улсын бүртгэлээс хасуулдаг байна.

Харин ОХУ-ын Төлбөрийн чадваргүйдлийн (дампуурал) тухай хуулийн 53 дугаар зүйлд зааснаар хариуцагчийг дампуурсанд тооцож, татан буулгах ажиллагааг эхлүүлэх шийдвэрийг гаргадаг. Уг шийдвэр хүчин төгөлдөр болсны дараа татан буулгах ажиллагааг эхлүүлж, хөрөнгө хуваарилах, нэхэмжлэлийг барагдуулах, дахин хөрөнгөжүүлэх хүсэлт гаргах, хуульд заасан үндэслэлээр хэлцлийг

гэж зохицуулсан. ХБНГУ-ын хувьд мөн адил дампуурсанд тооцож, татан буулгах шийдвэр гаргах үед үүрэг гүйцэтгэгчийн өмчлөлд байсан бүх хөрөнгө болон татан буулгах ажиллагааны явцад бий болсон хөрөнгө нь хуваарилагдах хөрөнгөд хамаарна зохицуулсан./Төлбөрийн чадваргүйдлын тухай хууль/

³² Энэ тохиолдолд дахин хөрөнгөжүүлэх боломжгүй болно.

хүчин төгөлдөр бусад тооцох, эрх бүхий албан тушаалтанд хамтын хариуцлага хүлээлгэх, дахин хөрөнгөжүүлэх төлөвлөгөөг баталж, удирдлагыг нь гаднаас томилох зэрэг дампуурлын хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг зохион байгуулдаг. Улмаар нэхэмжлэлийн шаардлага бүрэн, эсхүл хэсэгчлэн хангагдсан тохиолдолд дампуурлын хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг дууссан гэж үзэж, мөн хуулийн 149 дүгээр зүйлд үндэслэн шүүгчээс татан буулгах ажиллагааг дуусгавар болгох захирамжийг гаргаснаар хуулийн этгээдийг татан буулгаж, уг захирамжийг улсын бүртгэлд хүргүүлэн хуулийн этгээдийн нэгдсэн бүртгэлээс хасалт хийдэг онцлогтой.

Компанийг татан буулгах ажиллагааны явцад төлбөрийн үүргийн тодорхой хувь хэсэгчлэн биелэгдэх бөгөөд биелэгдээгүй үлдсэн үүргээс чөлөөлөгдөж, хуулийн этгээдийн улсын бүртгэлээс хасагдсанаар түүний эрх зүйн харилцааны субъект байх боломжгүй бол эрх эдэлж, үүрэг хүлээх чадвар дуусгавар болдог.

ХОЁР. ШҮҮХИЙН ШИЙДВЭРИЙН ДҮН ШИНЖИЛГЭЭ

2.1 КОМПАНИЙГ ДАМПУУРСАНД ТООЦОХ ХҮСЭЛТИЙГ ХЯНАН ШИЙДВЭРЛЭХДЭЭ ТӨЛБӨРИЙН ЧАДВАРГҮЙ БОЛСОН ТУХАЙ ЗАХИРАМЖ ГАРГАСАН БАЙДАЛ

Улсын Дээд шүүхээр хянан шийдвэрлэгдсэн дараах шийдвэрүүдийг сонгон авч, “Төлбөрийн чадваргүй болохыг тогтоосон захирамж”-ийн үндэслэлийн талаар шүүхийн шийдвэрт тусгагдсан байдал, түүнийг хоёр шатны шүүхээс хянасан байдлыг дараах байдлаар судалж үзлээ.

Хүснэгт 1. Анхан шатны шүүхийн “Төлбөр чадвартай эсэх”-ийг тогтоосон захирамж түрний эрх зүйн үр дагавар

Улсын Дээд шүүхийн тогтоол	Хүсэлт гаргагч буюу хариуцагч компанийг төлбөрийн чадваргүйг тогтоосон шүүгчийн захирамж	Захирамжид оролцогч тал гомдол гаргасан эсэх	УДШ тухайн захирамжийг хянавал хэсэгт дурдсан/ дурдаагүй	Тухайн захирамжийн үнэн бодит байдал болон хүчин төгөлдөр байдалтай холбоотой дүгнэлт шүүхийн шийдвэр, магадлал, тогтоолд байгаа эсэх	УДШ-ийн тогтоолын дүгнэлт
1 Улсын Дээд шүүхийн 2022.05.31-ний өдрийн хуралдааны 001/ХТ2022/00660 дугаар тогтоол	2018.11.07-ны өдрийн шүүгчийн 181/ШЗ2018/012410 дугаар захирамж	Гаргаагүй	Хянавал хэсгийн 8-д дурдсан	“Хуульд заасан ажиллагаа явуулсан байна” гэж үзсэн	Хянавал хэсгийн 15, 16-д “... санаатай дампуурлын шинжийг агуулсан... Хариуцагч компанийг дампууруулах үндэслэл үүсээгүй гэж үзсэн хоёр шатны шүүхийн дүгнэлт хуульд нийцсэн...” гэж дүгнэсэн.



ХАРИУЦАГЧ КОМПАНИЙГ “ДАМПУУРСАНД ТООЦОХ ТУХАЙ ХҮСЭЛТ”-ИЙГ ХЭРЭГСЭХГҮЙ БОЛГОСОН ШҮҮХИЙН ШИЙДВЭРТ ХИЙСЭН ДҮН ШИНЖИЛГЭЭ

<p>2 Улсын Дээд шүүхийн 2022.01.18-ны өдрийн хуралдааны 001/ХТ2022/00093 дугаар тогтоол</p>	<p>2019.04.05-ны өдрийн шүүгчийн 102/ШЗ2019/04686 дугаар захирамж</p>	<p>Гаргаагүй</p>	<p>Хянавал хэсгийн 7-д дурдсан</p>	<p>“Дампуурлын тухай хуулийн 5 дугаар зүйлд заасан ажиллагааг хуулийн дагуу хэрэгжүүлсэн байна” гэж үзсэн</p>	<p>“... хамаарал бүхий этгээдээс авах ёстой авлага авч чадахгүй байгаа нь тус компанийг дампууруулж, таган буулгах үндэслэл болохгүй” гэж үзэн ДтХ-ийн 4.1, 5.1.2, 33.1-д заасныг үндэслэж хүсэлтийг хэрэгсээгүй болгосон давж заалдах шатны шүүхийн магадлалыг хэвээр үлдээсэн.</p>
<p>3 Улсын Дээд шүүхийн 2021.10.07-ны өдрийн хуралдааны 001/ХТ2021/01183 дугаар тогтоол</p>	<p>шүүгчийн 2019.02.14-ний өдрийн захирамжаар хүсэлт гаргагч компанийг төлбөрийн чадваргүйд тооцсон</p>	<p>Гаргаагүй</p>	<p>Дурдаагүй</p>	<p>Ямар нэг дүгнэлттгүй.</p>	<p>Шийдвэр магадлалыг хэвээр үлдээсэн учир нь “...хариуцагч компани нь үүргээ биелүүлж чадахгүй болсон нь тогтоогдоогүй тул түүний хүсэлтийг ханаагүй нь Дампуурлын тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.2, 5 дугаар зүйлийн 5.1.2, 5.4-д нийцжээ. Хэрэгт байгаа баримтаас үзвэл ***** ХХК-ийг төлбөрийн чадваргүй гэж үзэх үндэслэл тогтоогдоогүй байна...” гэж үзсэн.</p>

4	Улсын Дээд шүүхийн 2018.06.12-ны өдрийн хуралдааны 001/ХТ2018/00932 дугаар тогтоол	2017 оны 03 дугаар сарын 31-ний өдрийн 3354 дүгээр шүүгчийн захирамжаар тус компанийг төлбөрийн чадваргүйд тооцсон	Гаргаагүй	Хянавал хэсгийн 3 цогцолборт тусгасан.	Шүүх ДТХ-ийн 5 дугаар зүйлийн 5.5-д заасан ажиллагааг явуулсан байна.	<p>Анхан болон давж заалдах шатны шүүхийн шийдвэр, магадлал Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 116 дугаар зүйлийн 116.2-т заасан хууль ёсны бөгөөд үндэслэл бүхий байх шаардлагад нийцээгүй байна.</p> <p>Шүүх хүсэлт гаргагчийн хууль зөрчсөн үйл ажиллагаануудын нөхцөл байдлыг анхаараагүйгээс “И Ж Э Э” ХХК-ийн бусдад төлөх өрийн нийт хэмжээ компанийн өөрийн хөрөнгөөс давсан гэж дүгнэж, хүсэлтийг хангасан нь Дампуурлын тухай хуулийн зорилго, агуулгад нийцээгүй гэж үзсэн.</p>
---	--	--	-----------	--	---	---

ХАРИУЦАГЧ КОМПАНИЙГ “ДАМПУУРСАНД ТООЦОХ ТУХАЙ ХҮСЭЛТ”-ИЙГ ХЭРЭГСЭХГҮЙ БОЛГОСОН ШҮҮХИЙН ШИЙДВЭРТ ХИЙСЭН ДҮН ШИНЖИЛГЭЭ

5	Улсын Дээд шүүхийн 2018.10.18-ны өдрийн хуралдааны 001/ХТ2018/01435 дугаар тогтоол	2017 оны 12 дугаар сарын 15-ны өдрийн 5843 тоот шүүгчийн захирамжаар хүсэлт гаргагчийг төлбөрийн чадваргүйд тооцсон	Гаргаагүй	Хянавал хэсгийн 3 дах цогцолборг дурдсан	“Шүүх хүсэлтийг хүлээн авч, 2017 оны 12 дугаар сарын 15-ны өдрийн 5843 тоот шүүгчийн захирамжаар хүсэлт гаргагчийг төлбөрийн чадваргүйд тооцож, энэ талаар нийтэд мэдээлсэн... байна” гэж дүгнэсэн.	Дампуурсанд тооцож, татан буулгах шийдвэр гаргасан хоёр шатны шүүхийн шийдвэр, магадлал нь хууль ёсны бөгөөд үндэслэл бүхий байх хуулийн шаардлагад нийцээгүй гэж үзсэн. Учир нь төлбөрийн чадваргүйг шүүгчийн захирамжаар тогтоож нийтэд зарлахад зөвхөн татварын өрийн нэхэмжлэл ирсэн бөгөөд татвар төлөх үүрэг болон шүүхийн шийдвэр биелэгдэх учиртай тул “... тухайн компанийг дампуурсанд тооцож, татан буулгаж, татвар төлөх үүргээс чөлөөлөх үндэслэлгүй...” гэж дүгнэсэн бөгөөд ДтХ-ийн 4.1, 5.1.2, 33.1-д заасан үндэслэл тогтоогдоогүй тул дампуурсанд тооцож, татан буулгахыг хүссэн “Т” ХХК-ийн хүсэлтийг хэрэгсэхгүй болгосон.
---	--	---	-----------	--	---	---

6	Улсын Дээд шүүхийн 2018.04.17-ны өдрийн хуралдааны 001/ХТ2018/00617 дугаар тогтоол	2015 оны 11 дүгээр сарын 19-ний өдрийн 2331 дүгээр захирамжаар төлбөрийн чадваргүйд тооцсон	Гаргаагүй	Хянавал хэсгийн 2 дах цогцолборт дурдсан	“Дампуурлын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.5-д заасан ажиллагааг явуулжээ” гэж дүгнэсэн.	Дампуурлын хэрэг үүсгэх замаар “М” ХХК-ийг татан буулгах хуулийн үндэслэл тогтоогдоогүй тул шийдвэр, магадлалыг хүчингүй болгож, нэхэмжлэгчийн хүсэлтийг хэрэгсэхгүй болгох нь зүйтэй гэж хяналтын шатны шүүх үзэв. ДТХ-ийн 4.1, 5.1.2, 33.1-д заасан үндэслэл тогтоогдоогүй тул дампуурсанд тооцож, татан буулгахыг хүссэн “М” ХХК-ийн хүсэлтийг хэрэгсэхгүй болгосон.
7	Улсын Дээд шүүхийн 2021.02.02-ны өдрийн хуралдааны 001/ХТ2021/00118 дугаар тогтоол	Түр хэрэг гүйцэтгэгчийн төлбөрийн чадваргүй гэсэн дүгнэлт гаргасныг үндэслэн 2018 оны 6 сарын 26-ны өдрийн 9189 захирамжаар төлбөрийн чадваргүйд тооцсон	-	Хянавал хэсгийн 2-г дурдсан	Захирамжийн үндэслэл болсон түр хэрэг гүйцэтгэгчийн дүгнэлтээс өөр дүгнэлтийг хэрэг гүйцэтгэгч гаргасан нь өөр төлбөрийг тодорхойгүй болгосон гэж үзсэн.	Хүсэлт гаргагчийн өр төлбөрийн хэмжээг хэрэгт авагдсан баримтын хэмжээнд тогтоох боломжгүй, хүсэлтийг хангах үндэслэлгүй байх тул анхан шатны шүүх хүсэлтийг хэрэгсэхгүй болгохдоо Дампуурлын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.1, 7.1.2, 7.1.3, 7.1.4-д заасныг зөрчөөгүй байна. Анхан шатны шийдвэрийг хэвээр үлдээсэн давж заалдах шатны шүүхийн зөв байна.

2.1.1 Анхан шатны шүүхийн “Төлбөрийн чадваргүй болсон тухай” захирамж хүчин төгөлдөр болсон боловч давж заалдах болон хяналтын шатны шүүхээс дахин хянаж дүгнэлт өгсөн байдал

Хариуцагч компанийг дампуурсанд тооцох тухай хүсэлтийг хүлээн авсан анхан шатны шүүхийн шүүгч төлбөрийн чадвартай эсэхийг шалгаж, төлбөрийн чадваргүй нь тогтоогдсон тохиолдолд хүсэлт гаргагч компанийг “төлбөрийн чадваргүй”-д тооцож, захирамж гаргадаг. Дүн шинжилгээ хийж буй УДШ-ийн тогтоолуудад “Төлбөрийн чадваргүйд тооцсон” анхан шатны шүүгчийн захирамжид оролцогчид гомдол гаргаагүй. Мөн УДШ-ийн тогтоолын Хянавал хэсэгт тухайн захирамжийг дурдаж, “*шүүх хуульд заасан ажиллагааг явуулсан байна*” гэж дүгнэх нь нийтлэг байна. Өөрөөр хэлбэл, хүсэлт гаргагч компанийг төлбөрийн чадваргүйд тооцсон шүүгчийн захирамжтай хэн ч маргаагүй бөгөөд УДШ дүгнэлтдээ уг захирамж хууль ёсны болохыг дүгнэсэн.

Гэтэл УДШ нь тухайн захирамжаас эрс зөрүүтэй дүгнэлт буюу “*хариуцагч компани төлбөрийн чадваргүй нь тогтоогдохгүй байна, төлбөрийн чадваргүй гэх үндэслэл байхгүй байна, хариуцагч компани төлбөрийн чадваргүй болохоо нотолж чадахгүй байна*” гэж дүгнэж байгаа нь шүүгчийн захирамж болон шийдвэрийн агуулга хоорондын зөрчил үүсгэж, компанийг төлбөрийн чадвартай эсэх талаар тогтоосон эрх зүйн үр дагавар бүхий хоёр шүүхийн шийдвэрийг бий болгож байна. Жишээлбэл, 2022.05.31-ний өдрийн 001/ХТ2022/00660 дугаар тогтоолд Улсын Дээд шүүх нь хянавал хэсгийн 8-д³³ “...Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 133 дугаар зүйлийн 133.1.10-д зааснаар “ **** * ”ХХК-ийн хүсэлтийг шүүх онцгой ажиллагааны журмаар хянан шийдвэрлэх бөгөөд анхан шатны шүүхийн шүүгчийн 2018 оны 11 дүгээр сарын 07-ны өдрийн 181/ШЗ2018/012410 дугаар захирамжаар тус компанийг чадваргүй

³³ Улсын Дээд шүүхийн 2022.05.31-ний өдрийн 001/ХТ2022/00660 дугаар тогтоол Монгол Улсын Шүүхийн шийдвэрийн цахим сан (shuukh.mn)

болсныг тогтоож, энэ тухай “Өнөөдөр” сонины 2018.11.16-ны өдрийн 221 дугаарт нийтлэн нийтэд мэдээлж, Дампуурлын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.2, 5.3, 5.5-д заасан ажиллагааг явуулжээ...” гэж дүгнэсэн боловч мөн тогтоолын хянавал хэсгийн 15-д³⁴ “...хоёр шатны шүүх хэрэгт авагдсан баримтын хүрээнд “ **** **** **** ****” ХХК-ийг дампууруулах үндэслэл үүсээгүй гэж үзсэн нь хуульд нийцсэн...” гэж дүгнэсэн.

Ингэснээр Дампуурлын тухай хуулийн 5.3, 5.5-д заасныг үндэслэн анхан шатны шүүхээс дампуурлын хэрэг үүсгэснээс хойш 5 хоногийн дотор шүүх нэхэмжлэлийн хувийг хариуцагчид гардуулж, 30 хоногийн дотор хариуцагчийг төлбөрийг чадвартай эсэхийг тогтоож, үүнээс хойш 7 хоногийн дотор шүүх нь энэ тухай хэвлэл, мэдээллийн хэрэгслээр нийтэд мэдээлэх ажиллагааны эрх зүйн ач холбогдол үгүйсгэгдэж байна.

Анхан шатны шүүхээс “Төлбөрийн чадваргүй болсон тухай” захирамжийг гаргаж, олон нийтэд хариуцагч компанийг төлбөрийн чадваргүй болсныг зарласны дараа дампууруулах ажиллагааг эхлүүлж, хэрэг гүйцэтгэгч томилж, нэхэмжлэгчдийн хурлыг зохион байгуулж, нэхэмжлэлийн хүлээн авч, дахин хөрөнгөжүүлэх хүсэлтийг шийдвэрлэх зэрэг ажиллагааг гүйцэтгэсний дараа анхан шатны шүүхээс татан буулгах эсэхийг хэлэлцэхдээ “төлбөрийн чадваргүй болох нь нотлогдохгүй байна” гэх үндэслэлээр дампуурлын хэргийг хэрэгсэхгүй болгосон шийдвэр гаргах эсхүл анхан шатны шүүхээс дампуурсанд тооцож, татан буулгах шийдвэр гарсны дараа давах, хяналтын шатны шүүхээс “төлбөрийн чадваргүй болох нь нотлогдохгүй” гэсэн дүгнэлтийг гаргаж, дампуурлын хэргийг хэрэгсэхгүй болгож байна. Өөрөөр хэлбэл, анхан шатны шүүх, давах, хяналтын шүүхээс “Төлбөрийн чадваргүй болсон тухай” захирамжийг хүчин төгөлдөр эсэхийг үл харгалзан, компанийг төлбөрийн чадваргүй эсэхийг дахин хянаж, дампуурлын хэргийг хэрэгсэхгүй болгох эсхүл анхан шатны шүүх рүү хэргийг буцаах шийдвэрийг гаргаж байна.

³⁴ Мөн тэнд.

Шүүхийн практикт дампуурсанд тооцож, татан буулгах ажиллагааг дараах 4 үе шатаар явуулж байна. Үүнд:

- 1) **Дампуурлын хэрэг үүсгэх;**
- 2) **Хариуцагчийг төлбөрийн чадвартай эсэхэд тооцож, дампуурлын хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг эхлүүлэх:** Анхан шатны шүүхээс “Төлбөрийн чадваргүй болсон тухай” захирамжийг гаргаж, олон нийтэд хариуцагч компанийг төлбөрийн чадваргүй болсныг зарлах буюу дампуурлын хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа эхлүүлж байна.
- 3) **Дампуурлын хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа хийх:** Энэ хүрээнд хэрэг гүйцэтгэгч томилж, нэхэмжлэгчдийн хурлыг зохион байгуулж, нэхэмжлэлийн хүлээн авч, дахин хөрөнгөжүүлэх хүсэлтийг шийдвэрлэх зэрэг ажиллагааг гүйцэтгэж байна.
- 4) **Хариуцагчийг төлбөрийн чадвартай эсэхэд тооцож, дампуурсанд тооцох эсэх, татан буулгах ажиллагаа эхлэх эсэх:** анхан шатны шүүхээс татан буулгах эсэхийг хэлэлцэхдээ “төлбөрийн чадваргүй болох нь нотлогдохгүй байна” гэх үндэслэлээр дампуурлын хэргийг хэрэгсэхгүй болгосон шийдвэр гаргах эсхүл анхан шатны шүүхээс дампуурсанд тооцож, татан буулгах шийдвэр гарсны дараа давах, хяналтын шатны шүүхээс “төлбөрийн чадваргүй болох нь нотлогдохгүй” гэсэн дүгнэлтийг гаргаж, дампуурлын хэргийг хэрэгсэхгүй болгож байна.

Дээрхээс үзвэл, анхан шатны шүүх, давах, хяналтын шүүхээс “Төлбөрийн чадваргүй болсон тухай” захирамжийг хүчин төгөлдөр эсэхийг үл харгалзан, компанийг төлбөрийн чадваргүй эсэхийг дахин хянаж, дампуурлын хэргийг хэрэгсэхгүй болгох эсхүл анхан шатны шүүх рүү хэргийг буцаах шийдвэрийг гаргаж байна. Шүүхийн практикт 2 дугаар үе шатанд эцэслэн хийгдсэн “Хариуцагчийн төлбөрийн чадвартай эсэх”-ийг тогтоох ажиллагааг

4-р үе шатанд дахин хянан хэлэлцэж байгаа нь хариуцагчийн дампуурах тухай хүсэлтийн дагуу хэрэг үүсгэхдээ явуулах шүүгчийн ажиллагаа, хуулийн этгээдийг төлбөрийн чадвартай эсэхийг тогтоохын тулд явуулах шүүгчийн ажиллагаа, хуулийн этгээдийг төлбөрийн чадваргүйд тооцсон шүүгчийн захирамж болон дахин хөрөнгөжүүлэх ажиллагаа дуусгавар болох үндэслэлийн логик уялдаа, үр дагаврыг нэг мөр ойлгох, хэрэглэх шаардлага байгааг харуулж байна.

Улмаар Дампуурлын тухай хуулийн 5.3, 5.5-д заасныг үндэслэн гарч бус анхан шатны шүүхийн “Төлбөрийн чадваргүй болсон тухай” захирамж нь эрх зүйн үйлчлэлгүй, тодорхой үр дагаврыг үүсгэхгүй байгаа нь энэ захирамжид үндэслэн хийгдэж буй дампуурлын хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа нь ямар нэгэн ач холбогдолгүй, гурван шатны шүүхээс “төлбөрийн чадваргүй гэдэг нь нотлогдоогүй” гэсэн дүгнэлт гаргаж, хэргийг хэрэгсэхгүй болгосноор оролцогчдын гаргасан зардал, хугацаа нь үр дүнгүй болж үлдэж байна.

2.1.2 “Төлбөрийн чадваргүй болсон тухай” шүүгчийн захирамж хүчинтэй боловч шүүхээс дампуурлын хэргийг хэрэгсэхгүй болгож шийдвэрлэх эрх зүйн үндэслэл байгаа эсэх

Дампуурлын тухай хуулийн системчлэлийг авч үзвэл дампуурсанд тооцож, татан буулгах ажиллагааг 1) хүсэлт, нэхэмжлэл хүлээж авах 2) хэрэг үүсгэх 3) төлбөрийн чадвартай эсэхийг тогтоох 4) оролцогчдын өр төлбөрийг хянан шийдвэрлэх гэсэн ерөнхий 4 үе шатанд хувааж болно. Үүнийг дараах зургаас дэлгэрүүлэн харна уу.

Дампуурлын тухай хуулийн дампуурлын хэрэг үүсгэх тухай 2 дугаар бүлэгт зохицуулсны дагуу дампуурсанд тооцуулах хүсэлт хүлээн авсан шүүгч нь дампуурлын хэрэг үүсгэх, төлбөрийн чадвартай болох эсэх захирамж гаргадаг. Дампуурлын тухай хуулийн 5.4, 6.1-д зааснаар шүүхээс дампуурлын хэргийг дараах 2 тохиолдолд хэрэгсэхгүй болгоно. Үүнд:

1. Шүүхээс компанийг төлбөрийн чадвартай эсэхийг шалгаж, төлбөрийн чадвартай болох нь тогтоогдвол дампуурлын хэргийг хэрэгсэхгүй болгож, оролцогчдын өр төлбөрийн асуудлыг шийдвэрлэнэ.
2. Шүүхээс компанийг төлбөрийн чадвартай эсэхийг шалгаж, төлбөрийн чадваргүй болсон тухай захирамж гаргасан боловч оролцогчид тухай захирамжийг эс зөвшөөрч гомдол гаргаснаар тухайн шатны шүүх гомдлыг хянан хэлэлцэж, гомдлыг хангасан тохиолдолд компанийг төлбөрийн чадвартай болохыг тогтоож, дампуурлын хэргийг хэрэгсэхгүй болгон оролцогчдын өр төлбөрийн асуудлыг шийдвэрлэнэ.

Үүнээс гадна 3 дугаар үе шат буюу “**дампуурлын хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа**”-г удирдан явуулах үе шатанд дахин хөрөнгөжүүлэх төлөвлөгөөг бүрэн биелүүлж дууссан эсвэл төлөвлөгөөг биелүүлж дуусаагүй боловч нэхэмжлэгчдийн нэхэмжлэлийн шаардлагыг төлөвлөгөөний дагуу бүрэн хангасан тохиолдолд Дампуурлын тухай хуулийн 32.3-д заасны дагуу дампуурлын хэргийг хэрэгсэхгүй болгодог. Энэ тохиолдолд дампуурлын хэргийг хэрэгсэхгүй болгохдоо хариуцагч компанийг “төлбөрийн чадвартай” эсэхэд анхаарал хандуулах бус, батлагдсан дахин хөрөнгөжүүлэх төлөвлөгөөг чухалчилж байгааг анхаарах шаардлагатай.

Шүүхээс өөрөөр төлбөрийн чадваргүй болсон хуулийн этгээдийн дампуурлын хэргийг хэрэгсэхгүй болгох хууль зүйн үндэслэл байхгүй. Дампуурлын тухай хуулийн 5.5-д зааснаар төлбөрийн

чадваргүй болсныг шүүхээс шалгаж, тогтоосон бол дампуурлын ажиллагаа эхэлдэг. Улмаар дампуурлын ажиллагаа эхэлсэн нөхцөлд “төлбөрийн чадвартай эсэх”-ийг тогтоосон захирамжийг дахин хянах ажиллагааг хуульчлаагүй ч шүүхийн практикт уг ажиллагааг зохион байгуулдаг.

Дампуурлын тухай хуулиар компанийг дампуурсанд тооцож, татан буулгахад нэгдүгээрт, **төлбөрийн чадваргүй байх** (ДтХ 5.3) хоёрдугаарт, **дахин хөрөнгөжүүлэхгүйгээр шийдвэрлэсэн эсхүл боломжгүй болсон** (ДтХ 33.1) гэсэн хоёр урьдчилсан нөхцөлийг шаарддаг. Эхний нөхцөл буюу төлбөрийн чадвартай эсэхийг нэхэмжлэл, хүсэлтийг хүлээж авснаас хойш 30 хоногийн дотор шүүх тогтоодог бөгөөд энэхүү захирамжаар хуулийн этгээдийг дампуурсанд тооцдоггүй. Компанийг төлбөрийн чадваргүй болохыг тогтоосноос хойш шүүх дампуурсанд тооцож, татан буулгах хүртэл хамгийн багадаа 60, ихдээ 130 хоног³⁵ байдаг. Үүний дараа хоёр дах нөхцөл хангагдаагүй тохиолдолд шүүх хариуцагчийг дампуурсанд тооцож, татан буулгах тухай шийдвэр гаргадаг.

Хэдийгээр дээрх эрх зүйн зохицуулалтын үр дүнд анхан шатны шүүх захирамж, шийдвэр гэсэн хоёр шийдвэр гаргаж байгаа боловч шийдвэрлэж буй асуудлын хүрээ нь өөр өөр юм. Дампуурлын тухай хуулийн системчлэлийн хувьд эхний шийдвэрээр төлбөрийн чадваргүй болохыг тогтоосон боловч дампуурсанд тооцож, татан буулгахгүй байгаа гол үндэслэл нь дахин хөрөнгөжих боломжийг хуульчилж өгсөнд оршино. Өөрөөр хэлбэл, төлбөрийн чадваргүйг нь тогтоосон захирамж нь дахин хөрөнгөжих хүсэлт өгөх эрхийг нээдэг бөгөөд энэхүү боломж ашиглагдаагүй тохиолдолд төлбөрийн чадваргүй нь тогтоогдчихсон компанийг дампуурсанд тооцож,

³⁵ 1. Дахин хөрөнгөжүүлэх хүсэлтийг 60 хоног хүлээнэ (ДтХ 23.1).

2. Хүсэлт өгсөн этгээд хэрэг гүйцэтгэгчийн дүгнэлттэй танилцсан өдрөөс хойш 30 хоногийн дотор дахин хөрөнгөжүүлэх төлөвлөгөө батална.

3. Дээрх хугацаанаас хойш 20 хоногийн дотор төлөвлөгөөг хэлэлцэх хурал хийнэ (ДтХ 26.1).

4. Төлөвлөгөө хэлэлцсэнээс хойш 20 хоногийн дотор шүүх батлах эсэх шийдвэр гаргана (ДтХ 28.1).

татан буулгах шийдвэр гаргах нь заавал байх үр дүн байдлаар хуульчилжээ.

Гэтэл сонгон судалсан УДШ-ийн тогтоолууд болон анхан, давж заалдах шатны шүүхийн шийдвэр, магадлалд төлбөрийн чадваргүй болохыг тогтоосон шүүгчийн захирамж байсаар байхад дахин төлбөрийн чадвартай эсэх асуудлыг судалж дүгнэлт өгчээ. Ингэхдээ төлбөрийн чадваргүйг тогтоосон шүүгчийн захирамжийг хууль зүйн үндэслэлтэй гэж үзэж, уг захирамжийн талаар ямар нэг байдлаар алдаа мадаг, хууль зөрчсөн эсэхийг тогтоогоогүй. Хэрэв шүүгчийн захирамжийг хууль ёсны гэж үзэж байгаа тохиолдолд хоёр дах нөхцөл бүрдсэн эсэхийг шалгаад дампуурсанд тооцож, татан буулгах нөхцөлийг Дампуурлын тухай хуулийн 33 дугаар зүйлд хуульчилсан. Энэ хүрээнд шүүх 1) дахин хөрөнгөжүүлэх хүсэлт ирсэн эсэх, 2) хүсэлт ирсэн ч дахин хөрөнгөжүүлэх төлөвлөгөөг шүүхэд ирүүлсэн эсэх, 3) төлөвлөгөө ирүүлсэн ч шүүх баталсан эсэх, 4) шүүх төлөвлөгөөг баталсан ч төлөвлөгөө хэрэгжүүлэх боломжгүй болсон эсэхийг тогтоох юм. Харин Хүснэгт №1-д дурдсан шүүхийн шийдвэрүүдэд төлбөрийн чадваргүй эсэхийг тогтоосон захирамж гарч, уг захирамжид гомдол гаргаагүй хүчин төгөлдөр байхад дампууруулах ажиллагаа эхэлснээс хойш дахин төлбөрийн чадваргүй эсэхийг шийдвэрлэж байгаа нь энэ төрлийн маргааныг шийдвэрлэх хуулиар тодорхойлсон процессыг өөрчилж байна.

Монгол Улсын Дампуурлын тухай хуулиар тодорхойлсон дампуурлын маргааныг хянан шийдвэрлэх ажиллагаа нь “төлбөрийн чадвартай эсэх”-ийг захирамжаар тогтоодог онцлогтой бөгөөд ОХУ-ын дампуурлын маргааныг хянан шийдвэрлэх ажиллагааны дарааллаас дараах байдлаар ялгаатай.

Хүснэгт 2. Монгол Улс болон ОХУ-ын дампуурлын хэргийг шүүхээр хянан шийдвэрлэх ажиллагааны нийтлэг болон ялгаатай тал

Үе шат	Монгол Улс	Оросын Холбооны Улс	Нийтлэг болон ялгаатай тал
I. Дампуурлын хэрэг үүсгэх	Хариуцагч компани, эсхүл үүргийн гүйцэтгэлийг шаардах эрх бүхий харилцагчийн гаргасан хүсэлт, нэхэмжлэл нь хуульд заасан шаардлага хангасан эсэхийг судалж, шүүгчийн захирамжаар дампуурлын хэрэг үүсгэнэ.	Хариуцагч компани, төрийн эрх бүхий байгууллага, өмнө нь ажиллаж байсан ажлын хөлсний авлагатай ажилтан, төлбөр авагчаас гарсан хүсэлт нь хуульд заасан шаардлагыг хангасан эсэхийг судалж, шүүгчийн захирамжаар дампуурлын хэрэг үүсгэнэ.	Нийтлэг тал: Дампуурсанд тооцох хүсэлтийг онцгой ажиллагааны журмаар шийдвэрлэдэг. Ялгаатай тал: хүсэлт гаргагчид тавигдах шаардлагыг өөрөөр хуульчилсан. Монгол Улсад үүргийн гүйцэтгэлийг шаардах эрх бүхий харилцагч хугацаандаа үүргээ биелүүлээгүй, өр төлбөр ихтэй ихтэй гэх нөхцөл байдлыг шаарддаг. ³⁶ Харин ОХУ-д өмнө нь ажиллаж байсан ажилтан, төлбөр төлөгчийн шаардах төлбөрийг шүүхээр шийдвэрлэсэн, хүчин төгөлдөр шийдвэр, эрх бүхий байгууллагын хувьд төлбөрийн үүргийг шаардах шийдвэртэй байхыг шаарддаг. ³⁷

³⁶ Монгол Улсын Дээд Шүүх, "Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн дэлгэрэнгүй тайлбар", УБ, 2014, 379-р тал.

³⁷ ОХУ-ын Төлбөрийн чадваргүйдэл (дампуурал)-ийн тухай хуулийн 7-р зүйл, https://www.consultant.ru/document/cons_doc_LAW_39331/7bfd798d41c90791dfc0fe4dc91d70atd54c580/

<p>II. Төлбөрийн чадваргүйд тооцож, дампуурлын хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг эхлүүлэх</p>	<p>- Дампуурлын хэрэг үүсгэснээс хойш 5 хоногийн шүүх нэхэмжлэлийг хариуцагчид гардуулж, 30 хоногийн дотор хариуцагчийг төлбөрийн чадвартай эсэхийг тухай захирамж гаргаж, олон нийтэд мэдээнэ.</p> <p>- Дампууруулах ажиллагаа эхэлж, хэрэг гүйцэтгэгчийг томилох, дүгнэлт гаргах, нэхэмжлэгчийн анхны хурлыг хийх, нэхэмжлэлийн шаардлагыг шийдвэрлэх, дахин хөрөнгөжүүлэх хүсэлтийг шийдвэрлэх зэрэг хуульд заасан ажиллагааг гүйцэтгэнэ.</p>	<p>- Дампуурлын хэрэг үүсгэснээс хойш хүсэлтийн түүний үндэслэлийг шалгах зорилгоор хянан шалгах ажиллагааг эхлүүлэх захирамжийг гаргаж, нэхэмжлэгчдийн анхны хурлыг зарлаж, хэрэг гүйцэтгэгч томилогдоно.</p> <p>- Хүсэлтийг хянан шалгах хугацаанд төлбөрийн чадваргүй болох нь тогтоогдвол шүүхээс “Дампуурсанд тооцож, татан буулгах ажиллагааг эхлүүлэх” шүүхийн шийдвэр гаргана.</p> <p>- Татан буулгах ажиллагааг эхлүүлэх шийдвэрийн хэрэгжилтийг Хэрэг гүйцэтгэгч хариуцах бөгөөд нэхэмжлэлийн шаардлагыг тооцоолж, нэхэмжлэгчдийн хурлаас гарсан шийдвэрийн хэрэгжилтийг зохион байгуулах, төлбөрийн хуваарилалт хийх, хөрөнгийн бүртгэх, хамтын хариуцлага хүлээх этгээдийг тодорхойлох зэрэг татан буугдах ажиллагааг хийж гүйцэтгэдэг. Дахин хөрөнгөжүүлэх хүсэлт гарсан тохиолдолд түүнийг шийдвэрлэх, удирдлага томилох зэрэг асуудлуудыг шийдвэрлэнэ.</p>	<p>Монгол Улсын Дампуурлын тухай хуулиар шүүгчээс “Төлбөрийн чадваргүй болсон тухай” захирамж гарснаар дампуурлын хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг хийж гүйцэтгэж эхэлдэг. Гэхдээ практикт, уг захирамж нь шүүхийн шийдвэрийн нэгэн адил эрх зүйн хүчин төгөлдөр байдлаа хадгалж чадахгүй байгаа бөгөөд анхан, давах, хяналтын шатны шүүхээс “төлбөрийн чадвартай эсэх”-ийг дахин хянаж, төлбөрийн чадвартай гэсэн шийдвэр гаргадаг.</p> <p>ОХУ-д хүсэлтийг хянан шалгах ажиллагааг гүйцэтгэсний үндсэн дээр төлбөрийн чадваргүй (дампуурсан) гэж үндэслэл илэрвэл “Дампуурсанд тооцож, татан буулгах ажиллагааг эхлүүлэх” шийдвэр гаргадаг.</p>
---	--	---	---



ХАРИУЦАГЧ КОМПАНИЙГ “ДАМПУУРСАНД ТООЦОХ ТУХАЙ ХҮСЭЛТ”-ИЙГ ХЭРЭГСЭХГҮЙ БОЛГОСОН ШҮҮХИЙН ШИЙДВЭРТ ХИЙСЭН ДҮН ШИНЖИЛГЭЭ

		<p>Төлбөрийн чадваргүй болсон тухай захирамж гарснаар хийгддэг дампуурлын хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа нь ОХУ-ын хувьд татан буугдах ажиллагаанд хамаарна.</p>	<p>Энэ шийдвэр нь давах, хяналтын журмаар гомдол гаргах эрхтэй бөгөөд энэ шийдвэр хүчин төгөлдөр болсноор татан буугдах ажиллагааг эхэлдэг онцлогтой.</p>
<p>III. Татан буулгах шийдвэр гаргах</p>	<p>- Дахин хөрөнгөжүүлэх төлөвлөгөө хүсэлт гаргаагүй, эсхүл шүүх төлөвлөгөөг батлаагүй, төлөвлөгөөг шүүхэд ирүүлээгүй, төлөвлөгөөг биелүүлэх боломжгүй болсон бол дампуурсанд тооцож, татан буулгах шийдвэр гаргана.</p> <p>- Шүүхийн практикт, шүүхийн төлбөрийн чадвартай эсэхийг дахин хянаж, дампуурлын хэргийг хэрэгсэхгүй болгож байна.</p>	<p>- Дахин хөрөнгөжүүлэх ажиллагаа амжилтгүй болсон, эсхүл оролцогчид эвлэрээгүй татан буугдах ажиллагааг дуусгавар болгож, шүүхээс захирамж гаргаж, улсын бүртгэлд хүргүүлнэ.</p>	<p>Монгол Улсын шүүхийн практикт, төлбөрийн чадваргүй болсон тухай захирамж гаргаснаас хойш дампуурлын хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны дийлэнх хэсгийг гүйцэтгэж дуусаад дампуурсанд тооцож, татан буулгах шийдвэр гарах эсхүл “төлбөрийн чадваргүй болсноо нотлоогүй” гэсэн үндэслэлээр дампуурлын хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа дуусахаас өмнө хариуцагч компани төлбөрийн чадвартай гэсэн шийдвэр шүүхээс гарах магадлалтай.</p> <p>ОХУ-д зохицуулалтаар татан буугдах ажиллагааг дууссан, нэхэмжлэгчдийн шаардлыг зарим хэсгийг хангагдсан, үлдсэн хэсэг хангагдаагүй үлдсэн, дахин хөрөнгөжүүлэх төлөвлөгөө гараагүй гэж үзвэл Шүүгчээс татан буугдсан захирамж гаргана.</p>

<p>IV. Таган буулах ажиллагааг дуусгавар болгох</p>	<p>- Мөнгөн хөрөнгийг хуваарилах ажлыг хуулийн дагуу зохион байгуулж, шүүхэд тайлагнана. - Шүүхээс таган буулах ажиллагаа дуусгавар болгож, Хөрөг гүйцэтгэгч нь энэ тухай бүртгэх байгууллагад мэдэгдэж, улсын бүртгэлээс хасуулна.</p>	<p>-</p>	<p>Монгол Улсад шүүхийн шийдвэр дампуурсанд тооцож, таган буугдах шийдвэр гарсны дараа үлдсэн таган буугдах ажиллагааг хийж гүйцэтгэдэг онцлогтой.</p>
---	---	----------	--



2.1.3 Төлбөрийн чадваргүйд тооцсон шүүгчийн захирамжийг хүчингүй болгох замаар хүсэлтийг хэрэгсэхгүй болгож шийдвэрлэх боломж байгаа эсэх

Дампуурлын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу оролцогч этгээдүүд шүүгчийн захирамж, шүүхийн тогтоолыг эс зөвшөөрвөл түүнийг гарсан өдрөөс хойш 5 хоногийн дотор гомдол гаргах эрхтэй гэж зохицуулсан. Харин хариуцагч компанийн хүсэлтээр үүссэн дампуурлын хэргийн хувьд төлбөрийн чадваргүйг тогтоож байгаа шүүгчийн захирамж гарсантай холбоотойгоор нэхэмжлэгч нар гомдол гаргах эрхээ хэрэгжүүлж чадахгүйд хүрч болно.

Учир нь шүүгчийн захирамжид гомдол гаргах хугацаа өнгөрсний дараа нэхэмжлэгч нар хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны оролцогч болох боломжтой. Өөрөөр хэлбэл, захирамжаа 7 хоногийн дотор хэвлэл мэдээллийн хэрэгслээр нийтэд мэдээлэхдээ нэхэмжлэл хүлээж авах хугацааг тогтоох бөгөөд захирамжид гомдол гаргах хугацаа өнгөрсний дараа нэхэмжлэгч нар сая тодорхой болдог.³⁸ Мөн сонгогдсон шийдвэрүүдийн агуулгаас үзвэл хүснэгтийн 5-д байгаа УДШ-ийн тогтоолоос бусад шийдвэрийн хувьд нэхэмжлэгчдийн зүгээс хариуцагчийг төлбөрийн чадвартай эсэх дээр огт маргаагүй байна.

Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны оролцогчид гомдол гаргаагүй бол “төлбөрийн чадваргүй болсон тухай” захирамжийг шүүх өөрийн санаачилгаар хүчингүй болгох хууль зүйн үндэслэл байгаа эсэх, тухайн захирамжийг гаргасан шүүгчид компанийг төлбөрийн чадваргүй эсэхэд үндэслэл бүхий эргэлзээ хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад үүссэн, нотлох баримтууд хоорондоо зөрчилдсөн, захирамж гарсны дараа шинэ нөхцөл байдал үүссэн тохиолдолд гаргасан захирамжаа хүчингүйд тооцож эсэх

³⁸ Нэхэмжлэгчийн нэхэмжлэлээр үүсч байгаа дампуурлын хэргийн хувьд хэдийгээр зарим нэхэмжлэгч нар анханаасаа хэрэгт оролцоод явж байгаа боловч бүх нэхэмжлэгч биш тул мөн ялгаагүй нийтэд захирамжийг мэдээлсний дараа орж ирсэн нэхэмжлэгч нарын хувьд төлбөрийн чадваргүйд тооцсон шүүгчийн захирамжид гомдол гаргах эрхээ эдлэх боломжгүй.

асуудал үүсэж байна. Тухайлбал, хүснэгт №1-т дурдсан эхний хэргийн анхан шатны шүүхийн шийдвэрт төлбөрийн чадваргүй болохоо нотлоогүй гэсэн үндэслэлээр хүсэлтийг хэрэгсэхгүй болгож шийдвэрлэсэн боловч “Төлбөрийн чадваргүй болсон” гэх захирамжийг хүчингүйд тооцоогүй, хүчин төгөлдөр хэвээр үлдээсэн байна. ИХШХШТХ-ийн 124 дүгээр зүйлийн 124.1-д зааснаар шүүхийн тогтоол, шүүгчийн захирамж илт үндэслэл муутай бол тухайн шүүх бүрэлдэхүүн тогтоол, шүүгч захирамж гарган хүчингүй болгох, эсхүл өөрчилж болохоор зохицуулсан. Хэрэв анхан шатны шүүхийн шүүгч компанийг төлбөрийн чадваргүй болох нь нотлогдоогүй гэж дүгнэж байгаа бол төлбөрийн чадваргүй болсон талаар өөрийн гаргасан захирамжийн агуулгыг үгүйсгэж байгаа тул уг захирамжийн хүчин төгөлдөр байдал, үйлчлэлийг дуусгавар болгох нь зүй ёсны хэрэг юм.

Шүүгчийн захирамжийг өөрчлөх, хүчингүй болгох бүрэн эрх нь зөвхөн уг захирамжийг гаргасан шүүгчид хадгалагддаг бөгөөд энэ актыг бусад шүүгч, шүүх бүрэлдэхүүн хүчингүй болгох үндэслэл байхгүй юм. Шүүгч гаргасан захирамжаа хүчингүй болгох урьдчилсан нөхцөлийг ИХШХШТХ-ийн 124 дүгээр зүйлд “илт үндэслэл муутай” гэж тодорхойлсон. Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн онолын тайлбарт³⁹ шүүгч, хэргийн оролцогч, өөр хэн ч үзсэн бодит үнэнд нийцээгүй, үг, үсэг, тооцооны алдаатай зэрэг байдлыг “илт үндэслэл муутай” гэж ойлгохоор тайлбарласан хэдий ч уг зохицуулалтын хэрэглээ үүгээр хязгаарлагдахгүй юм.

Анхан шатны шүүхээс гадна давж заалдах, хяналтын шатны шүүхээс төлбөр чадваргүй болсон тухай захирамжийн хүчин төгөлдөр байдлыг хүлээн зөвшөөрдөг боловч төлбөрийн чадвартай эсэхийг хянаж, төлбөрийн чадвартай эсэх нь нотлогдоогүй үндэслэлээр шүүхийн шийдвэрийг хүчингүй болгон буцаах, эсхүл хэвээр үлдээх шийдвэрийг гаргасан байна. ИХШХШТХ-ийн 166

³⁹ Монгол Улсын Дээд шүүх, Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн тайлбар, УБ, 2014, 326-р тал

дугаар зүйлийн 166.4-д зааснаар давж заалдах журмаар хянан шийдвэрлэж буй шүүх зөвхөн гомдолд дурдсан үндэслэлээр хязгаарлалгүй хэргийг бүхэлд нь хянан үзнэ. Давж заалдах шатны шүүх нь хэргийг бүхэлд нь хянах зарчмыг хуульд тусгасан бөгөөд дампуурлын хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд нэгэн адил хамаарна. Гэхдээ хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад гаргасан шүүгчийн захирамж, тогтоолыг зөвхөн гаргасан шүүгч өөрчилж, хүчингүй болгох эрхтэй бөгөөд давж заалдах шатны шүүх шүүхийн шийдвэрийн үндэслэлийг хянах үүрэгтэй байна. Тиймээс дампуурлын хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад гарч буй төлбөрийн чадвартай эсэхийг тогтоож буй захирамж, түүний эрх зүйн үйлчлэл, хүчин төгөлдөр байдал болон тухайн хэргийг шийдвэрлэж буй шүүхийн шийдвэр хоорондын уялдааг хангаж, агуулгын зөрүүг арилгах шаардлагатай юм.

Дүн шинжилгээ хийхээр сонгон авсан шийдвэрүүдэд, Улсын Дээд шүүхээс анхан болон давж заалдах шатны шүүхийн шийдвэрийг хянахаас гадна “төлбөрийн чадваргүйд тооцсон” захирамжийн агуулгыг төвлөрөн хянаж, нотлох баримт дутуу эсхүл нотлох баримтыг үнэн зөв үнэлэхгүйгээр төлбөрийн чадваргүйд тооцсон гэсэн үндэслэлээр өмнөх шатны шүүхийн шийдвэрийг хүчингүй болгож, хүсэлтийг хэрэгсэхгүй болгож шийдвэрлэж байна. Үүний үр дагаварт, дампуурлын хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа дуусаж, дахин шүүхэд хандах боломжтой эсэх нь тодорхойгүй нөхцөл байдлыг үүсгэж байна. Гэтэл нотлох баримт дутуу, эсхүл нотлох баримтын үнэн зөв үнэлээгүй нь процессын алдаанд хамаарах тул хяналтын шатны шүүхээс “төлбөрийн чадваргүй” гэж дүгнэсэн нь хангалттай нотлогдоогүй гэж үзэж байгаа тохиолдолд, дахин нотлох баримт бүрдүүлж, дампуурсанд тооцох тухай хүсэлтийг шийдвэрлүүлэхээр анхан шатны шүүх рүү буцааж шийдвэрлэх нь оновчтой юм.

2.2 ТӨЛБӨРИЙН ЧАДВАРГҮЙГ НОТЛОХ ҮҮРЭГ БҮХИЙ СУБЪЕКТИЙГ ТОДОРХОЙЛОХ АСУУДАЛ

Хүснэгт 3. Хүсэлт гаргагчид нотлох үүргийг хуваарилсан байдал

Шийдвэрийн огно, дугаар	Анхан шатны шүүхийн шийдвэрт “төлбөрийн чадваргүйг нотлох үүрэг бүхий этгээд”	Анхан шатны шүүхийн шийдвэрт “төлбөрийн чадваргүй нь тогтоогдоогүй гэж үзсэн” үндэслэл	УДШ-ийн тогтоолын үндэслэл:
1 Улсын Дээд шүүхийн 2022.05.31-ний өдрийн хуралдааны 001/ХТ2022/00660 дугаар тогтоол	Хариуцагч шаардсан баримт гаргаж өгөөгүй.	1. Нягтлан бодох бүртгэлийн анхан шатны баримт гаргаж өгөөгүй учир тооцоо хийх боломжгүй. 2. Санаатай дампуурах шинжийг агуулсан./Хянавал 12, 13/	Дампууруулах үндэслэл үүсээгүй гэж үзсэн./Хянавал 15/
2 Улсын Дээд шүүхийн 2022.01.18-ны өдрийн хуралдааны 001/ХТ2022/00093 дугаар тогтоол	Хариуцагч үнэн зөв мэдүүлээгүй.	1. Компани нь өмчлөлдөө байгаа хөрөнгийн талаар үнэн зөв мэдүүлээгүй, өр төлбөрийн хэмжээгээ бодитоор тодорхойлоогүй, тоног төхөөрөмжийн өнөөгийн бодит үнийг тогтоож, бүртгэлдээ тусгаагүй. 2. Дампуурлын шалтгаан нь хамаарал бүхий этгээдээс авлагаа авч чадахгүй байгаа явдал	Хамаарал бүхий этгээдээс авах ёстой авлагаа авч чадахгүй байгаа нь тус компанийг дампууруулж, татан буулгах үндэслэл болохгүй

ХАРИУЦАГЧ КОМПАНИЙГ “ДАМПУУРСАНД ТООЦОХ ТУХАЙ ХҮСЭЛТ”-ИЙГ
ХЭРЭГСЭХГҮЙ БОЛГОСОН ШҮҮХИЙН ШИЙДВЭРТ ХИЙСЭН ДҮН ШИНЖИЛГЭЭ

3	Улсын Дээд шүүхийн 2018.06.12-ны өдрийн хуралдааны 001/ХТ2018/00932 дугаар тогтоол	Хариуцагч нягтлан бодох бүртгэлээ аккруэл сууриар, үнэн зөв хөтлөх үүргээ биелүүлээгүй. Гүйлгээтэй холбоотой анхан шатны баримт гаргаж өгөөгүй.	1. Сүүлийн 2 жилийн 48 удаагийн зарлагын гүйлгээ хүчин төгөлдөр бус байна. 2.Бусдаас зээлсэн мөнгийг санхүүгийн тайланд тусгаагүй, анхан шатны баримтгүй байгаа нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 3.1.3-т заасныг зөрчсөн ба энэ талаар хэрэг гүйцэтгэгч дүгнэлтдээ дурдаагүй байна.	Хоёр шатны шүүх хэргийн энэхүү нөхцөл байдлыг анхаараагүйгээс бусдад төлөх өрийн нийт хэмжээ компанийн өөрийн хөрөнгөөс давсан гэж дүгнэж, хүсэлтийг хангасан нь Дампуурлын тухай хуулийн зорилго, агуулгад нийцээгүй гэж үзнэ.
4	Улсын Дээд шүүхийн 2018.10.18-ны өдрийн хуралдааны 001/ХТ2018/01435 дугаар тогтоол	Хариуцагч худалдан авалтуудаа тайлагнаагүй зөрчил илэрсэн байх тул хүсэлт гаргагч нь тухайн жилүүдэд үйл ажиллагаа явуулж байсан нь тогтоогдсон байх тул шүүхэд гаргасан хүсэлтээ нотлоогүй гэж үзнэ.	Орлого орсон байхад дээрх орлого хэрхэн зарлагдсан нь тодорхойгүй буюу албан татвараа төлөөгүй хүндэтгэн үзэх үндэслэл тогтоогдоогүй байна.	Татварын ерөнхий хуульд зааснаар татвар төлөгч нь татварыг төлөх үүрэгтэй, түүнчлэн шүүхийн шийдвэр биелэгдэх учиртай тул дээр дурдсан үндэслэлээр тухайн компанийг дампуурсанд тооцож, татан буулгаж, татвар төлөх үүргээс чөлөөлөх үндэслэлгүй.

5	Улсын Дээд шүүхийн 2018.04.17-ны өдрийн хуралдааны 001/ХТ2018/00617 дугаар тогтоол	-	1. Цор ганц хувьцаа эзэмшигч болох толгой компани нь хариуцагч охин компаниас төлбөр төлөхийг шаардах эрхгүй учир нь нэг этгээд гэж үзнэ. 2. Бусдад төлөх өрийн нийт хэмжээ хариуцагч компанийн өөрийн хөрөнгөөс давсан боловч тухайн компанийн хувьцаа эзэмшигч толгой компани нь дампуураагүй юм.	Дампуурлын хэрэг үүсгэх замаар хариуцагч компанийг татан буулгах хуулийн үндэслэл тогтоогдоогүй.
6	Улсын Дээд шүүхийн 2021.02.02-ны өдрийн хуралдааны 001/ХТ2021/00118 дугаар тогтоол	Дампуурлын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.1, 7.1.2, 7.1.3, 7.1.4-д заасан шаардлагыг биелүүлээгүй, үндсэн болон эргэлтийн хөрөнгийн хэмжээ тодорхойгүй, өр төлбөрийн хэмжээ тодорхойгүй буюу төлбөрийн чадваргүй болсноо нотлоогүй.	Хүсэлт гаргагчийн өр төлбөрийн хэмжээг хэрэгт авагдсан баримтын хэмжээнд тогтоох боломжгүй.	Хүсэлт гаргагчийн хүсэлтийг хангах үндэслэлгүй

Дээрх хүснэгтээс үзвэл, шүүх нь хүсэлт гаргагч буюу хариуцагчийг “төлбөрийн чадваргүй” гэдгээ нотлох үүрэгтэй гэж үзэж байгаа бөгөөд мөн хариуцагчийг дараах тохиолдолд “төлбөрийн чадваргүй”-г тогтоосон шүүгчийн хүчин төгөлдөр захирамж болон хэрэг гүйцэтгэгчийн дүгнэлт байсан ч дампууруулж, татан буулгах хүсэлтийн үндэслэл болсон “төлбөрийн чадваргүй” байдлаа нотолж чадахгүй байна гэж үзэж байна:

- Дампуурлын тухай хуулийн 7-р зүйлд заасан материалаа дутуу өгөх;
- Баримт, материал дээрх тоо зөрүүтэй байх;
- Санхүүгийн тайлан болон хүсэлт дээрх өр төлбөрийн тоо зөрүүтэй байх;
- Нягтлан бодох бүртгэлийн анхан шатны баримт материалыг нэмж гаргаж өгч чадахгүй байх;
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль зөрчих;

Мөн нэг онцгой тохиолдол байгаа нь дээрх хүснэгийн 5 дах хэсэгт заасан тогтоолд УДШ хариуцагчийг төлбөрийн чадваргүй болохыг нь тогтоож байгаа боловч цор ганц хувьцаа эзэмшигч толгой компани дампуураагүй байгаа тул хариуцагчийг дампууруулж, татан буулгах үндэслэл тогтоогдоогүй гэж дүгнэсэн байна. Компанийг шүүхийн журмаар дампууруулж, татан буулгах гол үндэслэл нь хариуцагч төлбөрийн чадваргүй байх явдал байдаг. Гэтэл УДШ нь “төлбөрийн чадваргүй” болох нь тогтоогдсон хариуцагчийг дампууруулж татан буулгахгүй байх өөр үндэслэлийг гаргаж тавьсан байна.

2.2.1 Онцгой ажиллагааны журмаар дампуурсанд тооцох хүсэлтийг шийдвэрлэхэд нотлох үүргийн хуваарилалт

Иргэний хэрэг хянан шийдвэрлэх онцгой ажиллагаа нь эрхийн маргаантай холбоогүй бөгөөд эрх зүйн үйл явдал болон үйлдлийг шүүхээс тогтоодог.⁴⁰ Процессын эрх зүйн шинжлэх ухаанд онцгой ажиллагааны журмаар хянан шийдвэрлэх хэрэг нь дараах шинжүүдийг агуулна: талуудын хооронд үүссэн маргаантай асуудлыг шийдвэрлэдэггүй бөгөөд хууль зүйн факт нь эрх зүйн үндэслэл болдог, иргэний процессын зарчмаас гадна нийтийн эрх зүйн зарчмыг дагаж мөрдөх шаардлага үүсдэг буюу шүүгч өөрийн санаачилгаар нотлох баримт бүрдүүлэх зэрэг мөрдөн шалгах ажиллагааг хэрэгжүүлэх зэрэг шүүгчээс илүү идэвхтэй ажиллагаа хийхийг шаарддаг, хуулиар хамгаалагдсан эрх, ашиг сонирхол, оролцогч, хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны журамтай байдаг онцлогтой.⁴¹

ИХШХШТХ-д 2007 оны 08 дугаар сарын 03-ны өдөр оруулсан нэмэлт, өөрчлөлтөөр хуулийн этгээдийг дампуурсанд тооцох хүсэлтийг онцгой ажиллагааны журмаар шийдвэрлэхээр зохицуулсан. Тиймээс компанийг дампуурсанд тооцох хүсэлтийг шийдвэрлэхэд талуудын хооронд үүссэн аливаа эдийн болон эдийн бус маргааныг шийдвэрлэхийг зорьдоггүй, гагцхүү хүсэлт гаргагч нь дампуурсан эсэхийг шүүх тогтоодог ажиллагаа юм. Өмнөх бүлэгт дурдсанчлан дампуурсан эсэхийг тогтоох урьдчилсан нөхцөл нь төлбөрийн чадвартай эсэх бөгөөд төлбөрийн чадваргүй гэдэг нь тогтоогдсон тохиолдолд дампуурсан үйл явдалд хамаарах бөгөөд дахин хөрөнгөжүүлэх ажиллагаа хийгдэх боломжгүй нөхцөлд дампуурсан үйл явдлыг баталгаажуулж, татан буугдах буюу улсын бүртгэлээс хасагдах ажиллагаа юм.

⁴⁰ Монгол Улсын Дээд шүүх, Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль, УБ, 2014, 341-р тал

⁴¹ <https://cyberleninka.ru/article/n/osoboe-proizvodstvo-priroda-osobennosti/viewer>

Онцгой ажиллагааны журмаар хэргийг хянан шийдвэрлэх ажиллагаанд маргалдагч талууд оролцож, тайлбар, нотлох баримтыг няцаах замаар мэтгэлцэх зарчим хэрэгждэггүй нь ердийн журмаар буюу нэхэмжлэл, гомдлын үндсэн дээр иргэний хэргийг шийдвэрлэхээс ялгагддаг. Зарим тохиолдолд гуравдагч этгээд оролцсоноор хүсэлт гаргагчийн тайлбарыг няцаах, дэмжих байдлаар оролцогчид мэтгэлцэх зарчмыг хэрэгжүүлэх боломж бий болдог. Тиймээс үйл явдал, үйлдэл бий болсныг шүүхээр тогтоолгох хүсэлтэй этгээд нь өөрт байгаа баримтуудыг шүүхэд гаргаж өгөх бөгөөд үнэн зөв эсэхийг няцаах хариуцагч тал байхгүй тул шүүх үнэн зөв эсэхийг судалж тогтоох шаардлага үүсдэг.

Дампуурсанд тооцох хүсэлтийг шийдвэрлэх ажиллагаа нь бусад онцгой ажиллагааны журмаар шийдвэрлэгддэг бусад хэргүүдээс ялгаатай бөгөөд Дампуурлын тухай хуулиар уг ажиллагаа зохицуулагддаг. Дампуурлын хэрэг үүсгэхээс өмнө хүсэлт нь гаргагч нь шүүхэд мэдүүлэхэд Дампуурлын тухай хуульд 7 дугаар зүйлд заасан төлбөрийн чадваргүй байдлыг нотлох баримтуудыг гаргаж өгөх үүргийг хүлээдэг. Дампуурлын хэрэг үүсэхээс өмнө шүүхэд мэдүүлэхдээ нотлох баримтыг бүрдүүлэх, цуглуулах үүргийг хүсэлт гаргагч хариуцдаг. Харин шүүхэд хүсэлт гаргаснаас хойш нотлох үүргийг зөвхөн хүсэлт гаргагч хариуцахгүй буюу хүсэлтийг шийдвэрлэхэд шаардлагатай асуудлуудыг шүүгчээс тодорхойлж, өөрийн санаачилгаар хүсэлт гаргагч болон бусад байгууллагаас нотлох баримтыг шаардах замаар нотлох баримтыг бүрдүүлэх, цуглуулах ажиллагааг гүйцэтгэдэг. Энэ нь хүсэлт гаргагчийн гаргаж өгсөн нотлох баримтын үнэн зөвийг тодорхойлохоос гадна тухайн үйл явдал болсон эсэхийг тогтоох шүүгчийн үүрэгтэй холбоотой тул хэргийг шийдвэрлэхэд чухал ач холбогдолтой юм. Ердийн журмаар хэргийг хянан шийдвэрлэхэд зөвхөн талуудын бүрдүүлсэн нотлох баримтаар, эсхүл тэдгээрийн хүсэлтээр шаардлагатай нотлох баримтыг бүрдүүлж, талуудын мэтгэлцээний үндсэн дээр хэргийг шийдвэрлэж, диспозитив зарчмыг хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд түлхүү баримталдаг. Харин онцгой

ажиллагааны журмаар хэргийг шийдвэрлэхэд шүүгч өөрийн санаачилгаар хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг удирдаж, зайлшгүй мөрдөн шалгах зарчмыг хэрэгжүүлдэг.

Онцгой ажиллагааны журмаар хэргийг шийдвэрлэхэд “хүсэлт гаргагч нотлоогүй” гэдэг үндэслэлээр хүсэлтийг хэрэгсэхгүй болгож шийдвэрлэж байгаа нь шүүгч өөрийн санаачилгаар нотлох баримтыг хүсэлт гаргагчаас шаардах, бусад байгууллагаас гаргуулах зэргээр мөрдөн шалгах зарчмыг хэрэгжүүлээгүй нь процессын зөрчилд тооцно. Тухайлбал, судалсан шүүхийн шийдвэрт хөрөнгө, өр төлбөрийн хэмжээ нь бусад нотлох баримтуудаар нотлогдож байгаа учраас хариуцагчийг үнэн зөв мэдүүлээгүй, энэ нь төлбөрийн чадваргүй гэдгээ нотлохгүй байгаа шалтгаан болж байгааг дүгнэсэн⁴² нь шүүгчээс зөвхөн хүсэлт гаргагч нотлох үүрэгтэй гэж үзэж, өөрийн санаачилгаар мөрдөн шалгах ажиллагааг гүйцэтгэсэн эсэхийг хянах шаардлага үүсэж байна. Тиймээс онцгой ажиллагааны журмаар хэргийг шийдвэрлэхэд диспозитив зарчмаас илүүтэй шүүгч өөрийн санаачилгаар нотлох баримт бүрдүүлэх, шалгах зэргээр мөрдөн шалгах зарчмыг хэрэгжүүлдэг тул “нотлох үүрэг”-ийг зөвхөн хүсэлт гаргагч хүлээхгүй. Зөвхөн хариуцагч компанид “төлбөрийн чадваргүй” гэдгээ нотлох үүргийг ногдуулсан тохиолдолд санхүүгийн нөхцөл байдлаа үнэн бодитой мэдээлэхээс илүүтэй, хөрөнгөө нуух, хуурамч бичиг баримт бүрдүүлэх гэх мэт аргагүй байдалд хүргэх эрсдэлтэй. Түүнчлэн санхүүгийн хүндрэлд орсон компанийг дахин хөрөнгөжүүлэх, нэхэмжлэлийн шаардлагыг хангах гэх мэт дампууруулах ажиллагааны зорилго хангагдахгүйд хүрнэ. Мөн хүсэлт гаргагч компанийг “төлбөрийн чадваргүй” болсноо нотлох “баттай” баримттай болсон үедээ дампуурсанд тооцох хүсэлтийг өгөхийг шаардах тохиолдолд дампууруулах хүсэлт өгөхгүй хойшлох, удаашрах гэх мэтээр санхүүгийн байдал улам хүндэрч дампууруулах ажиллагааны зорилго биелэх боломжгүй болох юм.

⁴² Улсын Дээд шүүхийн 2022.01.18-ны өдрийн хуралдааны 001/ХТ2022/00093 дугаар тогтоол Монгол Улсын Шүүхийн шийдвэрийн цахим сан (shuukh.mn)

Харьцуулсан судалгааны хүрээнд БНСУ-ын дампууруулах хүсэлтийг нотлох үүргийн хуваарилалтыг авч үзлээ. Дампуурлын хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд нотлох үүргийг хуваарилахдаа “Хүсэлт гаргагч-Компани” болон “Хүсэлт гаргагч-Үүргийн гүйцэтгэлийн шаардах эрх бүхий этгээд”-ээс хамаарч ялгаатай зохицуулдаг байна. БНСУ-ын “Үүрэг гүйцэтгэгчийн дахин хөрөнгөжүүлэлт ба дампуурлын тухай хууль”-ийн 294-р зүйлийн 294.1-д “Үүрэг гүйцэтгүүлэгч болон үүрэг гүйцэтгэгч нь дампууруулах хүсэлтийг гаргаж болно.”, мөн хуулийн 294.2-т “Үүрэг гүйцэтгүүлэгч дампууруулах хүсэлт гаргаж байгаа тохиолдолд шаардаж буй үүргийн гүйцэтгэл болон дампууруулах үндэслэлийн үнэн бодит байдлыг нотлох үүрэгтэй” гэж заасан байна.⁴³ Үүргийн гүйцэтгэлийг шаардах эрх бүхий этгээдэд хуулиар тусгайлан нотлох үүргийг хуваарилж байгаа нь дампууруулах хүсэлт гаргах эрхээ буруугаар ашиглах магадлал нэхэмжлэгч буюу үүрэг гүйцэтгүүлэгчид хариуцагч буюу үүрэг гүйцэтгэгчээс илүү байдагтай холбоотой байна. Жишээлбэл, Компанийн үйл ажиллагаанд саад болох зорилгоор шүүхэд хандах, шүүхээс хэргийг хэрэгсэхгүй болгосон ч дахин дахин шүүхэд хандаж болно.⁴⁴ Эсрэгээрээ хариуцагч Компанийн хувьд ч мөн санаатай дампуурах гэх мэтээр дампуурлын хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг буруугаар ашиглах магадлал байдаг.⁴⁵

⁴³ БНСУ-ын “Үүрэг гүйцэтгэгчийн дахин хөрөнгөжүүлэлт болон дампуурлын тухай хууль” 294-р зүйл

⁴⁴ Үүнээс гадна ердийн журмаар нэхэмжлэл гаргаснаас онцгой журмаар нэхэмжлэл гаргах нь амар, эсвэл ашигтай санагдах, нэхэмжлэлийн шаардлагад байгаа өр төлбөр авахаас өөр зорилготой байх гэх мэт байж болно.

⁴⁵ 이무룡(Lee Mooryung). "법인파산절차 남용에 관한 연구 - 판례의 동향, 일본의 연구와 판례, 권리남용금지원칙에 기초하여 -." 저스티스 -.176 (2020): 237-304, 295-296면.

2.2.2 Шүүхээс мөрдөн шалгах зарчмыг хэрэгжүүлэх хүрээнд хийгдэх ажиллагаа

Онцгой ажиллагааны журмаар хэргийг хянан шийдвэрлэж байгаа шүүгч нь хүсэлтийг шийдвэрлэхэд шаардлагатай нотлох баримтыг бүрдүүлэх, хүсэлт гаргагч болон этгээдээс ирүүлсэн баримтын үнэн зөвийг хянан шалгах зэргээр хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг удирддаг. Зөвхөн онцгой ажиллагааны журмаар хэргийг шийдвэрлэх үед нь иргэний хэргийн шүүгч нь процессын императив шинжтэй мөрдөн шалгах зарчмыг түлхүү хэрэгжүүлдэг байна. Мөрдөн шалгах зарчмыг хэрэгжилтийг хангах зорилгоор Дампуурлын тухай хуулиар шүүгч өөрийн санаачилгаар гүйцэтгэх ажиллагааг дараах байдлаар зохицуулсан. Үүнд:

- Шүүгч шаардлагатай гэж үзвэл хариуцагчийг төлбөрийн чадваргүй болсон тухай нэмэлт нотлох баримтыг нэхэмжлэл, хүсэлт гаргагч этгээдээс шаардах;
- Шүүхийн шийдвэрийн биелэлтийг баталгаажуулах арга хэмжээ авах;
- Түр хэрэг гүйцэтгэгчийг томилох;
- Хэрэг гүйцэтгэгчийг өөрчилж, томилох;
- Төлбөрийн чадвартай эсэхийг тогтоох;
- Дахин хөрөнгөжүүлэх төлөвлөгөө батлах;
- Төлөвлөгөөний биелэлтийг хангах үүргийг хариуцагчид даалгах;
- Тооллогын комисс томилох зэрэг хамаарна.

Дээрхээс гадна, ИХШХШТХ-ийн 133 дугаар зүйлд заасан онцгой ажиллагааны журмаар хэрэгт нотлох баримт бүрдүүлэх, гэрчээс мэдүүлэг авах, шинжээч томилох зэрэг ажиллагааг шүүгч өөрийн санаачилгаар хийнэ.⁴⁶

⁴⁶ Монгол Улсын Дээд шүүх, “Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн тайлбар”, УБ, 2014, 39-р тал

Сонгосон шүүхийн шийдвэрт “шүүхээс шаардсан баримтыг гаргаж өгөөгүй”, “нотлох баримтууд” хоорондоо зөрүүтэй, “тооцоо хийх боломжгүй”, “өр төлбөрийг авагдсан нотлох баримтын хэмжээ”-нд тогтоогдохгүй зэрэг төлбөрийн чадвартай эсэхийг тогтоохтой холбоотой дүгнэлтүүдийг гаргаж, төлбөрийн чадвартай эсэх нь тогтоох боломжгүй учраас дампуурсанд тооцох хүсэлтийг хэрэгсэхгүй болгож шийдвэрлэсэн байна. Энэ нь төлбөрийн чадвартай эсэхийг шалгах ажиллагаанд мөрдөн шалгах зарчмыг хангалттай хэрэгжүүлээгүй улмаас “Төлбөрийн чадваргүй болсон тухай” захирамжийг гаргаж, улмаар явцын дунд төлбөрийн чадваргүй эсэх нь тогтоогдоогүйгээс шүүхийн шийдвэрийн агуулга өмнө гарсан захирамжаас зөрүүтэй гарчээ.

Улмаар төлбөрийн чадваргүй эсэх нь нотлогдохгүй гэж дүгнэснээр, холбогдох баримтыг бүрдүүлэн дахин шүүхэд хандах эрхтэй эсэх тал дээр хууль хэрэглээний нэгдмэл бус байдал үүсэж байна. Сонгон авсан шүүхийн шийдвэрүүдэд “хүсэлттэй хэргийг хэрэгсэхгүй болгох”, “хүсэлтийг хэрэгсэхгүй болгох” үндэслэлийг ялгаж, шийдвэр гаргаагүй байна. Угтаа, хуулийн этгээдийг дампуурсанд тооцох тухай хүсэлт нь онцгой ажиллагааны журмаар шийдвэрлэгдэж байгаа тул анхан шатны шүүхээс мөрдөн шалгах зарчмыг хэрэгжүүлж, шүүгч нь хүсэлт гаргагчийг удирдан чиглүүлж, төлбөрийн чадвартай эсэхийг тогтооход шаардлагатай баримт, мэдээллийг шаардах гаргуулах бүрэн эрхээ хэрэгжүүлээгүй нь “хүсэлтийг хэрэгсэхгүй болгох” үндэслэл бус, өмнөх шатны шатны шүүхийн шийдвэрийг хүчингүй болгож, хэргийг дахин шийдвэрлэх үндэслэл болох нь зохистой.

Харьцуулсан судалгааны үүднээс авч үзэхэд БНСУ-д мөрдөн шалгах зарчим хэрхэн хэрэгждэг болон дампуурлын хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд шүүхийн гүйцэтгэх үүргийг авч үзье.

- 1) **Шүүх дампууруулах хүсэлтийг хүлээж авч хянах:** энэ үе шатанд нэгдүгээрт, хүсэлт нь хуульд заасан бүрдүүлбэрийг бүрэн хангасан эсэхийг шалгах бөгөөд хоёрдугаарт,

бүрдүүлбэр дутуу байгаа нөхцөлд БНСУ-ын ИХШХШТХ-ийн 249 дүгээр зүйлд заасны дагуу шүүх шаардлагатай баримт бичгийн бүрдүүлбэр хангуулахаар хүсэлт гаргагчаас шаардах боломжтой. Хүсэлт гаргагч нь шаардлагатай баримт бичгийг ирүүлэгүй тохиолдолд хуульд заасан бүрдүүлбэр дутуу үндэслэлээр хүсэлтийг хүлээн авахаас татгалзах бөгөөд хэрэв шаардлагатай баримт бичгүүдийг ирүүлсэн тохиолдолд хүсэлтийн дагуу дампуурлын хэрэг үүсгэх боломжтой эсэхийг дахин хянана.

- 2) **Компанид дампуурах үндэслэл бүрдсэн эсэхийг тогтоох:** Энэ үе шатанд хүсэлтийг хүлээж авахаас татгалзах хуульд заасан үндэслэл⁴⁷ байгаа эсэхийг хянадаг. Энэхүү хяналтыг хэрэгжүүлэхийн тулд шүүхээс нэг талаас дампууруулах хүсэлт гаргасан этгээд дампуурлын хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг урвуулан ашиглах эсхүл үнэн санаанаасаа бус (бусдын бизнесийн үйл ажиллагаанд саад болох гэх мэт) зорилгоор хүсэлт гаргасан эсэхийг шалгах, нөгөө талаас хариуцагч компанид дампуурах үндэслэл бүрдсэн эсэхийг шалгахад гол анхаарлаа хандуулдаг. Иймд шүүх нь БНСУ-ын ИХШХШТХ-ийн 183-д дурдсанаар талуудаас тайлбар, нэмэлт нотлох баримт шаардах, мөн үүрэг гүйцэтгэгчийн дахин хөрөнгөжүүлэлт болон дампуурлын тухай хуулийн 295-д зааснаар хүсэлт гаргагчийн нотлох үүргийнх нь хүрээнд асуулга авах бүрэн эрхтэй байдаг.

⁴⁷ Үүнд:

1. Дампуурлын хэрэг хянан шийдвэрлэх үйл ажиллагааны зардал төлөөгүй;
2. Дахин хөрөнгөжүүлэх ажиллагаа үргэлжилж байгаа бөгөөд нэхэмжлэгчийн ашиг сонирхол хангагдаж байгаа тохиолдол;
3. Хариуцагчид дампуурлын үндэслэл бүрдээгүй;
4. Хүсэлт гаргагчийн хаяг тодорхойгүй;
5. үнэн санаанаасаа гаргаагүй;
6. урвуулан ашиглах тохиолдлууд хамаарна(Үүрэг гүйцэтгэгчийн дахин хөрөнгөжүүлэлт болон дампуурлын тухай хуулийн 309 дүгээр зүйл).

Мөн шүүх нь хариуцагч компанийг өр төлбөрөө гүйцэтгэх чадваргүй⁴⁸ болон өр төлбөр нь өөрийн хөрөнгөөс давсан гэсэн хоёр үндэслэлээр дампууруулах тухай шийдвэр гаргаж дампуурлын хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг эхлүүлдэг. Иймд энэхүү үндэслэл бүрдсэн эсэхийг дараах байдлаар шалгаж тогтоодог.

а. Төлбөрийн чадваргүй байдал

Санхүүгийн тайлан: Компанийн хөрөнгө, өр төлбөрийг хамгийн сүүлийн үеийн санхүүгийн тайлангуудаар (баланс, орлогын тайлан гэх мэт) үнэлнэ.

Мөнгөн гүйлгээний тайлан: Компанийн мөнгөн гүйлгээний тайланд дүн шинжилгээ хийж, үндсэн үйл ажиллагаанаас орж ирж буй мөнгөн урсгалыг тодорхойлно. Гол нь бэлэн мөнгө гадагшаа урсаж байгаа эсэх нь л чухал.

Өрийн нөхцөл байдал: Өр төлбөрөө төлөх хугацаа дуусахад нь төлөх чадвартай эсэхийг тодорхойлно.

б. Бусдын өмнө хүлээсэн өр төлбөрийг зогсоосон байдал

Шинж тэмдгийг шалгах: Компани нь дампуурал, цалингаа өгөөгүй, бизнесийн түншүүдтэй хийсэн гүйлгээг түдгэлзүүлсэн гэх мэт төлбөрийг зогсоосон гэж гаднаас мэдэгдсэн эсэхийг шалгана.

Бизнесийн байдал: Бизнесийг хаах, бизнесийн үйл ажиллагааг зогсоох, ажилчдыг бөөнөөр нь цомхотгох гэх мэт төлбөрийг зогсоосон бодит байдлыг үнэлнэ.

в. Өр төлбөр нь нийт хөрөнгөөс давсан байдал

Хөрөнгө, өр төлбөрийн үнэлгээ: Компанийн нийт хөрөнгөөс нийт өр төлбөр давсан эсэхийг тодорхой үнэлнэ.

⁴⁸ БНСУ-д Үүрэг гүйцэтгэгчийн дахин хөрөнгөжүүлэлт болон дампуурлын тухай хуулийн 305 дугаар зүйлд зааснаар бусдын өмнө хүлээсэн өр төлбөрөө төлөх боломжгүй болох болон өр төлбөр төлбөрөө төлөхгүй байх хоёр ойлголтыг хоёуланд нь “төлбөрийн чадваргүй байдал”-д хамааруулдаг.

Хөрөнгийн бодит үнэ цэнэ: Хөрөнгийн зах зээлийн үнэ цэнийг үнэн зөв үнэлж, хөрөнгөө хэт үнэлээгүй эсэхийг шалгана.

3) Дампуурлын хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа

Компанид дампуурах үндэслэл бүрдсэн гэж үзсэн тохиолдолд шүүх дампууруулах шийдвэр гаргах бөгөөд энэ нь дампуурлын хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг эхлүүлдэг. Энэ үе шатанд хэрэг гүйцэтгэгчийг томилох, хариуцагчийн хөрөнгийг шалгаж, тогтоох, хуваарилах төлөвлөгөө батлах, төлөвлөгөөний дагуу нэхэмжлэгч нарт хуваарилах гэх мэт үйл ажиллагаанууд хамаардаг.

ОХУ-ын Төлбөрийн чадваргүйдлийн (дампуурлын) тухай хуулийн⁴⁹ дагуу Арбитрын шүүхийн шүүгч нь дампуурсанд тооцох хүсэлтийн үндэслэлтэй байдлыг хянаж шалгах ажиллагааг эхлүүлэх захирамж гаргадаг. Шалгах ажиллагаа эхлүүлснээр нэхэмжлэгчдийн анхны хурлыг хуралдуулж, дампууруулах үндэслэл бүрдсэн эсэхийг мөрдөн шалгаж, шүүхийн шийдвэрийг гаргадаг. Уг ажиллагаа нь 2 сарын хугацаанд үргэлжлэх бөгөөд энэ хугацаанд компанийг дампуурсанд тооцох үндэслэл байгаа эсэхийг тогтоодог байна.

2.3 КОМПАНИЙГ ТӨЛБӨРИЙН ЧАДВАРГҮЙ БОЛОХОД ХҮРГЭСЭН БУРУУТАЙ ЭТГЭЭДИЙГ ТОГТООСНЫ ЭРХ ЗҮЙН ҮР ДАГАВАР

Хариуцагчийг төлбөрийн чадваргүй байдалд хүргэсэн буруутай этгээдийг шүүх тогтоож байгаа бөгөөд нийтлэг байдлаар хувьцаа эзэмшигч болон компанийн удирдлага нар байна. Харин буруутай этгээдийг тогтоосны үндсэн дээр тухайн этгээд ямар нэг байдлаар хариуцлага хүлээлгэдэг жишиг байхгүй байна.

⁴⁹ Федеральный закон "О несостоятельности (банкротстве)" от 26.10.2002 N 127-ФЗ (последняя редакция) \ КонсультантПлюс (consultant.ru)

Хүснэгт 4. Компанийг төлбөрийн чадваргүй болсон буруутай этгээдийг тодорхойлсон байдал

Улсын Дээд шүүхийн тогтоол	Төлбөрийн чадваргүйдэлд буруутай этгээдийг шүүх тогтоож байгаа эсэх	Буруутай гэж үзсэн үндэслэл	Буруутай этгээдэд хүлээлгэж буй хариуцлага	Буруутай этгээд тогтоосны үр дагавар
1 Улсын Дээд шүүхийн 2022.05.31-ний өдрийн хуралдааны 001/ХТ2022/00660 дугаар тогтоол	Хянавал 12, 13 дах хэсгүүдээрээ хувьцаа эзэмшигчийг компанийг санаатай дампууруулах шинжийг агуулсан гэж үзсэн.	1. Өр төлбөрийг барагдуулах арга хэмжээ аваагүй нь удирдлагын үйл ажиллагаанаас шууд хамаарсан 2. Компанийн мөнгөн хөрөнгийг хувийн хэрэгцээндээ зарцуулах, хуримтлал үүсгэх зэргээр захиран зарцуулсан.	Байхгүй.	Байхгүй.
2 Улсын Дээд шүүхийн 2022.01.18-ны өдрийн хуралдааны 001/ХТ2022/00093 дугаар тогтоол	Хянавал 8 дах хэсэг КтХ-ийн 6.6 -гийн дагуу толгой компани буруутай гэж үзсэн.	Хамаарал бүхий этгээдийн захиалгаар өрөмдлөгийн ажил гүйцэтгэж, ажлын гүйцэтгэлийн төлбөрийг хамаарал бүхий этгээдээс авахгүй, авлагад бүртгэж, хувьцаа эзэмшигчдээс хэт хамааралтай ажиллаж байсан.	Байхгүй.	Хамаарал бүхий этгээдээс авах ёстой авлагаа авч чадахгүй байгаа учраас дампууруулахгүй гэж шийдвэрлэсэн.

Улсын Дээд шүүхийн тогтоол	Төлбөрийн чадварг үйдэлд буруутай этгээдийг шүүх тогтоож байгаа эсэх	Буруутай гэж үзсэн үндэслэл	Буруутай этгээдэд хүлээлгэж буй хариуцлага	Буруутай этгээд тогтоосны үр дагавар
3 Улсын Дээд шүүхийн 2018.04.17-ны өдрийн хуралдааны 001/ХТ2018/00617 дугаар тогтоол	Хянавал хэсгийн 2 дах хэсэгт толгой компанийг буруутай гэж үзсэн.	КтХ-ийн 6.6-д заасны дагуу цор ганц хувьцаа эзэмшигч толгой компани нь хариуцагч компанигай нэг этгээд гэж үзсэн.	Нэхэмжлэлийг хэрэгсэхгүй болгосон.	Хариуцагчийн толгой компани болон зэргэлдээ компанийн өмнө хүлээсэн үүрэг дуусгавар болсон.
4 Улсын Дээд шүүхийн 2018.10.18-ны өдрийн хуралдааны 001/ХТ2018/01435 дугаар тогтоол	Хувьцаа эзэмшигч болон удирдлагын буруутай үйл ажиллагаа.	Компанийн үйл ажиллагааг өргөжүүлэх, хөрөнгө оруулалт хийх, татварын өр төлбөрийг хугацаанд нь барагдуулах талаар санаачилгатай ажиллаагүй,	байхгүй	Албан татвар төлөх үүргээс чөлөөлөхгүй нь тулд хүсэлтийг хэрэгсэхгүй болгосон.
5 Улсын Дээд шүүхийн 2018.06.12-ны өдрийн хуралдааны 001/ХТ2018/00932 дугаар тогтоол	-	-	-	-

Дээрх хүснэгтийн 5-д дурдсан тогтоолд “толгой компани” нь нэхэмжлэгчээр орсон ч хариуцагчтай нэг этгээд болсон учраас үүргийн гүйцэтгэл дуусгавар болсон гэж дүгнэжээ.

Энэ хэсэгт, сонгон авсан УДШ-ийн тогтоолуудын хянавал хэсэгт дурдсан үүсгэн байгуулагч, хувьцаа эзэмшигч, компанийн эрх бүхий албан тушаалтан, толгой компанийн хариуцлагатай холбоотой дүгнэлт тус бүрд хууль зүйн дүгнэлтийг хийж гүйцэтгэлээ.

2.3.1 Санаатай дампуурлын шинжтэй хувьцаа эзэмшигч болон үүсгэн байгуулагчийн үйлдэлд хийсэн дүгнэлт

Жишээ 1. Улсын Дээд шүүхийн 2022.05.31-ний өдрийн хуралдааны 001/ХТ2022/00660 дугаар тогтоолын Хянавал хэсэгт: *“Шүцх ХХК-ийн үүсгэн байгуулагч бөгөөд хувьцаа эзэмшигчийн хувийн данс руу компанийн мөнгийг шилжүүлж хувьдаа ашиглаж байсныг тогтоосон бөгөөд энэ нь санаатай дампуурлын шинжийг агуулж байна”*⁵⁰ гэж дүгнэж, улмаар дампуурах үндэслэл үүсээгүй гэж үзсэн.

Компанийн тухай хуулийн 84 дүгээр зүйлийн 84.10-т зааснаар хязгаарлагдмал хариуцлагатай компанийн нийт гаргасан хувьцааны 20 буюу түүнээс дээш хувийг нэгдмэл сонирхолтой этгээдтэй хамтран эзэмшдэг хувьцаа эзэмшигч нь Компанийн тухай хуульд заасан эрх бүхий албан тушаалтны үүргийг нэгэн адил хүлээх

⁵⁰ Хянавал хэсэг 13. “Анхан болон давж давж заалдах шүүх Б.Золзаяагийн шүүхэд ирүүлсэн” **** ** ХХК-ийн хувьцаа эзэмшигч, үүсгэн байгуулагч Ц. ***-ын эзэмшлийн Голомт банк дах 2205108240 тоот дансаар 2015.11.18-ны өдрөөс 2017.06.30-ны өдрийн хооронд 116,857,679 төгрөгийн орлого орж, 116,849,647 төгрөгийн зарлага гарсан, Худалдаа хөгжлийн банк дах 499229815 тоот дансаар 2014.11.01-ний өдрөөс 2017.06.30-ны өдрийн хооронд нийт 508,840,576 төгрөгийн орлого орж, 508,838,486 төгрөгийн зарлага гарсан, мөн банк дах 450012282 тоот дансаар 2014.11.01-ний өдрөөс 2017.06.30-ны өдрийн хооронд нийт 88,263,399 төгрөгийн орлого орж, 88,263,399 төгрөгийн зарлага гарсан баримтуудыг компанийн үйл ажиллагаатай хамааралгүй гэж үзэх боломжгүй, Ц. ***-ын дансанд орсон компанийн мөнгөн хөрөнгийг хувийн хэрэгцээндээ зарцуулах, хуримтлал үүсгэх зэргээр захиран зарцуулсан үйлдлийг компанийг санаатай дампууруулах шинжийг агуулсан гэж дүгнэснийг Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 40 дүгээр зүйлийн 40.1, 40.2-т заасныг зөрчсөн гэж үзэх үндэслэл тогтоогдсонгүй.”

бөгөөд үүргээ биелүүлээгүй эсхүл удаа дараа зөрчсөнөөс компанид хохирол учруулсан тохиолдолд тус хуулийн 84.6-д зааснаар нөхөн төлөх үүргийг хүлээдэг бөгөөд хохирлыг нөхөн төлүүлэхээр 86.2-т заасны дагуу компани болон хувьцаа эзэмшигч нь шаардах эрхтэй. Шүүхийн тогтоолд хувьцаа, эзэмшигчийн буруутай үйлдлийг тодорхойлсон боловч хохирлыг нөхөн төлүүлэх эрхийг хэрэгжүүлэх боломжтой талаар дурдаагүй орхисон. Мөн тухайн үйлдэл нь хэрэв гэмт хэргийн шинжтэй гэж дүгнэж байгаа бол цаашид ямар ажиллагаа хийх шаардлагатай талаар дурдаагүй.

2.3.2 Компани нь хамаарал бүхий этгээдээс авах ёстой авлагыг авч чадахгүй нөхцөлд хийсэн дүгнэлт

Жишээ 2: Улсын Дээд шүүхийн 2022.01.18-ны өдрийн хуралдааны 001/ХТ2022/00093 дугаар тогтоолоор “Хамаарал бүхий этгээд гэдэгт хариуцагч компанийн 100 хувийн хувьцаа эзэмшигч толгой компани болон зэргэлдээ компаниудыг авч үзэж байгаа бөгөөд хариуцагч нь эдгээр компаниудын туслан гүйцэтгэгчээр гэрээ байгуулан ажилласан боловч гэрээний төлбөрийг толгой компани шилжүүлж авсан нь тогтоогдсон. Хариуцагч энэхүү авлагаа авч чадаагүй учраас төлбөрийн чадваргүй болсон бөгөөд авлагаа авч чадахгүй байх нь дампуурсанд тооцож, татан буулгах үндэслэлгүй болохгүй” гэж үзэж, дампуурсанд тооцох хүсэлтийг хэрэгсэхгүй болгосон шүүхийн шийдвэр, магадлалыг хэвээр үлдээсэн.⁵¹

⁵¹ Хянавал хэсгийн 8-д “Хоёр шатны шүүхийн дүгнэсэнчлэн, “.....” ХХК-ийн санхүүгийн тайлан, Автотээврийн үндэсний төвийн лавлагаа, татварын улсын байцаагчийн акт болон бусад бичгийн нотлох баримтаар тухайн компани нь өмчлөлдөө байгаа хөрөнгийн талаар үнэн зөв мэдүүлээгүй, өр төлбөрийн хэмжээгээ бодитоор тодорхойлоогүй, үндсэн хөрөнгө болох 285,944,000 төгрөгийн үнэ бүхий ермийн тоног төхөөрөмжийн өнөөгийн бодит үнийг тогтоож, бүртгэлдээ тусгаагүй үйл баримт тогтоогдсон. Мөн хэрэг гүйцэтгэгч дампуурлын шалтгааныг “...”, “.....”, “.....” ХХК нь “.....” ХХК, “Пикюрис” ХХК зэрэг өөрийн хамаарал бүхий этгээдийн захиалгаар өрөмдлөгийн ажил гүйцэтгэж, ажлын гүйцэтгэлийн төлбөрийг хамаарал бүхий этгээдээс авахгүй, авлагад бүртгэж, хувьцаа эзэмшигчдээс хэт хамааралтай ажиллаж байсан нь гол эрсдэл болсон...” гэж дүгнэсэн, Компанийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.6-д “Толгой компанийн гаргасан шийдвэрийн улмаас охин компани төлбөрийн чадваргүй болсон бол толгой компани нь тухайн өрийг хамтран хариуцна” гэж заасан тул хамаарал бүхий этгээдээс авах ёстой авлагаа авч

Улсын Дээд шүүхийн 2018.04.17-ны өдрийн хуралдааны 001/ХТ2018/00617 дугаар тогтоолтой дампуурлын хэргээс ялгаатай нь энэ тохиолдолд толгой компани нь нэхэмжлэгчээр оролцоогүй байв. Толгой компани буюу хувьцаа эзэмшигч дампуурлын хэрэгт нэхэмжлэгчээр орсон тохиолдолд нэхэмжлэлийн дарааллын хувьд хамгийн сүүлд ордог.⁵² Гэхдээ толгой компанийн гаргасан шийдвэрийн улмаас хариуцагч төлбөрийн чадваргүй болсон нь тогтоогдсон тохиолдолд толгой компани өрийг хамтран хариуцагч болох тул нэхэмжлэгч байх боломжгүй. Дээрх тогтоолд шүүх толгой компаниас авлагаа авч чадахгүй байгаагаас хариуцагч охин компани нь төлбөрийн чадваргүй болсныг шүүх тогтоосон боловч толгой компани өрийг төлөх үүрэгтэйг дурдаагүй байна. Толгой компанитай холбоотой хууль зүйн дүгнэлтийг дараагийн хэсэгт оруулсан болно.

2.3.3 Толгой компанитай нэг этгээд буюу толгой компани дампуураагүй, буруутай байгаа нөхцөлд хийсэн дүгнэлт

Толгой компани дампуураагүй гэдэг үндэслэлээр охин компанийг төлбөрийн чадвартай гэж үзэж, огт дампууруулахгүй байх нь хуулийн этгээдийн эрхийн чадварыг хүлээн зөвшөөрсөн иргэний эрх зүй, компанийн эрх зүйн онолтой зөрчилдөнө. Гэхдээ хувьцаа эзэмшигчийн хязгаарлагдмал хариуцлагыг урвуулан ашиглахаас хамгаалах механизмын хувьд толгой компани болон охин компанийг нэг этгээд гэж хэсэгчлэн хуулийн этгээдийн эрхийн чадварыг үгүйсгэх онол (piercing the corporate veil)⁵³ үздэг

чадахгүй байгаа нь тус компанийг дампууруулж, татан буулгах үндэслэл болохгүй” Дэлгэрэнгүйгээр Анхан шатны шүүхийн шийдвэрээс харна уу https://shuukh.mn/singgle_case/94665?start_date=&end_date=&id=1&court_cat=1&bb=1

⁵² Энэ талаар Нээлттэй нийгэм форумаас эрхлэн гаргадаг “Шүүхийн шийдвэрийн судалгаа” цувралын 2023 оны 11 дэх дугаарт нийтлэгдсэн судлаач, доктор Г.Даваанямын “Улсын дээд шүүхийн тогтоолд хийсэн дүн шинжилгээ” судалгааны тайлангаас дэлгэрүүлэн үзэх боломжтой.

⁵³ Нөлөө бүхий хувьцаа эзэмшигч гэх мэт хяналтыг хэрэгжүүлэгч этгээд хязгаарлагдмал хариуцлагаа урвуулан ашиглахаас хамгаалахын тулд ① урьдчилан сэргийлэх хүрээнд хувь нийлүүлсэн хөрөнгийн доод хязгаарыг хуульчлах ② хуулийн этгээдийн үүсгэн байгуулсан зорилгыг хууль бус тохиолдолд татан буулгах ③ бүхэлд нь биш хэсэгчлэн

бөгөөд “охин компани нь толгой компанитайгаа нэг этгээд” гэсэн дүгнэлтэд хүрэхийн тулд шүүх энэхүү онолын үүднээс тайлбарлах шаардлага үүснэ.

Компанийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.5-д заасны дагуу толгой болон охин компани нь нэг нэгнийхээ өрийг хариуцахгүй ба тус тусдаа бие даасан хуулийн этгээд, эрх зүйн чадвартай этгээдүүд болохыг зарчмын хүрээнд тодорхойлсон байдаг. Гэхдээ энэхүү зарчмын хазайлтыг тус хуулийн 6 дугаар зүйлийн 6.6-д зохицуулжээ. Хэдийгээр тус тусдаа хуулийн этгээд боловч толгой компани нь охин компанийн удирдлагад шууд нөлөөтэй гэдэг утгаараа толгой компанийн шийдвэрийн улмаас охин компани төлбөрийн чадваргүй болсон тохиолдолд толгой компани нь тухайн өрийг хамтран хариуцах зохицуулалтыг хийж, хэсэгчлэн хуулийн этгээдийн эрхийн чадварыг үгүйсгэх онолын үндсийг тодорхой хэмжээнд тусгасан.

Энэхүү толгой компанийн хариуцлагын зохицуулалтын зорилго нь охин компанийг төлбөрийн чадвартай эсэхийг тогтоож, дампуурсанд тооцох эсэхийг шийдвэрлэхэд ач холбогдолтой биш бөгөөд охин компанийн төлбөрийн чадваргүй нь тогтоогдчихсон нөхцөлд төлбөрийн чадваргүйдэлд хүргэсэн шалтгаан нь толгой компанийн шийдвэр байгаа тохиолдолд толгой компанийг хариуцлагад татах зорилготой зохицуулалт юм. Мөн энэхүү зохицуулалтыг төлбөрийн чадваргүйд тооцсон тухай шүүгчийн захирамж⁵⁴ гармагц нэхэмжлэгч нарт шаардах эрх үүснэ гэж ойлгож болохгүй.

Учир нь нэгдүгээрт, охин компани төлбөрийн чадваргүй болох нь тогтоогдох, хоёрдугаарт, энэ нь толгой компанийн шийдвэрээс шалтгаалсан гэдгийг шүүх тогтоосон байх ёстой, гуравдугаар, дампуурсанд тооцож, татан буулгах болон дахин хөрөнгөжүүлэх

буюу тухайн асуудлын хүрээнд хуулийн этгээдийн эрхийн чадварыг үгүйсгэж, түүний ард байгаа бодит үнэнийг үндэсээ болгож, эрх зүйн зохицуулалт хийх гэсэн аргуудыг хэрэглэдэг /최준신, “회사법”, 삼성사, 2017, 64면.

⁵⁴ Төлбөрийн чадваргүй чадваргүй байдлыг зөвхөн шүүх тогтооно/ДтХ 5.3/

ажиллагааны зардал нь мөн төлбөрийн чадваргүй болсонтой холбоотойгоор үүссэн өр төлбөрт тооцогдох тул энэхүү зардлыг үүсгэсэн шүүхийн шийдвэр гарснаар толгой компанийн өрийг хамтран хариуцах үүрэг үүснэ.

Улсын Дээд шүүх нь 2018.04.17-ны өдрийн хуралдааны 001/ХТ2018/00617 дугаар тогтоолдоо Компанийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.6 үйлчлэх нөхцөл байдал үүссэн эсэхийг өмнөх хоёр шатны шүүх анхаараагүйг шүүмжилсэн боловч хяналтын шатны шүүх өөрөө энэ тухай тодорхой авч үзээгүй байна. Улмаар охин компани нь толгой компанитайгаа нэг этгээд⁵⁵ гэсэн дүгнэлтийнхээ хүрээнд хянавал хэсгийн 2, 3 дах хэсэгт “толгой компани дампуураагүй, цор ганц хувьцаа эзэмшигч болсон даруйдаа дампуурсанд тооцуулах хүсэлт өгөх нь дампуурлын тухай хуулийн зорилго, агуулгад нийцэхгүй” гэж үзсэн. Мөн тогтоолд Дампуурлын тухай хуулийн ямар зорилго, агуулгад хэрхэн нийцэхгүй байгаа талаараа үндэслэлтэй дүгнэлт хийгээгүй байна. Өөрөөр хэлбэл, УДШ нь хэсэгчлэн хуулийн этгээдийн эрхийн чадварыг үгүйсгэх онолыг хөндөж, Компанийн тухай хуулийн 6.3, 6.5, 6.6-г хэрэглэхийг оролдсон боловч үндэслэлтэй тайлбарлаж чадаагүй бөгөөд дампуурсанд тооцож, татан буугдахтай холбоотой үүссэн нэхэмжлэлийн шаардлага болон өр төлбөрийг хариуцах этгээд нь хариуцагч компаниас гадна түүний толгой компани байж болох эсэхийг тогтооход хэрэглэх хуулийн зохицуулалтыг хариуцагчийн “төлбөрийн чадваргүй” байдлыг үгүйсгэх нөхцөл гэдэг үүднээс тайлбарлаж, хэрэглэж байгаа нь буруу байна.

⁵⁵ Хянавал хэсгийн 2-т “Шүүх “М” ХХКомпани, түүний хувьцаа эзэмшигчийн талаар дүгнэж чадаагүй, Компанийн тухай хуулийн 6.3-т заасан зохицуулалтыг хэрэглээгүйгээс нэхэмжлэл гаргах эрх бүхий этгээд, “М” ХХК-ийн өрийн хэмжээг үндэслэл бүхий тодорхойлж чадаагүй байна. Үүрэг гүйцэтгүүлэгч, үүрэг гүйцэтгэгч хоёр нэг этгээд болсноор бие биедээ шаардлага гаргах боломжгүй болох тул үүрэг дуусгавар болдог байна. Өөрөөр хэлбэл “М” ХХКомпанийн хувьцаа эзэмшигч “Г П” НХН нь өөрөөсөө буюу “М” ХХКомпаниас үүрэг шаардах эрхгүй юм. Мөн “Г П” НХН нь “Г П П”НХН-ийн толгой компани бөгөөд “Г П П”НХН нь “М” ХХКомпанийн нэгэн адил охин компанийн статустай, агуулгын хувьд “Г П” НХН-тэй хамааралтай, нэг ашиг сонирхолтой юм. Иймд “Г П” НХН болон “Г П П” НХН нь “М” ХХКомпаниас арбитрын шийдвэрийн дагуу төлбөрөө гаргуулах үндэслэлгүй болно”

Шүүх төлбөрийн чадваргүй нь тогтоогдсон охин компанийг дампуурсанд тооцож, татан буулгах шийдвэр гаргахдаа өр төлбөрийг хамтран хариуцах толгой компанийн үүрэг үүссэн эсэхийг тогтоож байж, татан буулгах ажиллагааны явцад нэхэмжлэгчид толгой компаниас нэхэмжлэх эрх үүснэ. Гэтэл УДШ-ийн 2018.04.17-ны өдрийн хуралдааны 001/ХТ2018/00617 дугаар тогтоолын хувьд төлбөрийн чадваргүй болсон охин компанийг дампуурсанд тооцохгүй, толгой компанид өрийг хамтран хариуцах үүрэг үүссэн эсэхийг тогтоохгүй, үндэслэлгүйгээр охин компани болон толгой компани нь нэг этгээд гэж үзэн буруу жишиг тогтоосон. Нэгэнт охин компани болон толгой компанийг нэг этгээд гэж үзвэл, нэхэмжлэгчид толгой компанийг хариуцагчаар татаж ердийн журмаар нэхэмжлэлээ барагдуулах бүрэн боломжтой гэсэн логикт хүрэх бөгөөд охин компани эрх зүйн чадвартай байх, үгүй нь ач холбогдолгүй байхад дампуурсанд тооцож, татан буулгахгүй байх үндэслэл, шалтгаан тодорхойгүй, зөрчилдөөнт үр дагаварт хүргэж байна.

2.3.4 Хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр албан татвараа төлөхгүй байгаа компанийн удирдлагын буруутай үйлдэл, түүний эрх зүйн үр дагавар

Жишээ 3: Улсын Дээд шүүхийн 2018.10.18-ны өдрийн хуралдааны 001/ХТ2018/01435 дугаар тогтоолд “...Орлого орсон байхад ... татвар төлөгч татвараа төлөөгүй нь хүсэлт гаргагч компанийн өөрийн удирдлагын буруутай үйл ажиллагаатай холбоотой, бусдаас шалтгаалаагүй байгаа нь хэрэгт авагдсан баримтаар тогтоогдсон, Татварын ерөнхий хуульд зааснаар татвар төлөгч нь татварыг төлөх цүрэгтэй, түүнчлэн шүүхийн шийдвэр биелэгдэх учиртай тул дээр дурдсан үндэслэлээр тухайн компанийг дампуурсанд тооцож, татан буулгаж, татвар төлөх цүргээс чөлөөлөх үндэслэлгүй...” гэж дүгнэсэн. Энэхүү дүгнэлтээс үзвэл, нэгдүгээрт, хариуцагч төлбөрийн чадваргүй, хоёрдугаарт, хариуцагчийн төлбөрийн чадваргүй байдалд тухайн компанийн

удирдлага нь буруутай, гуравдугаарт, хэрэв шүүх компанийг дампуурсанд тооцоод шийдчихвэл татварын өрнөөс чөлөөлөгдөх магадлалтай гэж үзсэн тул хүсэлтийг хэрэгсэхгүй болгож байна.

Юуны өмнө шүүхийн дээрх дүгнэлт нь дампуурсанд тооцох гол үндэслэл болох төлбөрийн чадвартай эсэхийг нотлохтой ямар ч хамааралгүй байна. Хариуцагчийг дампуурсанд тооцсоноор татан буулгах ажиллагаа буюу хариуцагчийн хөрөнгөөр нэхэмжлэлийн шаардлагыг хангуулах ажиллагаа эхэлдэг байхад шүүх “*нэхэмжлэлийн шаардлага буюу татвараас чөлөөлөгдөх үндэслэл болно*” гэж үзэж байгаа нь Дампуурлын тухай хуулийн зорилгыг буруу ойлгож байгааг илтгэж байна.

Шүүх дампуурсанд тооцож, татан буулгах шийдвэр гаргаснаараа тухайн этгээдийн бусдын өмнө хүлээсэн үүргийг дуусгавар болгодоггүй бөгөөд дампуурсанд тооцогдсон шүүхийн шийдвэртэй этгээд нь арилжааны үйл ажиллагаа явуулах чадвараа алдах хэдий ч татан буулгах ажиллагааны зорилгоор эрх зүйн харилцаанд орох хуулийн этгээдийн чадвар нь хэвээр байдаг. Өөрөөр хэлбэл, дампуурсан компани нь татан буулгах ажиллагаа явагдаж дуусаад улсын бүртгэлээс хасагдах хүртлээ хуулийн этгээдийн статусаа алддаггүй. Харин хариуцагчийг дампуурсанд тооцож, татан буулгах тухай шүүхийн шийдвэр нь Дампуурлын тухай хуулийн 4 дүгээр бүлэгт заасан татан буулгах ажиллагааг эхлүүлдэг. Энэхүү ажиллагааны гол зорилго нь компанийн хөрөнгөд холбогдох эрх, үүргийн харилцааг шийдвэрлэж, тухайн этгээдийн хуулийн этгээдийн статусыг байхгүй болгоход⁵⁶ чиглэх бөгөөд шүүх татан буулгах ажиллагааг дуусгавар болгоно. Дампуурлын тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.1-д заасны дагуу татан буулгах ажиллагаа дуусгавар болсноор хариуцагч нэхэмжлэлийн шаардлагын хангагдаагүй үүргээс чөлөөлөгдөж, түүний нэхэмжлэгчдийн өмнө хүлээсэн үүрэг дуусгавар болно. Иймд шүүх хариуцагчийг бусдын өмнө хүлээсэн үүргээс чөлөөлөхгүйн тулд дампуурсанд тооцохгүй,

⁵⁶ 최준선, “회사법”, 삼영사, 2017, 825면.

татан буулгах ажиллагааг эхлүүлэхгүй байгаа нь дампуурлын хэрэг хянан шийдвэрлэх үе шат болон татан буулгах ажиллагааны зорилго, үр дагаврыг зөв ойлгож хэрэглэхгүй байна⁵⁷ гэж үзэхэд хүргэж байна.

Харин шүүх хариуцагчийн төлбөрийн чадваргүй болсон шалтгаан, нөхцөлийг тодруулснаараа хуваарилагдах хөрөнгийн хэмжээг нэмэгдүүлэх, хамтран хариуцлага хүлээх буруутай этгээдийг тогтоох замаар нэхэмжлэгчийн эрх ашгийг хамгаалах боломжтой. УДШ-ийн тогтоолд *“орлого орсон байхад дээрх орлого хэрхэн зарлагдсан нь тодорхойгүй, энэ талаар үндэслэл бүхий дүгнэлт гараагүй байх ба тухайн орлогоос хуулиар хүлээсэн албан татвар ногдох татвараа төлөөгүй хүндэтгэн үзэх үндэслэл тогтоогдоогүй байна”* гэж дүгнэж, үүнд компанийн удирдлагыг буруутай гэж үзсэн. Шүүх нэгэнт буруутай гэж үзэж байгаа бол буруутай этгээдийн хийсэн үйлдэлд ямар хуулиар хэрхэн хариуцлага хүлээлгэх вэ гэдэг асуудлыг тодорхойлох нь шүүхийн үүрэг юм.

⁵⁷ Анхан шатны шүүх дампуурсанд, тооцож татан буулгах шийдвэр гаргахдаа тогтоох хэсэгт “Дампуурлын тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.1-д заасныг баримтлан Т ХХК-ийн татан буулгах ажиллагаа дуусгавар болсноор нэхэмжлэгч Орхон аймгийн Татварын хэлтсийн зөрчлийн хуулиар ногдуулсан төлбөр 7 042 074.6 төгрөг, Нийслэлийн шүүхийн шийдвэр гүйцэтгэх газарт гүйцэтгэлийн ажиллагаанд байгаа татварын өр 62 710 400 төгрөгийн үүргээс чөлөөлөгдсөн болохыг дурдсугай” гэж заасан нь Дампуурлын тухай хуулийн 36, 37-р зүйлийг буруу хэрэглэсэн буюу татан буулгах ажиллагаа явагдаж, хэрэг гүйцэтгэгчийн тайлантай шүүх танилцахаасаа өмнө хариуцагчийн үүргийг дуусгавар болгосон байхад Улсын дээд шүүх анхаарахгүйгээр шүүхийн шийдвэр, магадлалыг хүчингүй болгох өөр үндэслэл гаргаж ирсэн.

Зарчмын хувьд дампуурлын хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад Эрүүгийн хуульд заасан татвар төлөхөөс зайлсхийх (18.3), зориуд, зохиомлоор дампуурах (18.10), хууль бусаар дампуурах (18.11) гэмт хэргийн аль нэгний шинжийг агуулж байгаа гэж шүүх үзсэн тохиолдолд хариуцагчийн хүсэлтийг хэрэгсэхгүй болгож, бусад шаардлагатай арга хэмжээг авах шаардлагатай.⁵⁸ Дээр дурдсанчлан шүүхээс “*татвар төлөх цүргээс чөлөөлөгдөх зорилгоор санаатайгаар дампуурах зорилготой байна*” гэж үзэж байгаа тохиолдолд хангалттай тайлбар, мэдүүлэг, нотлох баримтад тулгуурлан шийдвэрийнхээ үндэслэлийг “*татвараас зайлсхийх гэмт хэргийн шинжийг агуулж байгаа тул хуулийн дагуу шалгуулах шаардлагатай*” гэж тодорхой дүгнэлт хийж, дампуурсанд тооцох хүсэлтийг хэрэгсэхгүй болгох нөхцөл хангагдана. Өөрөөр хэлбэл, шүүх дампуурлын маргааныг хянан шийдвэрлэх явцад шалгах шаардлагатай хууль бус үйлдэл, эс үйлдэхүй байна гэж үзсэн тохиолдолд энэ талаар үндэслэл бүхий дүгнэлт гаргаж, хүсэлтийг хэрэгсэхгүй болгох боломжтой юм.

Үүнээс гадна компанийн эрх бүхий албан тушаалтанд Компанийн тухай хуулийн дагуу хариуцлага хүлээлгэж болдог. Монгол Улсын хувьд эрх бүхий албан тушаалтан нь Компанийн тухай хуульд заасан үүргээ биелүүлээгүйгээс компанид хохирол учирсан тохиолдолд тухайн эрх бүхий албан тушаалтнаар нөхөн төлүүлэхээр зохицуулсан (КтХ 84.10, 84.6, 86.2) бөгөөд компани өөрөө эсхүл хувьцаа эзэмшигч шүүхэд нэхэмжлэл гаргах эрхтэй байдаг. Мөн Дампуурлын тухай хуулийн 14 дүгээр зүйлд заасны дагуу хариуцагчийг дампуурсанд тооцож, татан буулгах тухай шийдвэр гарснаар хариуцагчийн аж ахуй удирдах болон эд хөрөнгө захиран зарцуулах эрх хэрэг гүйцэтгэгчид шилждэг. Энэхүү эрхийг шилжүүлж авсан хэрэг гүйцэтгэгч нь Дампуурлын тухай

⁵⁸ Монгол Улсын хувьд энэ талаар тодорхой хуулийн зохицуулалт байхгүй бөгөөд Дампуурлын тухай хууль болон Эрүүгийн хуулийн уялдааг тодорхой тусгаагүй байдаг. Гэмт хэргийн шинж илрэх тохиолдолд нэхэмжлэл, хүсэлт хүлээж авахаас эхлүүлээд дампуурсанд тооцож, татан буулгах ажиллагааны аль ч үе шатад хэргийг хэрэгсэхгүй болгох, ажиллагааг зогсоох арга хэмжээ авах шаардлагатай байдаг.

хуулийн 12 дугаар зүйлийн 12.1.5 болон Компанийн тухай хуулийн 86 дугаар зүйлийн 86.2-т заасны дагуу хариуцагч компанийн эрх бүхий албан тушаалтнаар компанид хохирол учруулсан хохирлыг нөхөн төлүүлэхээр шүүхэд нэхэмжлэл гаргах эрх нь татан буулгах ажиллагааны эхлэхэд нээлттэй болдог.

Иймд шүүх хариуцагч компанийн эрх бүхий албан тушаалтныг буруутай гэж үзэж байгаа тохиолдолд хууль зүйн үндэслэлээ тодорхой гаргаж, тэрхүү дүгнэлтээр хэн хэн хохирол нөхөн төлөх үүрэгтэй болон хэнд шаардах эрх үүсэж байгааг тогтоох ёстой. Мөн энэхүү шаардах эрх нь шүүх тухайн компанийг дампуурсанд тооцож, татан буулгах шийдвэр гаргасан ч нээлттэй хэвээр байна. Учир нь дээр дурдсанчлан дампуурсанд тооцож, татан буулгах шийдвэр нь хариуцагч компанийн хуулийн этгээдийн чадварыг байхгүй болгодоггүй бөгөөд татан буулгах ажиллагааны зорилгоор оршсоор байдаг. Түүнчлэн улсын бүртгэлээс хасагдах хүртэлх үүссэн хөрөнгө нь хуваарилагдах хөрөнгөд хамаарах тул “компанийн эрх бүхий албан тушаалтнаас хохирол нөхөн төлөхийг шаардах эрх”-ийн хэмжээгээр хуваарилагдах хөрөнгө нэмэгдэх боломжийг бий болгодог ач холбогдолтой.

Дээрхийг товч дүгнэвэл, шүүхийн “компанийн удирдлага буруутай” гэсэн дүгнэлт нь хариуцагчийг дампуурсанд тооцож, татан буулгах шийдвэртэй хамт гарсан тохиолдолд хэрэг гүйцэтгэгчид (нэхэмжлэгч) хохирол шаардах эрх үүснэ. Харин дампуурсанд тооцож, татан буулгах тухай хүсэлтийг хэрэгсэхгүй болгож шийдвэрлэсэн тохиолдолд зөвхөн тухайн компани болон хувьцаа эзэмшигч нь компанийн удирдлагаас компанид учирсан хохирлоо шаардах эрхтэй. Нэхэмжлэлийн шаардлагыг хангах сонирхолгүй байгаа компанийн удирдлага болон хувьцаа эзэмшигч нь энэхүү шаардах эрхээ хэзээ ч хэрэгжүүлэх сонирхолгүй буюу компани хөрөнгөжих ямар ч боломжгүй. Иймд энэхүү шийдвэр нь нэхэмжлэгч нарт давуу тал үүсгэхгүй юм. Гэтэл УДШ-ийн тогтоолд компанийн эрх бүхий албан тушаалтныг буруутай гэж үзэх хангалттай, тодорхой үндэслэл гаргаагүй бөгөөд буруутай гэж үзсэний дагуу

компанийн эрх бүхий албан тушаалтан нь ямар хуулийн дагуу ямар хариуцлага үүсэж байгааг тогтоогоогүй буюу хохирол нөхөн төлөх үүрэг үүссэн эсэхийг тогтоогоогүй орхигдуулжээ. Мөн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаандаа холбогдох буруутай этгээдүүдийг гуравдагч этгээдээр оролцуулаагүй байна.⁵⁹ Шүүх “компанийн удирдлагыг буруутай” гэж тогтоосон ч хариуцагчийг дампуурсанд тооцоогүй тохиолдолд нэхэмжлэгч болох татварын газар компанийн удирдлагаас компанид учирсан хохирол нөхөн төлөхийг шаардах эрхгүй.

2.3.5 Нягтлан бодох бүртгэлийн анхан шатны баримт дутуу байгаа хариуцагчийн буруутай үйлдэл

Дампуурлын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.3-д заасныг үндэслэн Шүүх нь хүсэлтийг шийдвэрлэхэд шаардлагатай нотлох баримтуудыг хүсэлт гаргагчаас шаардан авах эрхтэй. Нотлох баримтыг хүсэлт гаргагч нь шүүхэд гаргаж өгөх боломжгүй, эсхүл тухайн баримт байхгүй нөхцөлд энэ талаар шүүхэд тайлбар гаргаж өгөх үүрэгтэй. Шаардлагатай гэж үзвэл шүүхээс тухайн баримтыг эрх бүхий этгээдээс гаргуулах ажиллагааг хийж гүйцэтгэнэ. Хүсэлт гаргагч болон эрх бүхий этгээдээс нотлох баримтыг гаргаж өгөөгүй тохиолдолд шүүгч хавтаст хэрэгт цугларсан баримтад дүгнэлт хийж, хэргийг шийдвэрлэнэ.

Жишээ 4: Улсын Дээд шүүхийн 2018.06.12-ны өдрийн хуралдааны 001/ХТ2018/00932 дугаар тогтоолын хянавал хэсгийн 2.3-д “...зарлагын гүйлгээнүүдийн утга тодорхой бус, хариуцагч ...эмчилгээ болон банкны төлбөр, хүч, хувь хүмүүсээс авсан өр, зээл, хувийн амьдралын зайлиггүй хэрэгцээнд зарцуулсан... гэсэн тайлбар өгч байгаа. Энэ нь Дампуурлын тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.1.1-д зааснаар хүчин төгөлдөр бус байна... 30.000.000 төгрөгийг түрээсийн төлбөрт зарцуулсан гэх боловч

⁵⁹ Онцгой ажиллагааны журмаар хэрэг хянан шийдвэрлэх явцад бусад иргэн, хуулийн этгээдийн эрх хөндөгдсөн тохиолдолд тэдгээр нь гуравдагч этгээдээр оролцож болно. (ИХШХШТХ 134.3)

анхан шатны баримт байхгүй, санхүүгийн тайланд тусгаагүй нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 3.1.3-д заасныг зөрчсөн ба энэ талаар хэрэг гүйцэтгэгч дүгнэлтдээ дурдаагүй байна...Иймд Дампуурлын хэрэг үүсгэх замаар хүсэлт гаргагчийг татан буулгах хуулийн үндэслэл тогтоогдоогүй” гэж дүгнэсэн. Эндээс үзвэл хувьцаа эзэмшигч, үүсгэн байгуулагч нь компанийн хөрөнгийг хувьдаа ашиглаагүй, шилжүүлж аваагүй⁶⁰ гэдгээ нотлох нягтлан бодох бүртгэлийн анхан шатны баримт гаргаж өгч чадаагүй буюу байхгүй байжээ.

Дээрх нөхцөл байдал нь тухайн хариуцагч компанийг төлбөрийн чадвартай гэж үзэх үндэслэл биш, харин төлбөрийн чадваргүй болоход нөлөөлсөн буруутай этгээдийг олж тогтоох, хуваарилагдах эд хөрөнгийг тодорхойлоход хамааралтай. Энэ нь нэгэнт хүсэлтээр үүссэн дампуурлын хэргийн тухайд нэхэмжлэгчийн эрх ашгийг хамгаалах хууль зүйн механизмууд болох Эрүүгийн хуульд заасан зориуд, зохиомлоор дампуурах (18.10), хууль бусаар дампуурах (18.11) гэмт хэргийн шинжийг агуулж байгаа эсэхийг шалгах, Компанийн тухай хуульд заасан хувьцаа эзэмшигчийн компанид оруулсан хөрөнгө нь хувийн хөрөнгөөс зааглагдаагүй тохиолдолд хувьцаа эзэмшигчийн хүлээх давхар хариуцлага (9.5), компанид хохирол учруулсан эрх бүхий албан тушаалтны хариуцлага (84, 85, 90), Дампуурлын тухай хуульд заасан хэлцлийг хүчин төгөлдөр бусад тооцуулах зохицуулалт (19) зэргийг үйлчлэх эсэхийг тогтооход чухал ач холбогдолтой. Ингэснээр нэхэмжлэлийн шаардлагыг хангах хөрөнгө болон нэхэмжлэлийн шаардлагыг биелүүлэх хариуцагч компаниас гадна төлбөр төлөх үүрэг бүхий этгээдүүд нь үнэн зөв тогтоогдох юм.

Гэтэл шүүхээс нотлох баримт байхгүй шалтгаанаар “хариуцагч компанийг төлбөрийн чадваргүй нь тогтоогдохгүй байна буюу дампууруулах хууль зүйн үндэслэл бүрдээгүй” гэж үзэх нь үүсгэн байгуулагч болон компани хоёрыг нэг субъект эсхүл үүсгэн

⁶⁰ Дампуурлын хэрэг үүсгэхээс өмнө 2 жилийн дотор хариу төлбөргүйгээр хариуцагчийн удирдах байгууллагын гишүүд, тэдгээрийн гэр бүлийн гишүүдийн өмчлөлд эд хөрөнгө шилжүүлэх тухай гэрээ, хэлцэл/ДтХ 19.1.1/

байгуулагчийн хөрөнгө нь компани гэж үзэх хандлагаас үүдэлтэй үндэслэлгүй бөгөөд оролцогчдын эрх ашгийг хохироосон шийдвэр гаргаж байна. Энэхүү шийдвэрийн үр дүнд компанийн хөрөнгийг хувьдаа шилжүүлж авдаг үүсгэн байгуулагчийн хууль бус ажиллагаа хэвээр үргэлжлэх бөгөөд нэхэмжлэгч нарт хариуцагч компани төлбөрөө төлж чадахгүй байсаар байх болно. Цаашид нэхэмжлэгчдийн тоо ч нэмэгдэх боломжтой бөгөөд нэхэмжлэгч нар ердийн журмаар нэхэмжлэл гаргаж шийдвэрлүүлсэн ч шүүхийн шийдвэр гүйцэтгэх дараалалд орж, төлбөрийн шаардлага хангагдахгүй үлдэх эрсдэл үүсгэж байна.

2.4. ШҮҮХ ХҮСЭЛТИЙГ ХЭРЭГСЭХГҮЙ БОЛГОХ ХУУЛЬ ЗҮЙН ҮНДЭСЛЭЛ БА ОРОЛЦОГЧДЫН АШИГ СОНИРХОЛ

Доорх хүснэгт дэх эхний 6 шийдвэрт дампуурсанд тооцох хүсэлт гаргасан компанийг төлбөрийн чадваргүй болсон тухай шүүгчийн захирамж гарч, дампуурлын хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа явагдаж, дахин хөрөнгөжүүлэх хүсэлт шүүхэд ирүүлээгүй байхад дампуурсанд тооцох хүсэлтийг хэрэгсэхгүй болгож шийдвэрлэжээ. Шүүхийн шийдвэрт Дампуурлын тухай хуулийн 4.1, 5.1.2, 33.1-д заасныг дурдсан боловч хуульд заагаагүй дараах үндэслэл шалтгаанаар дампуурсанд тооцох хүсэлтийг хэрэгсэхгүй болгосон байна. Үүнд:

- 1) Санаатай дампуурлын шинжтэй;
- 2) Хамаарал бүхий этгээдээс авлагаа авч чадахгүй;
- 3) Хэрэгт байгаа баримтаас төлбөрийн чадваргүй гэж үзэх үндэслэл тогтоогдоогүй;
- 4) Нягтлан бодох бүртгэлийн анхан шатны баримт байхгүй .
- 5) Албан татвараа төлөөгүй хүндэтгэн үзэх үндэслэл тогтоогдоогүй;
- 6) Бусдад төлөх өрийн нийт хэмжээ хариуцагч компанийн өөрийн хөрөнгөөс давсан боловч тухайн компанийн хувьцаа эзэмшигч толгой компани нь дампуураагүй зэрэг хамаарна.

Хүснэгт 5. Дампуурсанд тооцох хүсэлтийг хэрэгсэхгүй болгосон үндэслэл

Улсын дээд шүүхийн тогтоол	Дахин хөрөнгөжүүлэх санал болон төлөвлөгөө гарсан эсэх	Хүсэлтийг хэрэгсэхгүй болгосон үндэслэл	Хүсэлтийг хэрэгсэхгүй болгож шийдвэрлэж буй дүгнэлтийн хууль зүйн үндэслэл
1 Улсын Дээд шүүхийн 2022.05.31-ний өдрийн хуралдааны 001/ХТ2022/00660 дугаар тогтоол	Гараагүй.	1. Нягтлан бодох бүртгэлийн анхан шатны баримт гаргаж өгөөгүй учир тооцоо хийх боломжгүй. 2. Санаатай дампуурах шинжийг агуулсан./Хянавал 12, 13/	ДтХ 4.1, 5.1.2, 33.1
2 Улсын Дээд шүүхийн 2022.01.18-ны өдрийн хуралдааны 001/ХТ2022/00093 дугаар тогтоол	Гараагүй.	1. Компани нь өмчлөлдөө байгаа хөрөнгийн талаар үнэн зөв мэдүүлээгүй,ер төлбөрийн хэмжээгээ бодитоор тодорхойлоогүй, тоног төхөөрөмжийн өнөөгийн бодит үнийг тогтоож, бүртгэлдээ тусгаагүй. 2. Дампуурлын шалтгаан нь хамаарал бүхий эгтгээдээс авлагаа авч чадахгүй байгаа явдал	. ДтХ-ийн 4.1, 5.1.2, 33.1..
3 Улсын Дээд шүүхийн 2021.10.07-ны өдрийн хуралдааны 001/ХТ2021/01183 дугаар тогтоол	Гараагүй.	Анхан шатны шүүхийн шийдвэрээс үндэслэл олох	3 дугаар зүйлийн 3.1.2, 5 дугаар зүйлийн 5.1.2, 5.4, 33.1

4	Улсын Дээд шүүхийн 2018.06.12-ны өдрийн хуралдааны 001/ХТ2018/00932 дугаар тогтоол	Гараагүй.	<p>1. Сүүлийн 2 жилийн 48 удаагийн зарлагын гүйлгээ хүчин төгөлдөр бус байна.</p> <p>2. Бусдаас зээлсэн мөнгийг санхүүгийн тайланд тусгаагүй, анхан шатны баримтгүй байгаа нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 3.1.3-г заасныг зөрчсөн ба энэ талаар хэрэг гүйцэтгэгч дүгнэлтдээ дурдаагүй байна.</p>	4 дүгээр зүйлийн 4.1, 5 дугаар зүйлийн 5.1.2, 33 дугаар зүйлийн 33.1 дэх хэсэг
5	Улсын Дээд шүүхийн 2018.10.18-ны өдрийн хуралдааны 001/ХТ2018/01435 дугаар тогтоол	Гаргаагүй.	Орлого орсон байхад дээрх орлого хэрхэн зарлагдсан нь тодорхойгүй буюу албан татвараа төлөөгүй хүндэтгэн үзэх үндэслэл тогтоогдоогүй байна.	4 дүгээр зүйлийн 4.1, 5 дугаар зүйлийн 5.1.2, 33 дугаар зүйлийн 33.1.
6	Улсын Дээд шүүхийн 2018.04.17-ны өдрийн хуралдааны 001/ХТ2018/00617 дугаар тогтоол	Гаргаагүй.	<p>1. Цор ганц хувьцаа эзэмшигч болох толгой компани нь хариуцагч охин компаниас төлбөр төлөхийг шаардах эрхгүй учир нь нэг этгээд гэж үзнэ.</p> <p>2. Бусдад төлөх өрийн нийт хэмжээ хариуцагч компанийн өөрийн хөрөнгөөс давсан боловч тухайн компанийн хувьцаа эзэмшигч толгой компани нь дампуураагүй юм.</p>	4 дүгээр зүйлийн 4.1, 5 дугаар зүйлийн 5.1.2, 33 дугаар зүйлийн 33.1
7	Улсын Дээд шүүхийн 2021.02.02-ны өдрийн хуралдааны 001/ХТ2021/00118 дугаар тогтоол	Гаргаагүй.	хүсэлт гаргагчийн өр төлбөрийн хэмжээг хэрэгт авагдсан баримтын хэмжээнд тогтоох боломжгүй.	4 дүгээр зүйлийн 4.1, 7 дугаар зүйлийн 7.1.1, 7.1.2, 7.1.3, 7.1.4

Харин УДШ-ийн 2021.02.02-ны өдрийн хуралдааны 001/ХТ2021/00118 дугаар тогтоолоор “Хүсэлт гаргагчийн өр төлбөрийн хэмжээг хэрэгт авагдсан баримтын хэмжээнд тогтоох боломжгүй” гэж дүгнэж, Дампуурлын тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1, 7 дугаар зүйлийн 7.1.1, 7.1.2, 7.1.3, 7.1.4-ийг баримтлан хүсэлтийг хэрэгсэхгүй болгож шийдвэрлэсэн байна.

2.4.1 Дампуурлын тухай хуульд заасан дампуурсанд тооцох хүсэлтийг татгалзах, хэрэгсэхгүй болгох үндэслэл ба шүүхийн хууль хэрэглээний асуудал

Дампуурсанд тооцох хүсэлтийг хүлээн авахаас эхлээд хуулийн этгээдийг дампуурсанд тооцож, татан буулгах хүртэлх процесс ажиллагааны дарааллыг Зураг №1-т үзүүлсэн. Тус зурагт харуулсанчлан, дампуурлын хэргийг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад 1) дампуурсанд тооцох хүсэлтийг хүлээн авахаас татгалзах 2) төлбөрийн чадвартай болох нь тогтоогдсон 3) дахин хөрөнгөжүүлэх ажиллагааг дуусгавар болгосон гэсэн гурван үндэслэлээр дампуурлын хэргийг хэрэгсэхгүй болгоно.

- 1) Дампуурлын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.2-т зааснаар нэхэмжлэл, хүсэлт нь уг хуулийн 7 дугаар зүйлд заасан шаардлагыг хангасан гэж шүүгч үзвэл дампуурлын хэрэг үүсгэх захирамж гаргадаг. Дампуурлын хэрэг үүсгэх эсэх нь нэг талаас дампуурлын хэрэг үүсгүүлэх хүсэлт, нэхэмжлэл гаргах эрхээ урвуулан ашиглах магадлал болон нөгөө талаас төлбөрийн чадваргүй компанийг зах зээлээс даруй гаргаж талуудын эрх, ашиг сонирхлыг хангах хангалттай боломж хоёрыг ялгаж харах шаардлага шүүхэд тулгардаг тул хангалттай нотлох баримтыг үндэслэж дампуурлын хэрэг үүсгэх шаардлага бий болдог. Иймд энэ үе шатад шүүгч Дампуурлын тухай хуулийн 7.1, 7.2-т заасан шаардлагыг хангаагүй тохиолдолд хүсэлт, нэхэмжлэлийг хүлээж авахаас татгалзах ёстой. Үүнээс гадна хуульд зааснаас өөр нэмэлт нотлох баримт шаардлагатай болбол 7.3-д зааснаар

шаардаж авах эрхийг шүүгчид олгосон. Үүний үр дүнд шүүгч хангалттай үндэслэлтэйгээр дампуурлын хэрэг үүсгэх ёстой эсхүл хангалттай үндэслэл тогтоогдохгүй бол нэхэмжлэл, хүсэлтийг хүлээж авахаас татгалзана.

- 2) Шүүх дампуурлын хэрэг үүсгэснээс хойш 30 хоногийн дотор хариуцагчийг төлбөрийн чадвартай эсэхийг тогтоох (ДтХ 5.3) бөгөөд төлбөрийн чадвартай болох нь тогтоогдвол дампуурлын хэргийг хэрэгсэхгүй болгодог (ДтХ 5.4). Шүүхийн практикт “Төлбөрийн чадваргүй болсон тухай” захирамжийг шүүхийн шийдвэр гаргахад харгалзан үзэхгүй байгаа боловч захирамжийг гарсан даруйд хэвлэл, мэдээллийн хэрэгслээр нийтэд мэдээлдэг тул хариуцагчийн эрх, ашиг цаашлаад зах зээлд хүчтэй нөлөө үзүүлдэг. Иймд энэ үе шатад шүүх хариуцагчийн санхүүгийн байдлыг бүрэн тогтоох шаардлага бий болдог. Иймд Дампуурлын тухай хуулиар түр хэрэг гүйцэтгэгчээр⁶¹ дамжуулан хариуцагчийн эд хөрөнгийг битүүмжлэх, эд хөрөнгө, холбогдох баримт бичгийг хамгаалалтад авч, тооллого явуулах, шаардлагатай тохиолдолд хариуцагчийн үйл ажиллагаанд баримтын шалгалт хийх ажлыг зохион байгуулах, нэхэмжлэгчдийн хурлыг зарлан хуралдуулах⁶², шүүхээр шийдвэрлүүлэх асуудлаар шүүхэд хандах, шаардлагатай мэдээ баримтыг хариуцагчаас гаргуулан авах боломжтой байхаар хуульчилсан. Хариуцагчаас мэдээ баримтыг гаргуулан авах эрх хэмжээнээс гадна хэрэг үүсгэхээс өмнө шаардлагатай баримт бичгийг нэхэмжлэгч, хариуцагчаас шаардаж авах шүүхийн эрх нь энэ үе шатад ч мөн хамаарна.

⁶¹ Шүүх дампуурлын хэрэг үүсгэхдээ хэрэг гүйцэтгэгчийг түр томилж болно/ДтХ 5.7/

⁶² Дампуурлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1-д нэхэмжлэгчдийн анхны хурлыг төлбөрийн чадваргүйд тооцсон тухай нийтэд мэдээлснээс хойш 30 хоногийн дотор шүүх зохион байгуулахаар хуульчилсан боловч төлбөрийн чадвартай эсэхийг тогтоохоос өмнөх түр хэрэг гүйцэтгэгчид нэхэмжлэгчдийн хурлыг хуралдуулах эрх олгож байгаа нь зөрчилтэй бөгөөд үндэслэлгүй байна.

Дампуурлын тухай хуулиар шүүгчид олгосон бүрэн эрх нь онцгой ажиллагааны журмаар хэргийг хянан шийдвэрлэхэд диспозитив зарчмаас илүүтэй императив зарчим хэрэгжүүлдэгтэй холбоотой. Тухайлбал, Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.6-д нэхэмжлэлийн шаардлагын талаарх тайлбарыг гагцхүү зохигч талууд гаргана. Энэ хуулийн 133 дугаар зүйлд заасан журмаар хянан шийдвэрлэх хэрэгт хамаарахгүй талаар зохицуулсан. Тиймээс онцгой ажиллагааны журмаар хэргийг хянан шийдвэрлэхэд талууд тайлбар гаргаж, нотлох баримт бүрдүүлж, шүүгч хөндлөнгийн байхаас илүүтэй хүсэлт гаргагчийн гаргасан хүсэлт, түүнд хавсаргасан нотлох баримтыг үнэн зөв, үндэслэлтэй эсэхийг шүүгч мөрдөн шалгах зарчмын дагуу шалгах, өөрийн санаачилгаар нэмэлт нотлох баримтуудыг эрх бүхий байгууллага болон хүсэлт гаргагчаас шаардах, хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг удирдана. Мөн энэ хүрээнд дээрх ажиллагаануудыг заавал түр хэрэг гүйцэтгэгчийг томилох замаар хэрэгжүүлэх шаардлагагүй бөгөөд ингэх эсэх нь шүүхийн өөрийнх нь эрх хэмжээний асуудал байдаг. Ийнхүү шүүхэд мөрдөн шалгах, баримт бичиг шаардах, баримтыг бүрдүүлэх бүрэн эрхийг олгох замаар хариуцагчийн санхүүгийн байдлыг үнэн зөв тогтоох бололцоог хуульчилсан бөгөөд шүүх дүгнэлт дээрээ тулгуурлаад өөрийн санаачилгаар шаардлагатай арга хэмжээнүүдийг (ИХШХШТХ-ийн 69-р зүйл⁶³) авах боломжтой. Эсрэгээрээ 30 хоногийн дотор явуулсан үйл ажиллагааны үр дүнд төлбөрийн чадвартай болох нь тогтоогдсон тохиолдолд дампуурлын хэргийг хэрэгсэхгүй болгох шийдвэрийг гаргана.

⁶³ 1/хариуцагчийн эд хөрөнгө буюу мөнгийг тухайн нэхэмжлэлийн үнийн дүнгийн хэмжээгээр битүүмжлэх; 2/хариуцагчаас эд хөрөнгөтэй холбоотой ямар нэгэн тодорхой ажиллагаа явуулахыг нэхэмжлэлийн үнийн дүнгийн хэмжээгээр хориглох; 3/ хариуцагчийн дансны зарлагын хөдөлгөөнийг нэхэмжлэлийн үнийн дүнгийн хэмжээнд зогсоох; 4/ нэхэмжлэлээр шаардсан хэмжээний мөнгийг шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн дансанд урьдчилан оруулах; 5/ тодорхой ажиллагаа гүйцэтгэх, эсхүл гүйцэтгэхгүй байхыг хариуцагчид даалгах/ИХШХШТХ 69.1./

- 3) Дампуурлын тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.2-т зааснаар шүүхээс баталсан дахин хөрөнгөжүүлэх төлөвлөгөөг бүрэн биелүүлж дууссан эсхүл төлөвлөгөөг биелүүлж дуусаагүй боловч нэхэмжлэгчдийн нэхэмжлэлийн шаардлагыг төлөвлөгөөний дагуу бүрэн хангасан тохиолдолд дампуурлын хэргийг хэрэгсэхгүй болгож шийдвэрлүүлнэ.

УДШ-ийн тогтоолоор дампуурсанд тооцохгүй буюу хүсэлтийг хэрэгсэхгүй болгохдоо **Нэгд**, Дампуурлын тухай хуулийн 4.1, 5.1.2, 33.1, **Хоёрт**, 4 дүгээр зүйлийн 4.1, 7 дугаар зүйлийн 7.1.1, 7.1.2, 7.1.3, 7.1.4-ийг баримталсан байна. Дампуурлын хэрэг үүсгэснээс хойш шүүх Дампуурлын тухай хуулийн 7 дугаар зүйл болон 33 дугаар зүйлийн 33.1-д заасныг үндэслэн “дампуурсанд тооцохгүй”, “хүсэлтийг хэрэгсэхгүй болгох” шийдвэрийг гаргаж байгаа нь шүүхийн шийдвэр хууль ёсны байх шаардлагыг хангахгүй байна.

2.4.2 Дампуурсанд тооцож, татан буулгах хүсэлтийг хэрэгсэхгүй болгох шийдвэр гаргахдаа Дампуурлын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.1-ийг баримталж буй асуудал

Улсын Дээд шүүхийн 2022.05.31-ний өдрийн 001/ХТ2022/00660 дугаар тогтоолд Дампуурлын тухай хуулийн 33 дугаар зүйлийг “*хариуцагч өөрөө, хариуцагчаас нэхэмжилсэн нийт төлбөрийн гуравны нэг буюу түүнээс дээш хувийг нэхэмжилж байгаа нэхэмжлэгчид, хэрэг гүйцэтгэгчийн хэн аль нь хуулийн этгээдийг дахин хөрөнгөжүүлэх тухай хүсэлт илүүхэд ирээгүй, илүүх төлөвлөгөөг батлаагүй, эсхүл төлөвлөгөөг илүүхэд ирүүлээгүй, төлөвлөгөөг биелүүлэх боломжгүй болсон тохиолдолд хариуцагчийг дампуурсанд тооцож, татан буулгах шийдвэр гаргана*” гэж тайлбарлажээ. Энэ зохицуулалтын зорилго болон УДШ-ийн тайлбарлаж байгаагаас үзвэл, нэгэнт шүүгчийн захирамжаар төлбөрийн чадваргүй нь тогтоогдчихсон хариуцагчийн тухайд шүүх дампуурсанд тооцож, татан буулгах шийдвэр гаргахдаа үүнийг үндэслэх ёстой. Гэтэл энэ зүйлийг нийтлэг байдлаар дампуурсанд

тооцохгүй буюу хүсэлтийг хэрэгсэхгүй болгох шийдвэр гаргахад ч үндэслэл болгож байгаа нь хуулийн буруу хэрэглээ гэж үзэхээр байна.

Учир нь **Нэгд**, Дампуурлын тухай хуульд шүүхээс дампуурлын хэргийг хэрэгсэхгүй болгох 3 үндэслэлийг л заасан бөгөөд энэ хүрээнд шүүх шийдвэрээ гаргах ёстой, **Хоёрт**, шүүх Дампуурлын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.1-д заасан урьдчилсан нөхцөл хангагдсан тохиолдолд дампуурсанд тооцож, татан буулгах шийдвэр гаргана. Тус зохицуулалтын урьдчилсан нөхцөл хангагдаагүй тохиолдолд буюу дахин хөрөнгөжүүлэх хүсэлт болон төлөвлөгөөг шүүхэд ирүүлсэн, шүүх төлөвлөгөөг баталсан, төлөвлөгөө хэрэгжүүлэх боломжтой байгаа бүх нөхцөлд “хариуцагчийг дампуурсанд тооцож, татан буулгах эсэх” тухай хүсэлтийг хэлэлцэх шүүх хурал зохион байгуулагдах боломжгүй.

Иймд УДШ нь нэгдүгээрт, хүсэлтийг хэрэгсэхгүй болгохдоо хуулийг зөв баримталж хэрэглээгүй, хоёрдугаарт, хянавал хэсэгтээ эрх бүхий этгээдүүд “дахин хөрөнгөжүүлэх хүсэлт гаргаагүй” гэсэн дүгнэлт өгч байгаа хэдий ч энэ нь Дампуурлын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.1-д заасан урьдчилсан нөхцөлийг хангаж байгаа эсэхэд дүгнэлт өгөхгүйгээр өөр шалтгаануудыг гаргаж,⁶⁴ Дампуурлын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.1-д заасныг баримтлан хүсэлтийг хэрэгсэхгүй болгож байгаа нь тус зүйлд заасан урьдчилсан нөхцөлөөс өөр нөхцөлийн хангасан гэж үзэж, шүүх шийдвэрийн үндэслэлээ болгож буруу тайлбарлан, хэрэглэж байна.

⁶⁴ Хүснэгт 5-ын 3 дах баганаас уншина уу.

2.4.3 Дампуурсанд тооцож, татан буулгах хүсэлтийг хэрэгсэхгүй болгох шийдвэрийг гаргахдаа Дампуурлын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1 дэх хэсгийг баримталж буй асуудал

Дампуурлын тухай хуулийн 7 дугаар зүйлд дампуурлын хэрэг үүсгэх тухай нэхэмжлэл, хүсэлтэд тавих шаардлагыг зохицуулсан бөгөөд энэ нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.2⁶⁵-той хамт дампуурлын хэрэг үүсгэх эсхүл нэхэмжлэл, хүсэлтийг хүлээж авахаас татгалзах захирамжийн үндэслэл болдог. Энэ үе шатад дампуурлын хэрэг үүсээгүй байдаг учраас хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа эхлэхгүй. Иймд дампуурлын хэрэг үүсгэснээс дампуурсанд тооцох хүсэлтийг хэрэгсэхгүй болгоход энэ зүйлийг баримтлах боломжгүй. Өөрөөр хэлбэл, нэхэмжлэл, хүсэлтэд тавигдах шаардлагыг хангасан эсэхийг дампуурлын хэрэг үүсгэснээс хойш 2 жил орчмын дараа 3 шатны шүүхээр эцэслэж шийдвэрлэх нь хамгийн өндөр зардал, хохиролтой, системгүй үйл ажиллагаа юм. Энэ ч утгаараа хуульд заасан шаардлагыг хангаагүй байгаа нөхцөлд шүүхээс хүсэлтийг хүлээн авахаас татгалзах шийдвэрийг гаргадаг. Тиймээс 7 дугаар зүйлийг үндэслэж, хуулийн 5 дугаар зүйлийн 5.2-ыг дурдахгүйгээр хүсэлтийг хэрэгсэхгүй болгож байгаа нь хэрэглэх ёсгүй хуулийг үндэслэж, шийдвэр гаргаж байна гэсэн үг юм.

⁶⁵ Нэхэмжлэл, хүсэлт нь энэ хуулийн 7 дугаар зүйлд заасан шаардлагыг хангасан гэж шүүгч үзвэл түүнийг хүлээн авснаас хойш 5 хоногийн дотор дампуурлын хэрэг үүсгэх тухай захирамж гаргана.

ДҮГНЭЛТ

Дампуурлын хэргийг хянан шийдвэрлэх ажиллагааг зохицуулсан бие даасан хууль 1997 онд батлагдаж, Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуульд 2007 онд оруулсан нэмэлт, өөрчлөлтөөр “хуулийн этгээдийг дампуурсанд тооцох” хүсэлтийг онцгой ажиллагааны журмаар шийдвэрлэхээр хуульчилснаар хуулийн этгээдийг дампуурсанд тооцож, татан буулгах эрх зүйн зохицуулалт тодорхой хэмжээнд бүрджээ. Хуулийн эдгээр зохицуулалтыг шүүхээс хэрэглэж буй байдалд дүн шинжилгээ хийж үзвэл хууль хэрэглээний болон хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны холбогдолтой дараах хэд хэдэн асуудал тулгамдаж байна гэж үзлээ. Үүнд:

1. Компанийг төлбөрийн чадвартай эсэхийг тогтоосон шүүгчийн захирамжийн эрх зүйн үр дагавартай холбоотой асуудалд:

Шүүхийн шийдвэрт хийсэн дүн шинжилгээний үр дүнд шүүгчээс гаргасан төлбөрийн чадваргүй болсон тухай захирамж нь эрх зүйн үр дагаваргүй буюу эрх зүйн нөлөөлөл байдаггүй болох нь тогтоогдлоо. Учир нь дампуурлын хэрэг үүссэний дараа төлбөрийн чадвартай эсэхийг тогтоож, “төлбөрийн чадваргүй болсон тухай” захирамж гарсан хэдий ч анхан болон давж заалдах, хяналтын шатны шүүхээр хүсэлт гаргагчийн төлбөрийн чадвартай эсэх талаар дахин дүгнэлт гаргаж, “төлбөрийн чадваргүйн нотлогдоогүй” гэсэн үндэслэлээр дампуурлын хэргийг хэрэгсэхгүй болгодог шүүхийн практик нийтлэг байна. Үүний үр дүнд хүсэлтийг хянан шийдвэрлэх явцад гарсан шүүгчийн захирамж, шүүхийн

шийдвэрүүд хоорондын агуулга зөрчилтэй, нэг нэгнийгээ үгүйсгэх логик зөрчил бий болгожээ.

Ийнхүү шүүхээс өөр хоорондоо зөрчилдсөн захирамж, шийдвэр гаргаж байгаа мэт боловч нөгөө талаас Дампуурлын тухай хуулийн зохицуулалт нь өөрөө энэ ийм байдалд хүргэж байна. Учир нь, компанийг төлбөрийн чадваргүйд тооцсон шүүгчийн захирамжийн гүйцэтгэх үүрэг, ач холбогдлыг тодорхой бус байдлаар хуульчилсан байна. Дэлгэрүүлэн авч үзвэл:

- а) Төлбөрийн чадваргүй болсон тухай захирамжийг гарснаас хойш 5 хоногийн дотор гомдол гаргах эрхтэй байхаар хуульчилсан нь нэхэмжлэгчид нийтэд зарласан мэдээллийг харж, нэхэмжлэл гаргах замаар хэргийн оролцогч болохоос өмнө дуусах богино хугацаа юм. Нэхэмжлэгчид гомдол гаргах эрхээ хэрэгжүүлэх боломжгүй болох эрсдэлтэй.
- б) Төлбөрийн чадваргүйд тооцсон тухай захирамж гарснаар хариуцагчийн аж ахуй удирдах болон эд хөрөнгө захиран зарцуулах эрх шилжихгүй. Өөрөөр хэлбэл, шүүгчийн захирамж гарснаас хойш дампуурсанд тооцож, татан буулгах шүүхийн шийдвэр 3 шатны шүүхээр эцэслэгдэх хүртэл хугацаанд⁶⁶ хариуцагч нь өөрийн хөрөнгөө захиран зарцуулах, хэн нэгэнд шилжүүлэх, нуух зэргээр хувийн ашиг сонирхлоо хамгаалах боломжийг хуулиар олгож байна.
- в) Хуваарилагдах эд хөрөнгийг тодорхойлоход төлбөрийн чадваргүйд тооцохын тулд шүүхийн олж тогтоосон нөхцөл байдал хамаарахгүй байна. Дампуурлын тухай хуулийн 17 дугаар зүйлд зааснаар дампуурлын хэрэг үүсгэх үед хариуцагчийн өмчлөлд байсан хөрөнгө хуваарилагдах хөрөнгөд хамаарахаар зохицуулсан. Хуваарилагдах хөрөнгийг тодорхойлохын ач холбогдол нь тухайн хөрөнгийн

⁶⁶ Шүүхийн шийдвэрийн дүн шинжилгээний хүрээнд сонгон судалсан хэргүүдийн хувьд анхан болон давж заалдах, хяналтын шатны шүүхийн шийдвэр гарч дампуурсанд тооцох эсэхийг шийдэх хүртэл дунджаар 2 жил зарцуулсан байна.

тухайд хариуцагч захиран зарцуулах эрхээ алдаж, хэрэг гүйцэтгэгчид бүх эрх шилжиж, нэхэмжлэлийн шаардлагыг уг эд хөрөнгөөс барагдуулахад оршдог. Гэтэл төлбөрийн чадваргүйд тооцсон тухай шүүгчийн захирамж нь хуваарилагдах хөрөнгө тодорхойлох болон хэрэг гүйцэтгэгчид эрх шилжихтэй ямар ч холбоогүй бөгөөд эдгээр нь цаг хугацааны хувьд өөр өөр буюу хоорондоо багадаа 60, ихдээ 2 жил байгаа нь энэ хооронд хариуцагч эд хөрөнгөө захиран зарцуулж болох эсэх нь тодорхойгүй нөхцөл бий болгож байна.

- г) Төлбөрийн чадваргүйд тооцсон тухай захирамж нь эрх зүйн ач холбогдол бага боловч нийгэм, эдийн засгийн нөлөөлөл өндөр байна. Тухайлбал энэхүү захирамжийг хэвлэл, мэдээллийн хэрэгслээр олон нийтэд мэдээлдэг бөгөөд үүнээс үүдэлтэйгээр тухайн компанийн нэр хүнд маш ихээр унах, эдийн засагт сөрөг байдал бий болох зэргийг дурдаж болно. Дүн шинжилгээ хийсэн шийдвэрүүдээс үзвэл, хүсэлт гаргаснаас хойш 2 жил орчмын дараа 3 шатны шүүхийн шийдвэрээр дампуурсанд тооцохгүй тухай шийдвэр гаргасан бөгөөд энэхүү шийдвэрийг хэвлэл мэдээллийн хэрэгслээр нийтэд зарлахыг хуулиар шаарддаггүйн дээр олон нийтэд зарласан байлаа ч өмнөх шүүгчийн захирамжаас үүдэлтэй нэр хүнд болон эдийн засагт учирсан хохирлыг сэргээх боломжгүй юм.

2. Төлбөрийн чадваргүй байдлыг нотлох үүргийн хуваарилалт ба онцгой ажиллагааны журмаар хэргийг шийдвэрлэхэд шүүгчийн гүйцэтгэх үүрэг:

Онцгой ажиллагааны журмаар хэргийг хянан шийдвэрлэхэд мэтгэлцэх зарчим хэрэгжихгүй бөгөөд хүсэлт гаргагчийн гаргасан нотлох баримтад үндэслэн хэргийг шийдвэрлэх нь шүүхийн шийдвэр үндэслэл бүхий байх шаардлагыг хангахгүйд хүрнэ. Тиймээс хүсэлт гаргагчийн өгсөн нотлох баримтын үнэн зөвийг шалгах, шаардлагатай тохиолдолд Дампуурлын тухай хуулийн 7 дугаар

зүйлийн 7.3-д нэмэлт нотлох баримт гаргуулан авах, дампуурсанд тооцох эсэхийг тогтоохыг тул хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг чиглүүлэх идэвхтэй ажиллагааг шүүгчээс шаарддаг.

Ялангуяа дампуурсанд тооцох тухай хүсэлтийг хүлээн авсан шүүгч нь **Нэгд**, хүсэлт гаргагч нь дампуурлын хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг урвуулан ашиглах зорилготой эсэхийг тогтоох, **Хоёрт**, хариуцагч компани нь төлбөрийн чадвартай эсэхийг зөвхөн энэ үе шатанд тогтоох шаардлагатай. Ийнхүү тогтоохын тулд анхан шатны шүүх нь хангалттай нотлох баримт, мэдээллийг цуглуулах зорилгоор талуудаас нэмэлт баримт бичиг шаардах, шалгах бүрэн эрхтэй. Онцгой ажиллагааны журмаар хэргийг шийдвэрлэхэд шүүгч өөрийн санаачилгаар нотлох баримтыг хүсэлт гаргагчаас шаардах, бусад байгууллагаас гаргуулах зэргээр мөрдөн шалгах зарчмыг хэрэгжүүлэхгүй байгаа нь процессын зөрчилд тооцогдоно.

Түүнээс гадна анхан шатны шүүх төлбөрийн чадвартай эсэхийг шалгах хугацаанд мөрдөн шалгах зарчмыг хангалттай хэрэгжүүлээгүйн улмаас анхан, давах, хяналтын шатны шүүхээс нотлох баримтуудыг дахин үнэлж, төлбөрийн чадваргүй эсэх нь тогтоогдохгүй гэх мэт хууль зөрчсөн ч шударга ёсны үүднээс дүгнэлт гаргаж, хүсэлтийг хэрэгсэхгүй шийдвэр гаргах нь түгээмэл байна.

3. Компанийг төлбөрийн чадваргүй болоход хүргэсэн буруутай этгээдийг тогтоох:

Монгол Улс дах хуулийн этгээдийн дампуурлын хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг томъёолбол **[төлбөрийн чадваргүй (+) + дахин хөрөнгөжүүлэх (-) = дампуурсан тооцож, буулгах шийдвэр]** гаргахаар зохицуулжээ. Ийм учир нэгэнт дампуурлын хэргийг үүсээд хянан шийдвэрлэж явцад эсхүл татан буулгах ажиллагааны явцад хариуцагчийн хөрөнгө нуусан, шилжүүлсэн, хуурамчаар хуваарилагдах хөрөнгөөр хариуцах нэхэмжлэлийн шаардлага бий болгосон, эсхүл санаатайгаар бусдын өмнө хүлээсэн

үүргээ биелүүлэхээс зайлсхийхийн тулд дампуурч байгаа гэх мэт дампуурсанд тооцож, татан буулгах ажиллагааг урвуугаар ашигласан үйлдэл гаргасан гэж шүүх үзсэн тохиолдолд авах ёстой арга хэмжээнүүд тодорхой хуульчлагдаагүй байна.

Мөн төлбөрийн чадваргүй хариуцагчийг дампуурсанд тооцохгүй буюу хүсэлтийг хэрэгсэхгүй болгох үндэслэлийг тодорхой хуульчилж өгөөгүйгээс шүүх ижил хуулийн заалтыг үндэслэж байгаа мөртөө өөрийн үзэмжээр хуульд байхгүй үндэслэлээр хүсэлтийг хэрэгсэхгүй болгодог жишиг байна.

Шүүх хариуцагчийг төлбөрийн чадваргүй байдалд хүргэсэн буруутай этгээдийг тогтоохдоо “төлбөрийн чадваргүй” байдлыг үгүйсгэх нөхцөл байдлаар шүүхийн шийдвэртээ ашиглах нь нийтлэг байна. Өөрөөр хэлбэл, хариуцагч компанийн төлөх өр төлбөрийг төлөх үүрэг бүхий хамтран хариуцагч байгаа эсэхийг тогтоох зорилгоор хариуцагчийн төлбөрийн чадваргүй хүрсэн шалтгааныг хянан, тогтоохгүй байна.

4. Шүүх хүсэлтийг хэрэгсэхгүй болгох хууль зүйн үндэслэл, хэрэглээний зөрүү:

Шүүхээс компанийг дампуурсанд тооцох хүсэлтийг Дампуурлын тухай хуулийг үндэслэн хэрэгсэхгүй болгож байгаа хэдий ч үндэслэл болгож байгаа зохицуулалтын нөхцөлийг хангахгүй, өөр үндэслэл, шалтгаанаар дампуурлын хэргийг хэрэгсэхгүй болгосон байна. Энэ нь Дампуурлын тухай хуулийн зорилгыг үгүйсгээд зогсохгүй, хуулийн зохицуулалтыг буруу тайлбарлаж, хэрэглэхэд хүргэж байна.

САНАЛ

1. Дампуурлын тухай хуулиар тодорхойлсон дампуурлын хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг боловсронгуй болгох шаардлагатай байна. Дампуурлын үе шатыг зохистойгоор томьёолж, дампуурлын хэрэг үүсгэх шат, дампуурсанд тооцож, татан буугдах ажиллагааг эхлүүлэх шат, татан буугдах ажиллагааг дуусгавар болгох үед шат гэх байдлаар хуулийн зохицуулалтыг системчлэх нь зүйтэй.
2. Шүүхийн шийдвэрийг судалж үзэхэд, дампуурлын хэргийг хянан шийдвэрлэх хуулиар тогтоосон хугацаа нь бодит байдалт нийцэхгүй байх тул хуульд заасан хугацааг 2 - 6 сар хүртэлх хугацаагаар нэмэгдүүлэх шаардлагатай.
3. Шүүгчээс мөрдөн шалгах зарчмыг хэрэгжүүлэх хүрээнд Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуульд заасан онцгой ажиллагааны журмаар хэргийг хянан шийдвэрлэх тохиолдолд шүүгч өөрийн санаачилгаар нотлох баримтыг цуглуулах, бүрдүүлэх бүрэн эрхийг тодорхой зохицуулах нь зүйтэй.
4. Хүсэлтийг компани эсхүл үүргийн гүйцэтгэл шаардах эрх бүхий этгээд гаргасан эсэхээс хамаарч нотлох үүргийн ялгаатай хуваарилалтыг Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуульд тусгаж болохоор байна. Тухайлбал, уг хуульд “Үүргийн гүйцэтгэлийг шаардах эрх бүхий этгээд хуулийн этгээдийг дампуурсанд тооцох хүсэлт гаргасан тохиолдолд шаардаж буй үүргийн гүйцэтгэл болон дампууруулах үндэслэлийн үнэн бодит байдлыг нотлох үүрэгтэй” гэж нэмэх боломжтой.
5. Дампуурлын хэрэг үүсгэснээс хойш хүсэлт гаргагч нь Дампуурлын тухай хуулийн 7 дугаар зүйлд заасан хүсэлтэд хавсаргах баримтыг хавсаргаагүй буюу бүрдүүлбэр дутуу байх нөхцөл байдал үүссэн нөхцөлд шүүгчээс мөрдөн шалгах зарчмыг хэрэгжүүлж, талуудаас нотлох баримтыг

гаргуулах ажиллагааг явуулах, хэргийг удирдах бүрэн эрхээ хэрэгжүүлэх нь зүйтэй. Харин энэ бүрэн эрхээ хэрэгжүүлээгүйн улмаас үндэслэлгүй шийдвэр гаргасан тохиолдолд дээд шатны шүүхээс шийдвэрийг хүчингүй болгож, дахин шийдвэрлүүлэх буцаах арга хэмжээг авах нь зүйтэй.

6. Хариуцагч компани төлбөрийн чадваргүй болсонтой холбоотойгоор тухайн компанид хохирол нөхөн төлөх үүрэг бүхий компанийн эрх бүхий албан тушаалтан байгаа эсэх асуудал болон Компанийн тухай хуулийн 9.5 болон 6.6-д заасны дагуу өрийг давхар болон хамтран хариуцах этгээдүүд байгаа эсэх асуудлыг шүүхийн өөрийн санаачилга болон хэрэг гүйцэтгэгчийн хүсэлтээр хянан шийдвэрлэх талаар Дампуурлын тухай хуульд тусгаж өгөх шаардлагатай.
7. Дампуурсанд тооцох хүсэлтийг хэрэгсэхгүй болгох үндэслэлийг хуульчлаагүйн улмаас шүүх бүр өөр өөр үндэслэлээр хэрэгсэхгүй болгож байгааг анхаарах шаардлагатай. Ялангуяа, дампуурсанд тооцож, татан буулгах ажиллагааг урвуугаар ашиглах боломжийг хаах явдал маш чухал юм. Жишээ нь БНСУ-ын хувьд Үүрэг гүйцэтгэгчийн дахин хөрөнгөжүүлэлт болон дампуурлын тухай хуулийн 309 дүгээр зүйлд дампуурсанд тооцож, татан буулгах тухай хүсэлт, нэхэмжлэлийг хэрэгсэхгүй болгох үндэслэлийг тусгасан байдаг бөгөөд 309 дүгээр зүйлийн 2-т зааснаар “шүүх үүрэг гүйцэтгэгчийг дампуурсан тооцож, татан буулгах үндэслэл тогтоогдсон байсан ч үүрэг гүйцэтгэгч дампуурсанд тооцож татан буулгах ажиллагааг урвуулан ашиглах гэж байна хэмээн үзсэн тохиолдолд мөрдөн шалгах ажиллагаа явуулсны үндсэн дээр хариуцагчийн хүсэлтийг хэрэгсэхгүй болгож болно” гэж заасан байдаг. Монгол Улсын хувьд ч гэсэн ижил агуулгатай зохицуулалт оруулж ирснээр нэг талаас үндэслэл бүхий шалтгаанаар шүүх хүсэлтийг хэрэгсэхгүй болгох, нөгөө талаас Эрүүгийн хууль,

Зөрчлийн тухай хуулийн зохицуулалттай уялдах, тэдгээр зохицуулалтууд амь ороход ач холбогдолтой юм. Иймээс хуульд заасан үндэслэл, шалтгаангүйгээр, тааварлах байдлаар дүгнэлт хийж дампуурсанд тооцож татан буулгах тухай хүсэлтийг хэрэгсэхгүй болгож байгаа нөхцөлийг залруулах шаардлагатай.

8. Хариуцагч компанийн төлбөрийн чадвартай эсэхийг зөвхөн анхан шатны шүүх тогтоох бөгөөд ийнхүү тогтоохдоо дор хаяж дараах арга хэмжээг авна. Үүнд:

- *Санхүүгийн байдлын үнэлгээ:*

- а. Санхүүгийн тайлан: компанийн хөрөнгө болон өр төлбөрт дүн шинжилгээ хийнэ.
- б. Орлогын тайлан: орлого, зарлагыг шинжилж, үйл ажиллагааны алдагдал байгаа эсэхийг тогтооно.
- в. Мөнгөн гүйлгээний тайлан: бизнесийн үйл ажиллагаанд бэлэн мөнгөний гүйлгээний урсгал хэр байгааг шинжилнэ.
- г. Бэлэн мөнгөний нөөц: компанид бэлэн мөнгө болон түүнтэй адилтгах хөрөнгийн нөөц хэр байгааг тогтооно.
- д. Хөрвөх чадвар: богино хугацаанд бэлэн мөнгө рүү хөрвөх чадвар бүхий хөрөнгийн хэмжээ хэр байгааг үнэлнэ.
- е. Зээлжих зэрэглэл: компанийн зээлжих зэрэглэл болон гадаад санхүүжилтийн боломжуудыг үнэлнэ.
- ж. Өрийн бүтцийн үнэлгээ: хугацаа дуусаж буй өрийн бүтэц, хүү, эргэн төлөгдөх нөхцөл зэрэгт дүн шинжилгээ хийж бусдын өмнө хүлээсэн үүргээ биелүүлэх чадварыг үнэлнэ.
- з. Хөрөнгийн үнэлгээ: компанийн нийт хөрөнгийг зах зээлийн бодит үнэ тусгасан байдлаар дахин үнэлнэ.

- *Үйл ажиллагааны байдлын үнэлгээ:*
 - а. Борлуулалтын гүйцэтгэл: сүүлийн үеийн борлуулалтын гүйцэтгэлд дүн шинжилгээ хийж, тогтвортой үйл ажиллагаагаа үргэлжлүүлэх боломжтой эсэхийг үнэлнэ.
 - б. Томоохон харилцагч үнэлэх: гол гүйлгээ болон гэрээнүүдийн хэрэгжилт, үргэлжлэх боломжийг үнэлнэ.
 - в. Удирдлагын ур чадвар: компанийн үйл ажиллагааг амжилттайгаар удирдаж явах чадвар байгаа эсэхэд үнэлэлт өгнө.

Ийнхүү анхан шатны шүүх нь компанийн засаглал, санхүү, бизнесийн үйл ажиллагааны талаар нарийн дүн шинжилгээ хийсний үндсэн дээр нэгд, санаатай дампуурал гэх мэт урвуулан ашиглах зорилго хүсэлт гаргагчид байгаа эсэх, хоёрт, хариуцагч компани нь төлбөрийн чадвартай эсэхийг тогтоодог. Үүнийг хууль эрх зүйн чиглэлээр мэргэшсэн шүүгч дангаараа хийх боломжгүй учир шүүгч нь мөрдөн шалгах зарчмын хүрээнд холбогдох этгээдүүдээс нотлох баримт шаардах, шинжээч томилох, түр хэрэг гүйцэтгэгч томилж, мэргэжлийн туслалцаа авах ажиллагаануудыг авч хэрэгжүүлэх шаардлагатай.

АШИГЛАСАН ЭХ СУРВАЛЖ

Хууль тогтоомж, ном, судалгааны эмхэтгэл:

1. Дампуурлын тухай хууль, 1992
2. Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль, 2002
3. Иргэний хууль, 2002
4. Компанийн тухай хууль, 2011
5. ОХУ-ын Төлбөрийн чадваргүйдэл (дампуурал)-ийн тухай хууль, 2002
6. Монгол Улсын Дээд Шүүх, “Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн тайлбар”, 2014
7. Шүүхийн сургалт, судалгаа, мэдээллийн хүрээлэн “Иргэний хэргийн шүүхийн шүүгчдийн сургалтын гарын авлагын эмхэтгэл”, 2022
8. ХБНГУ-ын Ханнс-Зайделийн сангийн Монгол дах төлөөлөгчийн газар, Эрх зүйн боловсрол академи “Монгол Улсын Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн хялбаршуулсан тайлбар”, 2013
9. Б.Буянхишиг “Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх эрх зүй”, 2021

10. 김경옥 (2010) 파산신청의 원인으로서의 채무초과 - 2008년 독일의 채무초과 규정의 개정내용을 중심으로 -, 민사집행법연구,
11. 이무룡(Lee Mooryung). “법인파산절차 남용에 관한 연구 - 판례의 동향, 일본의 연구와 판례, 권리남용금지원칙에 기초하여 -.” 저스티스 -.176, 2020.
12. 최준선, “회사법”, 삼영사, 2017.

Цахим эх сурвалж:

1. <https://www.judcouncil.mn/site/news/7>
2. Монгол Улсын Шүүхийн шийдвэрийн цахим сан (shuukh.mn)
3. <https://legalinfo.mn/mn/detail?lawId=300071&showType=1>
4. https://www.consultant.ru/document/cons_doc_LAW_39331/7bfbd798d41c90791dfc0fe4dc91d70a1d54c580/
5. <https://cyberleninka.ru/article/n/osoboe-proizvodstvo-priroda-osobennosti/viewer>

2

ШААРДАХ ЭРХ ШИЛЖҮҮЛЭХ ГЭРЭЭТЭЙ ХОЛБООТОЙ МАРГААН ШИЙДВЭРЛЭСЭН ШҮҮХИЙН ШИЙДВЭРТ ХИЙСЭН ДҮН ШИНЖИЛГЭЭ

СУДЛААЧДЫН ТАНИЛЦУУЛГА



Б.БУЯНХИШИГ (PH.D./ ASS.JURI)

МУИС-ийн ХЗС-ийн багш

Хувийн эрх зүй, гэрээний эрх зүй, үнэт цаасны эрх зүйн сэдвээр хичээр орж, судалгаа хийдэг. МХХ-ны гишүүн өмгөөлөгч бөгөөд Өмгөөллийн “Өү Ти Партнерс” ХХН-ийн зөвлөх хуульч, Law in Action улирал тутмын сэтгүүлийн ерөнхий редакторын албыг хавсран хашдаг болно.

Тэрээр ХБНГУ-ын Алберт Людовигийн нэрэмжит Фрайбургийн их сургуулийг хуульч мэргэжлээр, МУИС-ийн Хууль зүйн сургууль болон ХБНГУ-ын Хагены их сургуульд тус тус магистрын зэрэг, 2021 онд МУИС-ийн ХЗС-д Хууль зүйн докторын зэрэг хамгаалсан болно.

Судлаачид

Ахлагч:
Б.Буянхишиг

Багийн гишүүн:
Б.Цэвээндэмбэрэл



БОЛДЫН ЦЭВЭЭНДЭМБЭРЭЛ

Монголын Өмгөөлөгчдийн холбооны гишүүн, өмгөөлөгч Б.Цэвээндэмбэрэл нь МУИС-ийн Хууль зүйн сургуулийг 2018 онд эрх зүйн бакалавр зэрэгтэйгээр төгсөж, 2021 онд хууль зүйн магистрын зэрэг хамгаалсан. 2018 оноос одоог хүртэл өмгөөллийн “Өү Ти Партнерс” ХХН-д хуульч, өмгөөлөгчөөр ажиллаж байгаагийн зэрэгцээ МУИС-ийн Хууль зүйн сургуульд цагийн багшаар ажиллаж байсан туршлагатай.

АГУУЛГА

ТОВЧИЛСОН ҮГСИЙН ЖАГСААЛТ.....	101
ТАЛАРХАЛ.....	102
УДИРТГАЛ.....	103
НЭГ. ШААРДАХ ЭРХИЙН ШИЛЖҮҮЛЭГ БОЛОН ГЭРЭЭНИЙ ҮНДСЭН ДЭЭР ШААРДЛАГА ШИЛЖИХТЭЙ ХОЛБООТОЙ МОНГОЛ УЛСЫН ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТ	106
1.1. Шаардах эрхийн шилжүүлэг, түүний хуульчлагдсан байдал	106
1.2. Гэрээгээр шаардах эрх шилжих эрх зүйн зохицуулалтын урьдчилсан нөхцөл, үүсэх эрх зүйн дагавар	114
ХОЁР. ШҮҮХИЙН ШИЙДВЭРИЙН ДҮН ШИНЖИЛГЭЭ	117
2.1. Хэлцлийн үндсэн дээр шаардах эрх шилжихэд тавигдах шаардлага	119
2.1.1. Шаардах эрх шилжүүлэх гэрээ	119
2.1.2. Шаардах эрх үүссэн, дуусгавар болоогүй, тодорхой байх шаардлага	123
2.1.3. Шаардах эрхийг шилжүүлэх боломжтой байх.....	137

2.2. Хэлцлийн үндсэн дээр шаардах эрх шилжсэний эрх зүйн үр дагавар.....	158
2.2.1. Хуучин үүрэг гүйцэтгүүлэгчийн эрх дуусгавар болж, шинэ үүрэг гүйцэтгүүлэгч шаардах эрхийн эзэн болох.....	158
2.2.2. Бусад эрх, баталгаа шилжих.....	161
2.2.3. Үүрэг гүйцэтгэгч шинэ үүрэг гүйцэтгүүлэгчийн эсрэг хэрэгжүүлэх боломжтой болох	171
2.3. Үүрэг гүйцэтгэгчийг хамгаалах арга хэрэгсэл.....	173
ДҮГНЭЛТ, САНАЛ.....	176
АШИГЛАСАН ЭХ СУРВАЛЖ.....	180

ТОВЧИЛСОН ҮГСИЙН ЖАГСААЛТ

ББСБ	Банк бус санхүүгийн байгууллага
ИХТА	Иргэний хуулийн тусгай анги
ИХШХШТХ	Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль
МУ	Монгол Улс
СЗХ	Санхүүгийн зохицуулах хороо
ХБНГУ	Холбооны Бүгд Найрамдах Герман Улс
ХЗХ	Хадгаламж зээлийн хоршоо
ЭХЭУБтХ	Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн тухай хууль

ТАЛАРХАЛ

Шүүхийн шийдвэрийн дүн шинжилгээ төслийг санаачлан хэрэгжүүлж энэхүү судалгааны бүтээлийг санхүүжүүлсэн Нээлттэй Нийгэм Форум ТББ-ын хамт олонд гүн талархал илэрхийлье.

2017 оноос шүүхийн хараат бус байдлыг бэхжүүлэх хөтөлбөрийн хүрээнд цувралаар хэвлэгдэж буй “Шүүхийн шийдвэрийн судалгаа”, “Шүүхийн шийдвэрийн дүн шинжилгээ” цуврал бүтээлүүд нь хэдийнээ эрх зүйн салбарын судлаачдын төдийгүй өмгөөлөгч, прокурор, шүүгчдийн хүлээн уншдаг, судалдаг бүтээл болсон билээ.

Хэдийгээр манай улсын хувьд эрх зүйн тогтолцооноос хамаараад Англи-Саксоны эрх зүйн тогтолцоотой улс орнуудтай адилаар ижил, төстэй хэрэг маргааныг хянан шийдвэрлэсэн шүүхийн шийдвэрийг шууд эрх зүйн эх сурвалжид тооцдоггүй боловч ийнхүү шүүхийн шийдвэрт тогтмол шинжилгээ, судалгаа хийх нь холбогдох эрх зүйн хэм хэмжээний хийдэл, дутагдлыг нээн илрүүлэх, шүүгчийн ур чадварыг нэмэгдүүлэх, хуулийн зохицуулалтыг зөв тайлбарлан хэрэглэхэд хувь нэмрээ оруулж буйд хувь судлаачдын зүгээс итгэдэг.

Цаашид ч Нээлттэй Нийгэм Форумын хамт олныг энэхүү төслөө үргэлжлүүлнэ гэдэгт найдаж байна.

*Судлаач Б.Буянхушиг Ph.D. Ass.juri
Б.Цэвээндэмбэрэл LL.M.*

УДИРТГАЛ

Шаардах эрхтэй хамт шилжиж буй бусад эрхийн талаарх маргаан практикт түгээмэл гарч байгаа нь дараах хэдэн шалтгаантай. Үүнд: нэгдүгээрт, шаардах эрх шилжүүлэх харилцааг зохицуулах эрх зүйн хэм хэмжээ бүрэн бус, дутмаг байгаа, хоёрдугаарт шаардах эрх бүхий этгээдийн эрхээ хэрэгжүүлэхтэй холбоотой **эрх зүйн ухамсрын байдал** харилцан адилгүй төлөвшсөн, эрх зүйн хуучин уламжлалд тулгуурлан эрхээ хэрэгжүүлэхийг эрмэлздэгтэй холбоотой. Иймээс судалгааны баг эдгээр практик эрх зүйн асуудлыг дутагдалтай байгаа эрх зүйн зохицуулалтыг тодорхойлох, Иргэний хуулийн шаардах эрх шилжүүлэхтэй холбоотой зохицуулалтыг сайжруулах, боловсронгуй болгох санал боловсруулан танилцуулах замаар шийдвэрлэхийг зорилоо. Энэхүү зорилгодоо цөөн тохиолдолд харьцуулсан эрх зүйн үүднээс дүн шинжилгээ хийх, эрх зүйн ухамсрын түвшинд шаардах эрхийг шилжүүлэх хэлцэл, түүний үр дагаврыг хүлээн зөвшөөрөх, маргаантай тохиолдолд эрх өөрчлөхөд чиглэсэн харьцангуй эрхийг хэрэгжүүлэх эрх зүйн арга хэрэгслийг (**legal remedy**) зөв төлөвшсөн эсэхийг нягтлах, нэхэмжлэлийн хэлбэрийг зөв тодорхойлж байгаа эсэхийг тогтоох хүрээнд шүүхийн шийдвэрүүдэд дүн шинжилгээ хийх замаар хүрэхийг эрмэлзлээ.

Судалгааг хийж гүйцэтгэхдээ түүвэр судалгаа, формал логик, харьцуулалтын аргыг тус тус ашиглалаа. Энэхүү судалгааны хүрээнд дүн шинжилгээ хийсэн анхан шатны шүүхийн шийдвэр, давж заалдах шатны шүүхийн магадлал, хяналтын шатны шүүхийн тогтоолыг сонгохдоо Монгол Улсын шүүхийн шийдвэрийн цахим сан www.shuukh.mn цахим хуудаснаас хоёр үе шаттайгаар

шүүхийн шийдвэрүүдийг түүвэрлэн авсан болно. Эхний шатанд нийт 1551 шийдвэрийг түүвэрлэн шалгасан бөгөөд хоёр дах шатанд 70 шийдвэрийг түүвэрлэснээс тодорхой шалгуурын дагуу 14 жишиг хэргийг сонгон авч дүн шинжилгээ хийсэн болно.

Дээрх жишиг шүүхийн шийдвэрээр хянан шийдвэрлэгдсэн маргааны төрөл ангиллын хувьд өөр өөр ангилалд хамаарч байв. Энэ нь шаардах эрх шилжүүлэх гэрээгээр шилжиж буй шаардлага хууль эсхүл гэрээ хэлцлийн үндсэн дээр үүсэх боломжтой байдаг ба www.shuukh.mn цахим сангийн хувьд¹ тухайн шаардах эрхийг үндэслэж буй эрх зүйн зохицуулалтын Иргэний хууль дах байршлаас хамаарч ангилдагтай холбоотой.

Жишээ нь А нь Б-ээс 1,000,000 төгрөг төлөхийг шаардах эрхтэй бөгөөд тэрээр уг шаардлагаа В-д гэрээгээр шилжүүлсэн гэж үзье. Тухайн тохиолдолд А-ийн өмнө 1,000,000 төгрөг төлөх Б-ийн үүрэг нь худалдах, худалдан авах гэрээний хариу төлбөр үү эсхүл А-д гэм хор учруулсны улмаас үүссэн хохирол арилгах үүрэг үү гэдгээс шалтгаалан “Худалдах-худалдан авах болон арилжааны гэрээ” эсхүл “гэм хор учруулснаас гаргуулсан эд хөрөнгийн хохирол” маргааны төрөл болгон ангилдаг.

Хүснэгт 1. Жишиг шүүхийн шийдвэрүүд дэх маргааны ангилал

Д/д	Маргааны төрөл	Тогтоолын агуулга
1	Бусад зээл	1
2	Худалдах-худалдан авах болон арилжааны гэрээ	1
3	Гэм хор учруулснаас гаргуулсан эд хөрөнгийн хохирол	2
4	Үндэслэлгүйгээр хөрөнгөжих	1
5	Барьцаалан зээлдүүлэх байгууллагын зээл, бусад зээл	1
6	Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулиар бусад	1
7	Банкны зээл	3
8	Бусад хуулиар	2
9	Ажил гүйцэтгэх гэрээ	1

¹ Шүүхийн ерөнхий зөвлөлөөс шүүн таслах ажиллагааны тайлан, мэдээг бэлтгэхдээ мөн дээрх ангиллыг ашигладаг

Гэхдээ ийнхүү өөр өөр ангилалд хамаарч буйг үл харгалзан жишиг шийдвэрүүдэд дурдагдаж буй маргааны харилцаа нь үүрэг гүйцэтгүүлэгч солигдсон буюу шаардлагын шилжүүлэгтэй холбоотой эрх зүйн харилцааг онцоллоо.

Жишиг шийдвэрүүдэд дүн шинжилгээ хийхдээ формаль логикийн арга түүний дотор анализ буюу задлан шинжлэх, синтез буюу нэгтгэн дүгнэх болон индукцийн аргыг дараах байдлаар ашигласан:

- Анализ буюу задлан шинжлэх - шүүхийн шийдвэр, магадлал, тогтоолоос тухайн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад нотлох баримтаар тогтоогдсон гэх үйл баримт маргааны агуулга, судалгаанд хамаарал бүхий эрх зүйн харилцааг хуулийн хийсвэр хэм хэмжээтэй нийцүүлэн хэрэглэсэн байдал, шүүхийн шийдэл хэсгийг тус тус ялган авч дүгнэх;
- Индукц - шүүхийн шийдвэрийг түүвэрлэх, жишиг шүүхийн шийдвэрүүдийг сонгох явцад ажиглагдсан тухайлсан эрх зүйн маргааныг хянан шийдвэрлэхдээ шүүхээс баримталж буй нийтлэг байр суурийг тодорхойлж, тэдгээрийг төлөөлөх нэг буюу хэд хэдэн шүүхийн шийдвэрийн сонгон авч дүгнэх;
- Синтез буюу нэгтгэн дүгнэх - шүүхийн шийдвэр дэх маргааны үйл баримт болон шүүхийн шийдлийг харьцуулах, нэгтгэх замаар шүүхээс хуулийн зохицуулалтын агуулгыг хэрхэн тайлбарлаж буйг дүгнэх².

Судалгааны өмнөх шатуудад ажиглагдсан Монгол Улсын хэлцлийн үндсэн дээр шаардлага шилжүүлэхэд **“эрх зүйн зохицуулалтын дутмаг байдал”** ажиглагдсаныг ХБНГУ-ын холбогдох хуулийн зүйл заалт, баримтлах үндсэн зарчим, онолын ойлголттой уялдуулан дүгнэх, зохицуулалт санал болгоход харьцуулалтын аргыг ашигласан болно.

² Цөөнгүй тохиолдолд шүүхээс хэрэг маргааныг хянан шийдвэрлэхдээ иргэний хуулийн холбогдох зүйл хэсэгтэй “нийцэж байна” эсхүл “нийцээгүй байна” гэж товч дүгнэсэн байх тул дээрх аргачлалыг ашигласан.

НЭГ. ШААРДАХ ЭРХИЙН ШИЛЖҮҮЛЭГ БОЛОН ГЭРЭЭНИЙ ҮНДСЭН ДЭЭР ШААРДЛАГА ШИЛЖИХТЭЙ ХОЛБООТОЙ МОНГОЛ УЛСЫН ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТ

1.1. ШААРДАХ ЭРХИЙН ШИЛЖҮҮЛЭГ, ТҮҮНИЙ ХУУЛЬЧЛАГДСАН БАЙДАЛ

Шаардах эрх хэмээх ойлголтыг Иргэний хуулийн 86.1-д бусдаас аливаа үйлдэл, эс үйлдэхүйг шаардан нэхэмжлэх боломж бүхий хэм хэмжээ хэмээн тодорхойлсон байдаг³. Үүнд юуны өмнө ИХШХШТХ-ийн 63.1-д дурдагдсан эд хөрөнгө, мөнгөн төлбөр зэргийг гаргуулах агуулга бүхий гүйцэтгэлд чиглэсэн нэхэмжлэлийн шаардлага хамаарахаас гадна ИХ-ийн 174.1, 135.1 гэх мэт хүлцэн тэвчих үүргийг хамруулан ойлгодог. Шүүхээр хэрэгжүүлэх боломж бүхий энэхүү субъектив эрхийн тогтолцоог илтгэх шаардах эрх нь оюуны үнэт зүйл, зохиогчийн эрхийн адил эдийн бус хөрөнгийн ангилалд багтдаг бөгөөд ИХ-ийн 83.1-д зааснаар бусад эд хөрөнгийн нэгэн адилаар шаардах эрхийг нэг этгээдээс нөгөөд шилжүүлэх, үүргийн гүйцэтгэлийг хангах зорилгоор барьцаалах зэргээр эрх зүйн гүйлгээнд оруулах бүрэн боломжтой.

Шаардах эрхийн шилжүүлэг (assignment) гэдэгт уг эрхийг нэг этгээдээс нөгөөд шилжүүлэх замаар эрхийн харьяаллыг өөрчлөх, үр дүнд нь тухайн шаардлагын өмчлөгч болох үүрэг гүйцэтгүүлэгч өөрчлөгдөхийг ойлгоно. Энэ нь өр шилжих (transfer of obligation)

³ Иргэний эрх зүй ерөнхий анги, Б.Тэмүүлэн, Д.Энхзул, Б.Буянхшиг, Монгол Улс, Улаанбаатар хот, Мөнхийн үсэг групп, 2010, 210 дах тал.



болон үүрэг солих, гэрээ шилжих (novation) эрх зүйн ойлголтоос ялгаатай. Тухайлбал, өр шилжихэд тухайн үүргийн харилцааны үүрэг гүйцэтгэгч өөрчлөгдөх бол үүрэг солиход үүрэг гүйцэтгэгч, үүрэг гүйцэтгүүлэгч нар хэвээр байх боловч талуудын хэлэлцэж тохирсон өмнөх үүрэг, шинэ үүргээр солигддог.

Хүснэгт 2. Үүргийн харилцаанд үзүүлэх өөрчлөлт

	Үүрэг гүйцэтгүүлэгч	Үүрэг гүйцэтгэгч	Үндсэн үүрэг
Шаардлага шилжих	өөрчлөгдөнө	хэвээр үлдэнэ	хэвээр үлдэнэ
Өр шилжих	хэвээр үлдэнэ	өөрчлөгдөнө	хэвээр үлдэнэ
Үүрэг солих	хэвээр үлдэнэ	хэвээр үлдэнэ	өөрчлөгдөнө

Харин гэрээ шилжих тохиолдолд дан ганц шаардах эрх төдийгүй тухайн гэрээний нөгөө талдаа хүлээсэн үүрэг хамтдаа шинэ этгээдэд шилждэг ба гэрээний нэг тал өөрчлөгддөг илүү өргөн цар хүрээтэй ойлголт юм. Одоогоор гэрээ шилжих талаар манай улсын Иргэний хуульд дэлгэрэнгүй тусгагдаагүй. Монгол Улсад гэрээг “*juris vinculum inter personas*” буюу гэрээ нь талуудын хооронд үүссэн хязгаарлалт бүхий холбоос⁴ гэж үздэг Ром-Германы эрх зүйн бүлд хамаардаг. Гэрээ шилжих харилцаанд ч мөн хэд хэдэн эрх болон шаардах эрхийг шилжүүлэх асуудал гардаг.

Эрх зүйн харилцаанд шаардах эрхийг хариу төлбөртэй шилжүүлбэл энд худалдах-худалдан авах гэрээ байгуулагдах ба ИХ-ийн 260 дугаар зүйлийн эрх худалдах, худалдан авах гэрээний үүргийн зохицуулалт үйлчилнэ. Түүнчлэн шаардах эрхээ арилжих (ИХ-ийн 274), бэлэглэх (ИХ-ийн 276), харилцан өрөндөө тооцуулах (ИХ-ийн 238) зэргээр гүйлгээнд оруулах боломжтой. Шаардах эрх шилжүүлэх суурь хэлцлийн гүйцэтгэлийг хууль тогтоогч

⁴ Marcus Baum, Dr.iur., M.Jur. (Oxford), Attorney in Stuttgart. 2021. Transfer of Contract. 14 10.

ИХ-ийн 123⁵ дугаар зүйлд зохицуулсан. Өөрөөр хэлбэл, биет бус шинжтэй эрхийг шилжүүлэх causa буюу шалтгаан үндэслэлийг агуулсан үүргийн хэлцэл, түүний гүйцэтгэлийг хангах зорилго бүхий өмчийн хэлцэл хэмээн ялгах боломжтой. Түүнчлэн шаардах эрхийг шилжүүлсэн суурь хэлцлийг хийлгүй, шаардлагыг гүйцэтгэлд тооцож өгөх зэргээр шууд ИХ-ийн 123 дугаар зүйлд заасан эд юмсын эрх зүйн шинжтэй хэлцэл хийх нь элбэг. Тиймээс энд шаардах эрх шилжүүлэх гэрээний хоёрдмол шинж, түүний практик хэрэглээг судлах нь эрх зүйн харилцаанд илүү тодорхой байдлыг бий болгоно хэмээн итгэж, энэхүү судалгааг хийж байна.

Үүргийн хэлцлийн хүрээнд шаардлага шилжих шалтгаан, хэмжээ зэргийг заадаг ч ИХ-ийн 123 дугаар зүйлд мөн үүний урьдчилсан нөхцөл, шилжсэнээс хойших үр дагавар, үүрэг гүйцэтгэгчийг хамгаалах арга хэрэгслийг тодорхойлсон байдаг. Шаардах эрхийн харьяаллыг үүргийн хэлцэл суурьтай шилжүүлэхэд ИХ-ийн 123 дугаар зүйлд нь шууд үйлчлэх бол үүнийг хуульд зааснаар (*legal*

⁵ МУ-ын ИХ-ийн 123. Шаардах эрхээ шилжүүлэх:

- 123.1. Шаардах эрх шилжих тухай үүрэг гүйцэтгэгчид мэдэгдэх хүртэл үүрэг гүйцэтгэгч анхны үүрэг гүйцэтгүүлэгчийн өмнө гэрээгээр хүлээсэн үүргээ гүйцэтгэнэ.
- 123.2. Хууль, гэрээ буюу үүргийн мөн чанарт харшлахгүй бол шаардах эрх эзэмшигч нь гуравдагч этгээдтэй байгуулсан гэрээний үндсэн дээр үүрэг гүйцэтгэгчийн зөвшөөрөлгүйгээр шаардах эрхээ шилжүүлж болно.
- 123.3. Үүрэг гүйцэтгэгчийн эрх, хууль ёсны ашиг сонирхол хөндөгдөхөөр бол шаардах эрх шилжүүлэхийг гэрээгээр хязгаарлаж болно.
- 123.4. Үүрэг гүйцэтгэгч нь шаардах эрх шилжих тухай мэдэгдэл хүлээн авах үеийн бүх татгалзал, хариу шаардлагыг шинэ үүрэг гүйцэтгүүлэгчид гаргах эрхтэй.
- 123.5. Үүрэг гүйцэтгэгч нь үүргийг гүйцэтгэснээр тооцох тухай шаардлагыг шаардах эрх шилжихээс өмнө анхны үүрэг гүйцэтгүүлэгчид гаргаж байсан бол энэхүү шаардлагаа шинэ үүрэг гүйцэтгүүлэгчид гаргаж болно.
- 123.6. Шаардах эрхийг шинэ үүрэг гүйцэтгүүлэгчид шилжүүлснээр түүнтэй холбоотой бусад эрх болон түүнийг хангах арга нэгэн зэрэг шилжинэ.
- 123.7. Шаардах эрх бүхий этгээд уг эрхээ шилжүүлэхээр хэд хэдэн этгээдтэй хэлэлцэн тохирсон бол шаардах эрх эзэмшигчтэй хамгийн түрүүнд хэлэлцэн тохирсон этгээд үүрэг гүйцэтгэгчийн өмнө шаардах бүрэн эрхтэй байна. Түрүүлж тохирсон этгээдийг тогтоох боломжгүй бол үүрэг гүйцэтгэгчид түрүүлж мэдэгдсэн этгээдэд шаардах эрх шилжсэн гэж үзнэ.
- 123.8. Хууль буюу гэрээнд заасан хэлбэрээр хийх хэлцлийн хувьд шаардах эрхийг шилжүүлэхдээ уг хэлцлийг хийсэн хэлбэрээр шилжүүлнэ.
- 123.9. Хуульд зааснаар буюу төрийн эрх бүхий байгууллага, шүүхийн шийдвэрийн үндсэн дээр шаардах эрхээ шилжүүлэхэд энэ зүйлд заасан журам нэгэн адил хамаарна.

cessio) эсвэл захиргааны шийдвэрийн үндсэн дээр шилжүүлэхэд нэгэн адил үйлчилнэ.

Хуулийн үндсэн дээр шаардах эрх шилжих (*legal cessio*) тохиолдлыг Иргэний хууль болон бусад хуулиудад тусгайлан зохицуулсан. Жишээ нь, ИХ-ийн 443.7-д “Даатгуулагч учирсан гэм хорыг нөхөн төлөх шаардлагыг гуравдагч этгээдэд гаргаж болох тохиолдолд даатгагч уг гэм хорыг даатгуулагчид нөхөн төлснөөр шаардах эрх даатгагчид шилжинэ” гэж, ИХ-ийн 210.4-д “Үүрэг гүйцэтгэгчийн эд хөрөнгөөс үүргийг албадан гүйцэтгүүлэхээр бол тухайн эд хөрөнгийн хувьд эрхээ алдаж болзошгүй гэж үзсэн этгээд нь үүрэг гүйцэтгүүлэгчийн шаардлагыг хангах эрхтэй. Энэ тохиолдолд үүрэг гүйцэтгүүлэгчийн шаардах эрх үүргийн гүйцэтгэлийг хангасан гуравдагч этгээдэд шилжинэ” хэмээн тус тус хуульчилжээ.

Энэхүү судалгааны хүрээнд хэлцлийн үндсэн дээр шаардах эрх буюу авлага шилжүүлэх бизнесийн үйл ажиллагааны хэлбэрт түлхүү анхаарал хандуулах болно. Үүнийг факторингийн үйлчилгээ гэх ба Банк бус санхүүгийн үйл ажиллагааны тухай хуулийн 4.1.2-т “факторингийн үйлчилгээ нь зээлдүүлэгч буюу үүрэг гүйцэтгүүлэгчээс мөнгөн төлбөрийн үүргийг шаардах эрхээ гуравдагч этгээдэд бүхэлд нь худалдах буюу шилжүүлэх, энэхүү эрхийг хүлээн авагч нь эрхээ хэрэгжүүлэх болон үүсэн гарах үр дагаврыг бүрэн хариуцах үйл ажиллагааг ойлгоно” хэмээн томъёолж, Зөвшөөрлийн тухай хуулийн 2.11-ээр зүйл хэсгээр Санхүүгийн зохицуулах хорооноос олгосон тусгай зөвшөөрлийн үндсэн дээр эрхлэх үйл ажиллагаа байхаар тогтоосон.

Шаардах эрх нь биет бус хийсвэр ойлголт учир түүний бодит эзэмшлийг хэн нэгний эрх мэдэлд бүрэн шилжүүлж хүлээлгэн өгөх боломжгүй. Тиймээс шаардах эрх шилжих гэрээний урьдчилсан нөхцөл хангагдмагц түүний өмчлөх эрх шилжсэнд тооцно. Хууль болон хэлцлийн үндсэн дээр шаардах эрх шилжих үндсэн хоёр хэлбэрийн ялгаа нь харилцан адилгүй урьдчилсан нөхцөл тавигдах байдлаар илэрнэ. Эхний тохиолдолд хуульд заасан тусгайлсан

хэм хэмжээний урьдчилсан нөхцөл бүрдсэн байх ёстой бол удаах тохиолдолд нэг талаас үүрэг гүйцэтгүүлэгч нөгөө талаас гуравдагч этгээд шаардлага шилжүүлэх талаар харилцан тохиролцсон байхад хангалттай.

Дээрх зохицуулалтыг ХБНГУ-ын шаардах эрхийг гэрээгээр шилжүүлэхтэй холбоотой эрх зүйн зохицуулалттай хийсвэр байдлаар шууд харьцуулбал эрх зүйн зохицуулалтын дутмаг байдал ажиглагдах бөгөөд энэ нь хууль хэрэглээний явцад шүүхийн шийдвэр гаргах ажиллагаанд мөн нөлөөлж буйг тэмдэглэх нь зүйтэй.

ХБНГУ-ын зохицуулалт:

Хэсэг 5. Шаардах эрх шилжүүлэх

398 Шаардах эрх шилжүүлэх. Аливаа шаардлагыг үүрэг гүйцэтгүүлэгч гуравдагч этгээдтэй гэрээ байгуулах замаар шилжүүлж болно. Энэхүү гэрээгээр шинэ үүрэг гүйцэтгүүлэгч хуучин үүрэг гүйцэтгүүлэгчийн оронд гэрээний тал болно.

399 Агуулгыг өөрчлөх ба шаардах эрх шилжүүлэхийг хориглох нь. Агуулгыг өөрчлөлгүй шаардах эрхийг шилжүүлэх боломжгүй эсвэл үүрэг гүйцэтгэгчтэй байгуулсан гэрээнд шаардах эрх шилжүүлэхийг хориглосон бол уг шаардлагыг бусдад шилжүүлж үл болно.

400 Битүүмжилж үл болох шаардлагыг шилжүүлж үл болох тухай. Битүүмжилж үл болох хэсгээр шаардлагыг шилжүүлж үл болно.

401 Нэмэлт дагавар болон түрүүнд шаардлагаа хангуулах эрх шилжих тухай

- (1) Шаардах эрх шилжсэнээр ипотекийн барьцаа, усан онгоцны ипотек эсвэл хөдлөх хөрөнгийн барьцаа болон үүнтэй холбоотой батлан даалтын эрх шинэ үүрэг гүйцэтгүүлэгчид шилжинэ.
- (2) Шүүхийн шийдвэр гүйцэтгэл эсвэл дампуурлын хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд дах түрүүлж шаардлагаа хангуулах эрхийг шинэ үүрэг гүйцэтгүүлэгч хэрэгжүүлэх эрхтэй.

402 Мэдээлэл өгөх үүрэг; баримт бичиг нийлүүлэх. Хуучин үүрэг гүйцэтгүүлэгч нь шинэ үүрэг гүйцэтгүүлэгчид шаардах эрхийг хэрэгжүүлэхэд шаардлагатай бүх мэдээллийг, мөн өөрийн эзэмшилд буй шаардлагыг нотлохтой холбоотой баримт бичгийг гаргаж өгнө.

403 Нийтээр гэрчлүүлэх үүрэг. Шинэ үүрэг гүйцэтгүүлэгчийн шаардлагаар хуучин үүрэг гүйцэтгүүлэгч нь шаардах эрх шилжүүлсэн тухайгаа нийтээр гэрчлүүлсэн баримтыг олгоно. Зардлыг үүрэг гүйцэтгүүлэгч хариуцах ба урьдчилан гаргаж өгнө.

404 Үүрэг гүйцэтгэгчийн татгалзах эрх. Үүрэг гүйцэтгэгч нь шинэ үүрэг гүйцэтгүүлэгчид хандан шаардах эрх шилжүүлэх мөчид хуучин үүрэг гүйцэтгүүлэгчийн эсрэг үүссэн байсан бүх татгалзах эрхээ сэргүүлэн тавьж болно.

405 Баримтыг үзүүлэх замаар шаардах эрхийг шилжүүлэх. Үүрэг гүйцэтгэгч өрийн талаар баримт үйлдэж өгсөн бөгөөд үүрэг гүйцэтгүүлэгч энэ баримтыг үндэслэн шаардлагыг шилжүүлсэн бол тэрээр шинэ үүрэг гүйцэтгүүлэгчийн эсрэг үүргийн харилцааг гагцхүү дүр үзүүлэх зорилгоор хүлээн зөвшөөрсөн эсвэл шинэ үүрэг гүйцэтгүүлэгч энэ талаар мэдсэн, мэдэх ёстойгоос бусад тохиолдолд хуучин үүрэг гүйцэтгүүлэгчтэй байгуулсан гэрээгээр шаардах эрх шилжүүлэхийг хориглосон байсан гэсэн хариу эсэргүүцэл гаргаж үл болно.

406 Шинэ үүрэг гүйцэтгүүлэгчийн шаардлагыг тооцож дуусгавар болгох. Үүрэг гүйцэтгэгч нь шаардах эрх олж авах мөчид шилжсэн талаар мэдэж байсан эсвэл шаардлага шилжсэн талаар мэдсэний дараа буюу шилжсэний дараа шаардах эрхийн гүйцэтгэх хугацаа болсон нөхцөлд хуучин үүрэг гүйцэтгүүлэгчийн эсрэг тооцож болох байсан шаардлагаа шинэ үүрэг гүйцэтгүүлэгчийн эсрэг тооцож дуусгавар болгож болно.

407 Шинэ үүрэг гүйцэтгүүлэгчид чиглэсэн эрх зүйн үйлдэл

- (1) Үүрэг гүйцэтгэгч үүргээ гүйцэтгэх, эрх зүйн үйлдэл хийхдээ шаардлага шилжсэн тухай мэдэж байснаас бусад тохиолдолд шинэ үүрэг гүйцэтгүүлэгч нь шаардах эрх шилжсэний дараа үүрэг гүйцэтгэгч хуучин үүрэг гүйцэтгүүлэгчид хандан явуулсан гүйцэтгэл болон аливаа шаардах эрхтэй холбоотой

үүрэг гүйцэтгэгч болон хуучин үүрэг гүйцэтгүүлэгчийн хооронд хийсэн хэлцлийг хүлээн зөвшөөрнө.

- (2) Нэхэмжлэлийг хүлээн авах мөчид үүрэг гүйцэтгэгч шаардах эрхийг шилжүүлсэн тухай мэдэж байснаас бусад тохиолдолд шинэ үүрэг гүйцэтгүүлэгч нь үүрэг гүйцэтгэгч ба үүрэг гүйцэтгүүлэгчийн хоорондын эрх зүйн маргааны явцад гарсан шүүхийн шийдвэрийг хүлээн зөвшөөрнө.

408 Нэг шаардлагыг хэд хэдэн этгээдэд шилжүүлэх

- (1) Шаардах эрхээ шилжүүлсэн үүрэг гүйцэтгүүлэгч уг шаардлагыг ахин гуравдагч этгээдэд шилжүүлсэн бөгөөд үүрэг гүйцэтгэгч гуравдагч этгээдэд хандан гүйцэтгэл явуулсан, эсвэл түүнтэй гэрээ байгуулсан эсвэл тэдгээрийн хооронд иргэний хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа эхэлсэн бол үүрэг гүйцэтгэгчийн тусын тулд энэ хуулийн 407 анх шилжүүлэн авсан этгээдийн эсрэг хэрэглэгдэнэ.
- (2) Шилжүүлсэн шаардлагыг шүүхийн шийдвэрээр гуравдагч этгээдэд оноож өгсөн эсвэл хуучин үүрэг гүйцэтгүүлэгч гуравдагч этгээдэд хандан шаардах эрх хуульд зааснаар гуравдагч этгээдийн өмчлөлд шилжсэн тухай мэдэгдсэн бол дээрх зохицуулалт нэгэн адил үйлчилнэ.

409 Шаардах эрх шилжсэн тухай мэдэгдэл. Үүрэг гүйцэтгүүлэгч нь үүрэг гүйцэтгэгчид хандан шаардах эрх шилжүүлсэн тухайгаа мэдэгдсэн бол шаардах эрх шилжээгүй эсвэл гэрээ хүчингүй байсан ч гэсэн үүрэг гүйцэтгэгчийн хувьд шаардах эрх шилжсэн мэт тооцуулна. Үүрэг гүйцэтгүүлэгч нь шаардах эрх шилжсэн тухай баримт бичиг үйлдсэн ба үүнийгээ үүрэг гүйцэтгэгчид толилуулсан бол мэдэгдэл хийсэнд тооцно.

- (1) Мэдэгдлийг баримт бичигт шинэ үүрэг гүйцэтгүүлэгч хэмээн тусгагдсан этгээдийн зөвшөөрөлтэй буцаан авч болно.

410 Шаардах эрхийг шилжүүлсэн тухай баримтыг гардуулах

- (1) Үүрэг гүйцэтгэгч нь хуучин үүрэг гүйцэтгүүлэгчээс олгосон шаардах эрх шилжүүлэх тухай баримтыг шинэ үүрэг гүйцэтгүүлэгчээс гардан авсны хариуд үүргээ гүйцэтгэнэ.

Энэхүү баримт бичгийг толилуулаагүй эсвэл үүрэг гүйцэтгэгч энэ үндэслэлээр нэн даруй няцаалт хийгээгүй бол шинэ үүрэг гүйцэтгүүлэгчийн цуцалсан эсвэл сануулсан үйлдэл хүчингүй.

- (2) Хуучин үүрэг гүйцэтгүүлэгч үүрэг гүйцэтгэгчид хандан шаардах эрх шилжсэн тухай бичгээр мэдэгдэл хүргүүлсэн бол дээрх зохицуулалт үйлчлэхгүй.

411 Цалин шаардах эрхийг шилжүүлэх. Армийн албан хаагч, төрийн албан хаагч, сүмийн ажилтан болон нийтийн эрх зүйн сургалтын байгууллагын багш нар цалин, хүлээлгийн хөлс, амралтын мөнгөний шилжүүлж болох хэсгийг шилжүүлсэн бол энэ тухай төлбөр хийгч санд хуучин үүрэг гүйцэтгүүлэгчийн гаргаж өгсөн, нийтээр эсвэл албан ёсоор баталгаажуулсан баримт бичгийг гардуулан өгөх замаар мэдэгдэнэ. Ийнхүү мэдэгдэх хүртэл төлбөр хийгч сан шаардах эрх шилжсэн тухай мэдээгүй гэж үзнэ.

412 Хуулиар шаардах эрх шилжих. Хуулийн дагуу шаардах эрхийг шилжүүлэхэд энэ хуулийн 399 bis 404, 406 -410-ыг төсөөтэй хэрэглэнэ.


413 Бусад эрхийг шилжүүлэх. Хуульд өөрөөр заагаагүй бол шаардах эрх шилжүүлэх тухай зохицуулалтууд нь эрх шилжихэд нэгэн адил хэрэглэгдэнэ.

1.2. ГЭРЭЭГЭЭР ШААРДАХ ЭРХ ШИЛЖИХ ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТЫН УРЬДЧИЛСАН НӨХЦӨЛ, ҮҮСЭХ ЭРХ ЗҮЙН ДАГАВАР

ИХ-ийн 123 нь шаардах эрх шилжих үндсэн зохицуулалт бөгөөд гэрээний үндсэн дээр ийнхүү шаардлага шилжихэд шаардах эрх шилжүүлэх гэрээ байгуулагдсан байх, шилжүүлэгч этгээд шаардахын эзэн буюу өмчлөгч байх, шаардах эрх нь тодорхой эсвэл тодорхойлох боломжтой байх, шаардах эрхийг шилжүүлэх боломжтой байх гэсэн үндсэн урьдчилсан нөхцөл хангагдсан байх шаардлагатай.

• Шаардах эрх шилжүүлэх гэрээ

ИХ-ийн 123-д заасан гэрээ нь тухайн шаардах эрх өмчлөгчийг солих үр дагавартай тул шинж чанарын хувьд үүргийн эрх зүйн бус, харин өмчийн эрх зүйн захиран зарцуулах хэлцэл⁶ болно. Иймд энэхүү хэлцлийг шаардах эрх шилжүүлэх харилцаанд холбогдож буй бусад хэлцлээс ялгах шаардлагатай. Тодруулбал, практикт дийлэнх нөхцөлд өмчийн хэлцлийн зэрэгцээ уг өмчийн хэлцэл байгуулагдах үндэслэл болсон суурь хэлцэл давхар хийгддэг. Мөн өмчийн хэлцлээр шилжигдэж буй шаардлага гэрээнээс үүдэлтэй бол нэлээд олон гэрээ, хэлцэл байгуулагдсан харагддаг.



⁶ Улсын Дээд шүүхийн Иргэний хуулийн 12 дугаар бүлгийн 1, 2 дугаар дэд бүлгүүдийн зарим зүйл, заалтыг тайлбарлах тухай тогтоол, дугаар 18, 2009.06.15.

Дээрх зурагт үзүүлсэн жишээнд тулгуурлан тайлбарлавал А болон Z хоорондын харилцаа нь шаардах эрхийг үндэслэж буй үүргийн харилцаа болно. А болон Y нарын байгуулсан үүргийн хэлцэл нь шаардах эрх шилжүүлэх суурь шалтгаан, нөхцөл нь бол Y-г гуравдагч этгээдийн статусаас үүрэг гүйцэтгүүлэгч болгож буй хэлцэл нь өмчийн хэлцэл болно. Хийсвэрлэх зарчим ёсоор үүргийн хэлцлийн хүчин төгөлдөр бус байдал болон гэрээнээс татгалзаж дуусгавар болгох нь өмчийн хэлцлийн хүчин төгөлдөр байдалд нөлөөлөхгүй. Иймээс ИХ-ийн 123-ын дагуу шаардах эрх шилжихэд зөвхөн өмчийн хэлцэл хийгдсэн байхад хангалттай.

Гэхдээ хэлбэрийн хувьд ИХ-ийн 123.8 нь ямар ч хэлбэрийн тусгайлсан шаардлага хуульд тусгагдаагүй бол шаардлагыг үндэслэж буй гэрээний хэлбэрийг баримтлахаар заасан. Жишээлбэл, А болон Z-ийн хооронд байгуулагдсан гэрээ нь бичгээр байгуулагдсан бол А болон Y-ийн хоорондын өмчийн хэлцэл нь зөвхөн бичгээр хийгдсэн байж хүчинтэй болно. Шаардах эрх эзэмшигч нь шаардах эрхээ бусдад шилжүүлэхдээ үүрэг гүйцэтгэгчид энэ талаар мэдэгдэх л үүрэгтэй болохоос түүний зөвшөөрлийг авах, шаардах эрхээ шилжүүлж буй гуравдагч этгээдтэй байгуулсан гэрээний талаар танилцуулах зэрэг ажиллагаа явуулах шаардлагагүй. Харин ИХ-ийн 123.3-д заасны дагуу үүрэг гүйцэтгэгчтэй байгуулсан гэрээнд шаардах эрх шилжүүлэхийг хязгаарлах талаар харилцан тохиролцсон бол шаардах эрхийг шилжүүлэх ажиллагаа тухайн гэрээний дагуу зохицуулагдана.⁷

• **Өмнөх өмчлөгчид шаардах эрх үүссэн байх**

Шаардах эрх нь эд зүйлсийн адил гарт баригдахгүй, нүдэнд үзэгдэхгүй буюу шууд бодит эзэмшилдээ авах боломжгүй тул өмчийн хэлцэл хийгдсэнээр хуучин үүрэг гүйцэтгүүлэгчээс шинэ үүрэг гүйцэтгүүлэгчид шилждэг. Иймд тухайн хэлцэл хийгдэх мөчид хуучин үүрэг гүйцэтгүүлэгчид шаардах эрхийн өмчлөл үүссэн байх буюу шаардах эрх бий болсон байх ёстой.

⁷ Б.Буянхишиг, 2017, 245 дах тал.

• **Шаардах эрх нь тодорхой эсвэл тодорхойлох боломжтой байх**

Шаардах эрхээ шилжүүлж байгаа нь өмчийн эрх зүйн үйлдэл болохын хувьд энэ гэрээнд өмчийн эрх зүйн хөрөнгийн эрх тодорхой байх зарчим мөн адил үйлчилнэ. Учир нь өмчийн эрх зүй нь тодорхой этгээд болон эд зүйлийн хоорондын харилцааг тодорхойлоход чиглэх ба энэ харилцаа нь нийтэд тодорхой байх ёстой. Үндсэндээ аливаа хөрөнгийг нэг буюу хэсэг бүлэг этгээд өмчлөх ба хөдлөх эд хөрөнгийн хувьд нэн ялангуяа нэгдсэн бүртгэл хөтлөгдөх нь бараг үгүй тул үүнтэй холбоо харилцаа бүхий этгээдүүдээс хэн нь эрх бүхий этгээд гэдгийг таних нь бэрхшээлтэй байдаг.⁸ Тиймээс өмчийн хэлцлээр шилжигдэж байгаа шаардах эрх нь хэлцлийн талуудад тодорхой байх эсхүл талууд тодорхойлох боломжтой байх шаардлагатай. Энэ шаардлага хангагдсан нөхцөлд ирээдүйд бий болох шаардах эрхийг ч шилжүүлэх боломжтой⁹.

• **Шаардах эрхийг шилжүүлэх боломжтой байх**

Ердийн нөхцөлд аливаа эрхийг шилжүүлэх бүрэн боломжтой хэдий ч тухайн эрхийн мөн чанараас үүдэн шилжүүлэх боломжгүй тохиолдол гэж байх ба заримдаа энэ талаар хуульд тусгасан байх нь бий¹⁰. ИХ-ийн 123-д заасан шаардлагыг шилжүүлснээр түүний мөн чанарт өөрчлөлт орох эсхүл хуучин үүрэг гүйцэтгүүлэгч, үүрэг гүйцэтгэгч нар шаардлагыг шилжүүлэхгүй байхаар урьдчилан тохиролцсон болон хуулиар хориглосон нөхцөлд тус тус шаардах эрхийг шилжүүлэх боломжгүй байхаар зохицуулжээ. Эдгээр эрх зүйн хязгаарлалт тавигдаагүй байх нь шаардлага шилжих хамгийн сүүлийн урьдчилсан нөхцөл болно.

Ийнхүү шаардах эрх шилжсэний дараагаар үүсэх эрх зүйн үр дагаварт нь үүрэг гүйцэтгэгчийн хамгаалалтын асуудал, мөн шаардлагыг дагаж шилжих эрхийн асуудал яригдана. Энэ хууль хэрэглээний дарааллын дагуу шүүхийн шийдвэрийн legal issue буюу шийдвэрлэх асуудлыг байршуулан судалгааны үр дүнг танилцуулж байна.

⁸ Иргэний хуулийн тайлбар толь: Ерөнхий анги, Улаанбаатар хот, 2006 он, 427 дах тал.

⁹ Иргэний хуулийн тайлбар толь: Ерөнхий анги, Улаанбаатар хот, 2006 он, 426-427 дах тал.

¹⁰ Б.Буянхшиг, 2017, 241 дэх тал.

ХОЁР. ШҮҮХИЙН ШИЙДВЭРИЙН ДҮН ШИНЖИЛГЭЭ

Судалгаанд хамруулан авч үзсэн нийт шүүхийн шийдвэрүүдээс хууль хэрэглээний хувьд эргэлзээ төрүүлж буй хэсгүүдийг, мөн онолын хувьд маргаантай байгаа асуудалд шүүхийн жишиг тогтох хэмжээнд эцэслэн шийдвэрлэсэн хэргүүдийг түүн авч анализ хийсэн ба улмаар дүн шинжилгээг шаардах эрх шилжүүлэхэд тавигдах хуулийн урьдчилсан нөхцөл, түүний үр дагавар гэсэн дарааллаар авч үзлээ.

Шүүхийн шийдвэрийг сонгохдоо хоёр үе шаттай шүүж, түүвэрлэсэн бөгөөд нэгдүгээр шатанд цаг хугацааны хувьд сүүлийн 5 жил буюу 2019 оны 01 сарын 01-ний өдрөөс 2023 оны 07 сарын 01-ний өдрийг хүртэлх хугацаанд хамаарах нийт 36,841 иргэний хэргийн анхан шатны шүүхийн шийдвэрээс шаардах эрх шилжүүлсэнтэй холбоотой хэрэг маргааныг хянан шийдвэрлэсэн бүхий л шийдвэрийг түүвэрлэн авахаар зорьсон. Ингэхдээ www.shuukh.mn цахим хуудаснаас “123”¹¹, “шаардах эрхээ шилжүүлэх”¹², “260”¹³ гэх гурван өөр түлхүүр үгээр хайлт хийхийн зэрэгцээ “google advanced search” хайлтыг ашигласан. Ийнхүү зөвхөн хуулийн зүйл заалтын тоог түлхүүр үг болгон ашигласан нь www.shuukh.mn сайтын “түлхүүр үгээр хайх” цэс нь боловсронгуй бус, хоёр буюу түүнээс дээш үгээр (123 дугаар зүйл, 123.1 г.м.) хайлт хийхэд тухайн

¹¹ Иргэний хууль дах шаардах эрх шилжүүлэх асуудлыг зохицуулсан зүйл, заалтын дугаар.

¹² Иргэний хуулийн 123 дугаар зүйлийн гарчиг

¹³ Иргэний хууль дах эрх, шаардлага, бусад хөрөнгө худалдах, худалдан авах гэрээний зохицуулалтын дугаар

түлхүүр үгс орсон шүүхийн шийдвэрийн жагсаалтыг бүлэг болгон харуулдаггүй, хэрэглэгч нийт шүүхийн шийдвэрийн жагсаалт бүрийг үзэх шаардлагатай болдогтой холбоотой. Түүнчлэн анхан шатны шатны шүүхийн шийдвэрийг түүвэрлэх хүрээнд холбогдох магадлал, тогтоолыг илрүүлэх боломжтой тул тэдгээрийг тусгайлан түүвэрлэх нь ач холбогдолгүй байлаа.

Эхний “123” гэсэн түлхүүр үгээр хайхад нийт 2,190 шүүхийн шийдвэрийн жагсаалт илэрсэн ба үүний дотор ИХШХШтХ, Хөдөлмөрийн тухай хуулийн 123 дугаар зүйлийг эшилсэн болон шийдвэрт дурдагдаж буй мөнгөн дүн, хуудасны дугаар зэрэг хэргийн үйл баримтад 123 цифрийг агуулсан шийдвэрүүд байсан тул нэг бүрчлэн үзээд ИХ-ийн 123-ыг хэрэглэсэн 95¹⁴ шүүхийн шийдвэрийг түүвэрлэн авсан.

Дараагийн “260” гэх түлхүүр үгээр хайхад 906 шүүхийн шийдвэрийн жагсаалт илэрснийг мөн адил нэг бүрээр нь шалгаж ИХ-ийн 260-ийг үндэслэсэн 49¹⁵ шүүхийн шийдвэрийг ялган авсан. Харин “шаардах эрхээ шилжүүлэх” түлхүүр үгийн илэрцэд 19,786 шүүхийн шийдвэр байснаас жагсаалт бүрийг шүүж 9¹⁶ шүүхийн шийдвэрийг түүвэрлэн авсан.

Хамгийн сүүлд google advance search хайлтын системээр keyword “шаардах эрх шилжүүлэх” domain “www.shuukh.mn” гэж хайхад 13 шүүхийн шийдвэр, магадлал, тогтоол илэрснээс 6 шийдвэр, магадлалыг нь авсан. Хоёр дах шатанд нийт 168 шүүхийн шийдвэрээс давхацсан 16 шийдвэрийг хасаж, анхан шатны шүүхийн 143 шийдвэртэй нарийвчлан танилцахад 73 шүүхийн шийдвэрийн агуулгыг хуулийн дагуу шаардлага шилжихтэй холбоотой, өр шилжихтэй холбоотой, компанийн хувьцаа, хувьцааны эрх шилжсэнтэй холбоотой буюу гэрээний үндсэн дээр шаардах эрх шилжих асуудалтай хамааралтай эсэхээр ялган авч үзсэн болно.

¹⁴ Жагсаалттай хавсралт хэсгээс танилцах боломжтой.

¹⁵ Жагсаалттай хавсралт хэсгээс танилцах боломжтой.

¹⁶ Жагсаалттай хавсралт хэсгээс танилцах боломжтой.

Ийнхүү 70 шүүхийн шийдвэр, тэдгээрт холбогдох давж заалдах шатны шүүхийн 42 магадлал, хяналтын шатны шүүхийн 12 тогтоолтой танилцаад дор дурдсан үзүүлэлтээр 14 хэргийг хянан шийдвэрлэсэн нийт 14 шийдвэр, 8 магадлал, 5 тогтоол (цаашид “Жишиг шүүхийн шийдвэр” гэх)-д дүн шинжилгээ хийсэн болно. Үүнд:

- Практикт түгээмэл гарч буй тохиолдлыг шийдвэрлэсэн буюу тухайн төрлийн хэрэг маргааныг хянан шийдвэрлэсэн бусад шүүхийн шийдвэрийг төлөөлөх чадвар;
- Хууль тогтоомж дах эрх зүйн хийсвэр хэм хэмжээг буюу ялангуяа ИХ-ийн 123.1-123.9-ийн аль нэг хэсгийг тодорхой нэг тохиолдлыг хянан шийдвэрлэх хүрээнд тайлбарласан буюу казуаль тайлбар хийсэн эсэх;
- Хууль хэрэглээний хувьд ач холбогдолтой эсэх буюу практикт тулгамдаж буй асуудлыг нээн илрүүлсэн эсэх зэрэг үзүүлэлт голлох үүрэг гүйцэтгэсэн.

2.1. ХЭЛЦЛИЙН ҮНДСЭН ДЭЭР ШААРДАХ ЭРХ ШИЛЖИХЭД ТАВИГДАХ ШААРДЛАГА

Дээр дурдсанчлан хуучин ба шинэ үүрэг гүйцэтгүүлэгчдийн хооронд ИХ-ийн 123.1-д заасан шаардах эрх шилжүүлэх гэрээ байгуулсан байх ёстой.

2.1.1. Шаардах эрх шилжүүлэх гэрээ

Шүүхийн практикаас үзвэл шаардах эрх шилжүүлэх гэрээнд тавигдах шаардлага, оролцогсод нь ямар үүрэгтэй байх, энэ гэрээний талаар мэдэгдэх үүргийн талаар зөрүүтэй авч үзэх тохиолдол гарч байсан тул дараах шийдвэрийг сонгон толилуулж байна.

Жишиг шүүхийн шийдвэр 1¹⁷

Маргааны төрөл	Бусад зээл
<p>Маргааны агуулга:</p>	<p>“Х” банк гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлж мөнгөн хөрөнгийг тэр даруй У-д олгосон бөгөөд У нь гэрээнд заасан хуваарийн дагуу эргэн төлөлтийг хийхгүй байсаар тэрээр 2021 оны 09 сарын 12-ны өдөр нас барсан. Энэ хугацаанд буюу 2020 оны 09 сарын 12-ны өдөр «Х» банк нь дээрх зээлийн гэрээний шаардах эрхийг «А» ББСБ-д факторингийн гэрээний үндсэн дээр шилжүүлэхээр болсон.</p> <p>Улмаар 2022 оны 03 сарын 09-ны өдөр «А» ББСБ нь эрх бүхий байгууллагын зөвшөөрөлтэйгөөр зохих журмын дагуу «С» ББСБ болон өөрчлөн байгуулагдаад нас барсан У-ийн хамтран зээлдэгч Д.У-д холбогдуулан зээлийн гэрээний үүргийг шаардаж шүүхэд нэхэмжлэл гаргасан.</p>
<p>Анхан шатны шүүх:</p>	<p>ИХ-ийн 123.1, 123.8-аар 2020 оны 08 сарын 20-ны өдөр байгуулагдсан шаардах эрх шилжүүлэх гэрээний эрх шилжүүлэгч тал болох “Х” банк болон эрх шилжүүлэн авагч тал болох “А” ББСБ нар тус гэрээ байгуулагдсан талаар үүрэг гүйцэтгэгч У, Д.У нарт мэдэгдэх, улмаар 2014 оны 03 сарын 06-ны өдөр зээлийн гэрээ байгуулагдсан хэлбэрээр, “А” ББСБ нь У, Д.У нартай бичгээр гэрээ байгуулсан байх шаардлага тус тус тавигдаж байгаа юм.</p> <p>Гэтэл хэргийн зохигч талууд буюу нэхэмжлэгч “А” ББСБ болон хариуцагч Д.У нарын хооронд дээрх хэлбэрээр хэлцэл хийгдээгүй, шаардах эрхийг гэрээгээр шилжүүлээгүй, гэрээний үүргийг шаардах эрх шилжсэн талаар П.У-д мэдэгдсэн баримтгүй байх тул “Х” банк болон У, Д.У нарын хооронд 2014 оны 3 сарын 06-ны өдөр байгуулагдсан зээлийн гэрээний үүргийг шаардах эрх “А” ББСБ-д шилжсэн гэж дүгнэх боломжгүй гэж үзсэн.</p> <p>Иймд “С” ББСБ-д ИХ-ийн 451.1-д заасан гэрээний үүргийг хариуцагч Д.У-ээс шаардах эрх мөн хуулийн 123.8-д заасны дагуу шилжээгүй бөгөөд энэхүү шийдвэр нь зээлдэгч “Х” банк тус зээлийн гэрээний үүргийг шаардахад саад болохгүй хэмээн нэхэмжлэлийн шаардлагыг бүхэлд нь хэрэгсэхгүй болгож шийдвэрлэсэн.</p>

¹⁷ Хан-Уул дүүргийн Иргэний хэргийн анхан шатны шүүхийн 2022 оны 11 сарын 30-ны өдрийн 183/ШШ2022/03564 дугаартай шийдвэр, Нийслэлийн Иргэний хэргийн давж заалдах шатны шүүхийн 2023 оны 03 сарын 03-ны өдрийн 210/МА2023/00454 дугаартай магадлал.

Маргааны төрөл	Бусад зээл
<p>Давж заалдах шатны шүүх:</p>	<p>Хэрэгт гэрээний үүргийг шаардах эрх шилжсэн талаар Д.Ү-д мэдэгдсэн баримтгүй байна. ИХ-ийн 82.1-д зааснаар хөөн хэлэлцэх хугацаа өнгөрсөн бол үүрэг гүйцэтгэгч үүрэг гүйцэтгэхээс татгалзах эрхтэй тул хариуцагч Д.Ү-с зээлийн гэрээний үүрэгт нийт 7,933,139 төгрөг гаргуулах тухай нэхэмжлэгч “С” ББСБ-ийн нэхэмжлэлийг хангах үндэслэлгүй гэж анхан шатны шүүхийн шийдвэрийг хэвээр үлдээсэн.</p>

Энэхүү шүүхийн шийдвэрээр ИХ-ийн 123.1 болон 123.8-д заасан шаардах эрх шилжүүлэх гэрээний хэлбэр, үүрэг гүйцэтгэгчид мэдэгдэх үүрэгтэй холбоотой эрх зүйн дүгнэлт хийжээ. Тодруулбал, анхан шатны шүүхээс хуучин үүрэг гүйцэтгүүлэгчээс шинэ үүрэг гүйцэтгүүлэгчид шаардлага шилжихийн тулд шинэ үүрэг гүйцэтгүүлэгч нь үүрэг гүйцэтгэгчтэй мөн адил гэрээ байгуулсан байх ёстой. Өөрөөр хэлбэл, шилжүүлгийн хүчинтэй эсэх нь ИХ-ийн 123.2-ыг үл харгалзан үүрэг гүйцэтгэгчийн оролцоо, зөвшөөрлөөс хамаарна гэх байр сууринаас тайлбарлаж нэхэмжлэлийн шаардлагыг хэрэгсэхгүй болгосон. Давж заалдах шатны шүүх анхан шатны шүүхийн шийдвэр дэх тус үндэслэлийг өөрчлөлгүй, хэвээр үлдээснээс харвал анхан шатны шүүхийн энэ тайлбарыг буруутгаагүй.

Шүүхийн уг шийдэл нь ИХ-ийн 123-д заасан гэрээнд тавигдах, шаардлага мэдэгдэх үүргийн зохицуулалтад бүрэн нийцэхгүй байна. Хууль тогтоогч энд гэрээний үндсэн дээр шаардах эрх шилжихэд үүрэг гүйцэтгэгчийн зөвшөөрөл шаардлагагүй болохыг ИХ-ийн 123.2-т туйлын тодорхой хуульчилсан. Хэрэв ИХ-ийн 123.1, 123.8-ыг эрх шилжүүлэн авах гэж буй гуравдагч этгээд нь үүрэг гүйцэтгэгчтэй гэрээ байгуулах шаардлагыг тогтоосон агуулгатай гэж үзвэл ИХ-ийн 123.2-той зөрчилдөнө. Шаардах эрх шилжих гэрээ байгуулагдахын тулд гуравдагч этгээд болон үүрэг гүйцэтгүүлэгчийн хүсэл зоригийн илэрхийлэл давхацсан байх шаардлагатай, харин үүрэг гүйцэтгэгчийн зөвшөөрөл энд хамааралгүй. Жишээ нь үүрэг

гүйцэтгэгч шинэ үүрэг гүйцэтгүүлэгчид зөвшөөрөх боломжгүй нөхцөл тавиад талууд харилцан тохиролцохгүй бол шаардлага шилжих эсэх нь үндсэндээ дан ганц үүрэг гүйцэтгэгчийн хүсэл зоригоос буюу нэг үгээр түүний зөвшөөрлөөс шууд хамааралтай болно.

Нөгөө талаар шүүх үүрэг гүйцэтгэгчийн эрх, ашиг сонирхол зөрчигдөж болзошгүй нөхцөлөөс сэргийлж ийнхүү тайлбарласан байж болох хэдий ч шаардлага нэг этгээдээс нөгөөд шилжсэнээр үүрэг гүйцэтгэгчийн эрх зүйн байдал дордохгүй. ИХ-ийн 123.4, 123.5-ын дагуу тэрээр хуучин үүрэг гүйцэтгүүлэгчийн эсрэг үүссэн, хэрэгжүүлэх боломжтой эрхээ шинэ үүрэг гүйцэтгүүлэгчийн эсрэг тавьж болно.

Хоёрдугаарт, үүрэг гүйцэтгэгчид мэдэгдсэн эсэх нь шаардлагын шилжүүлэг хүчин төгөлдөр эсэхэд нөлөө үзүүлэхгүй. Учир нь эдийн бус баялгийн өмчлөлийг шилжүүлэхэд түүний биет бус шинжээс үүдээд эзэмшлийг хүлээлгэн өгнө гэсэн ойлголт үгүй¹⁸ тул эрх шилжүүлэгч болон эрх хүлээн авагч талууд гэрээ байгуулснаар шаардах эрх шууд шилжих юм. Харин мэдэгдэх үүрэг нь үүрэг гүйцэтгэгчийг хамгаалах зорилготой ч гэрээг хүчин төгөлдөр болоход зайлшгүй бүрдэх ёстой хуулийн шаардлагад хамаарахгүй байна. Тиймээс шүүх ИХ-ийн 56.1.8-ыг баримтлан мэдэгдэл хүргээгүй тохиолдол бүрийг хүчингүй гэрээ байгуулсан мэтээр дүгнэх ёсгүй.

Банк дээрх тохиолдолд үүрэг гүйцэтгэгчид шаардлага шилжсэн талаар мэдэгдээгүй нь түүний зүгээс үүрэг гүйцэтгэгчид мэдээлэл өгөх хуульд заасан үүргийн зөрчил мөнөөс мөн боловч, энэ тохиолдолд хууль тогтоогч гэрээний харилцааг хүчинтэй хэмээн үзэж, энэ талаар огт мэдлэггүй байгаа үүрэг гүйцэтгэгчийг 2 удаа үүргээ гүйцэтгэхээс сэргийлэн процесст нэгэнт үүргээ гүйцэтгэсэн бол шаардах эрх шилжүүлэн авсан этгээдийн эсрэг ИХ-ийн 236-д заасан эсэргүүцлийг мөн гаргах эрхийг олгосон байдаг.

¹⁸ Энэ зохицуулалтын талаар 2.3. Үүрэг гүйцэтгэгчийг хамгаалах арга, хэрэгсэл хэсэгт дэлгэрэнгүй авч үзэх болно

2.1.2. Шаардах эрх үүссэн, дуусгавар болоогүй, тодорхой байх шаардлага

ИХ-ийн 122.2-т шаардах эрхийн эзэн уул эрхийг эзэмшиж байгаа хэмжээгээрээ л өөр этгээдэд шилжүүлэх боломжтой. Бусад өмчлөлийн зүйлтэй харьцуулахад шаардах эрхийг шударгаар олж авна гэсэн ойлголт байхгүй бөгөөд шаардах эрх шилжүүлэхэд эзэмшилдээ авах боломжгүйн улмаас өмчлөгч хэмээн тооцох, итгэл үнэмшлийг хамгаалах хангалттай үндэслэл байхгүй. Дараах шийдвэрийн хүрээнд давж заалдах шатны шүүхээс анхны өмчлөгчид шаардах эрх үүсээгүй байхад эрхээ шилжүүлэх гэрээ байгуулсан нь хуулийн шаардлагыг хангаагүй хэмээн үзжээ.

Жишиг шүүхийн шийдвэр 2¹⁹

Маргааны төрөл	Бусад хуулиар
Маргааны агуулга:	<p>“А” ХХК нь таунхаусын төсөл хэрэгжүүлэх явцдаа өөрийн толгой компани “Д” ХХН-тай 2014 оны 05 сарын 25-ны өдөр “Орон сууцны барилгад хөрөнгө оруулах гэрээ”-г байгуулсан. Тус гэрээний дагуу “Д” ХХН нь “А” ХХК-ийн барьж, ашиглалтад оруулж дуусаагүй барилгын ажилд хөрөнгө оруулах, “А” ХХК нь барилгыг ашиглалтад оруулсны дараа нийт 884 кв.м талбай бүхий нийт гурван таунхаус, эсхүл таунхасуудын нийт талбайн 50 хувь болон холбогдох газрыг зохих бүртгэлийн байгууллагуудад бүртгүүлсний дараа “Д” ХХН-д шилжүүлэн өгөхөөр харилцан тохиролцсон.</p> <p>Төслийн хэрэгжилтийн явцад “А” ХХК нь “ҮХОБ” ХХК-иас 2015 оны 03 сар, 04 саруудад тус тус “Зээлийн гэрээ”-ээр мөнгөн хөрөнгө зээлдэж авсан. Гэсэн хэдий ч “А” ХХК нь гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлээгүй тул 2015 оны 12 сард “Д” ХХН нь эдгээр зээлийн үүргийг барагдуулах зорилгоор “ҮХОБ” ХХК-д “Орон сууцны барилгад хөрөнгө оруулах гэрээ”-ний шаардах эрхийг шилжүүлэхээр харилцан тохиролцсон.</p>

¹⁹ Хан-Уул дүүргийн Иргэний хэргийн анхан шатны шүүхийн 2021 оны 09 сарын 08-ны өдрийн 183/ШШ2021/01904 дугаартай шийдвэр, Нийслэлийн Иргэний хэргийн давж заалдах шатны шүүхийн 2021 оны 12 сарын 27-ны өдрийн 210/МА2022/00036 дугаартай магадлал

ШААРДАХ ЭРХ ШИЛЖҮҮЛЭХ ГЭРЭЭТЭЙ ХОЛБООТОЙ МАРГААН ШИЙДВЭРЛЭСЭН ШҮҮХИЙН ШИЙДВЭРТ ХИЙСЭН ДҮН ШИНЖИЛГЭЭ

Маргааны төрөл	Бусад хуулиар
	<p>Ингээд “ҮХОБ” ХХК нь “Д” ХХН болон “А” ХХК-д холбогдуулан нэр бүхий орон сууцны зориулалттай барилгуудын өмчлөгчөөр тогтоолгох, ийнхүү бүртгүүлэхэд шаардлагатай бичиг баримтыг шилжүүлэхийг хариуцагч нарт даалгуулах шаардлага бүхий нэхэмжлэлийг шүүхэд гаргасан.</p>
<p>Анхан шатны шүүх:</p>	<p>ИХ-ийн 123 дугаар зүйлээр 2015 оны 12 сард байгуулагдсан шаардах эрх шилжүүлэх гэрээний эрх шилжүүлэгч тал болох “Д” ХХН болон эрх шилжүүлэн авагч тал болох “ҮХОБ” ХХК нар тус гэрээ байгуулагдсан талаар үүрэг гүйцэтгэгч “А” ХХК-д мэдэгдэх, улмаар 2014 оны 05 сарын 25-ны өдөр хариуцагч “А” ХХК болон ОХУ-ын “Д” ХХН-ийн хооронд “Орон сууцны барилгад хөрөнгө оруулах гэрээ” байгуулагдсан хэлбэрээр, “ҮХОБ” нь “А” ХХК-тай бичгээр гэрээ байгуулсан байх шаардлага тус тус тавигдаж байгаа юм.</p> <p>Гэтэл хэргийн зохигч талууд буюу нэхэмжлэгч “ҮХОБ” ХХК болон хариуцагч “А” ХХК-ийн хооронд дээрх хэлбэрээр хэлцэл байгуулагдаагүй, шаардах эрхийг гэрээгээр шилжүүлээгүй, гэрээний үүргийг шаардах эрх шилжсэн талаар “А” ХХК-д мэдэгдсэн баримтгүй байх тул “Д” ХХН болон “А” ХХК-ийн хооронд 2014 оны 05 сарын 25-ны өдөр байгуулагдсан гэрээний үүргийг шаардах эрх “ҮХОБ” ХХК-д шилжсэн гэж дүгнэх боломжгүй байна гэх үндэслэлээр нэхэмжлэлийн шаардлагыг бүхэлд нь хэрэгсэхгүй болгосон.</p> <p>Шаардах эрх шилжүүлэхэд тус эрх хүчинтэй байх, эрхийг тодорхойлох болон шилжүүлэх боломжтой байх, тухайн эрх нь маргаангүй, тодорхой байх зэрэг урьдчилсан нөхцөл хангагдах учиртай бөгөөд шаардах эрх шилжүүлэх гэрээ байгуулах үндэслэл болсон орон сууцны барилгад хөрөнгө оруулах гэрээний үүргийг шаардах эрх хариуцагч “Д” ХХН-д үүссэн тохиолдолд тус эрхийг шилжүүлэх боломжтой юм.</p>
<p>Давж заалдах шатны шүүх:</p>	<p>Гэтэл хариуцагч “Д” ХХН нь орон сууцны барилгад хөрөнгө оруулах гэрээний дагуу шаардах эрх үүсээгүй байхад гэрээний тал болох “А” ХХК-д мэдэгдэлгүйгээр нэхэмжлэгч “ҮХОБ” ХХК-д шаардах эрхээ шилжүүлсэн гэж үзэхээр байна. Энэ тохиолдолд дээрх хуульд зааснаар үүрэг гүйцэтгэгчийн зөвшөөрөлгүйгээр шаардах эрхийг шилжүүлэх боломжгүй тул шаардах эрх шилжүүлснийг мэдэгдээгүй нь гэрээний хүчинтэй эсэхэд нөлөөлөхгүй гэх нэхэмжлэгчийн итгэмжлэгдсэн төлөөлөгчийн давж заалдах гомдол үндэслэлгүй.</p>

ШҮҮХИЙН ШИЙДВЭРИЙН СУДАЛГАА: ЦУВРАЛ 17

Маргааны төрөл	Бусад хуулиар
	Өөрөөр хэлбэл, хариуцагч “Д” ХХН нь 1769,99 м.кв талбай бүхий дуусаагүй барилгад хөрөнгө оруулж, барилгын ажлыг “А” ХХК-иар гүйцэтгүүлэн 2014 оны 11 сарын 01-ний өдрөөс өмнө хүлээлгэн өгөх үүргийг хариуцагч “А” ХХК-ийн өмнө гэрээгээр хүлээсэн байх боловч тус үүргийг гүйцэтгэж, барилгын өмчлөх эрхийг шаардах эрхтэй болсон гэх нөхцөл байдал хэргийн баримтаар тогтоогдоогүй гээд анхан шатны шүүхийн шийдвэрийг хэвээр үлдээсэн.

Энэхүү шүүхийн шийдвэр, магадлалаар ирээдүйд үүсэх шаардах эрхийг шилжүүлэхээр харилцан тохиролцсон гэрээтэй холбоотой маргааныг шийдвэрлэжээ. Анхан шатны шүүхийн шийдвэр, давж заалдах шатны шүүхийн магадлалаар нэхэмжлэлийн шаардлагыг бүхэлд нь хэрэгсэхгүй болгож шаардлага шилжүүлэх тохиролцоо нь хүчингүй хэмээн шийдвэрлэсэн боловч ийнхүү шийдвэрлэсэн үндэслэлээ өөр өөр байр сууриас тайлбарласан. Тухайлбал анхан шатны шүүх шаардлага шилжих урьдчилсан нөхцөлд “үүрэг гүйцэтгэгчид мэдэгдсэн байх”, эрх шилжүүлж буй этгээд нь үүрэг гүйцэтгэгчтэй гэрээ байгуулсан байх шаардлагыг хангаагүй гэсэн бол давж заалдах шатны шүүх ирээдүйд үүсэх шаардах эрхийг шилжүүлэхэд тавигдах үүрэг гүйцэтгэгчийн зөвшөөрлийг авсан байх нөхцөл хангагдаагүй гэж тус тус тайлбарлажээ. Анхан шатны шүүхийн тайлбарын тухайд нэхэмжлэгч “ҮХОБ” ХХК болон “Д” ХХН гэрээ байгуулах үед “Орон сууцны барилгад хөрөнгө оруулах гэрээ”-ний шаардах эрх үүссэн эсэхийг дүгнэлгүйгээр шууд шаардлага шилжсэн эсэх талаар дүгнэжээ.

Шүүхийн шийдвэрийн үндэслэх хэсэгт шаардлага шилжүүлэх гэрээний хэлбэр, үүрэг гүйцэтгэгчид мэдэгдэх үүргийг ИХ-ийн 123 дугаар зүйлд зааснаас өөрөөр буюу буруу ташаа байдлаар тус зохицуулалтын агуулгаас зөрүүтэйгээр тайлбарласан байв.

Магадлалаар эрх шилжүүлэгч “Д” ХХН-д “А” ХХК-иас шаардах эрх бий болоогүй учир шилжүүлгийн хүчин төгөлдөр эсэх

нь үүрэг гүйцэтгэгч “А” ХХК-ийн зөвшөөрлөөс шалтгаална гэжээ. Үүрэг гүйцэтгүүлэгч нь анхнаасаа шаардлагын жинхэнэ эзэн биш, гуравдагч этгээд байх нөхцөлд л түүний байгуулсан шаардах эрх шилжих гэрээ хүчин төгөлдөр болох эсэх нь гуравдагч этгээдийн зөвшөөрлөөс шалтгаалдаг²⁰. Харин “Д” ХХН нь өөрт байхгүй шаардах эрхээ шилжүүлсэн үйл явдал огт байхгүй нөхцөлд гэрээг үүрэг гүйцэтгэгчийн зөвшөөрлөөс хамаатуулах нь утгагүй бөгөөд ИХ-ийн 123.2-той зөрчилдөнө.

Энэ маргааны хүрээнд “Д” ХХН-д үүсээгүй байгаа шаардах эрх шинэ эзэмшигчид шилжих үү, шаардах эрхийг хэдийд үүссэн гэж үзэх вэ гэдэг нь маргаантай бөгөөд шаардах эрхийн жинхэнэ эзэн, түүний эрхийг зөвшөөрөлгүй шилжүүлсэн гэх үйл баримт байхгүй. Ирээдүйд шаардах эрхтэй болох этгээд нь энэхүү эрх үүсэхэд олж авч байгаа этгээд нь шинэ эзэмшигчид уг шаардлагыг шилжүүлэх гэрээг байгуулах боломжтой²¹. Үндсэн шаардах эрхийг шилжүүлэхэд үүрэг гүйцэтгэгчийн зөвшөөрөл хэрэггүй мөртөө “шаардах эрхийг урьдчилан шилжүүлэх тохиролцоо” хүчин төгөлдөр болоход үүрэг гүйцэтгэгчийн зөвшөөрөл зайлшгүй байх ёстой гэж үзэх нь ойлгомжгүй юм. Өөрөөр хэлбэл, энэ хэлцлийг хийхэд үүрэг гүйцэтгэгчийн буюу “А” ХХК-ийн зөвшөөрлөөс шалтгаалах зүйл үгүй бөгөөд шилжүүлэх шаардах эрхийн өмнөх эзэн нь “А” ХХК байх үндэсгүй байна.

Харин шаардах эрх шилжүүлэх гэрээ байгуулагдахаас өмнө “Д” ХХН-д шаардах эрх үүссэн байх гэсэн шаардлагыг тавих нь үндэслэлтэй ч шаардах эрх үүсэх гэдгийг “Д” ХХН болон “А” ХХК-ийн хооронд хөрөнгө оруулалтын гэрээ байгуулагдсан, энэ гэрээний гүйцэтгэлийг харилцан шаардах боломжтой байхыг ойлгоно.

Дээр өгүүлсэнчлэн шаардах эрхээ шилжүүлэхэд тодорхой байх зарчим үйлчилнэ. Ирээдүйд үүсэх шаардах эрхийг одоо

²⁰ Монгол улсын Иргэний хуулийн тайлбар, Ё.Кают, Э.Шпанглер, П.Редел, Р.Хелмхаген, Д.Наранчимэг, Ц.Амарсайхан, Д.Дүгэржав, Н.Баярмаа, Монгол Улс, Улаанбаатар хот, Эдмон ХХК, 2010, 213 дах тал.

²¹ Иргэний хуулийн тайлбар толь: Ерөнхий анги, УБ хот 2006 он, 427 дах тал

шилжүүлж буй нөхцөлд шаардах эрхийн хувьд шинэ болон хуучин үүрэг гүйцэтгүүлэгчийн аль нь эзэн болохыг танихад хэцүү тул шилжүүлж буй эрх тодорхой, эсхүл ийнхүү тодорхойлох боломжтой байх шаардлага тавигдана. Өөрөөр хэлбэл, шаардах эрх шилжүүлэх гэрээнээс харилцагч талууд болон шаардлагын агуулга, хэмжээг тодорхойлох боломж бүрдсэн байх ёстой²⁴. Ирээдүйд хэрэгжүүлэх боломжтой шаардах эрхийг шилжүүлж буй нөхцөлд түүний гүйцэтгэлийг шаардсан нь оновчгүй байна.

Жишиг шүүхийн шийдвэр 3²²

Маргааны төрөл	Гэм хор учруулснаас гаргуулсан эд хөрөнгийн хохирол
Маргааны агуулга:	<p>“Н” ХХК нь худалдаа үйлчилгээ эрхлэх зорилгоор 2020 оны 08 сарын 18- ны өдрөөс III худалдааны төвийн 2 давхарт үйлчилгээний талбай түрээсэлж эхэлсэн. “Н” ХХК нь уг түрээсийн талбайд инженерийн ажил хийлгэх зорилгоор “Г” ХХК-тай ажил гүйцэтгэх гэрээг 2020 оны 10 сарын 29-ний өдөр байгуулсан.</p> <p>“Г” ХХК-ийн ажилчид түрээсийн талбайд ажил гүйцэтгэх явцдаа буюу 2020 оны 11 сарын 10-ны өдөр хөргөлтийн системийг гэмтээж, үүний улмаас их хэмжээний ус алдаж доод давхарт байрлах “Б” ХХК-ийн худалдаалж байсан бренд бараа бүтээгдэхүүнд их хэмжээний хохирол учирсан. Энэ тохиолдолтой холбогдуулан “Б” ХХК нь бүтээгдэхүүний даатгалын нөхөн төлбөрт 49,876,390 төгрөгийг даатгалаас авсан.</p> <p>“Н” ХХК нь “Б” ХХК-тай 2021 оны 03 сарын 29-ний өдөр “Бусдын өмнөөс хохирол барагдуулах гэрээ”, “Шаардах эрх шилжүүлэх гэрээ”-г тус тус байгуулсан. Гэрээний агуулгыг товч дурдвал:</p> <p>Ийнхүү “Н” ХХК нь “Г” ХХК-д холбогдуулан 148,240,754 төгрөгийг “Г” ХХК-иас гаргуулахаар шүүхэд нэхэмжлэл гаргасан.</p>

²² Сонгинохайрхан дүүргийн Иргэний хэргийн анхан шатны шүүхийн 2023 оны 01 сарын 20-ны өдрийн 184/ШШ2023/00398 дугаартай шийдвэр, Нийслэлийн Иргэний хэргийн давж заалдах шатны шүүхийн 2023 оны 04 сарын 03-ны өдрийн 210/МА2023/00701 дугаартай магадлал.

Маргааны төрөл	Гэм хор учруулснаас гаргуулсан эд хөрөнгийн хохирол
<p>Анхан шатны шүүх:</p>	<p>2021 оны 03 сарын 29-ний өдрийн шаардах эрх шилжүүлэх гэрээгээр “Б” ХХК нь өөрт учирсан эд хөрөнгийн хохирол буюу нэхэмжлэгчийн төлөхөөр хүлээн зөвшөөрсөн 180,000,000 төгрөгийг гэм буруутай этгээдээс нь шаардах эрхийг нэхэмжлэгч “Н” ХХК-нд шилжүүлсэн байна. Гэрээний талууд хуулийн хүрээнд гэрээг чөлөөтэй байгуулах, түүний агуулгыг өөрсдөө тодорхойлох эрхтэй бөгөөд өөрт учирсан гэм хорын хохирлыг шаардах эрхийг бусдад шилжүүлсэн талаар талуудын тохиролцоо хуульд нийцсэн.</p> <p>Тодруулбал, харилцан тохиролцсоны үндсэн дээр гэм хохирлыг шаардах эрхээ шилжүүлсэн нь эд хөрөнгөд хууль бусаар санаатай буюу болгоомжгүй үйлдэл /эс үйлдэхүй/-ээр гэм хор учруулсан этгээдийн уг гэм хорыг хариуцан арилгах талаар хуульд заасан үүргийн харилцаанд харшлахгүй ба хохирлыг өөр этгээд өөрөө мэдэж төлсөн нь хариуцагчийг гэм хорын хохирлыг хариуцан арилгах үүргээс чөлөөлөх үндэслэл болохгүй юм. Тиймээс нэхэмжлэгч “Н” ХХК нь хууль, гэрээнд заасны дагуу эд хөрөнгөд учирсан гэм хорын хохирлыг хариуцагч “Г” ХХК-иас гаргуулахаар нэхэмжлэл гаргасан нь үндэслэлтэй.</p> <p>Харин хохирлыг шаардах эрх шилжүүлэх гэрээний дагуу нэхэмжилж байгаа тохиолдолд нэхэмжлэгчийн шаардах эрхийн хүрээ нь шаардах эрх шилжүүлж байгаа этгээдийн хүсэл зориг буюу гэрээнд заасан хэмжээгээр хязгаарлагдах бөгөөд “Н” ХХК, “Б” ХХК нарын хооронд байгуулагдсан шаардах эрх шилжүүлэх гэрээгээр “Б” ХХК нь даатгалын нөхөн төлбөрийг хасаж, үлдэх 180,000,000 төгрөгийн хохирол төлбөр шаардах эрхийг нэхэмжлэгчид шилжүүлсэн байна.</p> <p>Тиймээс нэхэмжлэгч нь хууль, гэрээнд заасны дагуу хариуцагчид холбогдуулж 180,000,000 төгрөг шаардах эрхтэй тул “Н”ХХК-ийн ажилчдаа хүлээлгэн өгсөн 192 ширхэг бараа бүтээгдэхүүний үнэ 88,348,026 төгрөгийг хасаж үлдэх 91,651,974 төгрөгийг хариуцагч “Г” ХХК-иас гаргуулж нэхэмжлэгч “Н” ХХК-д олгож, нэхэмжлэлийн шаардгаас үлдэх хэсгийн шаардлагыг хэрэгсэхгүй болгож шийдвэрлэсэн.</p>

Маргааны төрөл	Гэм хор учруулснаас гаргуулсан эд хөрөнгийн хохирол
<p>Давж заалдах шатны шүүх:</p>	<p>ИХ-ийн 123.2-т хууль, гэрээ буюу үүргийн мөн чанарт харшлахгүй бол шаардах эрх эзэмшигч нь гуравдагч этгээдтэй байгуулсан гэрээний үндсэн дээр үүрэг гүйцэтгэгчийн зөвшөөрөлгүйгээр шаардах эрхээ шилжүүлж болно гэж зааснаар нэхэмжлэгч “Н” ХХК нь “Б” ХХК-д учирсан хохирлыг төлөх замаар уг хохирлыг бусад этгээдээс шаардах эрхийг гэрээгээр шилжүүлэн авсан нь хуульд харшлахгүй. Нэхэмжлэгч нь хариуцагчид холбогдуулан хохирол арилгуулахаар шаардах эрхтэй байна. Нэхэмжлэгч нь уг шаардах эрхийг үндэслэн хариуцагчаас хохирол нэхэмжлэхдээ “Х даатгал” ХХК-ийн “Б” ХХК-д төлсөн 49,876,390 төгрөгийг хариуцагчаас шаардаагүй, хасаж тооцсон учир мөн хуулийн 443 дугаар зүйлийн 443.7-д заасан даатгагчийн эрхийг хөндөхгүй.</p> <p>Мөн ИХ-ийн 123.4, 123.5-д зааснаар хариуцагч “Г” ХХК нь нэхэмжлэгчийн эсрэг бүх татгалзал, хариу шаардлагыг гаргах эрхтэй учир шаардах эрх шилжсэн нь хариуцагчийн эрх, ашиг сонирхлыг хөндсөн гэж үзэхээргүй байна гээд анхан шатны шүүхийн шийдвэрийг хэвээр үлдээсэн.</p>

Жишиг шүүхийн шийдвэр 3-д шийдвэр, магадлалаар шаардах эрх шилжүүлэгч талуудын хүсэл зоригийг үл анхаарч, суурь хэлцэл дэх өр авлагын бодит хэмжээгээр шилжсэн шаардах эрхийг танах замаар маргааныг шийдвэрлэжээ. Энд “Н” ХХК нь “Б” ХХК-тай “Бусдын өмнөөс хохирол барагдуулах гэрээ”-ээр 180,000,000 төгрөгийг төлж, хариуд нь 88,348,026 төгрөгийн бараа болон “Шаардах эрх шилжүүлэх гэрээ”-ээр “Г” ХХК-ийн эсрэг 148,240,754 төгрөгийн хохирол шаардах эрхийг шилжүүлэн авахаар тохиролцсон.

Шүүх шаардах эрхийн хүрээ нь шаардах эрх шилжүүлж байгаа этгээдийн хүсэл зориг буюу хохирол барагдуулах гэрээнд заасан хэмжээгээр хязгаарлагдана гээд, “Н” ХХК, “Б” ХХК нарын хооронд байгуулагдсан шаардах эрх шилжүүлэх гэрээгээр “Б” ХХК нь даатгалын нөхөн төлбөрийг хасаж, үлдэх 180,000,000

(бүтээгдэхүүний үнийг хасвал 91,651,974) төгрөгийн хохирол төлбөр шаардах эрхийг нэхэмжлэгчид шилжүүлсэн гэжээ.

Шүүхийн шийдвэр 3-т нэхэмжлэгч нь “Н” ХХК-иас хохирол шаардах эрхийг бүрэн хэмжээгээр шилжүүлэх гэрээ байгуулсан ч шаардлага шилжих болсон үндэслэл нь “Бусдын өмнөөс хохирол барагдуулах гэрээ” бөгөөд үүгээр 180,000,000 төгрөг төлсөн. Харин гэм хор учруулсан “Г” ХХК-ийн эсрэг үүссэн хохирол шаардах эрх нь 286,465,170,23 төгрөг бөгөөд гэм буруутай этгээдээр арилгуулах эрхээс барааны үнэ 88,000,000 төгрөг, даатгалын нөхөн олговор 49,000,000 төгрөгийг хасах уу, эсхүл 180,000,000 төгрөгөөс хасах нь зөв үү гэдэг нь маргаантай байна. Даатгалын компанид ИХ-ийн 443.7-ын дагуу шилжсэн болон барааны үнэ 88,000,000 төгрөгийг нийт хохирлоос хасах тухайд талууд санал нэгтэй байгаа.

“Б” ХХК нь өөрт анхнаасаа үүсээгүй шаардах эрхийг хэн нэгэнд шилжүүлэх боломжгүй тул энэхүү маргаантай асуудалд хариулт өгөхийн тулд гэм хорын шаардах эрх хэдий хэмжээгээр, ямар үндэслэлээр хэнд үүсэж, хэнд шилжсэн болохыг цаг хугацааны дарааллаар авч үзвэл:

1. Анх “Г” ХХК-ийн ажилтнуудын гэм буруутай үйлдлийн улмаас “Б” ХХК-ийн бүтээгдэхүүний үнэ цэнэ буурч 286,465,170 төгрөгөөс 88,348,026 төгрөг болсон. Эндээс “Б” ХХК-д учирсан гэм хор нь үнийн цэний алдагдал 198,117,144 төгрөг байх ба хэдийгээр брэнд бүтээгдэхүүний албан ёсны баталгаат борлуулагчийн хувиар тэдгээр доголдолтой бүтээгдэхүүнийг Монгол улсад худалдаалах эрх нь холбогдох гэрээгээр хязгаарлагдсан ч “Н” ХХК-д 88,348,026 төгрөгөөр тооцож шилжүүлснээс дүгнэвэл “Б” ХХК-д “Г” ХХК-ийн эсрэг хэрэгжүүлэх 198,117,144 төгрөгийн шаардах эрх үүссэн.

²³ Энэ хэсэгт “Б” ХХК нь 286,465,170 төгрөгийн шаардах эрхийг бүхэлд нь шилжүүлэх боломжгүй байсан гэдгийг дурдах нь зүйтэй. Учир нь “Х Даатгал” ХХК-иас 49,876,390 төгрөгийн нөхөн төлбөрийг “Б” ХХК- д төлсөн мөчөөс эхлэн хуулийн дагуу шаардах эрхийн тэрхүү хэсгийн өмчлөгчөөр “Х Даатгал” ХХК нь болно. Тиймээс “Б” ХХК нь өөрт байхгүй эрхээ “Н” ХХК-д шилжүүлэх угаас боломжгүй юм.

2. Үүний дараа даатгалын компани “Б” ХХК-д гэм хорын нөхөн олговорт 49,000,000 төгрөгийг төлснөөр хуулийн дагуу буюу ИХ-ийн 443.7-д зааснаар тэрхүү хэсгийн шаардах эрхийн өмчлөгч нь даатгагч компани болсон. Ингээд “Б” ХХК- д 148,240,750 (198,117,144 - 49,000,000) төгрөгийн шаардах эрх үлдсэн. Ийнхүү гэм хорын шаардах эрхийг хэсэгчлэн шилжүүлэх боломжтой эсэх нь түүнийг нөхцөлдүүлж буй үүргийн мөн чанараас хамаарна. Энэ нь хэсэгчилж болох үүрэг гүйцэтгүүлэх эрх байх нөхцөлд буюу уг үүрэг нь түүнийг хэсэгчлэн гүйцэтгэснээр өөрийн үнэ, ач холбогдол нь буурахгүй, үүргийн зорилгод муугаар нөлөөлөхгүй бол хэсэгчлэн шилжүүлж болох үүрэг гэнэ. Энэ нь төрлийн шинжээр тодорхойлогдох эд хөрөнгөтэй холбоотой, ялангуяа мөнгө болон бусад тоо, хэмжээ, жингээр хэмжигдэх (төлөөлж, орлуулж болохуйц) зүйл дээр зөвшөөрөгдөнө²⁴. Шүүхээс ИХ-ийн хуульд заасны дагуу эд хөрөнгөд учирсан хохирлыг мөнгөөр нөхөн төлөх арга хэлбэрээр арилгуулах боломжтой учир дээрх үүргийн зарим хэсгийг шаардах эрхийг шилжсэн хэмээн дүгнэх бүрэн боломжтой.
3. Цаашлаад “Б” ХХК нь “Н” ХХК-д 1) “Бусдын өмнөөс хохирол барагдуулах гэрээ”-ээр хохиролтой холбоотой шаардах эрх ба 88,348,026 төгрөгийн барааг шилжүүлэн хариуд нь 180,000,000 төгрөгийг төлөхөөр тохирч “Шаардах эрх шилжүүлэх гэрээ”-г байгуулсан. Тус “Шаардах эрх шилжүүлэх гэрээ”-нд “Б” ХХК-иас “Н” ХХК-д шилжигдэх шаардах эрхийн хэмжээг “гэм буруутай этгээдийн эсрэг гэм буруутай этгээдүүдээс хохирлыг барагдуулах шаардах эрхийг бүрэн шилжүүлнэ” гэж томъёолжээ. Эндээс шаардах эрх чухам аль гэрээний үндсэн дээр шилжсэн бэ гэдгээс хамаарч ямар хэмжээгээр шилжсэн нь тодорхойлогдох байна. ИХ-ийн 123 дугаар зүйлд заасан шаардах эрх шилжүүлэх гэрээ нь өмчийн хэлцэл болохын хувьд түүний суурь

²⁴ Ё.Кают нарын зохиогчид, 2010, 408 дах тал.

хэлцэл буюу шалтгааныг тусгасан үүргийн хэлцлээс ялгаж авч үзэх шаардлагатай. Ердийн нөхцөлд шалтгаант хэлцэл буюу causa, түүнчлэн шаардах эрхийг шилжүүлэх хэлцэл хоёрыг тусгаарлаж үзэх агуулга бүхий хийсвэрлэх зарчим үйлчилнэ²⁵. Хийсвэрлэх зарчим ёсоор өмчийн хэлцэл болон үүргийн хэлцэл нь тус тусдаа бие даасан хэлцэл бөгөөд аль нэг нь хүчин төгөлдөр бус байгаа нь нөгөө хэлцлийн хүчинтэй эсэхэд шууд нөлөөлөхгүй. Аливаа авлага, шаардлагыг шилжүүлэх үндэслэл болсон үүргийн хэлцэлд худалдах, худалдан авах гэрээ (ИХ-ийн 243), бэлэглэлийн гэрээ (ИХ-ийн 276), зээлээр худалдах, худалдан авах гэрээ (ИХ-ийн 263) гэх мэт ИХТА-д заасан өөр өөр гол нөхцөл бүхий гэрээ байх боломжтой. Эдгээр нь шаардлагыг шилжүүлэх шалтгааныг агуулах үүргийн хэлцэл бол гүйцэтгэлийг өмчийн хэлцэл буюу шаардах эрх шилжүүлэх хэлцлийн үндсэн дээр хэрэгжүүлэх ба гүйцэтгэл хангах хэлцэлд хэнээс юуг ямар үндэслэлээр шаардах эрх шилжихийг шууд тодорхойлохгүй. “Бусдын өмнөөс хохирол барагдуулах гэрээ”-ний агуулгыг үзвэл нэг тал нь 180,000,000 төгрөгийг урьдчилан төлөх, нөгөө тал нь гэм хорын шаардах эрх + эд хөрөнгийн (бараа) хамт шилжүүлэх үүрэг хүлээлгэсэн. Харин “Шаардах эрх шилжүүлэх гэрээ” нь тухайн гэрээний үүргийн үүргийн гүйцэтгэлийг хэрэгжүүлэх зорилго, агуулгатай байна. Иймд өмчийн хэлцэл нь “Шаардах эрх шилжүүлэх гэрээ” тул уг гэрээнд “гэм буруутай этгээдийн эсрэг гэм буруутай этгээдүүдээс хохирлыг барагдуулах шаардах эрхийг бүрэн шилжүүлнэ” гэж тусгаснаар “Б” ХХК-иас “Н” ХХК-д гэм хорын шаардах эрх бүхэлдээ (148,240,750 төгрөг)-ийн шаардах эрх шилжсэн.

Гэтэл шүүх үүргийн болон өмчийн хэлцлийг зааглан үзэлгүйгээр зөвхөн үүргийн хэлцэл “Бусдын өмнөөс хохирол барагдуулах гэрээ”-нд анхаарал хандуулан 180,000,000 төгрөгийн төлбөр төлсөн

²⁵ Б.Буянхишиг, 2017, 241 дэх тал.

бол түүнтэй тэнцэхүйц эд хөрөнгө + шаардах эрх шилжүүлэн авна гэх байдлаар дүгнэн шийдвэрлэсэн нь учир дутагдалтай болжээ.

Дээрхээс үзвэл шаардах эрх шилжих болон өр барагдуулах хэлцлийг тусгаарлан авч үзэх нь зүйтэй бөгөөд эдгээрийн хооронд хийсвэрлэх зарчим үйлчлэх нь бусдын авлагыг нийт үнийн дүнгээс бага үнээр худалдан авдаг факторингийн үйлчилгээг Монгол Улсад нэвтрүүлэхэд зайлшгүй шаардлагатай. Хэдийгээр энд “Н” ХХК нь факторингийн үйлчилгээ үзүүлэгч биш ч, “Б” ХХК нь яаралтай өр барагдуулан хохирлыг даамжруулахгүй байх арга хэмжээ авч, ирээдүйд “Г” ХХК-иас шаардаж авах эрхээ нэхэмжлэгчид бүрэн шилжүүлж байна.

Жишиг шүүхийн шийдвэр 4²⁶

Маргааны төрөл	Үндэслэлгүйгээр хөрөнгөжих
<p>Маргааны агуулга:</p>	<p>Япон улсын иргэн К нь Монгол Улсын иргэн Г-тэй танилцаж, банк бус санхүүгийн үйл ажиллагааг Монгол Улсад явуулахаар ярилцсан. Энэхүү бизнесээ Г нь өөрийн “М” ХХК-иар дамжуулан явуулахаар болж, К нь санхүүжилтийн асуудлыг хариуцахаар тохиролцсон.</p> <p>К нь уг тохиролцооны дагуу 2012 оны 11 сарын 07-ны өдрөөс 2013 оны 11 сарын 26-ны өдрийн хооронд өөрийн «С» ХХК-иар 40,000,000 иен болон 50,000 ам.доллар, Япон улсын 8 иргэнээс 35,932,177 иений санхүүжилтийг тус тус бүрдүүлэн “М” ХХК-д олгосон. “С” ХХК болон</p> <p>Япон улсын нэр бүхий иргэд нь хөрөнгө оруулалт хийхдээ “М” ХХК-тай мөнгөн хөрөнгийг 12 сарын хугацаатай хүлээлгэн өгч, хугацааны эцэст тохиролцсон ашгийг хүлээн авахаар итгэлцлийн гэрээ байгуулсан.</p>

²⁶ Хан-Уул дүүргийн Иргэний хэргийн анхан шатны шүүхийн 2020 оны 07 сарын 21-ны өдрийн 183/ШШ2020/02004 дугаартай шийдвэр, Нийслэлийн Иргэний хэргийн давж заалдах шатны шүүхийн 2020 оны 11 сарын 04-ны өдрийн 2228 дугаартай магадлал, Улсын дээд шүүхийн 2022 оны 12 сарын 08- ны өдрийн 001/ХТ2022/01237 дугаартай тогтоол.

ШААРДАХ ЭРХ ШИЛЖҮҮЛЭХ ГЭРЭЭТЭЙ ХОЛБООТОЙ МАРГААН ШИЙДВЭРЛЭСЭН ШҮҮХИЙН ШИЙДВЭРТ ХИЙСЭН ДҮН ШИНЖИЛГЭЭ

	<p>Хэсэг хугацааны дараа “М” ХХК нь гэрээ ёсоор хуваарилбал зохих ашгийг хуваарилахгүй байсан учир К нь ББСБ-ийн үйл ажиллагаа үнэхээр эрхэлж буй эсэхийг тодруулахад СЗХ-оос тусгай зөвшөөрөл аваагүй нь илэрсэн. Ингээд К, “С” ХХК нь энэ талаар цагдаагийн байгууллагад гомдол гарган шалгуулахад 50,000 ам.долларыг Г нь өөрийн “ББСБ” ХХК-д шилжүүлсэн, үлдсэн хэсгийг хэрхэн зарцуулсан нь тодорхойгүй байсан бөгөөд Нийслэлийн прокурорын газраас гэмт хэргийн шинжгүй гэж үзээд эрүүгийн хэрэг үүсгэхээс татгалзаж шийдвэрлэсэн.</p> <p>“С” ХХК нь арга буюу Япон улсын 8 иргэний мөнгөн хөрөнгийг хувиасаа төлж барагдуулаад «шаардах эрх шилжүүлэх гэрээ»-ээр “М” ХХК-д шилжүүлсэн мөнгөн хөрөнгийг шаардах эрхийг шилжүүлэн авсан.</p> <p>Улмаар “С” ХХК-иас Г болон “ББСБ” ХХК-д холбогдуулан 40,000,000 иен буюу 989,600,000 төгрөг, 50,000 ам.доллар буюу 133,543,500 төгрөг, мөн Япон улсын 8 иргэнд төлөх Г-ийн өрийг барагдуулсан 35,932,177 иен буюу 902,381,058 төгрөг, нийт 2,025,524,559 төгрөгийг гаргуулахаар шүүхэд нэхэмжлэл гаргасан.</p>
<p>Анхан шатны шүүх:</p>	<p>“М” ХХК нь банк бус санхүүгийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөлгүй тул итгэлцлийн үйлчилгээ явуулах эрхгүй. Иймд “С” ХХК болон Япон улсын иргэдийн “М” ХХК-тай байгуулсан итгэлцлийн гэрээ хүчин төгөлдөр бус болсон, уг гэрээний дагуу шилжүүлсэн мөнгийг хариуцагч Г нь хүлээн авч өөрийн болон “ББСБ” ХХК-ийн хэрэгцээнд захиран зарцуулсан байх тул тэднийг ИХ-ийн 492.1.1-д зааснаар үндэслэлгүй хөрөнгөжсөн гэж үзнэ.</p> <p>Япон улсын 8 иргэний “М” ХХК-д шилжүүлсэн нийт 35,932,177 иен буюу 902,381,058 төгрөгийг нэхэмжлэгч “С” ХХК-иас төлж барагдуулан тэдэнтэй шаардах эрх шилжүүлэх гэрээ байгуулсан нь талуудын хүсэл зоригийг илэрхийлсэн, ИХ-ийн 123.8-т заасан шаардлагыг хангаж бичгээр хийгдсэн, апостиль гэрчилгээгээр баталгаажсан, хүчин төгөлдөр гэрээ байна.</p>

	<p>Нэгэнт нэхэмжлэгч “С” ХХК-иас Япон улсын нэр бүхий иргэдийн мөнгийг төлж барагдуулан түүнийг шаардах эрхийг шилжүүлэн авсан тул уг мөнгийг гэрээний болон гэрээний бус үүргийн үндсэн дээр эзэмшиж, ашиглаж, захиран зарцуулж байгаа этгээд болох “М” ХХК болон Г, “ББСБ” ХХК нараас шаардах эрхтэй тул Г болон “ББСБ” ХХК нар нь нэхэмжлэгч “С” ХХК-тай гэрээ, хэлцэл байгуулж, мөнгө хүлээн аваагүй гэх тайлбар үндэслэлгүй бөгөөд хариуцагч Г, “ББСБ” ХХК нар нь гэрээний бус үүрэг буюу бусдын хөрөнгийг үндэслэлгүйгээр олж авсан буюу эзэмшиж байх тул хөрөнгө шилжүүлсэн болон шилжүүлсэн хөрөнгийг шаардах эрх бүхий этгээд нь уг зүйлийг олж авсан этгээдээс дээрх хөрөнгөө буцаан шаардах эрхтэй байна хэмээн Г-ээс 1,816,638,179 төгрөг, хариуцагч “ББСБ” ХХК-иас 133,343,500 төгрөг тус тус гаргуулж, нэхэмжлэгч Япон улсын “С” ХХК-д олгож, нэхэмжлэлийн шаардлагаас үлдэх 75,542,880 төгрөгийн шаардлагыг хэрэгсэхгүй болгож шийдвэрлэсэн.</p>
<p>Давж заалдах шатны шүүх:</p>	<p>Нэхэмжлэгч “С” ХХК болон Япон улсын 8 иргэний мөнгөн хөрөнгийг Г нь “ББСБ” ХХК болон өөртөө авсан хууль зүйн үндэслэлээ нотолж чадаагүй тул нэхэмжлэгч нь ИХ-ийн 492.1.1-д зааснаар үндэслэлгүй хөрөнгөжсөн гэх үндэслэлээр нэхэмжлэл гаргах эрхтэй гээд анхан шатны шүүхийн шийдвэрийн тогтоох хэсгийн “1,816,638,179 төгрөгийг” “1,796,124,000 төгрөгийг” гэж “75,542,880 төгрөгийн” гэснийг “96,057,059 төгрөгт” гэж өөрчлөн шийдвэрийн бусад хэсгийг хэвээр үлдээсэн.</p>
<p>Хяналтын шатны шүүх:</p>	<p>Анхан болон давж заалдах шатны шүүх “С” ХХК дээрх нэр бүхий 8 иргэнээс итгэлцлийн гэрээний үндсэн дээр “М” ХХК-д шилжүүлсэн мөнгөн хөрөнгийг шаардах эрхийг шилжүүлэн авсан гэрээний хүчинтэй байдал, апостиль гэрчилгээгээр баталгаажсан талаар хийсэн дүгнэлт ИХ-ийн 123.8-д заасантай нийцжээ гээд магадлалыг хэвээр үлдээж шийдвэрлэсэн.</p>

Шаардах эрхийн шилжүүлэг нь өмчийн эрх зүйн үйлдэл болохын хувьд энэ гэрээнд өмчийн эрх зүйн хөрөнгийн эрх тодорхой байх зарчим мөн адил үйлчлэх²⁷ ба шүүхээс дээрх хэргийг хянан шийдвэрлэхдээ Япон улсын иргэдээс “С” ХХК-д “шилжсэн”

²⁷ Б.Буянхишиг, Үүргийн эрх зүйн ерөнхий анги, 2-р хэвлэл, 2017, 245 дах тал.

шаардах эрх нь тодорхой буюу тодорхойлогдохуйц байсан эсэх асуудлаар дүгнэлт хийжээ. Шаардах эрхийн тодорхой бус байдал нь тухайн шилжүүлэг хүчингүй байх үндэслэл болно. Шаардах эрх шилжүүлэх гэрээ нь нэг талаас хуучин үүрэг гүйцэтгүүлэгч нөгөө талаас шинэ үүрэг гүйцэтгүүлэгчээс бүрдэх хэлцэл болохын хувьд тэдгээрийн хүсэл зоригийн илэрхийлэл нэгдсэн байх ёстой. Тодорхой буюу тодорхойлох боломжтой байх гэдэг нь шаардах эрх үүссэн, цар хүрээ нь танигдахаар тодорхойлогдсон байхыг²⁸ ойлгоно.

Нэхэмжлэгч “С” ХХК болон нэр бүхий 8 иргэний хооронд хийгдсэн шаардах эрх шилжүүлэх гэрээнд шилжиж буй шаардлагыг “М” ХХК-ийн хожим хэрэгжүүлэх мөнгөн хөрөнгийг шаардах эрх гэж тусгасан. Харин хэргийг хянан шийдвэрлэх явцад уг эрх нь “М” ХХК-ийн эсрэг хэрэгжүүлэх “Итгэлцлийн гэрээ”-ний шаардах эрх үү? эсхүл Г-ийн эсрэг гаргах үндэслэлгүй хөрөнгөжихөөс үүдэлтэй шаардах эрх үү? гэдгийг тодруулах шаардлагатай гэж үзжээ. Гурван шатны шүүхээс иргэд болон “С” ХХК-ийн хооронд байгуулагдсан гэрээг хүчин төгөлдөр гэж дүгнэсэн ба энэ нь үндэслэлгүй хөрөнгөжихтэй холбоотой шаардлагыг шилжүүлсэн гэх үндэслэл болжээ.

Шүүхийн энэхүү шийдэл нэг талаас “М” ХХК болон иргэдийн хооронд байгуулсан гэрээ нь хүчин төгөлдөр бус хэлцэл бол анхнаасаа нэг талд үүрэг, нөгөө талд шаардах эрх үүсгэхгүй. Тийм ч учраас нэр бүхий 8 иргэн анхнаасаа өөрт байхгүй эрхээ гуравдагч этгээд “С” ХХК-д шилжүүлэх нь техникийн хувьд боломжгүй хэдий ч нэгэнт мөнгө олгосон бодит үйлдлийг зөв зүйтэй үнэлэхийн тулд талууд энэхүү мөнгөн хөрөнгийг буцаан шаардах агуулга бүхий эрхийг шилжүүлэх хүсэлтэй байсан хэмээн хүсэл зоригийн илэрхийллийг өөрчлөн тайлбарласан. Энэхүү эрх нь хуулийн ямар зохицуулалтад үндэслэн байх нь ач холбогдолгүй, гол нь хүчингүй гэрээний үндсэн дээр олгосон мөнгийг буцаах хүсэл зориг нотлогдсон хэмээн тайлбарласан нь оновчтой байна.

²⁸ Ё.Кают нарын зохиогчид, 2010, 213 дах тал.

Дээрх шийдлээс үзвэл шилжиж буй шаардах эрхийн агуулга тодорхой байх гэдэг нь хэн хэнээс юуг, ямар хэмжээгээр шаардах агуулгыг хангалттай тусгасан, өөрөөр хэлбэл шаардлагын агуулгыг хууль тайлбарлах аргаар тогтоох боломжтой байх ёстой. Энэ хүрээнд шаардах эрх нь хуулийн систем, бүтцийн аль хэсэгт үндэслэн үүссэн болохыг нарийвчлан тодорхойлсон байхаас илүүтэй, буцаан шаардах эрх агуулгын хувьд үүссэн байх нь чухал ажээ.

2.1.3. Шаардах эрхийг шилжүүлэх боломжтой байх

Өмнө нь дурдсанчлан шаардах эрхийг гуравдагч этгээдэд шилжүүлж болохгүй хэд хэдэн тохиолдлуудыг хууль тогтоомжид тусгасан байдаг. Тухайлбал, үүнд: хуульд харшилсан буюу хуулиар хориглосон (ИХ-ийн 123.2), шилжиж буй шаардах эрхийг үндэслэж буй үүргийн мөн чанарт харш эсхүл тийнхүү шилжүүлснээр эрх өөрчлөгдөх бол, үүрэг гүйцэтгүүлэгч болон үүрэг гүйцэтгэгч нар нь харилцан тохиролцож шаардах эрх шилжихийг хязгаарласан (ИХ-ийн 123.3) нөхцөлүүд хамаарна.

ИХ-ийн 123.2-т “хууль, гэрээ болон үүргийн мөн чанарт харшлахгүй бол” гэж ерөнхий байдлаар хуульчилснаар тодорхой нэг харилцаа, түүнд үйлчлэх эрх зүйн зохицуулалт, үүргийн төрлөөс хамаарч тухайлсан тохиолдолд бүрд “харшлах” эсэх талаар дүгнэлт хийх эрхийг хууль тогтоогч шүүхэд олгожээ. Судалгааны явцад дээрх байдлаар шүүх тайлбар, дүгнэлт өгч шийдвэрлэсэн ач холбогдол бүхий үндсэн хоёр төрлийн агуулга бүхий маргаан байв. Эхний төрөл нь банк, зээлийн үйл ажиллагаа эрхлэх эрх бүхий хуулийн этгээдээс олгох зээлийн гэрээний зээлдүүлэгчийн эрхийг шилжүүлсэн талаарх маргаан бол дараагийн төрөл нь гэм хороос үүдэлтэй шаардах эрхийг шилжүүлэхтэй холбоотой маргаан байв.

Жишиг шүүхийн шийдвэр 5²⁹

Маргааны төрөл	Барьцаалан зээлдүүлэх байгууллагын зээл, Бусад зээл
<p>Маргааны агуулга:</p>	<p>“С ББСБ” ХХК нь тусгай зөвшөөрлийн үндсэн дээр банк бус санхүүгийн үйл ажиллагаа явуулдаг бөгөөд “Э” ХХК-тай 2014 оны 03 сарын 31-ний өдөр зээлийн гэрээ байгуулж, түүнд 2,000,000 ам.долларыг 12 сарын хугацаатайгаар зээлдүүлсэн.</p> <p>“С ББСБ” ХХК дээрх зээлийн гэрээний шаардах эрхээ өөрийн хувьцаа эзэмшигч Д.Н-д шилжүүлэхээр харилцан тохиролцсон ба “Э” ХХК үүнийг нь зөвшөөрч талууд 2014 оны 11 сарын 03-ны өдөр шаардах эрх шилжүүлэх гэрээ байгуулсан. Тус гэрээ ёсоор Д.Н нь зээлийн гэрээний үндсэн төлбөр, үндсэн хүүгийн төлбөрийг шаардах эрхийг, “С ББСБ” ХХК нь нэмэгдүүлсэн хүү шаардах эрхийг тус тус хэрэгжүүлэхээр тусгасан.</p> <p>Удалгүй “С ББСБ” ХХК-ийн тусгай зөвшөөрлийн хугацаа 2015 оны 04 сарын 30-ны өдөр дуусгавар болж сунгагдаагүй. Үүний хажуугаар “Э” ХХК нь зээлээ эргүүлэн төлөхгүй байсан учир Д.Н нь 2015 оны 12 сарын 23-ны өдөр зээлийн гэрээнд нэмэлт өөрчлөлт оруулан зээлийн хугацааг сунгаж, тогтоосон хугацаанд төлөөгүй тохиолдолд 0.5 хувиар тооцож “Э” ХХК-иар алданги төлүүлэхээр болсон. Гэсэн хэдий ч дээрх хугацаанд “Э” ХХК төлбөрөө төлөхгүй байсаар 2019 оны 05 сарын 08- ны өдөр Д.Н нь уг шаардах эрхээ “С ББСБ” ХХК-д буцаан шилжүүлсэн.</p> <p>Ингээд “С ББСБ” ХХК нь “Э” ХХК-д холбогдуулан зээлийн гэрээний үндсэн төлбөр, хүү, нэмэгдүүлсэн хүү 2,711,000 ам.доллар болон алданги 1,316,000 ам.доллар нийт 4,027,000 ам.доллар буюу 10,666,435,710 төгрөг гаргуулж, үүргийн гүйцэтгэлийг барьцаа хөрөнгөөр хангуулах шаардлага бүхий нэхэмжлэлийг шүүхэд гаргасан.</p>

²⁹ Хан-Уул дүүргийн Иргэний хэргийн анхан шатны шүүхийн 2019 оны 09 сарын 25-ны өдрийн 183/ШШ2019/02012 дугаартай шийдвэр, Нийслэлийн Иргэний хэргийн давж заалдах шатны шүүхийн 2019 оны 11 сарын 18-ны өдрийн 1942 дугаартай магадлал, Улсын дээд шүүхийн 2021 оны 04 сарын 15- ны өдрийн 001/ХТ2021/00392 дугаартай тогтоол.

<p>Анхан шатны шүүх:</p>	<p>Нэхэмжлэгч “С ББСБ” ХХК нь 2014 оны 11 сарын 03-ны өдрийн эрх шилжүүлэх гэрээг үндэслэн эрх хүлээн авагч Д.Н 2015 оны 12 сарын 23- ны өдөр 3 дугаартай Зээлийн гэрээ сунгах тухай нэмэлт гэрээ байгуулан “Э” ХХК-иас анз нэхэмжилсэн нь хуульд нийцээгүй байна.</p> <p>ИХ-ийн 123.6-д “Шаардах эрхийг шинэ үүрэг гүйцэтгүүлэгчид шилжүүлснээр түүнтэй холбоотой бусад эрх болон түүнийг хангах арга нэгэн зэрэг шилжинэ” гэж заасан байх тул 2014 оны 03 сарын 31-ний өдрийн 01 дугаар “Зээлийн гэрээ”-ний эрх, түүнийг хангах арга Д.Н-д шилжсэн байхад 2015 оны 12 сарын 23-ны өдрийн 03 дугаартай “Зээлийн гэрээг сунгах тухай нэмэлт гэрээ” байгуулан анз буюу нэмэлт шаардах эрхийг бий болгосон уг хэлцэл нь ИХ-ийн 56.1.8-д зааснаар зохих этгээдийн зөвшөөрөлгүй хийсэн хүчин төгөлдөр бус байх хэлцэл болсон гэж дүгнээд зээлийн гэрээний үндсэн төлбөр, хүү, нэмэгдүүлсэн хүү нийт 2,432,000 ам.доллар буюу 6,441,711,360 төгрөгийг хариуцагчаас гаргуулж нэхэмжлэгчид олгож, нэхэмжлэлийн шаардлагаас үлдэх алдангитай холбоотой хэсгийг хэрэгсэхгүй болгон үүргийн гүйцэтгэлийг барьцаа хөрөнгөөр хангуулахаар шийдвэрлэсэн.</p>
<p>Давж заалдах шатны шүүх:</p>	<p>Анхан шатны шүүхийн шийдвэрийг хэвээр үлдээж шийдвэрлэсэн.</p>
<p>Хяналтын шатны шүүх:</p>	<p>Зээлийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг хүчингүй болгосон үеэс “С ББСБ” ХХК нь хэтэрсэн хугацааны хүү шаардах эрхгүй, хэтрүүлсэн хугацааны хүү төлөхийг хүлээн зөвшөөрсөн хариуцагчийн бичгээр гаргасан баримтыг үндэслэх нь хууль зөрчихөөс гадна хариуцагч энэ талаар маргасан тул зээлийн хүүг гаргуулахыг хүссэн нэхэмжлэгчийн итгэмжлэгдсэн төлөөлөгчийн гомдлыг хангахгүй орхино.</p> <p>2014 оны 11 сарын 03-ны өдөр 3 талт гэрээ байгуулж “С ББСБ” ХХК зээлийн гэрээний шаардах эрхээ иргэн Д.Н-д шилжүүлсэн, Д.Н нь 2019 оны 05 сарын 08-ны өдөр шаардах эрхийг буцаан шилжүүлсэн нь зээлийн үйл ажиллагаа эрхлэх хуулиар тогтоосон журамд нийцээгүй боловч шүүх “С ББСБ” ХХК-ийн тусгай зөвшөөрлийг хүчингүй болгосон 2015 оны 04 сарын 31-ний өдрийг хүртэл хугацаанд зээлдэгч “Э” ХХК-ийн биелүүлэх ёстой үүргийг тооцсон байх тул хариуцагчийн эрхийг дордуулаагүй гэж дүгнээд шийдвэр, магадлалыг хэвээр үлдээсэн. (Хүүгийн тооцооллыг алдааг залруулж 32,366,507 төгрөгийг нэмж өөрчлөлт оруулсан)</p>

Манай улсын хувьд банк, зээлийн үйл ажиллагаа эрхлэх эрх бүхий хуулийн этгээдийн зээл олгох үйл ажиллагааг ИХ-ийн 451-453 болон Банкны тухай хууль, Банк, эрх бүхий этгээдийн мөнгөн хадгаламж, төлбөр тооцоо, зээлийн үйл ажиллагааны тухай хууль, Банк бус санхүүгийн үйл ажиллагааны тухай хууль зэрэг тусгайлсан хэм хэмжээгээр зохицуулдаг. Ийнхүү тодорхой субъектэд эрх олгосноор байгуулах арилжааны зээлийн гэрээ нь СЗХ зэрэг эрх бүхий байгууллагаас авсан зөвшөөрлийн үндсэн дээр эрхлэх боломжтой үйл ажиллагаа юм.

Гурван шатны шүүх тохиолдлын хүрээнд шилжиж буй шаардлагыг үндэслэж буй гэрээ буюу “С ББСБ” ХХК болон “Э” ХХК-ийн хооронд байгуулагдсан “Зээлийн гэрээ”-г зээлийн гэрээний тусгай төрөл болох ИХ-ийн 451-д заасан банк, зээлийн үйл ажиллагаа эрхлэх эрх бүхий хуулийн этгээдээс олгох зээлийн гэрээ гэж зөв тодорхойлсон. Энэ ч үүднээсээ тухайн төрлийн гэрээнд анз хэрэглэхгүй байх, хэтэрсэн хугацаанд хүү шаардах эрх нь “С ББСБ” ХХК-ийн тусгай зөвшөөрөл хүчингүй болсноор дуусгавар болох гэх зэргээр холбогдох эрх зүйн зохицуулалтыг хэрэглэсэн.

Харин анхан шатны шүүх болон давж заалдах шатны шүүх “С ББСБ” ХХК нь уг зээлийн гэрээний үндсэн шаардах эрхээ Д.Н-д шилжүүлэхээр харилцан тохиролцож гэрээ байгуулснаар Д.Н нь үүрэг гүйцэтгүүлэгч болсон гэж дүгнэснээс үзэхэд банк, тусгай зөвшөөрөл бүхий хуулийн этгээд зөвшөөрлийн үндсэн дээрх эрхлэх үйл ажиллагааныхаа хүрээнд байгуулсан гэрээний шаардлагыг иргэн, хуулийн этгээдэд шилжүүлэх нь ИХ-ийн 123.2-т заасан хууль болон үүргийн мөн чанарт харшлахгүй гэж үзжээ. Харин хяналтын шатны шүүхээс уг шаардах эрх шилжих хэлцлийг “зээлийн үйл ажиллагааг эрхлэх хуулиар тогтоосон журамд нийцээгүй” гэсэн боловч ийнхүү дүгнэсэн үндэслэлээ дэлгэрэнгүй тайлбарлаагүй байна.

Энэ шийдвэрийн хүрээнд ИХ-ийн 56.1.1, 56.1.8-д заасан хэлцэл хүчингүй гэж тооцвол зохих ерөнхий зохицуулалтыг банк, санхүүгийн үйл ажиллагаа эрхлэх байгууллагын үйл ажиллагааг

зохицуулах зорилго бүхий хууль тогтоомжтой хэрхэн хослуулан хэрэглэх тухай асуудлыг нэг мөр болгох шаардлагатай. Судалгааны багийн зүгээс эрх зүйн харилцаанд нэгэнт үүссэн шаардлагыг цааш банк, санхүүгийн үйлчилгээ эрхлэх байгууллагад шилжүүлэх нь өөрөө үүргийн мөн чанарт харшлахгүй. Уг шаардах эрхийг шилжүүлэн авч буй иргэн энэ төрлийн зээлийн гэрээг байгуулах эрхгүй байгаа нь нэгэнт банк, санхүүгийн байгууллагад үүссэн шаардах эрхийг шилжүүлэх хуулийн хориг болох ёсгүй. Үүнийг шүүх дараах шийдвэрээрээ бататган шийдвэрлэсэн нь ИХ-ийн 260-д шаардах эрхийг эрх зүйн гүйлгээний объект болгосон зохицуулалттай нийцэх шийдэл юм.

Энэ хүрээнд нэг шаардах эрхийг шилжүүлэн авснаар үүргийн харилцаанд бүхэлд нь тал болж орох нэг талаас, нөгөө талаас зөвхөн тухайн авлагыг гүйлгээнд оруулж, хэрэгжүүлэх эрхийг олж авах 2 институци байгааг ялгах шаардлагатай. Банк, санхүүгийн байгууллагатай зөвхөн 1 зээлийн гэрээний буцаан шаардах эрхийг шилжүүлэн гэрээ хийх нь ИХ-ийн 260-д шаардах эрхийг эрх зүйн гүйлгээний объект байх шийдлийг илтгэж буй хэрэг. Харин банкны зээлийн гэрээнд тусгай зөвшөөрөлгүй этгээд тал болж орох, субъект солих агуулга бүхий гэрээ хүчингүй бөгөөд гагцхүү эрх залгамжлалын тусламжтай, тусгай зөвшөөрөлтэй этгээд бүрэн тал болж орох агуулга бүхий гэрээ боломжтой. Тиймээс шүүх гэрээний агуулгыг судлах явцдаа зээлдүүлэгчид нэгэнт үүссэн дан шаардах эрхийг шилжүүлэхэд эрх хүлээн авагчийн субьектэд тавих шаардлагыг харилцан адилгүй авч үзэх ёсгүй.

Харьцуулсан эрх зүйн түвшинд зээлийн үйл ажиллагаа эрхлэгч хуулийн этгээд аж ахуйн үйл ажиллагаанаас үүдэлтэй шаардах эрхийг бусад иргэн болон өөрийн хувь нийлүүлэгчдээ шилжүүлэх явдал тун хомс бол факторингийн үйлчилгээ эрхлэгчийг гагцхүү ийнхүү өр барагдуулах зорилгоор байгуулж, түүнд шаардлагаа шилжүүлдэг. Хувь нийлүүлэгчид шаардлага шилжүүлэхэд дампуурлын хууль тогтоомжийн зөрчил бий эсэхийг, ялангуяа дампуурлын хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа үүсэх, хөрөнгийн

ШААРДАХ ЭРХ ШИЛЖҮҮЛЭХ ГЭРЭЭТЭЙ ХОЛБООТОЙ МАРГААН ШИЙДВЭРЛЭСЭН ШҮҮХИЙН ШИЙДВЭРТ ХИЙСЭН ДҮН ШИНЖИЛГЭЭ

массаас хууль бусаар хөрөнгийг гишүүний хувийн хөрөнгөд шилжүүлээгүй байх гэсэн ерөнхий хориг үйлчилнэ. Энэ төрлийн үйлдэл үгүй бол нэгэнтээ үүссэн банкны зээлийн гэрээний аль нэг шаардлагыг эрх зүйн гүйлгээнд оруулах, бусдад шилжүүлэх боломжтой.

Жишиг шүүхийн шийдвэр 6³⁰

Маргааны төрөл	Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулиар бусад
<p>Маргааны агуулга:</p>	<p>“Э” ХЗХ нь хадгаламж, зээлийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл эзэмшигч бөгөөд энэ төрлийн үйл ажиллагааныхаа хүрээнд Д.М, Д.АМ нараас зээлийн гэрээний төлбөр гаргуулахаар шүүхэд нэхэмжлэл гаргасан. Улмаар 2015 онд гурван шатны шүүхийн хуулийн хүчин төгөлдөр шийдвэр, магадлал, тогтоолоор Д.М-ээс 527,045,208 төгрөг Д.АМ-аас 27,328,044 төгрөгийг гаргуулж “Э” ХЗХ-д олгож шийдвэрлэсэн.</p> <p>Үүний дараа 2016 оны 03 сарын 04-ний өдөр Санхүүгийн зохицуулах хорооноос “Э” ХЗХ-ийн хадгаламж, зээлийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг түдгэлзүүлсэн.</p> <p>Д.М болон Д.АМ нар нь шүүхийн шийдвэрт заасан төлбөрийг төлөөгүй байсан тул “Э” ХЗХ нь М.Г-д 2017 оны 03 сарын 29-ний өдөр гэрээ байгуулан дээрх шаардах эрхүүдээ шилжүүлсэн ба уг гэрээг үндэслэн 2017 оны 04 сарын 05-ны өдөр Нийслэлийн шүүхийн шийдвэр гүйцэтгэх газарт шүүхийн шийдвэр гүйцэтгэх хэрэг үүсгэсэн.</p> <p>2019 оны 03 сарын 15-ны өдөр “Э” ХЗХ нь татан буугдаж, улсын бүртгэлээс хасагдсан. Улмаар Д.М шүүхэд нэхэмжлэл гаргаж “шаардах эрх шилжүүлэх гэрээг хүчин төгөлдөр бус болохыг тогтоолох, шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагаа үүсгэх тогтоолыг хүчингүй болгуулах, ажиллагааг дуусгавар болгох” шаардлагыг гаргасан.</p>

³⁰ Баянгол дүүргийн Иргэний хэргийн анхан шатны шүүхийн 2021 оны 09 сарын 22-ны өдрийн 102/ШШ2021/02375 дугаартай шийдвэр, Нийслэлийн Иргэний хэргийн давж заалдах шатны шүүхийн 2021 оны 12 сарын 01-ний өдрийн 210/МА2021/01728 дугаартай магадлал.

Маргааны төрөл	Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулиар бусад
<p>Анхан шатны шүүх:</p>	<p>ИХ-ийн 123.2-т зааснаар шаардах эрхээ шилжүүлэх гэрээг хууль, гэрээ болон үүргийн мөн чанарт харшилсан хэлцэл гэж үзэх үндэслэл тогтоогдохгүй байна. “Э” ХЗХ нь шаардах эрхээ М.Г-д шилжүүлснээр тухайн шаардах эрхийн агуулга болон үүргийн мөн чанар өөрчлөгдөөгүй байна. Хадгаламж зээлийн хоршооны тухай хуулийн 18.1.1-д энэ хуулийн 13.4-д заасан үйл ажиллагаа эрхлэх тусгай тусгай зөвшөөрлийг нь түдгэлзүүлсэн буюу хүчингүй болгосноос хойш зөвхөн хадгаламж, зээлийн үйл ажиллагаа эрхлэхийг хориглохоор заасан байна.</p> <p>“Э” ХЗХ-ийн гүйцэтгэх захирал, М.Г нарын хооронд 2017 оны 03 сарын 29-ний өдөр хийгдсэн шаардах эрхээ шилжүүлэх гэрээг хуулиар хориглосон буюу зөвшөөрөөгүй, нийтээр хүлээн зөвшөөрсөн зан суртахууны хэм хэмжээнд харшилсан, зээлийн үйл ажиллагаа эрхлэх үндсэн зорилгоо зөрчиж хийсэн хэлцэл гэж үзэх үндэслэл тогтоогдохгүй байна хэмээн дүгнээд Д.М-ийн нэхэмжлэлийн шаардлагыг бүхэлд нь хэрэгсэхгүй болгосон.</p> <p>ИХ-ийн 123.1-д Шаардах эрх шилжих тухай үүрэг гүйцэтгэгчид мэдэгдэх хүртэл үүрэг гүйцэтгэгч анхны үүрэг гүйцэтгүүлэгчийн өмнө гэрээгээр хүлээсэн үүргээ гүйцэтгэнэ гэж заасан бөгөөд хуульд заасны дагуу шаардах эрх шилжүүлэх тухай гэрээ байгуулснаар шаардах эрх нь шинэ үүрэг гүйцэтгэгчид шилждэг.</p>
<p>Давж заалдах шатны шүүх:</p>	<p>Мөн хуулийн 123.2-т зааснаар хууль, гэрээ буюу үүргийн мөн чанарт харшлахгүй бол шаардах эрх эзэмшигч нь гуравдагч этгээдтэй байгуулсан гэрээний үндсэн дээр үүрэг гүйцэтгэгчийн зөвшөөрөлгүйгээр шаардах эрхээ шилжүүлж болохоор заасан байх бөгөөд “Э” ХЗХ нь М.Г- д хариуцагч Д.М, Д.АМ нараас шүүхийн хүчин төгөлдөр шийдвэрээр тогтоосон зээлийн гэрээний үүрэг шаардах эрхээ шилжүүлсэн нь хууль болон гэрээний мөн чанарт харшилсан гэж үзэх үндэслэл тогтоогдоогүй, түүнчлэн шаардах эрхийн агуулга болон мөн чанар өөрчлөгдсөн гэж үзэхээргүй байна.</p>

Маргааны төрөл	Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулиар бусад
	<p>Анхан шатны шүүх “Э” ХЗХ-ны гүйцэтгэх захирал Т.Н, М.Г нарын хооронд 2017 оны 03 сарын 29-ний өдөр хийгдсэн “Шаардах эрхээ шилжүүлэх гэрээ”-г хуулиар хориглосон буюу зөвшөөрөөгүй, нийтээр хүлээн зөвшөөрсөн зан суртахууны хэм хэмжээнд харшилсан, “Э” ХЗХ нь хадгаламж, зээлийн үйл ажиллагаа эрхлэх үндсэн зорилгоо зөрчиж хийсэн хэлцэл гэж үзэх үндэслэлгүй гэж дүгнэсэн нь хууль зүйн үндэслэлтэй байх тул нэхэмжлэгчийн итгэмжлэгдсэн төлөөлөгчийн тус хорооны дарга, гүйцэтгэх захирал нар албан тушаалаа ашиглан, тус хорооны гишүүдэд ашиггүй, сонирхлын зөрчилтэй шаардах эрх шилжүүлэх гэрээ байгуулсан нь Хадгаламж зээлийн хоршооны тухай хууль болон Хадгаламж зээлийн хоршооны дүрмийг зөрчсөн гэсэн давж заалдах гомдол үндэслэлгүй байна гэж үзэн анхан шатны шүүхийн шийдвэрийг хэвээр үлдээж шийдвэрлэсэн.</p>

Дээрх тохиолдолд хадгаламж, зээлийн хоршооны үйл ажиллагаа нь мөн л тусгайлсан хууль болох Хадгаламж, зээлийн хоршооны тухай хуулиар зохицуулагдаж, зээлийн гэрээ нь ИХ-ийн 451-д хамаардаг. Анхан болон давж заалдах шатны шүүх *Жишиг шийдвэр 5*-д дурдсан хоёр шатны шүүхүүдтэй нэгэн адилаар гуравдагч этгээдэд шаардах эрхээ шилжүүлэх нь тухайн зээлийн гэрээний үүрэг шаардах эрхийн агуулгад нөлөөлөхгүй тул тус шилжүүлэг нь хууль зүйн хүчин төгөлдөр гэж дүгнэжээ. Энэ шийдвэрийн хувьд судалгааны түүвэрт багтсан шүүхээр хянан шийдвэрлэгдсэн бусад маргааны хүрээнд шилжиж буй шаардах эрхээс ялгаатай нь хуулийн хүчин төгөлдөр шүүхийн шийдвэрээр шаардах эрх үүссэн, дуусгавар болоогүй, хэрэгжүүлэх боломжтой болохыг нэгэнт тогтоосон байсан.

Шүүхийн шийдвэр, магадлалаар ийм шаардлага буюу шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн шатанд буй төлбөр авагчийн шаардах эрхийг шилжүүлэх боломжтой гэж дүгнэсэн эрх зүйн ач холбогдолтой байв.

Харьцуулсан эрх зүйн түвшинд судалбал шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн хүрээнд шаардах эрхийг битүүмжилж үл болох хүрээнд шилжүүлэхийг хориглодог. Энэ хориг нь үүрэг гүйцэтгүүлэгчийн амьжиргааны доод түвшнийг хангах зорилготой. Жишээ нь хөдөлмөрийн гэрээ болон бусад авлагын эзний эсрэг шаардлагыг хэрэгжүүлэх нөхцөлд битүүмжилж үл болох хэсэг нь бусдад шаардах эрх шилжүүлэх гэрээгээр шилжих боломжгүй³¹. Хэдийгээр энэ хориг ИХ болон шийдвэр гүйцэтгэх хууль тогтоомжийн хүрээнд бүрэн тусгагдаагүй, эдгээрийн зорилго зорилт нь харилцан адилгүйгээс ИХШХША болон дампуурлын хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд шаардлагыг гүйцэтгэхэд өөр өөр зарчим үйлчлэх зэргээс улбаалан практик хэрэглээг тухай бүр нь нягталж, танах байдлаар хэрэгжиж байгаа ч дэлхий нийтийн жишигт нийцүүлэн ИХ-даа холбогдох хоригийг тусган тайлбарлаж ява нь эрх зүйн тодорхой байдлыг бий болгоно.

Жишиг шүүхийн шийдвэр 7³²

Маргааны төрөл	Банкны зээл
Маргааны агуулга:	“Б” банк нь Т-д 200,000,000 төгрөгийг жилийн 20.4 хувийн хүүтэй, 36 сарын хугацаатай зээлдүүлэхээр харилцан тохиролцож зээлийн гэрээ байгуулсан. Т нь зээлийн гэрээний үүргийн гүйцэтгэлийг баталгаажуулж өөрийн өмчлөлийн 3 үл хөдлөх хөрөнгийг “Б” банканд барьцаалж, улсын бүртгэлд бүртгүүлсэн.

³¹ ХБНГУ-ын ИХ-ийн хэсгээс:

- 400. Битүүмжилж үл болох шаардлагыг шилжүүлж үл болох тухай.
Битүүмжилж үл болох хэсгээр шаардлагыг шилжүүлж үл болно.
- 394. Битүүмжилж үл болох шаардлагатай тооцож үл болох тухай
Битүүмжилж үл болох шаардлагыг нэхэмжлэлийн шаардлагатай тооцож үл болно. Эрүүл мэндийн даатгалын, тусламжийн болон нас барсны тэтгэмжийн сангаас олгох шаардах эрхтэй, ялангуяа халамжийн сан, халамжийн холбоодоос гаргуулах шаардлагатай тооцож болно.

³² Баянзүрх дүүргийн Иргэний хэргийн анхан шатны шүүхийн 2023 оны 01 сарын 07-ны өдрийн 102/ШШ2023/00311 дугаартай шийдвэр, Нийслэлийн Иргэний хэргийн давж заалдах шатны шүүхийн 2023 оны 03 сарын 31-ний өдрийн 210/МА2023/00696 дугаартай магадлал.

ШААРДАХ ЭРХ ШИЛЖҮҮЛЭХ ГЭРЭЭТЭЙ ХОЛБООТОЙ МАРГААН ШИЙДВЭРЛЭСЭН ШҮҮХИЙН ШИЙДВЭРТ ХИЙСЭН ДҮН ШИНЖИЛГЭЭ

Маргааны төрөл	Банкны зээл
	<p>Зээлийн гэрээний хугацаа дуусгавар болоход Т нь 80,000,000 төгрөгийн төлбөр төлөөд байсан тул “Б” банк нь 2022 оны 08 сарын 03-ны өдөр шүүхэд нэхэмжлэл гаргасан.</p> <p>Тус иргэний хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад буюу 2022 оны 12 сарын 05-ны өдөр “Б” банк нь “К” ХХК-тай “Чанаргүй зээлийн багц худалдах, худалдан авах гэрээ”-г байгуулсан. Уг зээлийн багцад Т-д холбогдох зээлийн гэрээний эрх хамаарч байсан тул шүүхээс “Б” банкны оронд “К” ХХК-г нэхэмжлэгчээр сольсон.</p>
<p>Анхан шатны шүүх:</p>	<p>Нэхэмжлэгч “Б” банк хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад хэргийн оролцогчийн эрх, үүргээ “К” ХХК-д шилжүүлж тухайн хуулийн этгээд иргэний хэргийн оролцогчийн эрх залгамжлагч болсноор хуульд заасан эрхээ хэрэгжүүлэн зээл төлөхийг шаардах эрхтэй.</p> <p>Мөн хуулийн 153.1, 156.2, 166.1-д заасны дагуу барьцааны гэрээг бичгээр байгуулж, улсын бүртгэлд бүртгүүлэх үндэслэл шаардлагыг хангасан тул нэхэмжлэгч барьцаа хөрөнгөөр нэхэмжлэлийн шаардлагыг хангуулах эрхтэй гээд нэхэмжлэлийн шаардлагыг хангаж шийдвэрлэсэн.</p>
<p>Давж заалдах шатны шүүх:</p>	<p>ИХ-ийн 123.2-т зааснаар хууль, гэрээ буюу үүргийн мөн чанарт харшлахгүй бол шаардах эрх эзэмшигч нь гуравдагч этгээдтэй байгуулсан гэрээний үндсэн дээр үүрэг гүйцэтгэгчийн зөвшөөрөлгүйгээр шаардах эрхээ шилжүүлж болно. Өөрөөр хэлбэл, шаардах эрхийг бусдад шилжүүлж болох боловч энэ нь хууль болон гэрээний мөн чанарт харшлахгүй байх ёстой.</p> <p>Банкны тухай хуулийн 6 дугаар зүйлд банкны эрхлэх үйл ажиллагааг, мөн хуулийн 7 дугаар зүйлд банканд хориглох үйл ажиллагааг тус тус нэрлэн заасан. Тухайлбал, банк нь Монгол банкны зөвшөөрөлтэйгөөр мөн хуулийн 6.1.11-д зааснаар зээл болон санхүүгийн бусад хэрэгслийг худалдах, худалдан авах үйл ажиллагааг эрхлэх боловч энэ нь тусгай зөвшөөрлийн үндсэн дээр банк болон банкны үйл ажиллагаа эрхлэх хуулийн этгээдүүдийн хооронд хамаарах эсэхийг анхан шатны шүүх анхаараагүй байна.</p>

Маргааны төрөл	Банкны зээл
	<p>Өөрөөр хэлбэл, “Б” банк болон “К” ХХК-ийн хооронд байгуулагдсан чанаргүй зээл худалдах-худалдан авах гэрээгээр шаардах эрх “Б” ХХК-д шилжсэн хэлцэл нь хуульд нийцсэн, хүчин төгөлдөр нөхцөлд нэхэмжлэгчид шаардах эрх үүснэ. Ийнхүү дээрх гэрээний хүчин төгөлдөр байдлын талаар шүүх дүгнэлт өгөхөд эрх шилжүүлэгч “К” ХХК-ийн эрх ашиг сонирхол хөндөгдөж болзошгүй тул түүнийг хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцуулах эсэхийг тодруулах шаардлагатай хэмээн анхан шатны шүүхийн шийдвэрийг хүчингүй болгож дахин хэлэлцүүлэхээр буцаасан.</p>

Анхан шатны шүүх “Б” ХХК болон “К” ХХК-ийн хооронд байгуулагдсан “Чанаргүй зээлийн багц худалдах, худалдан авах гэрээ”-г үндэслэн иргэний хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд явцад нэхэмжлэгчээр “К” ХХК-г сольсон үйл баримт нь “К” ХХК-ийн зүгээс авлага худалдан авсан гэрээг хүчин төгөлдөр гэж дүгнэсэн явдал юм. Харин давж заалдах шатны шүүхээс уг хэлцэл нь тусгай зөвшөөрөл бүхий үйл ажиллагааны хүрээнд хамаарах гэрээний эрх, үүргийг шилжүүлэх агуулгатай учир “К” ХХК нь дээрх шаардах эрхийг шилжүүлэн авах эрхтэй эсэх нөхцөл байдлыг тодруулах, дүгнэлт шаардлагатай гэжээ. Хэрэв шинэ үүрэг гүйцэтгүүлэгч “К” ХХК нь эрх бүхий байгууллагаас зөвшөөрөл аваагүй нөхцөлд шаардах эрх шилжүүлэн авах боломжгүй гэсэн байр суурийг давж заалдах шатны шүүх баримталжээ.

Дээрх гурван тохиолдлын хүрээнд шилжиж буй шаардлагыг үндэслэж буй гэрээ нь ИХ-ийн 451-д заасан банк, зээлийн үйл ажиллагаа эрхлэх эрх бүхий хуулийн этгээдээс олгох зээлийн гэрээ байх ба зээлдүүлэгч талын шаардах эрхийг энэ төрлийн тусгай зөвшөөрөл эзэмшдэггүй иргэн, хуулийн этгээдэд шилжүүлэхээр харилцан тохиролцсон байв. Энэ төрлийн зээлийн гэрээний ИХ-ийн 281-д заасан иргэд хоорондын зээлийн гэрээнээс ялгарах үндсэн шинжийг дурдвал гэрээний нэг тал болох зээлдүүлэгч нь хуулийн

дагуу зээлийн үйл ажиллагааг дагнан явуулах зөвшөөрөл авсан байх, гэрээний зүйл буюу зээлдүүлэх хөрөнгө нь зөвхөн мөнгө байх, нарийвчилсан хууль тогтоомжоор зохицуулагддаг байх зэрэг юм.

Шүүхүүд хэрэг маргааныг хянан шийдвэрлэхдээ шаардах эрх шилжүүлэх хэлцлийг харилцан зөрүүтэй байр сууриас дүгнэжээ. Дийлэнх тохиолдолд³³ эрх бүхий хуулийн этгээдийн зээлийн гэрээний шаардах эрхийг тусгай зөвшөөрөлгүй иргэн, хуулийн этгээдэд шилжүүлэх нь хууль болон үүргийн мөн чанарт харшлахгүй гэж үзсэн бол зарим тохиолдолд ийнхүү шилжүүлэх нь хуулиар хязгаарлагдсан гэх байр суурийг төлөөлжээ³⁴. Шаардах эрх шилжүүлнэ гэдэг нь үндсэндээ уг эрхийг шинэ үүрэг гүйцэтгүүлэгчид шилжүүлэх гэрээ юм³⁵. ИХ-ийн 451-т зохицуулагдсан зээлийн гэрээний зээлдүүлэгчийн үндсэн шаардлага гаргах эрх гэрээний чөлөөт байдлын зарчмын үндсэн дээр тухайлсан шалгуур хангаагүй гуравдагч этгээдэд чөлөөтэй шилжиж, үүрэг гүйцэтгүүлэгч нь өөрчлөгдөх боломжтой гэж үзвэл ИХТА-ийн 281-т заасан ердийн зээлийн гэрээнээс ялгарах үндсэн гол шинж үгүй болно хэмээн зарим шүүх эмээж байна. Өөрөөр хэлбэл шүүхээс үүргийн харилцааг тодорхойлж буй үүрэг гүйцэтгүүлэгчийг солигдсон хэмээн дүгнэж, өөр этгээд үүргийн харилцаа хэвээр байгаа мэтээр нарийвчилсан хуулийн зохицуулалтыг хэрэглэх нь тодорхойгүй байдал авчрах эрсдэлтэй хэмээн үзсэн.

Энэ тохиолдолд шүүхүүд холбогдох хууль тогтоомжийн зорилгыг анхаарч үзэх буюу банк, зээлийн үйл ажиллагаа эрхлэх эрх бүхий хуулийн этгээдээс олгох зээлийн гэрээгээр зээлдүүлэгч тал нь ерөнхий зээлийн гэрээтэй харьцуулбал харьцангуй давуу эрхийг эдэлж буйг онцлох нь зүйтэй. Жишээ нь зээлийн гэрээний хугацаа дууссан ч хэтэрсэн хугацааны хүүг тооцож авах (ИХ-ийн 453.1), үндсэн хүүгийн 20 хүртэлх хувиар тооцож нэмэгдүүлсэн хүү авах (ИХ-ийн 453.2) гэх мэт. Энэ нь тухайн төрлийн хуулийн

³³ Авч үзсэн нийт 6 шийдвэр, магадлал, тогтоолоос 4-т нь

³⁴ Ханс Зайделийн Сан: шүүхийн шийдвэрийн дүн шинжилгээ, 2021 он, 99 дэх тал.

³⁵ Б.Буянхишиг, 2017, 240 дэх тал.

этгээдийн нийгэм, эдийн засагт үзүүлэх нөлөө, санхүүгийн зах зээлд эзлэх байр суурь зэрэгтэй нь шууд уялдаатай. Хууль тогтоогч зөвхөн тусгай шалгуурыг хангасан аж ахуйн нэгжийг энэхүү зээлийн гэрээний оролцогч байхыг хүссэн. Шүүхээс дээрх байдлаар зээлдүүлэгчийн эрх, үүргийг шаардлага шилжүүлэх замаар шилжүүлэн авах нь хуулийн хүчин төгөлдөр гэж дүгнэсэн нь банк, санхүүгийн байгууллагаас олгох зээлийн тухай хуулийн үндсэн зорилгыг хазайлгасан гэж зарим судлаачид үздэг.

Гэхдээ энд нэгэнт үүссэн шаардлагыг өөр бусад хууль тогтоомжид харшлаагүй, тусгай зөвшөөрөлгүй шилжүүлэн авагч зээлийн гэрээний тал болж бүх эрхийг шилжүүлэн аваагүй нөхцөлд ИХ-ийн 260-д шаардах эрхийг эрх зүйн гүйлгээний объект болгохыг зөвшөөрөх ёстой. Харин эрх үүсэх түвшинд банкны зээлийн гэрээг зөвхөн тусгай зөвшөөрөл бүхий этгээд байгуулах ба хожим тусгай зөвшөөрөлгүй этгээд эсвэл факторингийн үйл ажиллагаа эрхлэгч зэрэгт шилжих, мөн банк, ББСБ нь дампуурсан, татан буугдсан нь шаардлагыг дуусгавар болгох үзүүлэлт болохгүй.

Жилиг шүүхийн шийдвэр 8³⁶

Маргааны төрөл	Бусад хуулиар
Маргааны агуулга:	Иргэн Д.Б-д 2000 оны 01 сард НЗД-ын захирамжаар “Гэрлэх ёслолын ордон”-ы баруун талын хэсэг газарт амины орон сууц барих зөвшөөрөл олгогдсон бөгөөд 2000 оны 09 сард дээрх захирамжийг хүчингүй болгосон. Гэтэл дээрх хугацаанд Д.Б нь тус газарт байшин барьж ашиглалтад оруулаад байсан.

³⁶ Чингэлтэй дүүргийн Иргэний хэргийн анхан шатны шүүхийн 2020 оны 06 сарын 25-ны өдрийн 182/ШШ2020/01488 дугаартай шийдвэр, Нийслэлийн Иргэний хэргийн давж заалдах шатны шүүхийн 2020 оны 08 сарын 12-ны өдрийн 01756 дугаартай магадлал, Улсын дээд шүүхийн 2022 оны 09 сарын 29- ний өдрийн 001/ХТ2022/00871 дугаартай тогтоол.

ШААРДАХ ЭРХ ШИЛЖҮҮЛЭХ ГЭРЭЭТЭЙ ХОЛБООТОЙ МАРГААН ШИЙДВЭРЛЭСЭН ШҮҮХИЙН ШИЙДВЭРТ ХИЙСЭН ДҮН ШИНЖИЛГЭЭ

Маргааны төрөл	Бусад хуулиар
	<p>Улмаар Д.Б-ийн байшинг нураасан. 2019 онд Захиргааны хэргийн гурван шатны шүүхээс НЗД нь илт хууль бус захиргааны акт гаргасныг тогтоосон боловч үүний улмаас Д.Б-д учирсан хохирлыг иргэний хэргийн шүүхээр шийдвэрлүүлэх нь зүйтэй гэж дүгнэсэн.</p> <p>Д.Б нь тухайн хохирол шаардах эрхээ 2020 оны 02 сарын 14-ний өдрийн “Шаардах эрх шилжүүлэх гэрээ”-ээр И.Г-д шилжүүлсэн. Ингээд И.Г нь НЗДТГ-т холбогдуулан хохирлыг арилгуулахаар шүүхэд хандсан.</p>
<p>Анхан шатны шүүх:</p>	<p>ИХ-ийн 123.2-т Хууль, гэрээ буюу үүргийн мөн чанарт харшлахгүй бол шаардах эрх эзэмшигч нь гуравдагч этгээдтэй байгуулсан итгэмжлэлийн үндсэн дээр үүрэг гүйцэтгэгчийн зөвшөөрөлгүйгээр шаардах эрхээ шилжүүлж болно гэж заасан. Тус заалтын дагуу шилжүүлэх шаардах эрх нь хууль болон гэрээний дагуу үүссэн байх боломжтойн зэрэгцээ үүргийн мөн чанарт харшлахгүй буюу үүрэг гүйцэтгүүлэгчийн хувийн шинж байдалтай салшгүй холбоотой бий болсон эрхээс бусад эрх байхаар хуульд томъёолжээ. Захиргааны байгууллагын хууль бус актын улмаас учирсан эд хөрөнгийн хохирлыг шаардах эрх нь хуульд зааснаар үүсэх үүргийн эсрэг хэрэгжиж байх ба уг эрх бүхий этгээд шаардах эрхээ гуравдагч этгээдэд шилжүүлсэн нь үүргийн мөн чанарт харшлахгүй гэж үзлээ. Зарим төрлийн хуульд зааснаар үүсэх үүргүүд, тухайлбал сэтгэл санааны гэм хорыг арилгуулах, хүүхдийн тэтгэлэг гаргуулах зэрэг шаардах эрхийг бусдад шилжүүлэх боломжгүй бөгөөд эдгээр нь үүргийн мөн чанарт харшилсан гэх урьдчилсан нөхцөлд хамаарах юм. Харин маргаан бүхий шаардах эрхийн тухайд эдгээртэй нэгэн адил үүргийн мөн чанарт харшлах нөхцөл байдал тогтоогдсонгүй. Иймд иргэн Д.Б гээс шаардах эрхээ И.Г д шилжүүлсэн нь ИХ-ийн 123.2-т заасныг зөрчөөгүй байна.</p> <p>Дээр дурдсан үндэслэл, үйл баримтад суурилан НЗД нь хууль бус захирамжийн улмаас бусдад учруулсан эд хөрөнгийн гэм хор 66,000,000 төгрөгийг хариуцан арилгаж, уг гэм хорын төлбөрийг шаардах эрхийг иргэн Д.Б-ээс шилжүүлэн авсан этгээд болох нэхэмжлэгч И.Г-д төлөх нь ИХ-ийн 123.2, 498.2-т заасантай нийцнэ гэж дүгнэн нэхэмжлэлийн шаардлагын зарим хэсгийг хангаж шийдвэрлэсэн.</p>

Маргааны төрөл	Бусад хуулиар
Давж заалдах шатны шүүх:	Д.Б нь ИХ-ийн 497.1, 510.1-д зааснаар өөрийн эд хөрөнгөд учирсан гэм хорын хохирлыг арилгуулахаар Нийслэлийн Засаг даргаас шаардах эрхтэй. Д.Б нь И.Г-тэй 2020 оны 02 сарын 14-ний өдөр бичгээр байгуулсан шаардах эрх шилжүүлэх гэрээний дагуу Нийслэлийн Засаг даргын 2000 оны 01 сарын 24-ний өдрийн А/12 дугаар захирамжийн улмаас учирсан хохирол болох амины орон сууцны үнэ 309,258,600 төгрөгийг шаардах эрхээ И.Г-д шилжүүлсэн нь Иргэний хуулийн 123 зүйлд заасан шаардах эрх шилжүүлэх журмыг зөрчөөгүй, шилжүүлж буй шаардах эрх нь хуулийн дагуу үүссэн, үүргийн мөн чанарт харшлахгүй буюу амин хувийн эрхэд хамаарахгүй байна гэж үзээд нэхэмжлэлийн шаардлагыг бүхэлд нь хангаж шийдвэрлэсэн.
Хяналтын шатны шүүх:	Хууль, гэрээ буюу үүргийн мөн чанарт харшлахгүй бол шаардах эрх эзэмшигч нь гуравдагч этгээдтэй байгуулсан итгэмжлэлийн үндсэн дээр үүрэг гүйцэтгэгчийн зөвшөөрөлгүйгээр шаардах эрхээ шилжүүлж болох ба захиргааны байгууллагын илт хууль бус актын улмаас эд хөрөнгөд учирсан хохирол гаргуулах эрх нь хуульд зааснаар үүсэх үүргийн эсрэг хэрэгжиж байгаа, энэхүү шаардах эрхээ Д.Б нь гуравдагч этгээд буюу И.Г-д шилжүүлэхэд үүргийн мөн чанарт харшилна гэх нөхцөл тогтоогдоогүй хэмээн анхан шатны шүүхийн шийдвэрийг хэвээр үлдээж шийдвэрлэсэн.

Эдгээр шүүхийн шийдвэр, магадлал, тогтоолоор гэм хороос үүдэлтэй шаардах эрхийг шилжүүлсэн маргааныг хянан шийдвэрлэхдээ ИХ-ийн 123.2-т заасан “үүргийн мөн чанарт харшлах” гэсэн тодорхойгүй нэр томъёог хууль хэрэглэгч хэрхэн ойлгож буй талаар дэлгэрэнгүй тайлбарласан нь эрх зүйн ач холбогдолтой болжээ.

Гэм хороос үүдэлтэй шаардлага нь хуулиас үүсэх үүргийн ангилалд багтах бөгөөд манай улсын хувьд гэм хор учруулсан субъект, үр дагавар бий болгосон объектив шинжээс нь хамааруулан ИХ-ийн 52 дугаар бүлэгт нарийвчилсан хэм хэмжээгээр хохирол арилгуулах шаардах эрхийг хуульчлахын хамт хамгаалагдсан

эрх ашиг буюу объектоос нь шалтгаалж хохирол арилгах хэлбэр, арга замыг зохицуулсан байдаг. Тухайлбал, бусдын эрүүл мэндэд учирсан гэм хорыг арилгах, хохирогч нас барснаас учирсан эд хөрөнгөд учруулсан гэм хорыг арилгах, эдийн бус гэм хорыг арилгах гэх мэт.

Шүүхээс гэм хор учруулсан үйлдэл, эс үйлдлийн улмаас зөрчигдсөн эрх, өртөгдсөн объектын шинжээс нь хамаарч шаардах эрхийг гуравдагч этгээдэд шилжүүлж болохоор тайлбарласан байна. Үүнд гэм хор арилгах хэлбэр болох гэм хор учруулахаас өмнөх байдалд сэргээх шаардлага гаргаж байна уу, эсхүл мөнгөн хэлбэрээр нөхөн төлүүлэхээр шаардаж байна уу гэдэг нь ач холбогдолгүй. Гэм хороос үүдэлтэй шаардах эрхийн хүрээнд эд хөрөнгөд учирсан гэм хор, сэтгэцэд учирсан гэм хорыг мөнгөн хэлбэрээр арилгах боломжтой боловч бусдад шилжүүлэх нь хувь хүнтэй салшгүй холбоо бүхий сэтгэцэд учирсан хохирлын хувьд боломжгүй³⁷ гэж тайлбарлажээ.

ИХ-ийн 123.2-т заасан шаардах эрх шилжүүлэх хориг нь “хууль ба гэрээний мөн чанарт харшлахгүй” хэмээх хэт ерөнхий агуулгатай. Тиймээс шүүх илүү дэлгэрэнгүй байдлаар тайлбараа бичиж, шийдвэрт тусгах үүрэгтэй. Үүнд юуны өмнө ИХ-ийн

437.7, 514 зэрэгт хуулиар шаардах эрх шилжих зохицуулалттай салбар багтах ба эдгээр зохицуулалтын зорилго нь шилжүүлж үл болох шаардах эрхийг хамрах, тэдгээрийг яг энэ шалтгааны улмаас хуулиар өөр этгээдэд шилжүүлэх арга замыг бүрдүүлэхэд оршино. Гэхдээ хуулиар шаардлага шилжүүлэх зохицуулалттай салбар бүрд энэ хориг үйлчлэх эсэх нь эргэлзээтэй, энэ талаар хууль тогтоогчийн хүсэл зоригийг нэг бүрчлэн тогтоох боломжгүй байна. Эдгээрийн ард ихэвчлэн гэм хорын эрх зүйн хариуцлага хүлээх шаардах эрхүүд багтах ба практикт гэм хорын шаардах эрхийг бусдад шилжүүлэх үзэгдэл үе үе тохиодог. Эрх зүйн

³⁷ Улсын Дээд шүүхийн Хүний сэтгэцэд учирсан хор уршгийг арилгах, нөхөн төлбөрийн жишиг аргачлалыг батлах тухай тогтоол, дугаар 25, 2023.07.23.

ухамсрын түвшин нийтлэг байдлаар хэрхэн төлөвшсөн нь мөн тогтооход бэрхшээлтэй. Ямартай ч нөхөн олговор олгосон даатгалын байгууллага, нийгмийн даатгал, халамжийн байгууллагад шилжвэл зохих шаардлагын хүрээнд тус хориг үйлчилнэ. Харин гэм хорын шаардах эрхийн хүрээнд тусгайлсан хориг үйлчлэх эсэх, эдийн бус гэм хор, сэтгэцэд учирсан хохирлын хувьд дараа дараачийн шүүхийн практикийг хүлээзнэх шаардлагатай.

Харьцуулсан эрх зүйн үүднээс судалбал энд ихэвчлэн агуулгыг нь өөрчлөлгүй шаардах эрхийг шилжүүлэх боломжгүй эсхүл үүрэг гүйцэтгэгчтэй байгуулсан гэрээнд шаардах эрх шилжүүлэхийг хориглосон эсвэл битүүмжилж үл болох хэсгээр шаардлагыг шилжүүлэхийг хориглоно. Харин эдгээрийн тайлбарт гэм хорын эрх зүйн шаардах эрхийг шилжүүлэхийг хориглосон заалт байхгүй байна. Гагцхүү ажил олгогчид удаан хугацаанд халамжийн байгууллагад тэтгэмж олгосон нийгмийн халамжийн байгууллагад түүний цалин хөлс шаардах эрх, бусад гэм хорын шаардах эрх заавал шилжих заалттай ажээ.

Жилиг шүүхийн шийдвэр 9³⁸

Маргааны төрөл	Даатгал
Маргааны агуулга:	Д.М нь Б.Г-ийн хамтаар “Х банк”-наас 58,800,000 төгрөгийг 20 жилийн хугацаатайгаар зээлдэн авахаар “Орон сууцны ипотекийн зээлийн гэрээ”-г 2015 оны 06 сарын 18-ны өдөр байгуулсан. Дээрх зээлийн гэрээний үүргийн гүйцэтгэлийг эрсдлээс хамгаалах зорилгоор Б.Г нь “М Даатгал” ХК-тай “Зээлдэгчийн эрсдэлийн даатгалын гэрээт баталгаа” гэх гэрээг байгуулсан.

³⁸ Дорноговь аймгийн Замын-Үүд сум дах сум дундын шүүхийн 2024 оны 01 сарын 11-ний өдрийн 137/ШШ2024/00014 дугаартай шийдвэр, Дорноговь аймгийн Эрүү, иргэний хэргийн давж заалдах шатны шүүхийн 2024 оны 03 сарын 12-ны өдрийн 202/МА2024/00008 дугаартай магадлалтай, Улсын дээд шүүхийн 2024 оны 06 сарын 04 өдрийн 001/ХТ2024/00126 дугаартай тогтоол.

ШААРДАХ ЭРХ ШИЛЖҮҮЛЭХ ГЭРЭЭТЭЙ ХОЛБООТОЙ МАРГААН ШИЙДВЭРЛЭСЭН ШҮҮХИЙН ШИЙДВЭРТ ХИЙСЭН ДҮН ШИНЖИЛГЭЭ

Маргааны төрөл	Даатгал
	<p>Гэтэл 2015 оны 10 сарын 19-ний өдөр Д.М нь зам тээврийн ослын улмаас амь насаа алдсан бөгөөд тухайн осолд Ж.Э нь гэм буруутай болох нь шүүхийн хүчин төгөлдөр тогтоолоор тогтоогдсон. Улмаар “М Даатгал” ХК нь ипотекийн зээлийн үлдэгдэл 56,847,827 төгрөгийг Б.Г-д шилжүүлж, түүнтэй “нэхэмжлэх эрх шилжүүлэх хэлцэл”-ийг байгуулсан.</p> <p>Ингээд “М Даатгал” ХК нь Ж.Э-ээс Б.Г-д төлсөн төгрөгийг гаргуулахаар шүүхэд нэхэмжлэл гаргасан.</p>
<p>Анхан шатны шүүх:</p>	<p>Хариуцагч Ж.Э-ын гэм буруутай үйлдлийн улмаас Д.М-ний амь нас хохирсон нь даатгалын нөхөн төлбөр төлөх үүрэг нэхэмжлэгч “М Даатгал” ХК-нд үүсэх үндэслэлгүй байна.</p> <p>ИХ-ийн 443.1-д “Гэм хорын даатгалаар даатгагч нь даатгуулагчийн амь нас, эрүүл мэнд, эд хөрөнгө, эд хөрөнгийн бус ашиг сонирхолд учирсан гэм хорыг даатгалын үнэлгээний хэмжээгээр мөнгөн хэлбэрээр нөхөн төлөх үүрэг хүлээнэ” гэж заасан. Б.Г нь “М Даатгал” ХК-тай 2015 оны 06 сарын 19-ний өдөр “Зээлдэгчийн эрсдэлийн даатгалын гэрээт баталгаа” гэх гэрээг байгуулж гэрээнд гарын үсэг зурж баталгаажуулсан боловч зам тээврийн ослын улмаас амь хохирсон Д.М-тэй “М Даатгал” ХК-ийг зээлдэгчийн эрсдэлийн даатгалын гэрээг байгуулсан гэж үзэх үндэслэл тогтоогдохгүй байна. Иймд Д.М болон “М Даатгал” ХК хоёрын хооронд эрсдэлийн даатгалын эрх зүйн харилцаа үүссэн гэж үзэх хууль зүйн үндэслэл тогтоогдохгүй байна гээд нэхэмжлэлийн шаардлагыг бүхэлд нь хэрэгсэхгүй болгосон.</p>
<p>Давж заалдах шатны шүүх</p>	<p>Даатгуулагч Д.М, “М Даатгал” ХК-ны хооронд ИХ-ийн 431.1-д заасан даатгалын гэрээ байгуулагдсан ба “...зээлдэгч амь насаа алдах...” зэрэг 3 төрлийн эрсдэлээр даатгалын хамгаалалтыг гэрээгээр тохирсон байсан, даатгуулагч нас барснаар даатгалын тохиолдол бий болсон тул “М Даатгал” ХК хэлэлцэн тохирсон даатгалын нөхөн төлбөрийг төлж үүргээ биелүүлсэн, ИХ-ийн 236.1.1-д зааснаар зохигчийн хооронд байгуулагдсан даатгалын гэрээний үүрэг дуусгавар болсон байна.</p> <p>Нэхэмжлэгч “М Даатгал” ХК даатгуулагчийн банкны зээлийн төлбөрийг төлсөн тул “М Даатгал” ХК-д хариуцагч Ж.Э-ээс хохирол шаардах эрх шилжсэн гэж үзнэ гээд нэхэмжлэлийн шаардлагыг бүхэлд нь хангасан өөрчлөлт оруулсан.</p>

Маргааны төрөл	Даатгал
	<p>“М Даатгал” ХК хохирогчийн банктай байгуулсан зээлийн гэрээний үлдэгдэл төлбөрийг эрсдэлийн даатгалын хүрээнд нөхөн төлсөн байна. Тодруулбал, даатгуулагч өөрийн амь нас хохирсон үед түүний банктай байгуулсан зээлийн өрийн үлдэгдлийг даатгагч түүний өмнөөс төлж барагдуулахаар даатгалын гэрээ байгуулсныг даатгагч маргаагүй бөгөөд тус гэрээнд заасан даатгалын тохиолдол бий болж эрсдэл учирсан тул зээлийн үлдэгдэл төлбөр 56,847,827 төгрөгийг төлжээ.</p>
<p>Хяналтын шатны шүүх:</p>	<p>Дээрх даатгалын гэрээ нь гэм хорын болон амь насны даатгалын төрөлд хамаарахгүй байна. Өөрөөр хэлбэл зээлдэгч нас барж, түүний бусдад өгөх зээл төлөгдөхгүй болох эрсдэл нь гэм хорын төрөл биш, харин зээлийн гэрээний үүрэг биелэгдэхгүй байх эрсдэл гэж үзнэ. Гэмт хэргийн улмаас хохирогч нас барснаар гэм буруутай этгээдээс шаардан нэхэмжлэх гэм хорын төрөлд хохирогчийн бусадтай байгуулсан зээлийн гэрээний төлөгдөөгүй үлдэгдэл хамаарахгүй.</p> <p>ИХ-ийн 443.7 нь даатгагч даатгалын нөхөн төлбөрийг гэм буруутай этгээдээс шаардан гаргуулах эрхийг хуулийн дагуу шилжүүлэн авах зохицуулалт мөн хэдий ч ийнхүү шилжүүлэн авах шаардах эрх нь гэм хорын эрх зүйн шаардах эрхтэй байх учиртай. Тодруулбал, ИХ-ийн 443.7-д “Даатгуулагч учирсан гэм хорыг нөхөн төлөх шаардлагыг гуравдагч этгээдэд гаргаж болох тохиолдолд ...” шаардах эрх түүнд шилжихээр зохицуулснаас үзвэл энэ зүйл заалтын дагуу шаардах эрх шилжихийн тулд даатгуулагч, түүнд учирсан гэм хорыг буруутай этгээдээс шаардах эрхтэй байх урьдчилсан нөхцөл тавигджээ. Гэтэл зээлийн эрсдэлийн даатгалын нөхөн төлбөрийг хүлээн авсан Б.Г-д ИХ-ийн 497.1-д заасны дагуу хохирогч Д.М-ийн банктай байгуулсан зээлийн гэрээний үлдэгдэл төлбөрийг хариуцагч Ж.Э-оос шаардах эрх байхгүй. Өөрт үүсээгүй шаардах эрхийг бусдад шилжүүлэх боломжгүй.</p> <p>Дээрх үндэслэлээр буюу зээлийн эрсдэлийн даатгалын нөхөн төлбөрийг хүлээн авсан Б.Г-д үүсээгүй шаардах эрхийг “М Даатгал” ХК хүлээн авсан байх боломжгүй тул нэхэмжлэлийн шаардлагыг хэрэгсэхгүй болгож шийдвэрлэх нь зүйтэй гэж үзлээ гээд нэхэмжлэлийн шаардлагыг бүхэлд нь хэрэгсэхгүй болгосон.</p>

Энэхүү шүүхийн шийдвэрээр хуулийн дагуу шаардах эрх шилжих тохиолдлыг шийдвэрлэсэн боловч манай улсын практикт түгээмэл³⁹ байгаа ипотекийн зээлийн гэрээ, түүний даатгалын гэрээний харилцаанд үүсэх нийтлэг тохиолдлыг авч үзсэн ач холбогдолтой. Тодруулбал, 2013 оноос эхлэн хэрэгжиж буй орон сууцны хөнгөлөлттэй зээлийн хөтөлбөрийн хүрээнд арилжааны банкнуудаас иргэдэд зээл олгохдоо холбогдох журмын⁴⁰ дагуу зээлдэгч иргэнийг амь насны даатгал хамруулах шаардлагыг тавьдаг. Шүүх зээлдэгчийн амь насанд хохирол учруулсан гэм буруутай үйлдэл нь даатгалын тохиолдол үүсэх нөхцөлд мөн эсэх, хамтран зээлдэгчийн нэг нь зээлийн эрсдэлээс сэргийлсэн даатгалтай нөхцөлд нөгөө зээлдэгч нас барсны улмаас хохирол шаардах эрх даатгагч компанид шилжих эсэх асуултад уг шүүхийн шийдвэрээр хариулт өгчээ.

Анхан шатны шүүх даатгагч “М Даатгал” ХК болон Д.М (нас барсан зээлдэгч) нарын хооронд даатгалын гэрээ байгуулагдаагүй учир даатгалын нөхөн төлбөр олгох шаардлагагүй байсан, тиймээс тэрхүү нөхөн төлбөрийн хэмжээгээр шаардах эрх “М Даатгал” ХК-д шилжихгүй гэж дүгнэсэн. Давж заалдах шатны шүүхээс талуудын дунд даатгалын эрх зүйн харилцаа үүссэн бөгөөд “М Даатгал” ХК нь даатгагчийн хувиар хүлээсэн үүргээ бүрэн гүйцэтгэсэн тул түүнд зам тээврийн осолд гэм буруутай Ж.Э-ээс 56,847,827 төгрөгийг шаардах эрхтэй гэж тайлбарласан.

Харин хяналтын шатын шүүхээс өмнөх хоёр шатны шүүхтэй харьцуулахад Ж.Э-ээс “Х Банк”-тай байгуулсан зээлийн гэрээний гүйцэтгээгүй үүргийн гүйцэтгэлийг шаардах эрх даатгагчид үүсэх үү гэдэгт хариулах байдлаар хэргийг шийдвэрлэсэн байна.

³⁹ Үндэсний статистикийн хорооны мэдээгээр 2024 оны 05 сарын өдрийн байдлаар 117,400 орчим иргэдэд ипотекийн зээл олгогдоод байгаа.

⁴⁰ Засгийн газрын 2013 оны 200 дугаар тогтоолын хавсралт Орон сууцны ипотекийн ерөнхий журмын 3.2.5 дах заалт, Засгийн газрын 2018 оны 369 дүгээр тогтоолын хавсралт Орон сууц хөнгөлөлттэй зээлийн санхүүжилтын журмын 4.2.9 дэх заалт.

ИХ-ийн 443.7-гийн урьдчилсан нөхцөл нь а) даатгалын гэрээ байгуулагдсан байх, б) даатгалын тохиолдол буюу даатгуулагчийн амь нас, эрүүл мэнд, эд хөрөнгө, эд хөрөнгийн бус ашиг сонирхолд гэм хор учирсан байх, в) даатгуулагч нь гэм хорыг гуравдагч этгээдээр арилгуулах эрхтэй байх, г) даатгагч даатгуулагчид нөхөн төлбөр олгосон байх юм. Тухайн тохиолдлын хувьд банкнаас ипотекийн зээл авсан Д.М, Б.Г нар “М Даатгал” ХК-тай хэрэв даатгуулагч (Д.М) нас барвал зээлийн төлөгдөөгүй үлдсэн хэсгээр нөхөн төлбөр авахаар хэлэлцэн тохирсон, даатгуулагч Д.М нь Ж.Э-ийн замын хөдөлгөөний дүрэм зөрчсөн гэм буруутай үйлдлийн улмаас амь насаараа хохирсон, “М Даатгал” ХК ипотекийн зээлийн үлдэгдэл 56,847,827 төгрөгийг Б.Г-д төлсөн гэсэн нөхцөлүүд хангагдаж байна.

Гэвч Ж.Э нь ИХ-ийн 499.1-ийн дагуу Д.М-д учирсан гэм хорыг арилгах үүрэгт Д.М-ын бусдын өмнө хүлээсэн өр төлбөр хамаарахгүй. Иймд Б.Г нь анхнаасаа үүсээгүй шаардлагыг хэн нэгэнд хууль эсвэл гэрээгээр шилжүүлэх боломжгүй учир ИХ-ийн 443.7 болон 2017 оны 02 сарын 22-ны “Нэхэмжлэх эрх шилжүүлэх хэлцэл” байгуулснаас үл хамааран “М Даатгал” ХК нь Ж.Э-ээр 56,847,827 төгрөгийг төлүүлэхээр шаардах эрхгүй гэжээ. Угтаа энэ шийдвэр нь анхан шатны шүүхийн шийдвэрийн агуулгыг бататгасан шинжтэй, гэхдээ Б.Г-ийн зүгээс даатгалын компанитай байгуулсан зээлийн эрсдэлээс сэргийлсэн даатгалын зорилго нь Д.М-ийн хувьд ИХ-ийн 203-д заасан гуравдагч этгээдэд ашигтай гэрээ мөн эсэх, Б.Г нь нас барсан хамтран зээлдэгчийн эрх залгамжлагч болж, зээлийн үүргийг хариуцах нөхцөл үүссэн эсэхэд дүгнэлт өгөөгүй байна. Түүнчлэн зээлийн эрсдэлийн даатгалын тохиолдол нь зээлдэгч насан эцэслэсэн, үүнд гэм хор учруулагчийн буруутай үйлдэл нөлөөлсөн нөхцөл багтах эсэх дээр нийт Монгол улсын нутаг дэвсгэрт үйлчлэх нийтлэг жишиг болж чадах эсэх нь эргэлзээтэй байна. Хэрэв Д.М нас барсан бол даатгалын компани нь нэн даруй даатгалаас нөхөн төлбөр гарган өгч, зээлийг тэглэх ба үүнийхээ хариуд ИХ-ийн 443.7- д регресс шаардах эрхийн дагуу Ж.Э-ээс гэм хорын шаардах эрхийг шилжүүлэн авах нь тус гэрээний зорилгод нийцнэ гэж үзэхээр байна.

2.2. ХЭЛЦЛИЙН ҮНДСЭН ДЭЭР ШААРДАХ ЭРХ ШИЛЖСЭНИЙ ЭРХ ЗҮЙН ҮР ДАГАВАР

2.2.1. Хуучин үүрэг гүйцэтгүүлэгчийн эрх дуусгавар болж, шинэ үүрэг гүйцэтгүүлэгч шаардах эрхийн эзэн болох

Жишиг шүүхийн шийдвэр 10⁴¹

Маргааны төрөл	Ажил гүйцэтгэх гэрээ
Маргааны агуулга:	<p>“МД” ХХК нь Б-тэй “Худалдааны талбайг худалдах, худалдан авах гэрээ”-г байгуулсан. Тус гэрээний дагуу “МД” ХХК нь өөрийн хэрэгжүүлж буй барилгын төслөөс худалдаа үйлчилгээний зориулалттай талбайг Б-д хүлээлгэн өгөх, Б нь хариуд нь 47,520 ам.доллар төлөхөөр харилцан тохиролцсон. Б нь төлбөр төлөх үүрэгтээ тооцуулан автомашиныг “МД” ХХК-ийн нэрлэн заасан гуравдагч этгээдэд шилжүүлж гүйцэтгэсэн.</p> <p>Гэсэн хэдий ч “МД” ХХК нь гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлээгүй тул 2021 ны 11 сарын 23-ны өдөр Б нь Д-д “Шаардах эрх шилжүүлэх гэрээ”- ний үндсэн дээр “МД” ХХК-тай байгуулсан гэрээний шаардах эрхээ шилжүүлсэн. Ингээд Д нь “Худалдааны талбайг худалдах, худалдан авах гэрээ”-нээс татгалзаж, хариу төлбөр болох 47,520 ам.долларыг “МД” ХХК-иас буцаан шаардаж шүүхэд нэхэмжлэл гаргасан.</p>
Анхан шатны шүүх:	<p>ИХ-ийн 123.1-д Шаардах эрх шилжих тухай үүрэг гүйцэтгэгчид мэдэгдэх хүртэл үүрэг гүйцэтгэгч анхны үүрэг гүйцэтгүүлэгчийн өмнө гэрээгээр хүлээсэн үүргээ гүйцэтгэнэ гэж заасан. Хуульд заасны дагуу шаардах эрх шилжүүлэх тухай гэрээ байгуулснаар шинэ үүрэг гүйцэтгүүлэгчид шилжих бөгөөд мөн хуулийн 123.2-т хууль, гэрээ буюу үүргийн мөн чанарт харшлахгүй бол шаардах эрх эзэмшигч нь гуравдагч этгээдтэй байгуулсан гэрээний үндсэн дээр үүрэг гүйцэтгэгчийн зөвшөөрөлгүйгээр шаардах эрхээ шилжүүлж болохоор заасан.</p>

⁴¹ Баянзүрх дүүргийн Иргэний хэргийн анхан шатны шүүхийн 2022 оны 12 сарын 21-ны өдрийн 101/ШШ2023/00015 дугаартай шийдвэр.

Маргааны төрөл	Ажил гүйцэтгэх гэрээ
	<p>Б нь Д-д “МД” ХХК-иас 2014 оны 05 сарын 29-ны өдөр 35/14 дугаартай “Худалдааны талбайн худалдах, худалдан авах гэрээ”-ээр хүлээсэн үүргийг шаардах эрхээ шилжүүлсэн нь хууль болон гэрээний мөн чанарт харшилсан гэж үзэх үндэслэлгүй байх тул нэхэмжлэгч Д нь “МД” ХХК-иас 2014 оны 05 сарын 29-ны өдрийн 35/14 дугаартай гэрээний үүрэг болон гэрээнээс татгалзсаны үр дагаврыг шийдвэрлүүлэхээр шаардах эрхтэй гэж үзээд нэхэмжлэлийн шаардлагыг бүхэлд нь хангаж шийдвэрлэсэн.</p>

Тус шүүхийн шийдвэрээр шаардлагыг шилжүүлэн авсан этгээд гэрээнээс татгалзаж, үр дагаврыг шаардсантай холбоотой маргааныг хянан шийдвэрлэжээ. Шүүхээс шаардах эрх шилжүүлэх гэрээ байгуулагдсанаар Д нь “Худалдааны талбайг худалдах, худалдан авах гэрээ”-ний нэг тал болсон тул үүрэг гүйцэтгүүлэгчийн татгалзах эрхийг хэрэгжүүлж, “өгсөн авснаа буцаах” үүрэг болох 47,520 ам.долларыг шаардах эрхтэй гэж дүгнэжээ.

Ийнхүү дүгнэсэн шүүхийн шалгуур нь нийтлэг хэрэглэх боломжтой, тодорхой байх шаардлагатай. ИХ-ийн 122.2-т хууль тогтоогч эрх ба шаардах эрхийг өөр хооронд ялгаж үзсэн байдаг. Харин хэрэглэх зохицуулалтын хувьд эрх шилжихэд мөн ИХ-ийн 123 үйлчлэх ёстой. Гэрээний эрх зүйн харилцаанд эдлэх эрх нь бусад өмчлөгчийн эрх, нэн ялангуяа зохиогчийн эрх зэрэгтэй адил төстэй эрхийн ангилалд багтдаг, эсрэг талын зөвшөөрөл ба үйл хөдлөл шаарддаггүйн улмаас шаардах эрхийн ангилалд багтдаггүй онцлогтой. Эрх өөрчлөхөд чиглэсэн харьцангуй эрхийг дотор нь бие даасан эрх, бие даасан бус эрх гэж ангилна. Гэрээний харилцааг дуусгавар болгоход чиглэсэн эрхүүд нь шаардах эрх биш, харин бие даасан бус эрхийн ангилалд багтана. Тухайлбал үүнд гэрээг цуцлах, хүсэл зоригийн илэрхийллээс татгалзах, гэрээнээс татгалзах эрхүүд багтдаг. Эдгээр нь заавал үүрэг гүйцэтгүүлэгчийн үүргийн харилцаанд эдлэх үндсэн эрхтэй хамт байх албагүй,

гэрээний үндсэн дээр бусдад шилжих, шаардах эрх шилжихэд хамт шилжих боломжтой.

Эрх зүйн харилцаанд ИХ-ийн 123-д зааснаар шаардлага шилжмэгц шаардах эрх шилжүүлэн авсан тал нь шинэ үүрэг гүйцэтгүүлэгч болох уу, эсхүл зөвхөн тухайн шаардлагыг хэрэгжүүлэх эрх олж авах уу гэдэг нь шаардах эрх шилжүүлэх гэрээний агуулгаас шалтгаална. Гэрээнээс татгалзсанаар шинэ үүрэг гүйцэтгүүлэгчийг тухайн үүргийн харилцааны нэг тал болгосон нөхцөлд гол үүргийг шаардах эрх дуусгавар болж, гэрээт харилцаа нь харилцан буцаан олгох харилцаа болж өөрчлөгддөг.⁴² Өөрөөр хэлбэл үүргийн харилцаа өргөн утгаараа бус хязгаарлагдмал утгаар дуусгавар болох учир тэрхүү өөрчлөгдсөн үүргийг шаардах эрх нь шинэ үүрэг гүйцэтгүүлэгчид үүсэх боломжтой. Дээрх шийдвэрийн хүрээнд шүүх а) гэрээнээс татгалзах эрх үндсэн шаардлагатай хамт шилжсэн, б) энэ эрхийг хуучин үүрэг гүйцэтгүүлэгчид хэрэгжүүлсэн, в) тиймээс түүнд буцаан шаардах эрх мөн шилжсэн гэсэн 3 үндсэн агуулгаар дүгнэлт хийжээ.

Энэ дүгнэлтийг өөр өөр маргаанд харилцан адилгүй хийхээс сэргийлэх үүднээс эрхийг шилжүүлэх асуудал юуны өмнө ИХ-ийн 122.2, 260-д заасан хэлбэрээр шаардах эрхээс тусдаа ойлголт болохыг шүүх тайлбарлах үүрэгтэй байсан. Мөн энэ хүрээнд гэрээний бие даасан, бие даасан бус эрх шилжихэд ИХ-ийн 123-ыг хэрэглэхдээ гэрээний тохиролцоонд үндэслэн гэрээг дуусгавар болгох эрх цуг шилжсэн эсэхийг тохиолдол бүрд зөв үнэлэх шаардлага тулгарч байна.

Харьцуулсан эрх зүйн үүднээс ИХ-ийн 122.2-оос гадна энд хуульд өөрөөр заагаагүй бол шаардах эрх шилжүүлэх тухай зохицуулалтууд нь эрх шилжихэд нэгэн адил хэрэглэгдэх тухай зохицуулалт нэмэх нь дээрхтэй адил шийдвэр гаргах ажиллагааг хялбаршуулах талтай. Түүнчлэн эрх зүйн ухамсрын түвшинд

⁴² Ё.Кают нарын зохиогчид, 2010, 387 дах тал.

эрх өөрчлөхөд чиглэсэн харьцангуй эрхийн ангиллыг шүүх хууль тайлбарлах аргаар нэг мөр болгох нь зохимжтой.

2.2.2.Бусад эрх, баталгаа шилжих

Жишиг шүүхийн шийдвэр 11⁴³

Маргааны төрөл	Банкны зээл
<p>Маргааны агуулга:</p>	<p>Монгол Улсын Хөгжлийн банк нь “ТОСК” ХХК-тай 2015 оны 05 сарын 28-ны өдөр зээлийн гэрээ байгуулж 50,000,000 ам.долларыг, жилийн 8.45 хувийн хүүтэй, 2024 оны 12 сарын 01-нийг хүртэл хугацаатайгаар зээлдүүлэхээр харилцан тохиролцсон.</p> <p>2015 оны 07 сарын 20-ны өдөр “ТОСК” ХХК нь дээрх зээлийн эх үүсвэрийг ашиглан “ЮПГ” ХХК-тай “Хөрөнгө оруулалт, санхүүжилт хийх хамтран ажиллах гэрээ”-г байгуулсан. Тухайн гэрээний үүргийн гүйцэтгэлийг баталгаажуулж “ТОСК” ХХК нь “ЮПГ” ХХК-ийн хувьцааг барьцаалсан. “ЮПГ” ХХК-ийн хувьцаа эзэмшигчийн зүгээс барьцааны гэрээнд заасан “ЮПГ” ХХК-ийн хувьцаатай холбоотой шаардах эрхийг “ТОСК” ХХК-д шилжүүлэх тухай мэдэгдлийг мөн гаргасан.</p> <p>Эдгээр барьцааны гэрээ болон мэдэгдлийг үндэслэн “ТОСК” ХХК нь 2015 оны 08 сарын 12-ны өдөр Монгол Улсын Хөгжлийн банктай байгуулсан зээлийн гэрээний үүргийн гүйцэтгэлийг баталгаажуулж “Хувьцаа барьцаалах гэрээ”-ний шаардах эрхийг барьцаалсан. Ийнхүү барьцаалахдаа хэрэв зээлийн гэрээний үүргээ зохих ёсоор биелүүлээгүй тохиолдолд хувьцаатай холбоотой эрх шилжихээр тусгасан.</p>

⁴³ Чингэлтэй дүүргийн Иргэний хэргийн анхан шатны шүүхийн 2020 оны 06 сарын 26-ны өдрийн 182/ШШ2020/01508 дугаартай шийдвэр, Нийслэлийн Иргэний хэргийн давж заалдах шатны шүүхийн 2020 оны 09 сарын 04-ний өдрийн 01889 дугаартай магадлал.

Маргааны төрөл	Банкны зээл
	<p>Ингээд зээлийн гэрээний үүрэг зөрчигдсөн тул Монгол Улсын Хөгжлийн банкнаас зээлийн гэрээний төлбөрийг шаардаж, барьцаа хөрөнгүүдээр үүргийн гүйцэтгэлийг хангуулахаар шүүхэд нэхэмжлэл гаргасан. Нөгөө талаас “ЮПГ” ХХК-ийн хувьцаа эзэмшигч нь “ТОСК” ХХК болон Монгол Улсын Хөгжлийн банкны хооронд байгуулагдсан 2015 оны 08 сарын 12-ны өдрийн “Шаардах эрх барьцаалах гэрээ”-г хүчин төгөлдөр бусд тооцуулах сөрөг нэхэмжлэл гаргасан.</p>
<p>Анхан шатны шүүх:</p>	<p>ИХ-ийн 155.1.-д “Үүрэг гүйцэтгүүлэгч барьцаагаар хангагдсан шаардлагыг гуравдагч этгээдэд шилжүүлэхэд барьцааны эрх шинэ үүрэг гүйцэтгүүлэгчид шилжинэ” гэж, 161.1.-д “Үүрэг гүйцэтгүүлэгч барьцаагаар хангагдах шаардлагыг шилжүүлэх замаар барьцааны эрхээ бусдад шилжүүлж болно” гэж заасан бөгөөд барьцаагаар хангагдсан үндсэн шаардах эрх өөр этгээдэд шилжихэд барьцааны эрх нь уг үндсэн шаардах эрхтэй хамт шилжих дагалдах эрх юм.</p> <p>Тодруулбал, “ЮПГ” ХХК болон “ТОСК” ХХК-ийн хооронд 2015 оны 07 сарын 20-нд байгуулсан “Хөрөнгө оруулалт, санхүүжилт хийх хамтран ажиллах гэрээ”-нд заасан “ТОСК” ХХК-ийн шаардах эрхүүд нэхэмжлэгч Монгол Улсын Хөгжлийн банканд шилжсэн гэж үзэх үндэслэлгүй байх тул барьцааны гэрээнүүдийн шаардах эрх Монгол Улсын Хөгжлийн банканд шилжих хууль зүйн боломжгүй болно.</p> <p>Түүнчлэн Үл хөдлөх эд хөрөнгийн барьцааны тухай хуулийн 37.1.-д “Барьцаалагч шаардах эрхээ шилжүүлэхэд Иргэний хуулийн 123 дугаар зүйлийг баримтална” гэж, ИХ-ийн 123.2.-т “Хууль, гэрээ буюу үүргийн мөн чанарт харшлахгүй бол шаардах эрх эзэмшигч нь гуравдагч этгээдтэй байгуулсан гэрээний үндсэн дээр үүрэг гүйцэтгэгчийн зөвшөөрөлгүйгээр шаардах эрхээ шилжүүлж болно” гэж, 123.6.-д “Шаардах эрхийг шинэ үүрэг гүйцэтгүүлэгчид шилжүүлснээр түүнтэй холбоотой бусад эрх болон түүнийг хангах арга нэгэн зэрэг шилжинэ” гэж тус тус заасан.</p>

Маргааны төрөл	Банкны зээл
	<p>Үүнээс үзхэд “ЮПГ” ХХК болон “ТОСК” ХХК-ийн хооронд 2015 оны 07 сарын 20-нд байгуулсан “Хөрөнгө оруулалт, санхүүжилт хийх хамтран ажиллах гэрээ”-ний шаардах эрх, үүрэг нь хариуцагч буюу хамтран ажиллах гэрээний барьцаалагч “ТОСК” ХХК-д шилжээгүй байхад уг гэрээний үүргийг хангах зорилготой барьцааны эрхийг шилжүүлэх боломжгүй байна гэж үзээд зээлийн гэрээний үүргийн төлбөрийн зарим хэсгийг хангаж, сөрөг нэхэмжлэлийн шаардлагыг хангаж шийдвэрлэсэн.</p>
<p>Давж заалдах шатны шүүх:</p>	<p>Анхан шатны шүүхийн шийдвэрийг хэвээр үлдээсэн.</p>

Энэхүү тохиолдлын хүрээнд шүүх ИХ-ийн 161.1-д заасанчлан үүргийн гүйцэтгэлийг хангах арга болох барьцааны эрх нь үндсэн шаардлагаас тусдаа шилжих боломжгүйг онцолжээ. Аливаа барьцааны эрх нь үндсэн үүргийг баталгаажуулах зорилго бүхий дагалдах эрх бөгөөд үндсэн шаардах эрхгүйгээр барьцааны эрх нь үүсэж, оршин тогтнож, бусдад шилжих боломжгүй.⁴⁴ Тиймдээ ч тухайн салгаж үл болох эрхийг дангаар шилжүүлэхээр харилцан тохиролцсон хэлцэл нь хууль зүйн хүчин төгөлдөр бус байх ёстой.

Энэ шийдвэрийн хүрээнд “үндсэн шаардлага + барьцааны эрх” гэсэн ойлголтуудын зэрэгцээ хувьцаа шаардах эрхийг барьцаалж, түүнийг шилжүүлж байгаа нь маргаан үүсгэх хүчин зүйл болсон. Тухайлбал, “ТОСК” ХХК-ийн зүгээс “ЮПГ” ХХК-тай байгуулсан “Хөрөнгө оруулалт, санхүүжилт хийх хамтран ажиллах гэрээ”-ээс үүдэлтэй хөрөнгө оруулалтаа буцаан шаардах эрх нь Хөгжлийн банканд шилжээгүй, харин хувьцаа барьцаалах эрх энэхүү үндсэн шаардлагаас тусдаа гэхдээ хувьцааг компаниас гаргуулах хувьцаа эзэмшигчийн шаардах эрхийн хамт шилжсэн. Хөгжлийн

⁴⁴ Ё.Кают нарын зохиогчид, 2010, 268 дах тал.

банк зээл олгохдоо дээрх буцаан шаардах эрхийг шилжүүлж аваагүй, гагцхүү “ЮПП”ХХК-ийн хувьцааг барьцаалах эрхийг л зээлийн гүйцэтгэлийн барьцаа болгон шилжүүлж авахыг хүссэн. Харин шүүхээс энэ эрхийг шилжүүлэхийн тулд ИХ-ийн 161.1-д заасан “үүрэг гүйцэтгүүлэгч барьцаагаар хангагдах шаардлагыг шилжүүлэх замаар барьцааны эрхээ бусдад шилжүүлж болно” гэжээ. Дээрх хөрөнгө оруулалтын гэрээний шаардлага нь барьцааны эрхтэй салшгүй холбоотой үндсэн шаардлага бөгөөд “ЮПП” ХХК-ийн хувьцаа эзэмшигчийн хувьцаа шаардах эрхээ барьцаалах гэрээнд мөн үндсэн шаардлага, барьцааны эрх гэсэн хоёр ухагдахуун бий.

ИХ-ийн 164 нь эрх барьцаалахад ИХ-ийн 161.1 мөн үйлчлэхээр заасан нь ямар ч барьцааны эрх шаардах эрхийн хамт шилжих аксессуар шинж буйг илтгэсэн зарчмын шинжтэй байна. Гэтэл практикт эрх зүйн харилцаанд оролцогч аж ахуйн нэгж, банк хүртэл энэ зохицуулалтыг буруу хэрэглэж, хувьцаа эзэмшигчийн хувьцаа шаардах эрхийг цуг шилжих үндсэн үүрэг хэмээн тайлбарлаж, барьцааны эрхийг нь түүнтэй хамт шилжүүлэн авахаар гэрээ байгуулсны улмаас хожим Хөгжлийн банк өгсөн зээлийнхээ үүргийн гүйцэтгэлийг хангах арга хэрэгслийг алдаж байгаа сөрөг үзэгдлийг бид энэ шийдвэрээс харж байна.

Харьцуулсан эрх зүйн хүрээнд гадаад улсын ялангуяа ХБНГУ-ын эрхийн барьцааны зохицуулалт нь тус улсын ИХ (BGB)-ийн 1273-1296-д нийт 20 зохицуулалтыг хамарсан ба үүнд тусгайлан заагаагүй бол эрхийн барьцаа шилжихэд МУ-ын ИХ-ийн 161.1-тэй адилтгах зохицуулалт болох ИХ (BGB)-ийн 1250⁴⁵ үйлчлэхээр заажээ. Эрх зүйн энэ үр дагаврын хувьд дээрх хоёр улсын ИХ-ийн зохицуулалт ижил үр дүнд хүрч байна.

Харин бусад барьцааны зохицуулалтын хүрээнд ИХ-ийн 164.1-ийн дагуу эрхийн барьцаанд хөдлөх хөрөнгийн бусад бүх зохицуулалтыг нэгэн адил хэрэглэнэ гэсэн нь төлөөлөх боломжгүй

⁴⁵ ХБНГУ-ын ИХ/BGB/-ийн 1250 нь МУ-ын ИХ-ийн 161.1-тэй төстэй агуулгатай.

үр дагаварт хүргэнэ гэдгийг тэмдэглэх нь зүйтэй. Жишээ нь барьцааны эрхийг шударгаар олж авах тухай, барьцааны эрхийн үр шимийг хүртэх тухай, мөн худалдан борлуулах ажиллагааны явцад гэрээний зүйлд өөрчлөлт оруулах тухай зохицуулалтыг эрхийн барьцаанд хэрэглэж үл болно. Ямартай ч энд эрхийн барьцааны зохицуулалт ихээхэн дутмаг болох нь ажиглагдаж байна.

Жишиг шүүхийн шийдвэр 12⁴⁶

Маргааны төрөл	Банкны зээл
<p>Маргааны агуулга:</p>	<p>ОССК-иас Ж, О нар нь 30,000,000 төгрөгийг жилийн 8 хувийн хүүтэйгээр 240 сарын хугацаатай зээлж авахаар 2011 оны 11 сарын 03-ны өдөр “Орон сууцны зээлийн гэрээ”-г байгуулсан. Энэхүү гэрээний үүргийн гүйцэтгэлийг баталгаажуулж Ж, О нар өөрсдийн өмчлөлийн орон сууц барьцаалж, улсын бүртгэлд бүртгүүлсэн.</p> <p>ОССК нь “А” банканд 2019 оны 12 сарын 20-ны өдрийн “Актив хөрөнгө шилжүүлэх тухай гэрээ”, “Шаардах эрх шилжүүлэх гэрээ”-ний дагуу Ж, О нартай байгуулсан зээлийн гэрээний шаардах эрхийг шилжүүлсэн.</p> <p>Улмаар Ж, О нар нь үүргээ зохих ёсоор гүйцэтгээгүй тул “А” банк нь тэдэнд холбогдуулан зээлийн гэрээний төлбөрийг хүүгийн хамтаар шаардаж, сайн дураар биелүүлээгүй нөхцөлд барьцаа хөрөнгөөр үүргийн гүйцэтгэлийг хангуулах шаардлага бүхий нэхэмжлэлийг шүүхэд гаргасан.</p>

⁴⁶ Сонгинохайрхан дүүргийн Иргэний хэргийн анхан шатны шүүхийн 2022 оны 10 сарын 06-ны өдрийн 184/ШШ2022/03009 дугаартай шийдвэр, Нийслэлийн Иргэний хэргийн давж заалдах шатны шүүхийн 2022 оны 12 сарын 07-ний өдрийн 210/МА2022/02082 дугаартай магадлал.

ШААРДАХ ЭРХ ШИЛЖҮҮЛЭХ ГЭРЭЭТЭЙ ХОЛБООТОЙ МАРГААН ШИЙДВЭРЛЭСЭН ШҮҮХИЙН ШИЙДВЭРТ ХИЙСЭН ДҮН ШИНЖИЛГЭЭ

Маргааны төрөл	Банкны зээл
<p>Анхан шатны шүүх:</p>	<p>2011 оны 10 сарын 03-ны өдрийн барьцааны гэрээний дагуу барьцааны зүйлээр үүргийг хангуулах тухай шаардлагыг хэрэгсэхгүй болгосон. Тодруулбал, энэхүү барьцааны гэрээ нь ИХ-ийн 165, 166, 167 зүйлд заасны дагуу талуудын хооронд байгуулагдсан, улсын бүртгэлд бүртгэгдсэн хүчин төгөлдөр хэлцэл хэдий ч уг хэлцлийн үүргийг шаардах эрхийг ИХ-ийн “Хууль буюу гэрээнд заасан хэлбэрээр хийх хэлцлийн хувьд шаардах эрхийг шилжүүлэхдээ уг хэлцлийг хийсэн хэлбэрээр шилжүүлнэ”, 172.2-т “Шинэ үүрэг гүйцэтгүүлэгчид ипотекийн баримт бичгийг шилжүүлж, түүнийг шинэ үүрэг гүйцэтгүүлэгч гэж улсын бүртгэлд бүртгэсэн нөхцөлд шаардлага шилжсэн гэж үзнэ” гэж заасны дагуу шилжүүлсэн эсэх нь баримтаар тогтоогдохгүй байна. Шинэ үүрэг гүйцэтгүүлэгч буюу нэхэмжлэгч “А” банк нь ипотекийн гэрээг улсын бүртгэлд бүртгүүлсэн болохоо нотлоогүй тул түүнд шаардах эрх шилжсэн гэж дүгнэх боломжгүй гэж үзээд нэхэмжлэлийн шаардлагаас зээлийн гэрээний төлбөрт хамаарах хэсгийг хангаж барьцаа хөрөнгөөр үүргийн гүйцэтгэлийг хангуулах хэсгийг хэрэгсэхгүй болгож шийдвэрлэсэн.</p>
<p>Давж заалдах шатны шүүх:</p>	<p>ИХ-ийн 123.6-д Шаардах эрхийг шинэ үүрэг гүйцэтгүүлэгчид шилжүүлснээр түүнтэй холбоотой бусад эрх болон түүнийг хангах арга нэгэн зэрэг шилжинэ гэж заасны дагуу шаардах эрх шилжүүлэх гэрээ байгуулснаар “А” банк нь 2011 оны 10 сарын 03-ны өдрийн орон сууцны зээлийн гэрээний үүргийн гүйцэтгэлийг барьцааны гэрээнд заасан орон сууцаар хангуулах барьцааны эрхийг шилжүүлэн авсан гэж үзжээ. Барьцааны зүйл нь үл хөдлөх эд хөрөнгө тул ИХ-ийн 172.2-т Шинэ үүрэг гүйцэтгүүлэгчид ипотекийн баримт бичгийг шилжүүлж, түүнийг шинэ үүрэг гүйцэтгүүлэгч гэж улсын бүртгэлд бүртгэсэн нөхцөлд шаардлага шилжсэн гэж үзнэ гэж заасан шаардлагыг хангасан тохиолдолд барьцаалуулагч буюу шинэ үүрэг гүйцэтгүүлэгч нь мөн хуулийн 175.1-д заасан шаардах эрхээ хэрэгжүүлэх боломжтой хэмээн анхан шатны шүүхийн шийдвэрт хууль хэрэглээ болон найруулгын өөрчлөлт оруулж шийдвэрлэсэн.</p>

Зээлийн шаардлагыг баталгаажуулж буй ипотек буюу үл хөдлөх хөрөнгийн барьцааны эрх хэрхэн шилжих, тусдаа шилжих боломжтой эсэх асуудлыг хөндсөн анхан болон давж заалдах шатны шүүхийн энэ шийдвэр нь 2009 оны ИХ-д орсон нэмэлт өөрчлөлт хэр оновчтой болсныг үзүүлсэн ач холбогдолтой⁴⁷. Анхан шатны шүүх тус хэргийг хянан шийдвэрлэхдээ нэхэмжлэлийн шаардлагаас зээлийн гэрээний үндсэн төлбөр, хүү, нэмэгдүүлсэн хүүг хангаж, үлдэх ипотектэй холбогдох хэсгийг хэрэгсэхгүй болгосноос үзвэл ипотекеэр баталгаажиж буй үндсэн шаардлага гаргах эрх нь тухайн ипотекеэс тусдаа шилжих боломжтой мэт харагдаж байна. Харин давж заалдах шатны шүүх зээлийн гэрээний үүрэг гүйцэтгүүлэгч болсноор барьцааны эрх давхар шилжсэн гэж дүгнэсэн боловч хуульд заасан ипотек шилжих шаардлагыг хангаагүй тул барьцааны эрхийг хэрэгжүүлэх боломжгүй гээд анхан шатны шүүхийн шийдвэрийг хэвээр үлдээсэн нь эцсийн үр дүндээ дээрхтэй ижил шийдэл болжээ.

Аливаа барьцааны эрх нь ИХ-ийн 87.1-д заасан үүргийн эрх зүйн шаардах эрхтэй салшгүй холбоотой салгаж үл болох эрх бөгөөд ипотекийн барьцаа нь олон улсад шаардах эрхтэйгээ нягт уялдаатай болох нь хүлээн зөвшөөрөгдсөн. Үүрэг гүйцэтгэгчээс үүргээ тогтоосон хугацаанд, зохих ёсоор шударгаар биелүүлэх амлалтаа үүрэг гүйцэтгүүлэгчийн өмнө баталгаажуулах зорилгоор барьцааны эрх үүсэх ба энэ утгаараа шаардлага биелснээр мөн дуусгавар болдог. Зээлийн үндсэн шаардлага гаргах эрх болон ипотекийн барьцааны эрх нь тус тусдаа эсхүл өөр өөр этгээдэд шилжих боломжгүй⁴⁸. Харин ИХ-д ипотекийн барьцаанаас өөр үл хөдлөх хөрөнгийн барьцаа хэмээх ерөнхий нэршилтэй, шаардлагатай нягт холбоогүй эрхийг хүлээн зөвшөөрөх нөхцөлд эдгээр нь харилцан өөр этгээдэд техникийн хувьд шилжих боломжтой ч үндэслэлгүй хөрөнгөжих болон бусад зохицуулалтын тусламжтай шаардлага,

⁴⁷ 2009 оны 07 сарын 07-ны өдрийн хууль.

⁴⁸ Энэ нь хуулиар тодорхойлсон exception буюу уг зарчмаас гадуурх жишээ нь барьцаагаар хангагдах шаардлагыг солих гэх мэт тохиолдлыг үгүйсгээгүй болно.

барьцаа хоёрыг нэгтгэх ажил хийгдэх боломжтой. Гэтэл МУ-ын ИХ-д зөвхөн ипотекийн барьцааг л зохицуулсан байна.

Үндсэн шаардлага ба барьцаа нягт уялдаатай байх нь ипотекийн хувьд заавал үйлчлэх суурь зарчмын шинжтэй бөгөөд энэ талаар ИХ-ийн 172.1-д “Ипотек болон түүний үндэслэл болж байгаа шаардлага нь гагцхүү энэ хуулийн 87.1-д заасны дагуу өөр этгээдэд нэгэн зэрэг хамтдаа шилжиж болно.”, ЭХЭУБтХ-ийн 17.2-т “Ипотек, түүний үндэслэл болж байгаа шаардлага нь нэгэн зэрэг өөр этгээдэд шилжих бөгөөд энэ тухай баримтыг мэдүүлэгт хавсаргана.” гэж хуульчилсан байдаг.

Үл хөдлөх хөрөнгийн барьцааны эрх нь эд хөрөнгийн шинжээсээ хамааран улсын бүртгэлд бүртгүүлснээр үүсэх (ИХ-ийн 166.1) учир өөр этгээдэд шилжүүлэх тохиолдолд ч шаардах эрхийг шилжүүлэн авахаар харилцан тохиролцсон гуравдагч этгээд үүрэг гүйцэтгүүлэгч хэмээн улсын бүртгэлд бүртгэгдсэн байх ёстой (ИХ-ийн 172.2) гэж заасан. Гэтэл бодит байдал дээр шаардах эрх шилжсэн ч энэ талаар бүртгэлд тусгаагүй тохиолдол их гардаг. Шүүх ийм бүртгэл хийгдээгүй байхад ОССК-иас “орон сууцны зээлийн гэрээ”-ний шаардах эрх “А” ХХК-д гэж дүгнэсэн нь бодит үйл баримтаар шаардах эрх шилжих нөхцөл бүрдсэнийг үнэлсэн явдал боловч 2009 оны нэмэлт өөрчлөлт логик зөрчилтэйг илтгэж байна. Хэрэв шинэ үүрэг гүйцэтгүүлэгч нь одоо “А” ХХК болсон бол зээлийн гэрээний үүргийг хариуцагчаас гаргуулах нь зүйтэй бөгөөд зээлийн шаардлагаас салшгүй эрх ипотекийн эрх шилжээгүй хэмээн үзэж, үл хөдлөх хөрөнгөтэй холбоотой барьцаагаар хангуулах нэхэмжлэлийн шаардлагыг хэрэгсэхгүй болгосон нь шийдвэрийг логик зөрчилдөөнтэй болгож байна. Давж заалдах шатны шүүх шаардах эрхийн хамт ипотекийн эрх амжилттай шилжсэн үзсэн нь ИХ-ийн 172.1-д нийцэх дүгнэлт хэдий ч энд ИХ-ийн 172.2-ын хуулийн шаардлага хангагдаагүй нь ойлгомжтой. Улсын бүртгэлд бүртгүүлэх тухай зохицуулалт нь энэ хэвээр үйлчилбэл барьцааны шаардах эрхээ хэрэгжүүлэх боломжгүй гэж үзэхэд бус, харин нийт шаардах эрх шилжүүлэх хэлцлийг хүчингүй гэж үзэх хүчин зүйл болно (ИХ-ийн 56.1.8).

Үүргийн эрх зүйд шаардах эрх хэрэгжүүлэх боломжгүй нөхцөл нь үүрэг гүйцэтгэгч нь уг шаардах эрхтэй холбогдсон үүргээ гүйцэтгэхээс татгалзах эрхтэй уялдан үүсдэг. Эдгээрт үүргийн гүйцэтгэлийг саатуулах эрх, үүрэг гүйцэтгэх хугацаа болоогүйн улмаас татгалзах эрх, гэрээний үндсэн дээр үүргээ гүйцэтгэхээс татгалзах, үүрэг гүйцэтгэх хугацаа болоогүйн улмаас татгалзах эрх, хөөн хэлэлцэх хугацаа дууссантай холбоотойгоор татгалзах эрх тус хамаарна.

Ипотекийн эрхээ хэрэгжүүлэх боломжгүй тохиолдолд үндсэн шаардлагын эсрэг хэрэгжих дээрх татгалзах эрхүүдийн дээр үл хөдлөх хөрөнгийн барьцааны гэрээний барьцаалуулагчаас хэрэгжүүлж болох татгалзал нэмэгдэнэ. Процессын явцад шүүх зөвхөн татгалзах эрхийн урьдчилсан нөхцөл биелсэн, нотлогдсон бөгөөд холбогдох талын үүнийг хэрэгжүүлэхэд чиглэсэн илэрхийлэл бий болсон нөхцөлд л үүнийг харгалзаж үзэх нь зүйтэй.⁴⁹ Гэвч тохиолдлын хүрээнд хариуцагч нарт зээлийн гэрээ болон ипотекийн үүргийн гүйцэтгэлийг татгалзах эрх үүссэн талаарх баримт байхгүй, энэ талаар маргаагүй байхад давж заалдах шатны шүүх шаардлагыг хэрэгжүүлэхээс татгалзах эрхтэй гэж дүгнэсэн нь ойлгомжгүй болсон.

Эрх зүйн бодлогын хувьд энд ИХ-ийн 172.2-ын энэ нэмэлт нүдээ олсон эсэхийг дүгнэх боломж нээгдэж байна. Томоохон зээлийн шаардах эрхийг худалдах, шилжүүлэх хэлцэл хийгдэж, факторингийн институтүүд өсөн нэмэгдэж буй өнөө үед материаллаг эрх зүйн хувьд зээлийн шаардлага хэд хэдэн этгээд дамжин шилжих нь элбэг бөгөөд тэр бүр улсын бүртгэлд шинэ үүрэг гүйцэтгүүлэгчийг тэмдэглүүлэх нь зардал, өртөг ихтэй, арилжааны харилцааны бодит байдалтай үл нийцэх шаардлага юм. Үндсэндээ ипотекийн барьцааны эрх нь бүртгэлтэй эрх боловч шаардах эрх нь чөлөөтэй гүйлгээнд орж байх ёстой. ИХ-ийн 123.8-д заасны дагуу шаардах эрх шилжүүлэх хэлцэл нь зээлийн гэрээний хэлбэрийн

⁴⁹ 2017. Б.Буянхишиг, 2017, 105 дах тал.

шаардлагад захирагдана. Харин дээрх асуудлыг шийдвэрлэхийн тулд үүн дээр нэмж ИХ-ийн 172.2-т заасан хэлбэрийг оруулж ирсэн нь зээлийн шаардлага хуулиар болон гэрээгээр шилжих олон янз практик нөхцөл байдалд нийцэхгүй. Жишээ нь зээлдүүлэгч дампуурсан, татан буугдсан, насан эцэслэсэн эсвэл факторингийн институтэд шилжүүлсэн бол түүний эрх залгамжлагч зээлийн үүргийг төлөх ба түүнд хуулиар ипотекийн барьцааны эрх шилжинэ. Төлөлт хийсэн этгээд нэн даруй шаардах эрх шилжсэн болохыг бүртгүүлж явах гэхээр зээлдүүлэгч нас барсан, татан буугдсан байх болно. Энэ тохиолдол бүрд хууль тогтоогч шүүхийн шийдвэр гаргах үйл ажиллагааг чиглүүлж өгч чадаагүй. Учир нь энд ИХ-ийн 172.2-т заасан хэлбэрийн шаардлагыг хангах эрх зүйн боломж байхгүй юм. Тиймээс ИХ-ийн 172.2-ын улсын бүртгэлийн хэлбэрийн шаардлагыг өөрчилж, улсын бүртгэлд засвар оруулах утга бүхий заалтаар солих нь эдийн засгийн бодит байдалд нийцнэ гэж үзэж байна.

Харьцуулсан эрх зүйн түвшинд судалбал барууны орнуудад ипотека шаардлага хоёрыг мөн үл салгах зарчим үйлчлэх бөгөөд энэ зарчмыг хэрэгжүүлэхийн тулд шаардах эрхийг шилжүүлэх гэрээнд бичгийн хэлбэрээр хийгдсэн байх шаардлага тавигддаг. Мөн барьцаалбарыг хүлээлгэн өгсөн бол түүнд үндсэн шаардлага ба ипотека хамт шилжсэн гэж үзэх бөгөөд тэрээр улсын бүртгэлд өөрчлөлт оруулахыг шаардах эрхтэй болох⁵⁰ тул шүүх уг этгээдийг шаардлагаа хэрэгжүүлэх боломжгүй хэмээн буцаах ёсгүй.

⁵⁰ Жишээ нь ХБНГУ-ын ИХ-ийн 894-ийг энд шаардах эрх шилжсэн тухай дүгнэлт бүхий ИХ-ийн 1153, 1154, 1155-ыг хамт хэрэглэн шийдвэрлэж байна: BGH LM ZVG, 91 №1; Palandt, Bürgerliches Recht, 64. Auflage, S.1544.

2.2.3. Үүрэг гүйцэтгэгч шинэ үүрэг гүйцэтгүүлэгчийн эсрэг хэрэгжүүлэх боломжтой болох

Жишиг шүүхийн шийдвэр 13⁵¹

Маргааны төрөл	Банкны зээл
<p>Маргааны агуулга:</p>	<p>О нь “МШ” банкнаас зээл авахаар хүсэлт гаргасан бөгөөд 2008 оны 07 сарын 07-ны өдөр “Зээлийн гэрээ”-г байгуулсан. Энэхүү гэрээний дагуу “МШ” банкнаас О-д 5,000,000 төгрөгийг жилийн 30 хувийн хүүтэйгээр 1 жилийн хугацаатай олгохоор харилцан тохиролцсон. Гэрээний хугацаа дуусгавар болоход О нь зээлийн үндсэн төлбөрийг хүүгийн хамт эргүүлэн төлөх үүргээ огт биелүүлээгүй.</p> <p>Үүний дараа 2010 оны 03 сарын 17-ны өдөр “МШ” банк болон “ЭХ” банкуудын хооронд “Банкны актив, пассив, хөрөнгө, тэдгээрийг шаардах эрх шилжүүлэх гэрээ”-г байгуулсан. Тус гэрээгээр “МШ” банк нь зээлийн гэрээний шаардах эрхүүдийг “ЭХ” банканд шилжүүлсний дотор О-с шаардах эрх байсан.</p> <p>Ингээд 2022 оны 03 сарын 09-ний өдөр “ЭХ” банкнаас О-д холбогдуулан зээлийн гэрээний үүргийг шаардаж шүүхэд нэхэмжлэл гаргажээ</p>
<p>Анхан шатны шүүх:</p>	<p>Зээлийн гэрээний хугацаа 2008 оны 07 сарын 07-ны өдөр эхэлж, 2009 оны 07 сарын 07-ны өдөр дуусгавар болсон. ИХ-ийн 75.2.1-д гэрээний үүрэгтэй холбоотой хөөн хэлэлцэх хугацаа гурван жил, 76.1-д хөөн хэлэлцэх хугацааг шаардах эрх үүссэн үеэс эхлэн тоолно гэж тус тус зааснаар нэхэмжлэгчийн зээлийн гэрээний үүрэг шаардах эрх 2009 оны 07 сарын 07-ны өдөр үүсэж, энэ өдрөөс хөөн хэлэлцэх хугацааг тоолж, хөөн хэлэлцэх гурван жилийн дараа буюу 2012 оны 07 сарын 07-ны өдөр дуусжээ.</p>

⁵¹ Өвөрхангай аймаг дах сум дундын Иргэний хэргийн анхан шатны шүүхийн 2022 оны 06 сарын 08-ны өдрийн 145/ШШ2022/00285 дугаартай шийдвэр.



Маргааны төрөл	Банкны зээл
	ИХ-ийн 123.6-д зааснаар шаардах эрхийг шинэ үүрэг гүйцэтгүүлэгчид шилжүүлснээр түүнтэй холбоотой бусад эрх нэгэн зэрэг шилжих бөгөөд зээлийн гэрээний шаардах эрхийг шилжүүлэн авсан “ЭХ” банк нь ИХ-ийн 75.2.1-д заасан хөөн хэлэлцэх хугацаанд уг гэрээний үүргийг шаардах эрхтэй гэж үзнэ гээд нэхэмжлэлийн шаардлагыг бүхэлд нь хэрэгсэхгүй болгож шийдвэрлэсэн.

Үүрэг гүйцэтгэгч нь шаардах эрх шилжүүлэх гэрээнд оролцдоггүй тул түүний эрх ашгийг хуулиар хамгаалах шаардлагатай. Тэрээр үндсэндээ шаардах эрхийг шилжүүлэх асуудлыг үүрэг гүйцэтгүүлэгчтэй байгуулсан гэрээгээр хязгаарлаж болох ба дээр дурдсанчлан шаардлага шилжсэний дараа бүх татгалзал, хариу эсэргүүцлээ хадгалж үлддэг.⁵² ИХ-ийн 123.4-д заасан “бүх эсэргүүцэл, шаардлага” гэдэгт хуучин үүрэг гүйцэтгүүлэгчийн үүрэг гүйцэтгэгчийн өмнө хүлээсэн үндсэн буюу хариу үүрэг хамаарахгүй. Учир нь ИХ-ийн 123 нь шаардах эрх, үүргийг хамтад нь шилжүүлэх гэрээ шилжих (novation) ойлголт бус гагцхүү шаардах эрх шилжих ойлголт юм. Иймд шаардах эрхийн эсрэг хэрэгжүүлж болох үүргээ гүйцэтгэхээс татгалзах эрхүүд хамаарна.

Дээрх шүүхийн шийдвэрээр шинэ үүрэг гүйцэтгүүлэгч зээлийн гэрээний үүргийг шаардсан бөгөөд хариуцагчийн зүгээс өмнөх зээлдүүлэгч буюу “МШ” банкны эсрэг гаргаж болох хөөн хэлэлцэх хугацаатай холбоотой татгалзлыг хэрэгжүүлэх боломжтой хэмээн дүгнэсэн боловч ИХ-ийн 123.6-г үндэслэсэн нь учир дутагдалтай болжээ. ИХ-ийн 123.6 нь шаардах эрхтэй хамт шилжих барьцааны эрх, анз шаардах эрх гэх мэт дагалдах эрхүүдийг хамт шилжих талаар зохицуулсан. Зүй нь шүүх ИХ-ийн 126.4-ийг баримтлах ёстой байсан.

⁵² 2017. Б.Буянхишиг, 2017, 247 дах тал.

2.3. ҮҮРЭГ ГҮЙЦЭТГЭГЧИЙГ ХАМГААЛАХ АРГА ХЭРЭГСЭЛ

Жишиг шүүхийн шийдвэр 14⁵³

Маргааны төрөл	Гэм хор учруулснаас гаргуулсан эд хөрөнгийн хохирол
<p>Маргааны агуулга:</p>	<p>Н.С нь «ЭМФ» ХХК-ийн гүйцэтгэх захирлаар 2013 оны 10 сарын 01-ний өдрөөс томилогдон ажиллах болсон бөгөөд тухайн хугацаанд түүний хайхрамжгүй, хариуцлагагүй байдлын улмаас компанийн бизнесийн үйл ажиллагаанд доголдол үүсэж, хохирол учирсан. “ЭМФ” ХХК-д учирсан хохиролд 806,250,000 төгрөгийг тооцон Н.С нь төлөхөөр болсон бөгөөд “ЭМФ” ХХК-ийн хувьцаа эзэмшигч нар “АЖГ” ХХК-тай 2016 оны 10 сарын 24-ний өдөр дээрх үүргийг гүйцэтгүүлэх тухай “Өглөг, авлага болон зээл баталгаажуулах, үүргийн гүйцэтгэлийг хангуулах тухай гэрээ”-г байгуулсан. Тус гэрээний дагуу 600,000,000 төгрөгт тооцуулан Н.С нь өөрийн “И” ХХК-тай байгуулсан “Захиалгаар ажлын байр барих гэрээ”-ний шаардах эрх болох оффисын 120 м.кв талбайг шилжүүлэхийг шаардах эрхийг “АЖГ” ХХК-д шилжүүлэхээр харилцан тохиролцсон.</p> <p>“АЖГ” ХХК, Н.С хэн хэн нь энэ тухайгаа «И» ХХК-д мэдэгдээгүй. Үүнээс хойш 2 жил гаруйн дараа 2018 оны 06 сарын 29-ний өдөр Н.С нь</p> <p>«И» ХХК-тай харилцан тохиролцож «Захиалгаар ажлын байр барих гэрээ»-ээс татгалзаж, дуусгавар болгосон. 2019 онд “АЖГ” ХХК нь “И” ХХК-иас оффисын талбайг шаардсан боловч ийнхүү шилжүүлэхээс татгалзсан тул шүүхэд нэхэмжлэл гаргасан.</p>

⁵³ Чингэлтэй дүүргийн Иргэний хэргийн анхан шатны шүүхийн 2021 оны 11 сарын 08-ны өдрийн 182/ШШ2021/02407 дугаартай шийдвэр, Нийслэлийн Иргэний хэргийн давж заалдах шатны шүүхийн 2022 оны 03 сарын 07-ны өдрийн 210/МА2022/00407 дугаартай магадлал, Улсын дээд шүүхийн 2022 оны 05 сарын 20-ны өдрийн 001/ХТ2022/00625 тогтоол.



Маргааны төрөл	Гэм хор учруулснаас гаргуулсан эд хөрөнгийн хохирол
<p>Анхан шатны шүүх:</p>	<p>“И” ХХК нь түүнтэй байгуулсан Талбай захиалгын гэрээний эрхээ Н.С нь “АЖГ” ХХК-нд шилжүүлсэн байсныг мэдэж байсан гэх нөхцөл байдал тогтоогдсонгүй. Иймд ИХ-ийн 123.1-д “Шаардах эрх шилжих тухай үүрэг гүйцэтгэгчид мэдэгдэх хүртэл үүрэг гүйцэтгэгч анхны үүрэг гүйцэтгэгчийн өмнө гэрээгээр хүлээсэн үүргээ гүйцэтгэнэ” гэж заасны дагуу гэрээний үүргийг цуцлах, дуусгавар болгох харилцааг анхны үүрэг гүйцэтгүүлэгч Н.С-тай тохиролцон шийдвэрлэсэн нөхцөл байдлыг буруутгах боломжгүй байна. Энэ үндэслэлээр энэ гэрээнээс үүдэлтэй маргаан бүхий шаардлагыг “АЖГ” ХХК нь “И” ХХК-нд холбогдуулан гаргах боломжгүй болсон гэж үзэж нэрлэн заасан оффисын талбайг “ЭМФ” ХХК-ийн өмчлөлд бүртгүүлэхэд шаардагдах баримт бичгийг бүрдүүлж өгөхийг даалгуулах нэхэмжлэлийн шаардлагыг хэрэгсэхгүй болгож шийдвэрлэсэн.</p>
<p>Давж заалдах шатны шүүх:</p>	<p>Нэхэмжлэгчийн 2015 оны 12 сарын 15-ны өдрийн захиалгаар ажлын байр барих гэрээний дагуу оффисын талбай буюу үл хөдлөх эд хөрөнгийг “ЭМФ” ХХК-ийн өмчлөлд бүртгүүлэхэд шаардагдах баримт бичгийг бүрдүүлж өгөхийг хариуцагч “И” ХХК-д, уг үл хөдлөх эд хөрөнгийг гаргуулан “ЭМФ” ХХК-ийн өмчлөлд шилжүүлэхийг хариуцагчид даалгах нэхэмжлэлийн шаардлагыг хангах хууль зүйн үндэслэлгүй. Шүүх нэхэмжлэлийн шаардлага, түүний үндэслэлийг талуудаас тодруулсны үндсэн дээр тухайн маргаанд хамааралтай хуулийг тайлбарлан хэрэглэх учиртай. Энэ талаар хийсэн шүүхийн дүгнэлт буруу биш байна гэжээ.</p>
<p>Хяналтын шатны шүүх:</p>	<p>Нэхэмжлэгчийн үл хөдлөх эд хөрөнгийг “ЭМФ” ХХК-ийн өмчлөлд бүртгүүлэхэд шаардагдах баримт бичгийг бүрдүүлж өгөхийг хариуцагч “И” ХХК-д, уг үл хөдлөх эд хөрөнгийг гаргуулан “ЭМФ” ХХК-ийн өмчлөлд шилжүүлэхийг хариуцагчид даалгах нэхэмжлэлийн шаардлагыг хангах хууль зүйн үндэслэлгүй талаарх хоёр шатны шүүхийн хийсэн дүгнэлт хэргийн баримтад тулгуурласан, ИХ-ийн 123.1-д заасныг зөрчөөгүй байна. Учир нь хэрэгт авагдсан баримтаас үзэхэд “АЖГ” ХХК-ийн 2019 оны 04 сарын 17-ны өдрийн “И” ХХК-д мэдэгдэл хүргүүлэх тухай албан бичгийг тухайн компани хүлээн авсан эсэх нь тодорхойгүй, “И” ХХК-ийн Н.С-тэй байгуулсан байр захиалгын гэрээг Н.С төлбөрөө төлөөгүйгээс талууд 2018 оны 06 сарын 29-ний өдөр цуцалсан гэх тайлбарыг үгүйсгэх хууль зүйн үндэслэлгүй гэжээ.</p>

Шаардах эрх шилжсэн талаар мэдэгдэх үүрэг нь үүрэг гүйцэтгэгчийг хамгаалах чухал арга хэрэгсэл бөгөөд шаардах эрх шилжүүлэх гэрээнд оролцдоггүй түүний эрх ашгийг хуулиар хамгаална. Зарчмын хувьд үүрэг гүйцэтгэгчид мэдэгдэлгүйгээр, түүний зөвшөөрөлгүйгээр шаардах эрхийг шилжүүлж болох тул үүрэг гүйцэтгэгчийн хуучин үүрэг гүйцэтгэгчийн өмнө гүйцэтгэсэн үүрэг нь шинэ үүрэг гүйцэтгүүлэгчийн хувьд ч гэсэн хүчинтэй байх нь шударга ёс, зүйд нийцнэ⁵⁴.

Энэхүү шүүхийн шийдвэр нь ИХ-ийн 123.1-т заасан “..анхны үүрэг гүйцэтгэгчийн өмнө үүргээ гүйцэтгэх” гэдгийг явцуу утгаар буюу үүрэг гүйцэтгэгч зөвхөн хуучин үүрэг гүйцэтгүүлэгчийн өмнө гүйцэтгэсэн үүргийн гүйцэтгэлийг хамрахын сацуу өргөн утгаараа бусад эрх зүйн харилцааг өөрчлөх эрхийг хэрэгжүүлэх боломжийг нэгэнт шаардлагын өмчлөгч биш болсон хуучин үүрэг гүйцэтгүүлэгчид олгож, түүнийг үүрэг гүйцэтгүүлэгч хэвээр мэт тооцох агуулгатайг тодотгосон эрх зүйн ач холбогдолтой шийдвэр болжээ.

Шүүх ИХ-ийн 123.1 зохицуулалтын үүрэг гүйцэтгэгчийг хамгаалах зорилгын хүрээнд шаардах эрх шилжсэн тухайд үүрэг гүйцэтгэгчид мэдэгдэх хүртэл түүний хувьд анхны үүрэг гүйцэтгүүлэгч нь шаардах эрхийн өмчлөгч мэт тооцогдох эрх зүйн үр дагавартай байхаар тайлбарлажээ. Тодруулбал “АЖГ” ХХК болон Н.С нарын хооронд шаардах эрх шилжүүлэхээр харилцан тохиролцсоноор “И” ХХК нь энэ талаар мэдсэн, зөвшөөрсөн эсэхээс үл хамааран тус гэрээний захиалагч нь “АЖГ” ХХК болсон. Гэхдээ аль аль нь түүнд мэдэгдээгүй тул “И” ХХК-г хамгаалах ба энд ИХ-ийн 123.1 үйлчлэх ёстой. Энэ заалтыг зөвхөн үүргийн гүйцэтгэлийн холбоотой гэж үзвэл дээрх тохиолдолд “И” ХХК-ийн эрх хамгаалагдах боломжгүйд хүрнэ. Тиймээс шүүх Н.С-г “үүрэг гүйцэтгүүлэгч” мэтээр тооцож, түүний дуусгавар болгосон үйлдлийн үр дагаврыг шинэ үүрэг гүйцэтгүүлэгч АЖГ-ХХК-ийн эсрэг хэрэглэжээ. Ийнхүү тооцох хамгийн гол үзүүлэлт нь “И” ХХК шаардлага шилжсэн талаар огт мэдээгүй байх юм.

⁵⁴ Ё.Каят нарын зохиогчид, 2010, 212 дах тал.

ДҮГНЭЛТ, САНАЛ

Шаардах эрх шилжүүлэх гэрээний маргаан бүхий шийдвэрүүдэд хийсэн дүн шинжилгээний явцад дараах эрх зүйн асуудал үүсэж, үүнийг шийдвэрлэхэд зарим талаар хууль хэрэглэгчийн хууль тайлбарлах үүрэг доголдож байгаа нь ажиглагдлаа.

Шаардах эрх шилжүүлэх гэрээний үндсэн дээр шаардах эрх шилжихэд үүрэг гүйцэтгэгчийн зөвшөөрөл шаардлагагүй болохыг ИХ-ийн 123.2-т туйлын тодорхой хуульчилсан ч практикт үүрэг гүйцэтгэгчид мэдэгдсэн эсэхээс шаардлагын шилжүүлэг хүчин төгөлдөр эсэхийг дүгнэж буй нь оновчгүй байна. Мөн ирээдүйд үүсэх шаардах эрхийг шилжүүлэхээр харилцан тохиролцсон гэрээтэй холбоотой маргаанд шаардах эрх агуулгын хувьд үүссэн байх шаардлага тавих албагүй байна. Түүнчлэн шаардах эрх шилжих болон өр барагдуулах хэлцлийг тусгаарлан авч үзэх нь зүйтэй бөгөөд эдгээрийн хооронд хийсвэрлэх зарчим үйлчлэх нь бусдын авлагыг нийт үнийн дүнгээс бага үнээр худалдан авдаг факторингийн үйлчилгээг Монгол Улсад нэвтрүүлэхэд зайлшгүй шаардлагатай.

Шаардах эрх үүссэн гэсэн шаардлага нь дээрх тодорхой байх зарчимтай харилцан хамааралтай бөгөөд үүнд заавал гэрээний нэрлэн заасан зохицуулалтын дагуу шаардах эрх үүссэн байхаас гадна хуулийн систем, бүтцийн аль хэсэгт үндэслэн шаардах эрхтэй болохыг тогтоох буюу буцаан шаардах эрх агуулгын хувьд үүссэн байхыг голчилж байна.

- *Шаардах эрх шилжүүлэх хориг:* Хувийн эрх зүйн хууль тогтоомжид нийтлэг байдлаар шаардах эрх шилжих гэрээг

хориглосон зохицуулалт байхгүй. Зээлийн үйл ажиллагаа эрхлэгч хуулийн этгээд нь зээлийн шаардах эрхийг бусад иргэн болон өөрийн хувь нийлүүлэгчдээ шилжүүлэх явдал гадаад улс оронд тун хомс боловч Монгол Улсад элбэг тохиож байна. Факторингийн үйлчилгээ эрхлэгчийг зөвхөн өр барагдуулах зорилгоор байгуулдаг тул түүнд шаардлагаа шилжүүлэх ба адилхан зээлийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл шаардахгүй. Түүний нэгэн адилаар иргэн, хувь нийлүүлэгчид шаардлага шилжүүлэхэд дампуурлын зэрэг бусад хууль тогтоомжийн зөрчил бий эсэхийг хянах ба ийнхүү шаардлагыг шилжүүлэхгүй байх гэсэн ерөнхий хориг байхгүй. Тиймээс бид банкны зээлийн гэрээнд зарим шүүхийн үзэл баримтлал, хууль тогтоогчийн хүсэл зориг зэргийг харгалзан зээлдүүлэгчийн эрхийг зөвхөн тусгай зөвшөөрөл бүхий этгээдэд шилжүүлэх зөвшөөрөгдөнө гэж дүгнэх боломжгүй. Хадгаламж, зээлийн хоршооны үйл ажиллагаа нь мөн л тусгайлсан хуулийн зохицуулалттай үйл ажиллагаа тул дээрх асуудал мөн үүсэх ба нэгэнт үүссэн шаардлагыг субъектээс үл хамааран шилжүүлэх харилцааг дүгнэх нь зүйтэй. Харин шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн хүрээнд шаардах эрхийг битүүмжилж үл болох хүрээнд шилжүүлэхийг хориглодог тул үүнийг ИХ-ийн 56.1.1-ийг хэрэглэхдээ тооцож үзэх нь зүйтэй.

Түүнчлэн гэм хорын шаардах эрхийг огт шилжүүлэхгүй байх эсвэл сэтгэцэд учирсан хохирлыг шилжүүлэх нь гэм хорын үүргийн мөн чанарт харшилж буй эсэх талаар шүүхээс эцэслэн шийдвэрлэсэн шийдвэр хараахан үгүй байна. Гэм хорын шаардлагыг шилжих боломжтой эсэхийг дүгнэхдээ а) тухайн шаардах эрхийг зохицуулж буй хууль тогтоомжийн агуулгад харш, б) үүргийн мөн чанарт харш, в) анхны үүрэг гүйцэтгэгч, гүйцэтгүүлэгч нар үүнийг гэрээгээр хязгаарласан, хүчин төгөлдөр нөхцөл бий эсэхийг тогтоох ба энд юуны өмнө ИХ-ийн 437.7, 514 зэрэгт хуулиар шаардах эрх шилжих зохицуулалттай салбар багтах ёстой. Ийнхүү хуулиар шаардлага шилжих нөхцөл нь тухайн гэм хорын шаардлагыг цааш шилжүүлэхгүй байх үндэс болох тул энэ талаар шүүх байр сууриа тодорхой илэрхийлэх шаардлага байсаар байна.

- Шаардах эрх шилжих гэрээний эрх зүйн үр дагаврыг тодорхойлсон байдал:
 - Шаардах эрх шилжүүлэн авсан этгээд үүрэг гүйцэтгүүлэгчийн үндсэн эрх буюу гэрээний харилцааг дуусгавар болгох эрхийг хамт шилжүүлэн авсан эсэхийг дүгнэсэн шийдвэрээс шүүхийн хэрэглэж буй шалгуур нь тодорхой бус байгаа нь ажиглагдсан. ИХ-ийн 122.2-т заасан эрхийг ИХ-ийн 123-т заасан шаардах эрхээс ялгаж үзэх боловч, хэрэглэх зохицуулалтын хувьд эрх шилжих ИХ-ийн 123 үйлчлэх ёстой. Практикт эрхийн ангилал бүрхэг байгаа нь шүүхийн шийдвэрээс харагдах ба гэрээний харилцааг дуусгавар болгох эрхүүд нь шаардах эрх биш, бие даасан бус эрхийн ангилалд багтаж, гэрээний үндсэн дээр шаардах эрх шилжихэд хамт шилжих боломжтой. Шүүхийн дүгнэлтийг өөр өөр маргаанд харилцан адилгүй авч хэрэглэхээс сэргийлэх үүднээс ИХ-ийн 122.2-ыг илүү тодорхой болгох, эрх зүйн ухамсрын түвшинд эрх өөрчлөхөд чиглэсэн харьцангуй эрхийн ангиллыг нэг мөр болгох шаардлагатай.
 - Хөгжлийн банк өгсөн зээлийнхээ үүргийн гүйцэтгэлийг хангах арга хэрэгслийг алдаж байгаа сөрөг үзэгдлээс бид шаардах эрхийг барьцаалах харилцаанд үйлчлэх зохицуулалт дутмаг, төөрөгдөл үүсгэх боломжтойг харж болохоор байна. ХБНГУ-ын эрхийн барьцааны зохицуулалт нь тус улсын ИХ/ВГВ/-ийн 1273-1296-д нийт 20 зохицуулалтыг хамарсан байхад эрхийн барьцаа шилжихэд МУ-д ИХ-ийн 61.1 үйлчлэх жишээтэй. Эрх зүйн энэ үр дагаврын хувьд уг маргаанд зохицуулалт нь ижил байсан тул шийдвэр нь төлөөлөх шинжтэй. Гэхдээ бусад барьцааны зохицуулалтын хүрээнд ИХ-ийн 164.1-ийн дагуу эрхийн барьцаанд хөдлөх хөрөнгийн бусад бүх зохицуулалтыг нэгэн адил хэрэглэнэ гэсэн нь боломжгүй юм. Жишээ нь барьцааны эрхийг шударгаар олж авах тухай, барьцааны эрхийн үр шимийг

хүртэх тухай, мөн худалдан борлуулах ажиллагааны явцад гэрээний зүйлд өөрчлөлт оруулах тухай зохицуулалтыг эрхийг барьцаанд хэрэглэж үл болох тул эрхийн барьцааны хувьд ихээхэн зохицуулалтын дутагдал байсаар байна.

- Үндсэн шаардлага ба барьцаа нягт уялдаатай байх нь ипотекийн хувьд заавал үйлчлэх суурь зарчмын шинжтэй шаардлага боловч зээлийн шаардах эрхийг худалдах, шилжүүлэх хэлцэл олноор хийгдэж, факторингийн институтүүд өсөн нэмэгдэж буй өнөө үед материаллаг эрх зүйн хувьд зээлийн шаардлага хэд хэдэн этгээд дамжин шилжих нь элбэг. Үндсэндээ ипотекийн барьцааны эрх нь бүртгэлтэй эрх боловч шаардах эрх нь чөлөөтэй гүйлгээнд орж байх ёстой. ИХ-ийн 172.2-т заасан хэлбэрийг 2009 оны хуулиар оруулсан нь зээлийн шаардлага хуулиар болон гэрээгээр шилжих олон янз практик нөхцөл байдалд нийцэхгүй. Тиймээс ИХ-ийн 172.2-ын улсын бүртгэлд заавал бүртгүүлэх хэлбэрийн шаардлагыг өөрчилж, улсын бүртгэлд засвар оруулах эрх олгосон заалтаар орлуулах нь эдийн засгийн бодит байдалд нийцнэ.
- Шүүх ИХ-ийн 123.1-ийг үүрэг гүйцэтгэгчийг хамгаалах зорилгын хүрээнд шаардах эрх шилжсэн тухайд үүрэг гүйцэтгэгчид мэдэгдэх хүртэл түүний хувьд анхны үүрэг гүйцэтгүүлэгч нь шаардах эрхийн өмчлөгч мэт тооцогдох, ийнхүү итгэж үнэмшсэний улмаас үүрэг гүйцэтгэгч түүнтэй гэрээг дуусгавар болгох зэргээр тохиролцвол энэ нь шинэ үүрэг гүйцэтгүүлэгчийн эсрэг хамгаалалт болно гэж үзсэн нь оновчтой байна.

АШИГЛАСАН ЭХ СУРВАЛЖ

Эрх зүйн баримт бичиг

1. Иргэний хууль, 2002.
2. Үл хөдлөх эд хөрөнгийн барьцааны тухай хууль, 2009.
3. Дампуурлын тухай хууль, 1997.
4. Компанийн тухай хууль, 2011.
5. Банк бус санхүүгийн үйл ажиллагааны тухай хууль, 2002.
6. Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хууль, 2001.
7. Зөвшөөрлийн тухай хууль, 2022.
8. Хадгаламж, зээлийн хоршооны тухай хууль, 2011.
9. Улсын дээд шүүхийн Иргэний хуулийн 12 дугаар бүлгийн 1, 2 дугаар дэд бүлгүүдийн зарим зүйл, заалтыг тайлбарлах тухай тогтоол, дугаар 18, 2009.06.15.
10. Улсын дээд шүүхийн Хүний сэтгэцэд учирсан хор уршгийг арилгах, нөхөн төлбөрийн жишиг аргачлалыг батлах тухай тогтоол, дугаар 25, 2023.07.23.

Гадаад улсын хууль тогтоомж

1. ХБНГУ-ын Иргэний Хууль, үүргийн ерөнхий ангийн шаардах эрх шилжүүлэхтэй холбоотой бүлэг зохицуулалт.

Монгол хэл дээрх ном, сурах бичиг

1. Монгол Улсын Иргэний хуулийн тайлбар, Ё.Кают, Э.Шпанглер, П.Редел, Р.Хелмхаген, Д.Наранчимэг, Ц.Амарсайхан, Д.Дүгэржав, Н.Баярмаа, Монгол Улс, Улаанбаатар хот, Эдмон ХХК, 2010.
2. Үүргийн эрх зүй ерөнхий анги, Б.Буянхишиг, Монгол улс, Улаанбаатар хот, LIA Publishing, 2017.

3. Үүргийн эрх зүй ерөнхий анги (анхны хэвлэл), Б.Буянхишиг, Монгол Улс, Улаанбаатар хот, LIA Publishing, 2013.
4. Иргэний эрх зүй ерөнхий анги, Б.Тэмүүлэн, Д.Энхзул, Б.Буянхишиг, Монгол Улс, Улаанбаатар хот, Мөнхийн үсэг групп, 2010.
5. Иргэний эрх зүй гарын авлага, Б.Тэмүүлэн, Ш.Ариунбилэг, Б.Буянхишиг, Монгол Улс, Улаанбаатар хот, ВСІ хэвлэлийн компани, 2013.
6. Иргэний хуулийн тайлбар толь: Ерөнхий анги, Улаанбаатар хот 2006.



З

ӨВ ЗАЛГАМЖЛАЛТАЙ ХОЛБООТОЙ ИРГЭНИЙ ХЭРЭГ МАРГААН ХЯНАН ШИЙДВЭРЛЭСЭН ШҮҮХИЙН ШИЙДВЭРИЙН СУДАЛГАА

СУДЛААЧДЫН ТАНИЛЦУУЛГА



ЧАДРААБАЛЫН БАЯНЖАРГАЛ

(Хууль зүйн ухааны доктор Ph.D, дэд профессор)

Ч.Баянжаргал нь Монголын Нотариатчидын Танхимын Ерөнхийлөгч, Монголын Хуульчдын Холбооны Нотариатын хөгжлийг дэмжих хорооны тэргүүнээр ажилладаг.

2021 онд Их засаг ОУИС болон ОХУ-ын Буриадын ИС-ийн хамтарсан олон улсын эрх зүйн докторын зэрэг хамгаалуулах зөвлөлд “нотариатын эрх зүйн зохицуулалтын харьцуулсан судалгаа” сэдвээр хууль зүйн ухааны докторын зэрэг хамгаалсан.

2005-2011 онд Монголын Өмгөөлөгчдийн Холбооны гишүүн, өмгөөлөгчөөр ажиллаж байсан бөгөөд боловсролын байгууллагад 20 гаруй жил багшилж, ном сурах бичиг, сургалтын хөтөлбөр боловсруулж, нийтлүүлсэн туршлагатай.

Судлаачид

Ахлагч:
Ч.Баянжаргал

Багийн гишүүн:
Ц.Оюунаа
Г.Сувд-Эрдэнэ



ЦЭРЭНДАГВЫН ОЮУНАА

(Хууль зүйн ухааны доктор Ph.D, дэд профессор)

ОХУ-ын БУИС-ийн Хуулийн факультетыг дүүргэсэн бөгөөд Шихихутуг их сургуульд магистр, ОХУ-ын Москвагийн МУФО академид Хууль зүйн ухааны докторын зэрэг хамгаалсан.

Боловсролын байгууллагад 20 гаруй жил багшлахдаа ном сурах бичиг, гарын авлага, олон тооны өгүүлэл шүүмж бичиж нийтлүүлжээ. Тэрээр докторын судалгааны ажилд шүүмж бичиж, хувийн эрх зүйн чиглэлээр докторын судалгааны ажил удирдаж, эрх зүйн философи, олон улсын хувийн эрх зүй, өв залгамжлалын эрх зүй, Азийн болон зарим орнуудын өв залгамжлалын хууль тогтоомжийн харьцуулсан судалгаа хийж, багшилж байна.



ГАЛДААГИЙН СУВД-ЭРДЭНЭ

(Хууль зүйн ухааны магистр)

Орхон Их Сургуулийг эрх зүйн бакалаврын зэрэгтэй төгсөж МУИС-ийн Хууль зүйн сургуульд Хууль зүйн магистрын зэрэг хамгаалсан.

НҮБ, МУ-ын ЗГ-ын хамтарсан “Монгол Улсад хүний эрхийг хангах үндэсний хөтөлбөр боловсруулах төсөл”, Нийслэлийн Хүүхэд Залуучуудын Газарт хуулийн зөвлөх, хуулийн фирмд хуульч, хуулийн зөвлөхөөр ажилласан туршлагатай. 2009 оноос Монголын Нотариатчидын Танхимын гишүүн, нийслэлийн тойргийн нотариатчаар ажиллаж байна.

АГУУЛГА

ГРАФИКИЙН ЖАГСААЛТ.....	187
ТОВЧИЛСОН ҮГИЙН ЖАГСААЛТ.....	188
УДИРТГАЛ.....	189
НЭГ. ӨВ ЗАЛГАМЖЛАЛЫН ОНОЛ, ЭРХ ЗҮЙН ШИНЖИЛГЭЭ.....	192
1.1. Өв залгамжлалын эрх зүйн мөн чанар, ач холбогдол.....	192
1.2. Олон улсын өв залгамжлалын эрх зүйн зохицуулалтын онцлог.....	193
1.2.1. Холбооны Бүгд Найрамдах Герман Улс.....	197
1.2.2. Бүгд Найрамдах Франц Улс.....	199
1.2.3. Япон Улс.....	199
1.2.4. Бүгд Найрамдах Хятад Ард Улс.....	200
1.3. Монгол улсын өв залгамжлалын эрх зүйн зохицуулалт.....	201
ХОЁР. ШҮҮХИЙН ШИЙДВЭРИЙН СУДАЛГАА.....	207
2.1. Иргэний хэргийн анхан шатны шүүхийн шийдвэрт хийсэн дүн шинжилгээ.....	208
2.1.1. Хууль ёсны өвлөгчөөр тогтоолгох тухай.....	213
2.1.2. Өмчлөгчөөр тогтоолгох тухай.....	217
2.1.3. Өвлөгдөх хөрөнгөнөөс оногдох хэсгээ гаргуулах тухай.....	220
2.1.4. Өв хүлээн авах хугацааг сунгах.....	222

2.1.5. Нотариатын үйлдлийг хүчингүй болгуулах тухай.....	224
2.1.6. Өвлөх эрхийн гэрчилгээ олгохыг даалгах тухай.....	226
2.2. Давж заалдах шатны шүүхийн магадлалд хийсэн дүн шинжилгээ.....	227
2.2.1. Шийдвэрийг хүчингүй болгож, дахин хэлэлцүүлэхээр буцаасан.....	231
2.2.2. Шийдвэрийг хэвээр үлдээж, гомдлыг хангахгүй орхисон.....	233
2.2.3. Шийдвэрт өөрчлөлт оруулсан.....	236
2.2.4. Шийдвэрийг хүчингүй болгож шийдвэрлэсэн.....	240
2.3. Хяналтын шатны шүүхийн тогтоолд хийсэн дүн шинжилгээ.....	244
2.3.1. Шийдвэр, магадлалыг хүчингүй болгож, дахин хэлэлцүүлэхээр анхан шатны шүүхэд буцаасан.....	246
2.3.2. Магадлалыг хэвээр үлдээж, гомдлыг хангахгүй орхисон.....	250
2.3.3. Магадлалыг хүчингүй болгож, анхан шатны шүүхийн шийдвэрт өөрчлөлт оруулсан.....	253
2.3.4. Магадлалд өөрчлөлт оруулсан.....	258
ДҮГНЭЛТ.....	263
САНАЛ.....	267
АШИГЛАСАН ЭХ СУРВАЛЖ.....	269

ГРАФИК, ХҮСНЭГТИЙН ИЙН ЖАГСААЛТ

График 1. Иргэний хэргийн анхан шатны шүүхээр шийдвэрлэгдсэн өв залгамжлалтай холбоотой 54 иргэний хэргээс сонгон судалсан 6 хэрэг.....	210
График 2. Сонгон судалсан 6 шүүхийн шийдвэр он тус бүрээр.....	211
График 3. Иргэний хэргийн анхан шатны шүүхэд хянагдсан иргэний хэрэг маргааны агуулга.....	211
График 4. Иргэний хэргийн анхан шатны шүүх хэргийг шийдвэрлэсэн байдал.....	212
График 5. Иргэний хэргийн анхан шатны шүүхийн шийдвэрийн хүчин төгөлдөр байдал.....	212
График 6. Иргэний хэргийн анхан шатны шүүхээр шийдвэрлэгдсэн 6 хэргийн шүүхийн харьяалал.....	213
График 7. Давж заалдах шатны шүүхийн сонгон авсан магадлалын ангилал.....	229
График 8. Судалгаанд хамрагдсан магадлалыг гаргасан Давж заалдах шатны шүүхийн харьяалал.....	229
График 9. Сонгон судлагдсан 4 магадлал он тус бүрээр.....	230
График 10. Давж заалдах шатны шүүхэд хянагдсан өв залгамжлалтай холбоотой иргэний хэргийн тоо (2020-2022 он).....	230
График 11. Давж заалдах шатны шүүхээс анхан шатны шүүхийн шийдвэрийг хянасан байдал.....	230
График 12. Хяналтын шатны шүүхэд хянагдсан 4 хэрэг он тус бүрээр.....	245
Хүснэгт 1. Өвлөх эрхийн гэрчилгээ олгосон болон гэрээслэлээр гэрчилсэн үйлдлийн тоо	267

ТОВЧИЛСОН ҮГИЙН ЖАГСААЛТ

БГД	Баянгол дүүрэг
БЗД	Баянзүрх дүүрэг
ЗСБНХУ	Зөвлөлт Социалист Бүгд Найрамдах Холбоот Улс
ИХ	Иргэний хууль
ИХАШШ	Иргэний хэргийн анхан шатны шүүх
ИХДЗШШ	Иргэний хэргийн давж заалдах шатны шүүх
ИХШХШТХ	Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль
МНТ	Монголын Нотариатчидын танхим
НТХ	Нотариатын тухай хууль
СБД	Сүхбаатар дүүрэг
СХД	Сонгинохайрхан дүүрэг
УДШ	Улсын Дээд шүүх
ХУД	Хан-Уул дүүрэг
ХХК	Хязгаарлагдмал хариуцлагатай компани
ШШГТХ	Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хууль

УДИРТГАЛ

Монгол Улсын Үндсэн хуульд иргэн хөрөнгөө өв залгамжлуулах эрхийг баталгаатай эдлэх талаар хуульчилжээ.¹ Өв залгамжлуулах эрх нь гэрээслэл үйлдэх болон хууль ёсоор өвлүүлэх замаар хэрэгждэг. Энэ эрхийг баталгаажуулах үндсэн чиг үүргийг нотариатч хэрэгжүүлдэг бөгөөд гэрээслэлээр болон хууль ёсоор өвлөх иргэдийн өв хүлээн авах хүсэлтийг үндэслэн тэдгээрт өвлөх эрхийн гэрчилгээ олгогдсоноор энэ эрхээ эдлэх хууль зүйн баталгаа бүрддэг.

Өвлөх эрхийн гэрчилгээг хуульд заасан тохиолдолд улсын бүртгэлд бүртгүүлснээр хүчин төгөлдөр болж, өв залгамжлалыг гүйцэтгэн өвлүүлэгчийн эрх болон хөрөнгө үе дамжин өвлөгдсөөр ирсэн уламжлалтай.

Нотариатчидаас олгосон нийт өвлөх эрхийн гэрчилгээтэй харьцуулбал цөөн тооны өвлөх эрхтэй холбоотой иргэний хэрэг маргаан үүсэж, тэдгээр нь шүүхээр шийдвэрлэгдсэн байна. Шүүх хэрхэн шийдвэрлэснээс шалтгаалж өвлөгчдийн эрх, хууль ёсны ашиг сонирхол хангагдах учиртай. Анхан шатны шүүхийн шийдвэрийг хэргийн оролцогчид буруу гэж үзэж гомдол гаргах нь түгээмэл байгаа бөгөөд түүнийг давж заалдах шатны шүүх хэвээр үлдээхээс гадна зарим хэсэгт нь өөрчлөлт оруулах замаар алдааг залруулах, эсхүл хүчингүй болгож, дахин хянан хэлэлцүүлэхээр буцаах тохиолдол цөөнгүй байна. Энэ нь анхан шатны шүүх нэг төрлийн хэрэг маргааныг харилцан адилгүй шийдвэрлэж байгаагийн илрэл юм.

¹ Монгол Улсын Үндсэн хуулийн хоёрдугаар бүлгийн 16 дугаар зүйлийн 3.

Иймээс өв залгамжлалтай холбоотой иргэний хэрэг, маргааныг хянан шийдвэрлэсэн шүүхийн шийдвэрийг судлах эл судалгааны ажлын зорилго нь шүүх маргааны үйл баримтын талаарх мэдээлэл бүхий нотлох баримтыг хэргийн оролцогчдын хүсэлтээр бүрдүүлж, түүнийг шинжлэн судлах, үнэлэх, хуулийн ямар зүйл, заалтын агуулгад тохирч байгааг шалгахдаа УДШ-ийн тайлбар болон зөвлөмж, хууль зүйн ойлголт, онол, үзэл баримтлалыг хэрхэн бодитой, зүй зохистой хэрэглэж буй байдал, тухайн хэрэг маргаанд дүгнэлт хийсэн байдалд дүн шинжилгээ хийх замаар хуулийг нэг мөр, зөв ойлгож хэрэглэх, эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгоход хувь нэмэр оруулах явдал юм.

Судалгааны хүрээг сүүлийн 3 жилийн хугацаанд шийдвэрлэсэн өв залгамжлалтай холбоотой нийт 14 иргэний хэргийн шүүхийн шийдвэр, магадлал, тогтоолоор тогтоож, дараах зорилтыг тавилаа.

1. Иргэний хэргийн анхан, давж заалдах болон хяналтын шатны шүүхийн шийдвэрт дүн шинжилгээ хийх замаар дүгнэлт, санал бэлтгэх;
2. Шүүхэд нэхэмжлэл гаргаж буй үндэслэл, хэрэг маргааны төрлийг тодорхойлох;
3. Анхан болон давж заалдах, хяналтын шатны шүүхээс шийдвэрийн үндэслэлээ хэрхэн тайлбарлаж, нотлох баримтыг үнэлэхдээ холбогдох баримтыг үгүйсгэсэн үндэслэлээ тодорхой зааж байгаа эсэх, нэхэмжлэлийн шаардлагыг хангаж, эсхүл хэрэгсэхгүй болгож шийдвэрлэхдээ НТХ, ИХ, ИХШХШТХ-ийг хэрхэн хэрэглэж байгаа талаар дүн шинжилгээ хийх;
4. Өв залгамжлалтай холбоотой гадаадын зарим орны эрх зүйн зохицуулалт, практикийг судалж, хууль тогтоомжийг боловсронгуй болгох санал бэлтгэх;

Судалгааг шүүхийн шийдвэрийн сан буюу www.shuukh.mn цахим хуудаст байршуулсан шүүхийн шийдвэр, бусад баримт бичиг судлах, тоон мэдээнд дүн шинжилгээ хийх, харьцуулалтын, задлан шинжлэх, нэгтгэн дүгнэх аргуудыг ашиглан Шүүхийн ерөнхий зөвлөлөөс баталсан “Шүүхийн шийдвэрт дүн шинжилгээ хийх аргачлал”²-д үндэслэн гүйцэтгэв.

² Шүүхийн ерөнхий зөвлөл, Шүүхийн судалгаа, мэдээлэл, сургалтын хүрээлэн, “Шүүхийн шийдвэрт дүн шинжилгээ хийх аргачлал”, 2015.

НЭГ. ӨВ ЗАЛГАМЖЛАЛЫН ОНОЛ, ЭРХ ЗҮЙН ШИНЖИЛГЭЭ

1.1. ӨВ ЗАЛГАМЖЛАЛЫН ЭРХ ЗҮЙН МӨН ЧАНАР, АЧ ХОЛБОГДОЛ

Өв залгамжлал нь нас барсан этгээдийн эдийн эрх болон үүрэг нь эрх зүйн өөр субъектэд шилжих харилцааг зохицуулдаг иргэний эрх зүйн эртний институтийн нэг юм. Эзэмшигч субъект нь нас барсны дараа эд хөрөнгийн хувь заяаны асуудал хувь хүний болон нийгмийн хувьд онцгой *ач холбогдолтой* байдаг учраас л энд янз бүрийн ашиг сонирхол тулгардаг.³ Өв залгамжлалын эрх зүйн хөгжил, хувьслын чиглэл өөрчлөгдсөөр ирсэн хэдий ч эд хөрөнгийн талаарх эрх, үүрэг хэнд шилжих, хэн эзэмшигч нь болох асуудал иргэний нийгмийн харилцаанд байсаар ирсэн.

Эд хөрөнгө *өв залгамжлалын журмаар шилжих шилжилтийг зохицуулсан эрх зүйн үндсэн бүтэц, ойлголт эртний Ромын эрх зүйд* боловсруулагдсан ба эрх зүйн бүтцийн олонхыг өнөөгийн иргэний эрх зүйн тогтолцоонд ямар нэг хэмжээгээр, их бага аль нэг засвар өөрчлөлттэйгөөр өвлөн авсан байдаг.⁴ *Ромын хуульчид өв залгамжлалын ойлголтыг* “Өвлөх гэдэг нь нас барагчийн эзэмшиж байсан бүх эрхийг цогцоор нь өвлөн авч буй хэрэг юм” хэмээн тодорхойлсон байдаг.⁵ *Ромын өв залгамжлалын эрх*

³ Ц.Оюунаа, Өв залгамжлалын эрх зүй - Олон улсын хувийн эрх зүйн хүрээн дэх судалгаа, 2017, 10 дах тал

⁴ Ц.Оюунаа, Эртний Ромын хувийн эрх зүй дэх өвлөх эрх, түүхэн тойм, 2016, 8 дах тал.

⁵ Hereditas nihil aliud est, quat succession inuversum ius quod sefunctus habuerit - Өвлөл нь нас барагчийн эзэмшиж байсан бүх эрх, үүргүүдийг үргэлжлүүлэн авах гэсэн утга илэрхийлдэг байна. Дигести Юстиниана: пер с лат. /отв.ред Л.Л.Кофанов, Т. 7. Полу том 2. М, Статут. 2005, 534-535 дах тал.



зүйн үзэл баримтлалын үндэс нь нас барагч этгээдийн удам угсааныханд болон үе залгамжлагчдад уг хувь хүн “үргэлжилж байдаг”, өөрөөр хэлбэл, эд хөрөнгө өв залгамжлалын дагуу шилжих нь түгээмэл эрх залгамжлал гэж үзээд өвлөгч болон өвлүүлэгч нь нэг л хүн мэтээр үздэгт оршдог⁶ байв.

Өв залгамжлалын мөн чанарыг ойлгох энэ ойлголт нь эх газрын буюу Ром-Германы эрх зүйн бүлийн олонх оронд хүлээн зөвшөөрөгдсөн онол-практикийн⁷ чухал ойлголт юм.

1.2. ОЛОН УЛСЫН ӨВ ЗАЛГАМЖЛАЛЫН ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТЫН ОНЦЛОГ

Өнөөдөр дэлхийн улс орон, ард түмэн хоорондоо улс төр, нийгэм, эдийн засаг, соёл, хүмүүнлэгийн харилцаанд идэвхтэй оролцох болсон нь иргэний эрх зүйн харилцааны хөгжлийн орчин үеийн хандлагын онцлог болж байна. Өвлөх харилцаа нь үүргээс салангид орших боломжгүй бөгөөд энэ харилцаа янз бүрийн шалтгаанаар “олон улсын шинжтэй” болох нь нэмэгдсээр байна. Тиймээс гадаад орнуудын өв залгамжлалын эрх зүйн үндсэн заалтуудыг судлах зайлшгүй шаардлага зүй ёсоор тавигдаж байна. Улс орнуудын эрх зүйн тогтолцоо өөр өөр байдгаас нас барсан хүний эд хөрөнгө бусад хүнд шилжих шилжилт ихээхэн өвөрмөц байдаг.

Нийтлэг эрх зүйн тогтолцоотой улс орнуудад өвлөх журам нь шүүхийн прецедентийн зэрэгцээ тусгай актуудаар (statutes) зохицуулагддаг байна. Тухайлбал, Англид 1925 оны “Өмчийн тухай хууль” (The British Law and Property Act 1925), “Гэрээслэлийн тухай хууль”, 1963 оны Гэрээслэлийн тухай акт, 1961 оны Гэрээслэлийн захирамжийн хэлбэрт хамааралтай хуулиудын зөрчилдөөний тухай Гаагийн конвенцын заалтууд, 1918 оны “Усан цэргийн болон цэргийн гэрээслэлийн тухай хууль”, 1938 оны “Өвлөх тухай хууль” (Гэр бүлийн хангамжийн тухай), “Гэрээслэл үлдээгээгүй өмчийн

⁶ Nostris videtur legibus una quo quodammodo persona heredas et illius qui hereditatum in eum transmittit - Өвлөгч, өвлүүлэгч хоёрыг нэг хүн гэж үздэг тухай ойлголт. Ромын хувийн эрх зүй, Ред. И.Б.Новицкий, И.С.Перетерский. М. Юрист, 1997, 222 дах тал.

⁷ Ц.Оюумаа, Эртний Ромын хувийн эрх зүй дэх өвлөлийн асуудал - Ромын эрх зүйн түүүхэн сурвалж III хэвлэл, 2022, 11 дэх тал.

эзний тухай”, “Өвлөлийн тухай хууль” (Гэр бүлээ тэжээн тэтгэх), 1995 оны “Өв залгамжлалын эрх зүйн шинэтгэлийн тухай хууль” зэрэг тусгай актуудаар зохицуулагддаг болно.

Зарим институт нь өв залгамжлалыг журамлахад ихээхэн ялгаатай байдаг нь ижилтгэсэн зохицуулалтыг боловсруулах шаардлагыг бий болгодог байна. Жишээлбэл, АНУ-ын Флорида (1975), Иллинойс, Калифорни муж улсуудад өв залгамжлалын тухай тусгай хууль үйлчилдэг ба олонх муж улсад (тухайлбал, Виржиниа, Теннесси, Техас, Өмнөд Каролина зэрэг) холбогдох зохицуулалтыг багтаасан тушаал, заавар зөвлөгөөг баталсан байдаг. Эдүгээ Луизианна муж улсад 1825 оны Иргэний хууль хүчинтэй үйлчилж байгаа ба энэ хуулийн сүүлийн нэмэлт, өөрчлөлт нь Францын Иргэний хуульд үндэслэсэн, өв залгамжлалын системийг хадгалсан, олонх зүйл нь Франц Улсын хуультай төсөөтэй хэрэглэгддэг. Өв залгамжлалын хүрээнд буй гол чухал ялгааг тогтоох, муж улсууд зайлшгүй зохицуулах ижилтгэсэн журамтай болох, түүнийг нийцүүлэх тал дээр ажилласаар байна.

Өв залгамжлалын эрх зүйн харилцааг хуульчлах хамгийн үр өгөөжтэй арга нь “эрх зүйн ижилтгэл” юм. Гэвч олон улсын өв залгамжлалын эрх зүйн хүрээнд түгээмэл шинжтэй улс хоорондын гэрээ хэлэлцээрийг цөөн байгуулсан байдаг. Тухайлбал, 1961 оны Гэрээслэлийн захирамжийн хэлбэрт хамааралтай хуулиудын зөрчилдөөний тухай конвенц, 1973 оны Олон улсын гэрээслэлийн хэлбэр болон нэгдсэн загварын тухай конвенц, Өвлүүлэгчийн эд хөрөнгийг олон улсын хэмжээнд захиран зарцуулах тухай Гаагийн конвенц, Өвлөх харилцаанд хэрэглэх эрхийн тухай 1989 оны Гаагийн конвенцыг дурдаж болно. Эдгээр конвенцод Монгол Улс нэгдэж ороогүй юм. Хэдийгээр нөхцөл байдал ийм байгаа ч хэд хэдэн үндэстний эрх зүйн тогтолцоотой холбоотой өв залгамжлалын харилцааг зохицуулах олон улсын зохицуулалтын үндсийг тухайн улсын оролцоотой иргэний, гэр бүлийн, худалдааны хэргийн талаар эрх зүйн туслалцаа үзүүлэх тухай хоёр талын болон олон талын гэрээ хэлэлцээрт агуулагдсан хэм хэмжээнүүд бүрдүүлдэг онцлогтой.

Монгол Улсын хувьд өвлөх харилцаанд хэрэглэгдэх хуулийг тодорхойлсон эрх зүйн туслалцаа үзүүлэх тухай хоёр талт гэрээг анх ЗСБНХУ-тай 1958 оны 08 сарын 25-ны өдөр “Иргэний ба эрүүгийн хэрэг болон гэр бүл, гэрлэхтэй холбогдсон хэргийн талаар хуулийн туслалцаа үзүүлэх гэрээ” нэртэйгээр байгуулсан байдаг. Монгол Улс 2023 оны 02 сарын 25-ны байдлаар иргэний хэргийн асуудлаар эрх зүйн туслалцаа үзүүлэх тухай хоёр талт гэрээг 23 улстай байгуулсан байна. Эрх зүйн туслалцаа үзүүлэх гэрээ нь хэлэлцэн тохирогч улсуудын эрх бүхий байгууллагын шууд бөгөөд тогтвортой харилцааг тогтоож өгдгөөрөө онцлогтой. Эрх зүйн харилцан туслалцаа үзүүлэх гэрээний зорилго нь улс орнууд шүүх эрх мэдлийг үр дүнтэй хэрэгжүүлэхэд харилцан дэмжлэг үзүүлэхэд чиглэдэг. Энэ гэрээ нь өөртөө *материаллаг, процессын, зөрчилдөөний хэм хэмжээ агуулсан* байдаг. Хоёр талт гэрээгээр дамжин илэрч байгаа иргэний хэргийн эрх зүйн харилцан туслалцаа үзүүлэх гэрээний *ач холбогдол нь* нэг улсын иргэдийн эд хөрөнгийн болон хувийн эрхийг нөгөө улсын нутаг дэвсгэрт хүлээн зөвшөөрч хэрэгжүүлэх явдлыг хангадагт оршдог.

Монгол Улс дээрх хоёр талт гэрээ байгуулсан улсаас цөөн улстай нь өв залгамжлалын харилцаанд хэрэглэгдэх эрх зүйн зөрчилдөөний хэм хэмжээг бататгасан. Монгол Улсын “Иргэн, гэр бүлийн хэргийн талаар эрх зүйн туслалцаа харилцан үзүүлэх” тухай хоёр талт олон улсын гэрээ нь нарийвчилсан, тусгайлсан зохицуулалттай бөгөөд тусгайлан зохицуулаагүй асуудлаар 1954 оны ерөнхийлсөн зохицуулалттай Гаагийн конвенцын заалтыг баримталдаг.^{8,9} Манай улсын эрх зүйн харилцан туслалцаа үзүүлэх

⁸ 1954 оны Гаагийн конвенц нь иргэний хэргийн эрх зүйн асуудлаар Монгол Улсын ИХШХШТХ-тай уялдан холбогддог, нөхөн хэрэглэгдэх шинжийг агуулдаг бөгөөд Монгол Улс уг конвенцод нэгдэн орсон байдаг.

Монгол Улсын Дээд Шүүхийн 2008 оны 02 сарын 28-ны өдрийн “Монгол Улсын олон улсын гэрээ болон олон улсын эрх зүйн нийтээр хүлээн зөвшөөрсөн хэм хэмжээ, зарчмыг шүүхийн практикт хэрэглэх тухай” 09 дүгээр тогтоолын 11 дэх заалт.

⁹ Б.Алтангэрэл, Ж.Амарсанаа нар, Олон улсын гэрээний тухай Монгол Улсын хуулийн дэлгэрэнгүй тайлбар, 2011, 153 дах тал.


тухай гэрээнүүдэд хүчин төгөлдөр байлгахад чиглэсэн кумулятив¹⁰ шинжтэй холболтыг түгээмэл хэрэглэсэн бөгөөд олон улсын шинжтэй өвлөх харилцаанд зонхилон тохиолдож болох буцаан ишлэх асуудлыг манай улсын хуулиар зохицуулсан¹¹ байдаг. Жишээлбэл, Монгол Улсын нутаг дэвсгэр дээр байгаа үл хөдлөх хөрөнгийг өвлүүлэх, гэрээслэх, түүнийг өөрчлөхөд Монгол Улсын хуулийг хэрэглэнэ. Учир нь энэ зүйлийн заалтыг нэг талаас манай улсын императив хэм хэмжээ, нөгөө талаас өөрийн орны хуулийг хэрэглэхийг зүйлчилсэн нэг талын зөрчилдөөний хэм хэмжээ гэж үзэж болно. Энэ заалт нь дэлхийн практикт өв залгамжлалын статутыг тодорхойлох зөрчилдөөний үндсэн зарчмын дагуу өвлөгдөх эд хөрөнгийг хөдлөх болон үл хөдлөх гэж хоёр хуваадаг тогтолцоо юм. Өөрөөр хэлбэл, манай улсад байгаа үл хөдлөх хөрөнгийн хувьд Монгол Улсын хуулийг, харин хөдлөх хөрөнгийн хувьд аль нэг улсын хуулийг хэрэглэх боломжийг агуулж байгаа болно.

Дэлхийн улс орнууд өв залгамжлалын эрх зүйн асуудлуудыг иргэний хуулийн нэг бүлэг болгох, бие даасан хууль батлах, мөн хэм хэмжээ агуулсан актад тусгах эсвэл олон улсын хувийн эрх зүйн бие даасан хуулиар зохицуулж байна. Энэ нь хуулийн зөрчилдөөнийг үүсгэх нөхцөл болдог ч олон улсын төрөлжсөн байгууллагууд олон улсын гэрээ, конвенцыг санал болгож, улс орнууд нэгдэн орсноор зөрчилдөөнийг шийдэх боломжийг бий болгодог учир ийм төрлийн олон улсын гэрээнд нэгдэж орох нь зүйтэй гэж хувийн эрх зүй судлаачид үздэг.

¹⁰ Зэрэгцээ буюу Кумлятив холболт гэдэг нь олон холбоос хэрэглэх, хоёрдогч холбоосыг ашиглах, хуваарилах холболтыг агуулсан ойлголт юм. Хоёр болон олон холбоос хэрэглэх тохиолдолд хоёр холбоос хоёулаа ижил эрхтэй хэрэглэгдэхийг, үндсэн нэг холбоосын дагуу хэрэглэгдэх эрхийн хүрээг хязгаарлахын тулд хоёрдогч холбоосыг ашигладаг өөрөөр хэлбэл, хамгаалах, хязгаарлах үүрэгтэй хэрэглэгддэг, ОУХЭЗ-н оролцогч бүрийн хувьд эрх зүйн үр дагаврыг тус тусад нь зохицуулсан холбоос хэрэглэхийг хуваарилах холболт гэдэг.

Ц.Оюунаа, Өв залгамжлалын эрх зүй - олон улсын хувийн эрх зүйн хүрээн дэх судалгаа, 2017, 219 дэх тал.

¹¹ Ц.Оюунаа, Олон улсын хувийн эрх зүй /Сурах бичиг/ Анхны хэвлэл, 2015, (2 дах хэвлэл 2017 он).



Ийнхүү өв залгамжлалын олон улсын эрх зүйн зохицуулалт нь ихэвчлэн олон улсын хоёр талт гэрээгээр зохицуулагдаж байгаа ч манай улсын болон гадаад орны иргэд олон улсын хувийн эрх зүйн харилцаанд оролцох явдал ихээр нэмэгдэж байгаа энэ цаг үед өв залгамжлалтай холбоотой хоёр талт гэрээ байгуулах, олон талт гэрээнд манай улс нэгдэж орох шаардлагатай байна.

Өв залгамжлалын эрх зүйн харилцаанд өвлөгчдийг зөв тогтоох асуудал чухал байр суурь эзэлдэг бөгөөд гадаадын зарим улсын өв залгамжлалын эрх зүйн зохицуулалтыг авч үзвэл:

1.2.1. Холбооны Бүгд Найрамдах Герман Улс

ХБНГУ-ын Үндсэн хуулийн 14 дүгээр зүйлийн 1-д “Өмч болон өв залгамжлах эрх нь баталгаатай байна. Эдгээрийн агуулга болон хязгаарлалтыг зөвхөн хуулиар тогтооно.”, 2-т “Өмч нь үүрэг үүсгэнэ. Зорилго нь нийтийн сайн сайхны төлөө үйлчилнэ.”¹² гэж хуульчилсан байдаг. Тус улсын Иргэний хуулиар хууль ёсны өвлөгчдийг дараах байдлаар зохицуулжээ.

Нэгдүгээр зэргийн хуулиар өв залгамжлагч:

1. Өвлүүлэгчийн үр хүүхдүүд¹³
2. Өв нээгдэх үед өвлүүлэгчийн үр хүүхэд амьд байгаа бол түүгээр дамжуулан өвлүүлэгчтэй холбогдож байгаа бусад үр хүүхэд өвлөхгүй.
3. Өв нээгдэх үед үр хүүхдийн зарим нэг нь насан эцэслэсэн бол түүгээр дамжуулан өвлүүлэгчтэй холбогдож буй үр хүүхдүүд өвлөх эрхтэй болно.

Хоёрдугаар зэргийн хуулиар өв залгамжлагч:

1. Өвлүүлэгчийн эцэг, эх тэдгээрийн үр хүүхэд байна.

¹² Хууль зүйн Үндэсний хүрээлэн, Холбооны Бүгд Найрамдах Герман Улсын Үндсэн хууль, 2020, 22 дах тал.

¹³ Б.Буянхишиг, ХБНГУ-ын Иргэний хууль (кодификацийн бүрэн эх) орчуулгыг нэгтгэсэн анхны хэвлэл, 1924 дүгээр зүйл.

2. Өв нээгдэх мөчид өвлүүлэгчийн эцэг, эх амьд байвал тэд дангаар, тэнцүү хэмжээтэй өвлөнө.
3. Өв нээгдэх мөчид өвлүүлэгчийн эцэг, эхийн нэг насан эцэслэсэн байвал нас барагчийн үр хүүхэд нэгдүгээр зэргийн хуулиар өв залгамжлагчид хамаарах зохицуулалтын дагуу өвлөнө.

Гуравдугаар зэргийн хуулиар өв залгамжлагч:

1. Өвлүүлэгчийн өвөг эцэг, эх байна.
2. Өв нээгдэх мөчид өвлүүлэгчийн өвөг эцэг, эхийн нэг насан эцэслэсэн байвал түүний үр хүүхэд түүнд ноогдох хэсгийг өвлөнө.

Дөрөвдүгээр зэргийн хуулиар өв залгамжлагч:

1. Хуланц өвөг эцэг, эмэг эх болон тэдний үр хүүхдүүд байна.
2. Өв нээгдэх мөчид өвлүүлэгчийн хуланц өвөг эцэг, эмэг эх амьд байвал тэд дангаар, хэд хэдэн этгээд байвал төрлийн холбооноос үл хамааран тэнцүү хэсгээр өвлөнө.
3. Өв нээгдэх мөчид өвлүүлэгчийн хуланц өвөг эцэг, эмэг эх нас барсан бол нас барагчийн үр хүүхдүүдээс өвлүүлэгчтэй хамгийн ойр төрлийн хамаатан өвлөнө. Ижил түвшний хэд хэдэн садан байвал тэнцүү хэмжээгээр өвлөнө.

Холын төрөл, зэрэглэл:

1. Тавдугаар зэргийн хуулиар өв залгамжлагч болон түүнээс хойших зэрэглэлд хамаарах өвлөгч нь өвлүүлэгчийн өндөр өвөг эцэг, эмэг эх болон тэдгээрийн хүүхэд байна.

Өмнөх зэрэглэлд хамаарах төрөл садан байгаа нөхцөлд дараагийн зэрэглэлд хамаарах төрөл садан өвлөх эрхгүй.

Гэр бүлийн гишүүний хуулиар өвлөх эрх:

1. Өвлүүлэгчийн гэр бүлийн хамтрагч нь нэгдүгээр зэргийн хуулиар өв залгамжлагчийн зэрэгцээ өвлөх нөхцөлд өв хөрөнгийн дөрөвний нэг хэсэг, хоёрдугаар зэргийн хуулиар

өв залгамжлагч болон өвөг эцэг, эмэг эхийн хамт өвлөх бол өв хөрөнгийн тэн хагасыг өвлөх эрхтэйгээр зохицуулсан.

2. Нэг ба хоёрдугаар зэргийн өвлөгч байхгүй бол гэр бүлийн хамтрагч бүх хөрөнгийг өвлөнө.

ХБНГУ-ын ИХ-ийн 1944 дүгээр зүйлд 6 долоо хоногийн дотор багтаан өвөөс татгалзахаа илэрхийлж болохоор хуульчилсан байдаг.

1.2.2.Бүгд Найрамдах Франц Улс

Тус улсын ИХ-ийн 731 дүгээр зүйлд зааснаар нас барагчийн өв хөрөнгө хуулийн дагуу ах, дүү, төрөл төрөгсөд болон гэр бүлийн хүнд нь (нөхөр, эхнэр) шилждэг. Нас барагч нь нөхөр эсхүл эхнэр байхгүй тохиолдолд төрөл төрөгсдөд нь дараах дарааллаар өвлөх эрх үүсдэг.¹⁴ Үүнд:

1. Өвлүүлэгчийн хүүхдүүд болон тэдний үр удам
2. Өвлүүлэгчийн эцэг, эх, ах эгч, дүү, тэдний үр удам
3. Өвлүүлэгчийн эцэг, эхээс дээших төрөл
4. Өвлүүлэгчийн хажуугийн төрлүүд болох үеэл, тэдний үр удам өвлөх эрхтэй байдаг.

Өмнөх ээлжийн нэг л төрөл байхад дараагийн ээлжийн бүх төрөл төрөгсөд өв залгамжлах эрхгүй болдог. Түүнчлэн нэг ээлжийн доторх төрлүүдээс нас барагчтай илүү ойрын төрөл байвал бусад төрлүүд нь өвлөх эрхгүй, харин ижил түвшний төрлүүд хөрөнгийг адил хэмжээгээр хуваадаг байна.

1.2.3.Япон Улс

Япон Улсын ИХ-ийн 887 дугаар зүйлд өвлүүлэгчийн төрсөн болон хэвлий дэх хүүхэд, 890 дүгээр зүйлд эхнэр, нөхөр¹⁵ хууль

¹⁴ Бүгд Найрамдах Франц Улсын Иргэний хуулийн 734 дүгээр зүйл. https://www.legifrance.gouv.fr/codes/section_lc/LEGITEXT000006070721/LEGISCTA000006136269/#LEGISCTA000006136269

¹⁵ Б.Урангоо, Япон Улсын Иргэний хуулийн орчуулга, 2018, 226-227 дах тал.

ёсны өвлөгч байхаар хуульчилжээ. Тэргүүн ээлжийн хууль ёсны өвлөгч байхгүй тохиолдолд тус хуулийн 889 дүгээр зүйлд тогтоосон дэс дарааллын дагуу дараах байдлаар өвлөгчдийг тогтоодог.

889.1.1. Өвлүүлэгчийн төрөл, садан. Эцэг эх нь өөр бол хамгийн ойрын төрөл саднаас эхэлнэ.

889.1.2. Өвлүүлэгчийн ах, эгч, дүүс.

Өвлөгч өв нээгдсэнийг мэдсэн цагаас эхлэн 3 сарын дотор өвийг бүхэлд нь буюу тодорхой хэсгийг өвлөхийг зөвшөөрсөн эсхүл татгалзсан тухайгаа мэдэгдэх бөгөөд энэ хугацааг ашиг сонирхлын холбоотой гуравдагч этгээд болон прокурорын хүсэлтээр сунгаж болдог байна.

1.2.4. Бүгд Найрамдах Хятад Ард Улс

Тус улсын ИХ-ийн 1127 дугаар зүйлд өв хүлээн авах дарааллыг хуульчилсан байна.¹⁶

1. Хань ижил, үр хүүхдүүд, эцэг эх
2. Ах, эгч, дүү, өвөг эцэг, эмэг эх

Эхний дарааллын өв залгамжлагчид байгаа тохиолдолд хоёр дах дарааллын өвлөгчид өвлөхгүй, эхний дарааллын өвлөгчид байхгүй бол хоёр дах дарааллын өвлөгчид өвлөнө. Өв залгамжлагч нь өвийг захиран зарцуулахаас өмнө өв хүлээн авахаас татгалзах тухайгаа бичгээр илэрхийлэх ба хэрэв илэрхийлээгүй бол өвийг хүлээн авсанд тооцно.

Эцэг эх гэдэгт төрүүлсэн, үрчилж авсан, өсгөн хүмүүжүүлэх харилцаатай хойд эцэг, эх ордог. Мөн ах, эгч, дүү гэдэгт нэг эцэг, эхийн, эцэг нэг, эх өөр, эсхүл эх нэг, эцэг өөртэй, өргөж авсан, өсгөн хүмүүжүүлэх харилцаатай хойд ах, эгч, дүү хамаардаг. Түүнчлэн хадам эцэг, эхээ тэжээн тэтгэхэд зонхилох хувь нэмэр оруулсан бэлэвсэн бэр, хүргэнийг хадам эцэг, эхтэйгээ дүйцүүлэн нэгдүгээр

¹⁶ Б.Амарсанаа, З.Сүхбаатар, Б.Батбаяр, БНХАУ-ын Иргэний хууль, анхны хэвлэл, 2021.



дарааллын өв залгамжлагч гэж үздэг онцлогтой. Өвлөгдөх эд хөрөнгийг тэнцүү хэмжээгээр хуваарилах хэдий ч амьдрал нь онцгой бэрхшээлтэй, хөдөлмөрийн чадамжгүй, өвлүүлэгчийг тэжээн тэтгэхэд гол үүрэг гүйцэтгэсэн, эсхүл өвлүүлэгчтэй хамт амьдарч байсан бол түүнийг илүү анхааран үздэг байна.

1.3. МОНГОЛ УЛСЫН ӨВ ЗАЛГАМЖЛАЛЫН ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТ

Монгол Улс өвлөх харилцааны эрт дээр үеийн уламжлалтай ба өв залгамжлах эрх зүйн хэм хэмжээ Монгол төрийн хууль цаазад хэрхэн тусгагдаж байсныг түүхэн үүднээс нягтлан судлах явдал нь Монголын өв залгамжлалын харилцаа ямар онцлогтойгоор, хэрхэн хөгжиж өнөөг хүрснийг ойлгож мэдэх, цаашид өв залгамжлалын эрх зүйн судлагдахууныг боловсронгуй болгоход чухал ач холбогдолтой¹⁷ юм.

Монгол хэлний үгийн гарлын тайлбар тольд Өв* (ebe) ‘өвөдөх’ гэсэн үгийн анхдагч язгуур. Энэ язгуураас ‘өвчи-’, ‘өвөд’ гэсэн үүсмэл язгуурууд үүсэж, ‘өвчил-’, ‘өвчин’ гэх мэт үгс үүссэн талаар дурджээ.¹⁸

Монгол хэлний товч тайлбар тольд “Өв” гэдгийг эзэмшиж байсан хүний нас барахад өөр хүнд шилжин очих хөрөнгө¹⁹, Өв гэдэг I нэр. 1. эцэг эх, өвөг дээдсийн үр хүүхэд болон ойр дотнын хүмүүстээ үлдээсэн эд хөрөнгө; **өв залгамжлах** (эзэмших эрх бүхий хүн эд хөрөнгийг өмчлөн авах), **өв идэх** (эд хөрөнгийг нь залгамжлах), **өв өмч хорш** (үе улиран уламжлагдсан хөрөнгө), **өв хөрөнгө хорш** (уламжлан ирсэн эд зүйл)²⁰ гэж оноосон байна. Академич С.Нарангэрэл өв залгамжлал (англ. inheritance, succession) нас барагчийн (өвлүүлэгчийн) эд хөрөнгө түүний өвлөгчид шилжих,

¹⁷ Ц.Оюунаа, Өв залгамжлалын эрх зүй, Олон улсын хувийн эрх зүйн хүрээн дэх судалгаа, 2017, 32 дах тал.

¹⁸ ШУА, Д.Төмөртогоо, Монгол хэлний үгийн гарлын тайлбар толь, 2018, 200 дах тал.

¹⁹ Я.Цэвэл, Монгол хэлний товч тайлбар толь, 2021, 624 дэх тал.

²⁰ Монгол хэлний хураангуй тайлбар толь, 2009, 497 дах тал.

өв залгамжлал нь хувийн өмчтэй салшгүй холбоотой, иргэний өв залгамжлуулах эрх үндсэн хуулийн эрхэд хамаарагдана²¹ гэж бүтээлдээ томъёолсон байдаг.

Харин “Өв залгамжлалын эрх зүй” гэдэг нэр томъёо нь хоёр утгатай:

1. Тухайн улсын иргэний эрх зүйн тогтолцоонд нэгэн дэд салбарыг үүсгэдэг харьцангуй хэм хэмжээнүүдийн цогцыг энэ нэр томъёогоор тэмдэглэдэг.
2. Өв залгамжлалын эрх зүй нь хууль зүйн сургалтын байгууллагуудын оюутны судалдаг хичээл гэдэг утгыг илэрхийлдэг.

Өв залгамжлалын эрх зүй нь иргэний эрх зүйн бие даасан дэд салбарын хувьд эрх зүйн зохицуулалтын онцгой зүйлтэй бөгөөд энэ нь иргэний эрх зүйн хэм хэмжээнүүдийн зохицуулах нөлөөллийн ерөнхий хүрээнд багтдаг. Орчин үеийн өв залгамжлалын эрх зүйн судалгааны чиглэлээр цөөнгүй судлаачид, тухайлбал, Т.Мөнхжаргал “Өв залгамжлалын эрх зүй”, 2002, 2009 он, А.Оюунчимэг “Нотариатын үйлдэл (Гарын авлага), 2007 он, Г.Эрдэнэбаяр, Ч.Баянжаргал “Хууль ёсны өвлөх эрх зүй”, 2009 он, М.Ванчигмаа “Гэрээслэлээр өвлөх эрх”, 2015 он, Б.Улаанбаатар “Монгол Улс дах гэрээслэл: асуудал, шинэчлэлт”, 2017 он (Докторын судалгааны ажил), Ц.Оюунаа “Эртний Ромын хувийн эрх зүй дэх өвлөх эрх, түүхэн тойм”, 2016 он, Ц.Оюунаа “Өв залгамжлалын эрх зүй - Олон улсын хувийн эрх зүйн хүрээн дэх судалгаа”, 2017 он, Ц.Оюунаа “Эртний Ромын хувийн эрх зүй дэх өвлөлийн асуудал - Ромын эрх зүйн түүхэн сурвалж”, II, III хэвлэл, 2019, 2022 он, Ч.Баянжаргал “Нотариатын эрх зүйн асуудал, харьцуулсан судалгаа” 2021 он зэрэг нэг сэдэвт бүтээл болон сурах бичгийг энэ салбарын судалгааны эргэлтэд оруулсан байна.

²¹ С.Нарангэрэл, Монгол Улсын хууль зүйн нэвтэрхий толь бичиг, 2021, 326 дах тал.

Өв залгамжлалын эрх зүй нь маш чухал бөгөөд байнгын практик ач холбогдолтой. Учир нь хувь этгээдийн иргэний үйл ажиллагаа зогсоход түүний эдийн эрхийн хувь заяаны асуудал үүсдэг. Ямар ч хүн өөрийнхөө амьдралын бүхий л үеүдэд янз бүрийн эд хөрөнгийн харилцаанд оролцдог. Өөрөөр хэлбэл, иргэний эрх эдэлж, иргэний үүрэг хүлээдэг онцлогтой. Хүн эд хөрөнгийг өмч болгон олж авдаг, ганцаараа болон бусадтай нийлэн үйл ажиллагаа эрхэлж, хуулийн этгээд байгуулан, хэлцэл хийдэг. Ингэснээр гэрээний болон өөр бусад үүргийн харилцаанд оролцдог. Шинжлэх ухаан, урлаг, утга зохиолын бүтээл туурвих, техникийн тодорхой шинэ шийдэл олох зэрэг өөрийн оюуны хөдөлмөрийн үр дүнг эзэмших эрхтэй байдаг. Бие этгээд нас барснаар түүний энэ бүх харилцаанд оролцох явдал зайлшгүй дуусгавар болдог. Энэ нь өөд бологч субъект эзэн нь болж байсан тэр бүх эдийн харилцаа бүрэн төгс утсан байх ёстой гэсэн хэрэг үү гэдэгт л өв залгамжлалын эрх зүйн тодорхойлолт хариулт өгдөг учиртай.

Өв залгамжлалын эрх зүй гэдэг нь эдийн эрх болон үүрэг нь нас барсан хүнээс өөр этгээдүүдэд шилжих шилжилтийг журамладаг хууль зүйн тусгай хэм хэмжээнүүдийн цогц юм. Өв залгамжлалын эрх зүйг “өвлөх эрхээс” нарийн ялгах шаардлагатай байдаг. *Өвлөх эрх гэдэг бол “өвлөгч болох болон өвлөгч байх субъектив эрх”* юм. Энэ нь иргэн бүрд буюу бие хүнд хамаардаг. Өвлөх эрхийн агуулга нь нас барсан иргэний эд хөрөнгийг бусад этгээд олж авах төдийгүй, мөн эд хөрөнгийг эзэмшигчийн хувьд нас барах тохиолдолд эд хөрөнгөө өөрийн үзэмжээр захиран зарцуулах боломжийг (гэрээслэл) мөн адил өөртөө багтаадаг. Энэ эрх нь өөртөө өвлүүлэгчийн өөрийн эд хөрөнгөө захиран зарцуулах эрхийг ч, өвлөгчид түүний эд хөрөнгийг авах эрхийг ч тус тус багтаадаг. Өв залгамжлалыг баталгаажуулах эрх хэмжээ зөвхөн нотариатчийн чиг үүрэгт хамаарч, түүнийг өвлөх эрхийн гэрчилгээ олгох замаар гүйцэтгэнэ.²²

²² Ч.Баянжаргал, Нотариатын эрх зүйн асуудал, харьцуулсан судалгаа (Докторын судалгааны ажил), 2021.

Иргэн бүр өв залгамжлалын харилцааны оролцогч байх чадвартайг улс орон бүрийн тухайлбал, Монгол Улсын Үндсэн хуульд хүлээн зөвшөөрч баталгаажуулдаг. Монголын өв залгамжлалын эрх зүйн үндэст олон улсын хувийн эрх зүйн харилцаанд хэрэглэгдэх хоёр талын болон олон талын олон улсын гэрээ, 1992 оны Монгол Улсын Үндсэн хууль, Иргэний хууль, Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль, Гэр бүлийн тухай хууль, Иргэний бүртгэлийн тухай хууль, Нотариатын тухай хууль, Газрын тухай хууль, Монгол Улсын иргэнд газар өмчлүүлэх тухай хууль, Банк, эрх бүхий хуулийн этгээдийн мөнгөн хадгаламж, мөнгөн хөрөнгийн шилжүүлэг, зээлийн үйл ажиллагааны тухай хууль, Улсын бүртгэлийн ерөнхий хууль, Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хууль, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хууль²³ болон Монгол Улсын Их Хурлын тогтоолууд багтдаг. Тухайлбал, энд Улсын Их Хурлаас 2002 оны 10 сарын 31-ний өдөр баталсан 71 дүгээр тогтоол буюу Монгол Улсын Консулын дүрэм орно.


Монгол Улсын ИХ-ийн 520 дугаар зүйлд зааснаар дор дурдсан этгээдийг хууль ёсны өвлөгч гэх бөгөөд тэдгээр нь адил хэмжээгээр өвлөх эрхтэй.

520.1.1. Нас барагчийн нөхөр, эхнэр, төрүүлсэн болон үрчилж авсан, түүнийг нас барсан хойно төрсөн хүүхэд, нас барагчийн төрүүлсэн болон үрчилсэн эцэг, эх;

520.1.2. Энэ хуулийн 520.1.1-д заасан өвлөгч байхгүй, эсхүл тэдгээр нь өвлөхөөс татгалзсан буюу өвлөх эрхээ алдсан бол нас барагчийн өвөг эцэг, эмэг эх, ах, эгч, дүү, ач, зээ.

520.2. Энэ хуулийн 520.1-д заасан өвлөгч байхгүй, эсхүл тэдгээр нь өв хүлээн авахаас татгалзсан буюу өвлөх эрхээ алдсан бол өвлүүлэгчийн ачинцар, зээнцэр нь эцэг, эхдээ хуульд зааснаар өвлөгдвөл зохих байсан эд хөрөнгийн хэсгийг хуваан өвлөнө.

²³ Монголын эрх зүйн мэдээллийн нэгдсэн систем, Монгол хэл дээрх эх. <http://www.Legalinfo.mn/law/>, (2022.11.16 -ны өдөр ишлэв.)



520.3. Энэ хуулийн 520.1, 520.2-т дурдсан иргэнээс гадна өвлүүлэгч нас барахаас өмнө нэгээс доошгүй жилийн хугацаанд түүний асрамжид байсан хөдөлмөрийн чадваргүй иргэн хууль ёсны өвлөгчид тооцогдох бөгөөд өөр өвлөгч байвал энэхүү асрамжид байсан этгээд нь тэдгээртэй адил хэмжээгээр өвлөнө.

Мөн хуулийн 528 дугаар зүйлд өв хүлээн авах, хүлээн авахаас татгалзах журмыг тодорхойлжээ.

528.1. Өвлүүлэгчийг нас барах хүртэл түүнтэй хамт амьдарч байсан өвлөгч нь өв нээгдсэнээс хойш гурван сарын дотор өв хүлээн авахаас татгалзсан тухайгаа нотариат буюу нотариат байхгүй газар баг, сумын Засаг даргад мэдэгдээгүй бол уг өвийг хүлээн авсан гэж үзнэ.

528.2. Энэ хуулийн 528.1-д зааснаас бусад өвлөгчид нь өв нээгдсэнээс хойш нэг жилийн дотор хуульд заасны дагуу өвлөгдсөн эд хөрөнгийг эзэмдэн авсан буюу эрхлэн удирдсан, эсхүл нотариат буюу баг, сумын Засаг даргад өв хүлээн авах буюу өвлөх эрхийн гэрчилгээ олгохыг хүсэж, өргөдөл гаргасан байвал уг өвийг хүлээн авсан гэж үзнэ.

528.3. Энэ хуулийн 528.1, 528.2-т заасан хугацаанд өвлөгч өвлөгдөх эд хөрөнгийг хүлээн аваагүй буюу хүлээн авах тухай хүсэлтээ зохих байгууллага, этгээдэд гаргаагүй бол түүнийг өвлөхөөс татгалзсан гэж үзнэ.

Иргэн нь хуульд зааснаар өвлөх эрхтэй буюу эрхгүй нэг буюу хэд хэдэн иргэн, түүнчлэн төр буюу хуулийн этгээдэд өөрийн эд хөрөнгө болон эд хөрөнгийн эрхийг бүхэлд нь буюу зарим хэсгийг нь үзэмжээрээ хуваарилан гэрээсэлж болно. Гэрээслэгч бүх эд хөрөнгөө хууль ёсны өмчлөгч бус этгээдэд гэрээслэх тохиолдолд өвлүүлэгчийн насанд хүрээгүй буюу хөдөлмөрийн чадваргүй, түүнчлэн түүнийг нас барсан хойно төрсөн хүүхэд, түүний асрамжид байсан хөдөлмөрийн чадваргүй нөхөр (эхнэр), төрүүлсэн болон үрчилсэн эцэг, эх, хууль ёсны бусад өвлөгчдөд хуульд зааснаар өвлүүлбэл зохих хөрөнгийн хоёрны нэгээс багагүй хэсгийг заавал

өвлүүлнэ. Ийнхүү заавал өвлүүлэх хэсгийн хэмжээг тодорхойлохдоо хуваарьт болон дундаа хамтран өмчлөх эд хөрөнгийн өвлүүлэгчид оногдох хэсгийг оролцуулан тооцдог. Гэрээслэлийг бичгээр хийж, үйлдсэн газар, он, сар, өдрийг зааж, нотариатаар, гэрээслэл хийсэн газар нотариат байхгүй бол баг, сумын Засаг даргаар гэрчлүүлнэ.

Доорх шүүхийн шийдвэрийн дүн шинжилгээ хийсэн иргэний хэрэг маргааны агуулга нь ИХ-ийн 515-538 зүйлүүдэд хамаарна.

ХОЁР. ШҮҮХИЙН ШИЙДВЭРИЙН СУДАЛГАА

2020-2022 онд шийдвэрлэгдсэн өв залгамжлалтай холбоотой ИХАШШ-ийн 6 шийдвэр, ИХДЗШШ-ийн 4 магадлал, Улсын Дээд шүүхийн 4 тогтоолд дүн шинжилгээ хийн, судалж үзэхэд 2012-2015 онд хийгдсэн өв залгамжлалтай холбоотой судалгааны үр дүнд сайжруулах шаардлагатай гэж дурдагдаж байсан хууль хэрэглээний нийтлэг алдаа багассаныг харж болохоор байна. Тухайлбал, нотариатын үйлдлийг хүчингүй болгохтой холбоотой нийт 22 маргаанаас 17 маргааны нэхэмжлэлийн шаардлагыг хангасан буюу 77,3 хувь нь хүчингүй болсон байна. Гэтэл 2020-2022 онд 15 маргаанаас 7 маргааны нэхэмжлэлийн шаардлагыг хангаж, 1 үйлдэлд өөрчлөлт оруулсан буюу 50 хувь нь хүчингүй болсон байна.

Мөн шүүхийн шийдвэрийн тогтвортой байдлыг авч үзэхэд нийт 55 хэргийн 25 хэрэг нь давж заалдах болон хяналтын шатны шүүхээр хянагдсан байх бөгөөд 9 хэргийн анхан шатны шүүхийн шийдвэрийг хэвээр үлдээж, 5 шийдвэрт өөрчлөлт оруулж, 11 шийдвэрийг хүчингүй болгосон байна.²⁴ Түүнчлэн өмнөх судалгааны тайлантай харьцуулан үзвэл өв залгамжлалтай холбоотой иргэний хэрэг маргааны тоо буураагүй.

2020-2022 онд шүүхээр шийдвэрлэгдсэн өв залгамжлалтай холбоотой иргэний хэрэг маргааны хувьд нотариатын үйлдлийг шүүхээс хүчингүй болгож шийдвэрлэх нь буурсан төдийгүй үйлдлийг хүчингүй болгох нэхэмжлэлийн шаардлага буурсан

²⁴ Өв залгамжлал, гэрээслэлтэй холбоотой маргааныг шүүхээр хянан шийдвэрлэсэн байдал, Түүвэр эмхэтгэл
Монголын Нотариатчидын танхим Сонгинохайрхан дүүргийн салбар, 2015.

үзүүлэлттэй байгаа нь нотариатч хуульд нийцүүлэн өвлөх эрхийн гэрчилгээ олгох ажиллагаа сайжирч байгааг илэрхийлж байна.

2.1. ИРГЭНИЙ ХЭРГИЙН АНХАН ШАТНЫ ШҮҮХИЙН ШИЙДВЭРТ ХИЙСЭН ДҮН ШИНЖИЛГЭЭ

Монгол Улсын шүүхийн шийдвэрийн цахим сангийн иргэний хэргийн шүүх (анхан шатны шийдвэр) гэсэн хэсгээс 2020 оны 01 сарын 01-ний өдрөөс 2022 оны 10 сарын 01-ний өдрийг хүртэлх хугацаанд хайлт хийхэд өв залгамжлалтай холбоотой нийт 55 иргэний хэргийн шийдвэр илэрсэн²⁵ бөгөөд нэхэмжлэлийн шаардлага, хэрэг маргааны төрөл давхцаж байгаа ч дараах 6 агуулгаар ангилан үзэж болохоор байна. Иймээс иргэний хэрэг маргааны агуулга тус бүрээс 1 шийдвэрийг сонгож судлав.

Монгол Улсын хэмжээнд 2020-2022 онд өв залгамжлалтай холбоотой шийдвэрлэгдсэн иргэний хэргээс түүвэрлэн судалсан 6 хэргийн дүгнэлт, саналыг нэгтгэвэл:

ИХШХШТХ-д анхан шатны шүүх хэргийг шийдвэрлэхдээ нэхэмжлэлийн шаардлагыг хангах, нэхэмжлэлийн шаардлагын зарим хэсгийг хангаж, үлдсэнийг нь хэрэгсэхгүй болгох, нэхэмжлэлийг бүхэлд нь хэрэгсэхгүй болгох шийдвэрийн аль нэгийг гаргах талаар хуульчилжээ. Судалгаанд хамрагдсан иргэний хэрэг маргааныг нэхэмжлэлийг бүхэлд нь хэрэгсэхгүй болгож, үндсэн нэхэмжлэлийг хангаж, сөрөг нэхэмжлэлийг хэрэгсэхгүй болгож, нэхэмжлэлийн шаардлагыг бүхэлд нь хангаж, нэхэмжлэлийн шаардлагын зарим хэсгийг хангаж шийдвэрлэсэн байна.

Шүүхээс гаргасан шийдвэр, хэрэг маргааныг хянан шийдвэрлэхдээ хэрэглэсэн хууль тогтоомжийн хэрэглээнд дүгнэлт хийх, улмаар энэ төрлийн маргаан гарч байгаа шалтгаан, нөхцөлийг судлах, түүнээс урьдчилан сэргийлэхэд анхаарах нь зүйтэй гэж үзлээ.

²⁵ <https://shuukh.mn/cases/1/1>



Түүвэрлэн судалсан маргаанд газар, орон сууц зэрэг үл хөдлөх эд хөрөнгөтэй холбогдуулан гаргасан нэхэмжлэл дийлэнх нь байхаас гадна НТХ-ийн 43 дугаар зүйлд заасан өөр өвлөгч байгаа эсэхийг заавал тогтоож, өвлөх эрхийн гэрчилгээ олгох шаардлагыг хангаагүйгээс шүүхэд нэхэмжлэл гаргасан байна.

Мөн шүүхэд гаргасан нэхэмжлэлээс үзэхэд Орхон аймгийн шүүхийн 1124 дүгээр шийдвэрээр нотариатчид өвлөх эрхийн гэрчилгээ олгохыг шүүхээс даалгасан нь нотариатч ажил үүргээ хуулийн дагуу гүйцэтгээгүйтэй шууд холбоотой.

Дархан-Уул аймаг дах сум дундын ИХАШШ-ийн 987 дугаар шийдвэртэй иргэний хэргийн хувьд хэргийг шийдвэрлэх явцад өв залгамжлахтай холбоотой сөрөг нэхэмжлэлийн шаардлага гаргасныг шүүх тусгаарлан шийдвэрлэжээ. Үүнээс үзэхэд нэг хэрэгт олон төрлийн маргааны агуулга байж болохыг харуулж байна.

Энэ төрлийн хэрэг маргааны шүүхээр шийдвэрлэгдсэн байдлыг судлахад:

- Хууль ёсны өвлөгчид өвлөх эрхийн гэрчилгээ олгохоос үндэслэлгүйгээр татгалзсан;
- Шүүхээс өвлөх эрхийн гэрчилгээ олгохыг нотариатчид даалгасан;
- Өв нээгдсэнээс хойш нэг жилийн дотор өв хүлээн авах өргөдөл гаргах талаар өвлөгчид зөвлөөгүй, өвлөх эрхийг нь хангаагүйгээс үүдэн өв хүлээн авах өргөдөл гаргах хугацаа хэтэрч өв хүлээн авахаас татгалзсанд тооцогдож, шүүхэд нэхэмжлэл гаргах замаар өв хүлээн авах хугацаагаа сунгуулсан маргаан байна.

Дээрх нөхцөл байдлыг дүгнэж үзвэл нотариатч өвлөх эрхийн гэрчилгээ олгохдоо ИХ-д заасан хугацааг баримталж, хууль ёсны өвлөгчийг зөв тогтоож, өөр өвлөгч байгаа эсэхийг шалгах, зайлшгүй шаардлагатай баримтыг өвлөгчөөс бүрэн гаргуулж, түүнийг бодитоор үнэлж, холбогдох нотлох баримтыг өөрийн архивд хадгалах, бүрэн өвлөгдөх эд хөрөнгийг хуваарилах хэлцэл байгуулах замаар маргаан

гарахгүй байх нөхцөлийг бүрдүүлж ажиллах хэрэгтэй байна. Түүнчлэн нотариатч өвлөх эрхийн гэрчилгээг өв нээгдсэнээс хойш 1 жилийн дараа олгож байх нь өв залгамжлагч нарт өвлөх эрхээ хэрэгжүүлэх боломж олгох, түүнтэй холбоотой маргаан гарахаас урьдчилан сэргийлэх чухал ач холбогдолтой юм.

Мөн ИХ-ийн 528 дугаар зүйлийн 528.2-т “Энэ хуулийн 528.1-д зааснаас бусад өвлөгчид нь өв нээгдсэнээс хойш нэг жилийн дотор хуульд заасны дагуу өвлөгдсөн эд хөрөнгийг эзэмдэн авсан буюу эрхлэн удирдсан, эсхүл нотариат буюу баг, сумын Засаг даргад өв хүлээн авах буюу өвлөх эрхийн гэрчилгээ олгохыг хүсэж, өргөдөл гаргасан байвал уг өвийг хүлээн авсан гэж үзнэ.” гэж зааснаас үзвэл мөн хуулийн 520 дугаар зүйлд заасан хууль ёсны өвлөгчид тооцогдох бүх өвлөгчид өв хүлээн авах өргөдөл гаргах эрхтэй гэж ойлгож болохоор байна. Үүнийг үндэслэн бусад өвлөгчид 1 жилийн дотор өв хүлээн авах хүсэлт гаргавал нотариатч, баг, сумын Засаг дарга түүнийг заавал хүлээн авч, тэдгээрийн эрхийг хангах нь зүйтэй юм.

Энэхүү судалгаанд зөвхөн ИХ-ийн 515 дугаар зүйлээс 538 дугаар зүйлийн хүрээнд иргэний хэрэг маргааныг хянан шийдвэрлэсэн шүүхийн шийдвэрийг түүвэр байдлаар сонгон авч судалсан болно.

График 1. Иргэний хэргийн анхан шатны шүүхээр шийдвэрлэгдсэн өв залгамжлалтай холбоотой 54 иргэний хэргээс сонгон судалсан 6 хэрэг




График 2. Сонгон судалсан 6 шүүхийн шийдвэр он тус бүрээр




График 3. Иргэний хэргийн анхан шатны шүүхэд хянагдсан иргэний хэрэг маргааны агуулга



График 4. Иргэний хэргийн анхан шатны шүүх хэргийг шийдвэрлэсэн байдал



График 5. Иргэний хэргийн анхан шатны шүүхийн шийдвэрийн хүчин төгөлдөр байдал





График 6. Иргэний хэргийн анхан шатны шүүхээр шийдвэрлэгдсэн 6 хэргийн шүүхийн харьяалал



2.1.1. Хууль ёсны өвлөгчөөр тогтоолгох тухай

Тохиолдол 1: Н.Т, Д.Э нарын нэхэмжлэлтэй, хариуцагч Б.Г, Ц.М нарт холбогдох хууль ёсны өвлөгчөөр тогтоолгож, үл хөдлөх эд хөрөнгөөс өөрт болон хүүхдүүдэд ногдох хэсгийг гаргуулах үндсэн нэхэмжлэлтэй, дундын эд хөрөнгөөс 568,464,964.75 төгрөг гаргуулах сөрөг нэхэмжлэлтэй.

Хэргийн товч агуулга: Нэхэмжлэгч Н.Т шүүхэд гаргасан тайлбартаа: Миний бие 1997 онд талийгаач нөхөр Г.Д-той оюутан байхдаа танилцаад, 2000 онд гэр бүл болж, 13 жил хамт амьдарч, гэрлэлтээ албан ёсоор батлуулсан. Бидний дундаас 4 охин төрсөн. 2013 онд нөхөр маань нас барж, бага охин гэдсэнд үлдсэн. Энэ явдлаас хойш хадмууд эд хөрөнгийн маргаан үүсгэж, шүүхээр яваад 4-5 жил болж байна. Маргаж буй хөрөнгө болох орон сууц, банкны данс дах мөнгөний тухайд нөхөр бид хоёр гэр бүл болсон цагаасаа эхлэн бий болгосон манай гэр бүлийн дундын хөрөнгө юм. Манайх 2012 онд Хан-Уул дүүрэгт 2 өрөө байр захиалаад хот руу шилжиж ямар нэгэн гүйлгээ хийх болгондоо Мөрөн явах боломжгүй байсан тул талийгаач өнгөрөхийнхөө өмнө захиран зарцуулалт хийлгэхээр Г.Л-ийг дансны хамтран эзэмшигч болгосон.

Г.Л хамтран эзэмшигч болсон ч ганц төгрөг оруулсан зүйлгүй. Энэ Голомт банкны дансыг 2000 онд манай нөхөр нээлгээд, 190,000,000 төгрөгийг анх хийж байсан. Тэрнээс биш энэ хүнд мөнгөнийхөө талыг өгөх гэж оруулсан юм байхгүй. Иймд бид хуульд зааснаар талийгаачийн өв залгамжлагч нар мөн тул хууль ёсны өвлөгчид болохыг тогтоож, үл хөдлөх эд хөрөнгөөс өөрт болон хүүхдүүдэд ногдох хэсгийг гаргуулах нэхэмжлэлийг хангаж өгнө үү гэжээ.

Хариуцагч Б.Г, Ц.М нар шүүх хуралдаанд гаргасан хариу тайлбар болон сөрөг нэхэмжлэлдээ: Бид 1974 онд гэр бүл болж, 6 хүүхэдтэй болсон. 1990 он хүртэл улсад жолооч, барилгын засал чимэглэлийн мэргэжлээр ажиллаж байгаад зах зээлийн нийгэмд шилжсэнээр сүүний чиглэлийн саалийн үнээ худалдан авч сүү цагаан идээ зарж борлуулах, хурааж хуримтлуулсан цалин хөлс, ээж ааваас өвлүүлж ирсэн хурдан морь, үнэт эдлэл зэрэг хөрөнгөөр ямаа, гахай улмаар арьс шир, ноос ноолуур, хоёрдогч түүхий эдийн зах зээлийн бизнес эрхлэх болсон. Энэ бизнес Б.Г, Ц.М нарын өөрсдийн өмчлөлийн эд зүйлсийг худалдан борлуулсан хөрөнгийн эх үүсвэрээр бий болсон.

1990 оноос Хөвсгөл аймгийн Ану худалдаа үйлчилгээний төвийн “Цасхан” цехэд сүү нийлүүлж эхэлсэн. Тухайн үед том хүү Г.Д 15 настай байсан бөгөөд энэ үеэс бизнест оролцож, 1993 онд 10 дугаар ангиа төгсөөд цэрэгт яваад 1995 онд цэргээс халагдаж ирсэн тул энэ бизнесээ удирдан явуулахыг даалгаснаар тэрээр санхүү тооцооны асуудлыг хөтөлж, хариуцаж байсан бөгөөд ямар нэгэн хуулийн этгээд байгуулаагүй байсан тул бүх хөрөнгө түүний нэр дээр байсан. Мөнгө болон хөдлөх, үл хөдлөх хөрөнгө бүгд талийгаач хүү Г.Д-ийн нэр дээр бүртгэлтэй байдаг боловч гэр бүлийн бүхий л гишүүдийн 20 гаруй жилийн хүч хөдөлмөр шингэсэн хөрөнгө. Г.Д нь бусад хүүхдийн хамтаар малын түүхий эд болох арьс шир, ноос ноолуур, өлөн гэдэс зэргийг худалдан авч, Улаанбаатар хотод аваачин зарж борлуулах худалдаа арилжааны хамтын аж ахуйн үйл ажиллагаа эрхэлж ирснийг шүүх тогтоосон. Энэ бизнесийн хамтын үйл ажиллагаа эрхэлж байх хугацаанд дараах дундын хөрөнгүүд бий болсон. Үүнд:

- Улаанбаатар хот, ХУД-т байрлах 59.67 м.кв талбайтай орон сууц;
- Улаанбаатар хот, БГД-т байрлах 18 м.кв талбайтай орон сууц;
- Хөвсгөл аймгийн Мөрөн хотод байрлах контейнер, гарааж;
- Талийгаач Г.Д-ийн нэр дээрх Хас банкны данснууд дах 35,839,960.39 төгрөг, 30,000,000 төгрөг;
- Талийгаач Г.Д-ийн нэр дээрх Хаан банкин дах 124,166,560.36 төгрөг;
- Талийгаач Г.Д, Г.Л-той хамтран эзэмшдэг Голомт банкны харилцах данс дах 322,530,768 төгрөг бүхий нийт 568,464,964.75 төгрөгийн үнэ бүхий мөнгө, эд хөрөнгүүд хамтын үйл ажиллагааны үр дүнд бий болсон.

Эдгээр эд хөрөнгүүдийг ИХ-ийн 126 дугаар зүйлийн 126.1, 520 дугаар зүйлийн 520.1, 520.1.1-д зааснаар шаардаж байгаа тул нэхэмжлэлийг зөвшөөрөхгүй. Харин нэхэмжлэгч нарыг талийгаачийн өвлөгч гэдэгтэй маргахгүй. Энэ шаардлагыг зөвшөөрнө. Сөрөг нэхэмжлэлийн зарим хэсэг болох Хөвсгөл аймгийн Мөрөнд байх контейнер, гараашнаас бусад үл хөдлөх эд хөрөнгө, мөнгөн хадгаламжаас оногдох хэсгийг гаргуулж өгнө үү гэжээ.

Нэхэмжлэгч Н.Т шүүх хуралдаанд сөрөг нэхэмжлэлд гаргасан тайлбартаа: Сөрөг нэхэмжлэлийг зөвшөөрөхгүй. Эдгээр хөрөнгүүд Н.Т миний бие, талийгаач Г.Д бидний дундаас гарсан 4 охин, гэр бүлийн хамтран өмчлөх дундын эд хөрөнгө юм. Эд хөрөнгүүдийг авахад та нар ямар хөрөнгө оруулсан юм. Энэ маргаанаас болоод хүүхдүүд бид хохирч байна. Том охин дөнгөж 10 жилийн сургуулиа төгсөөд аргагүйн эрхэнд ажил хийж байна. Сөрөг нэхэмжлэлийг хэрэгсэхгүй болгож өгнө үү гэжээ.

Шүүхийн шийдвэр: ИХ-ийн 520 дугаар зүйлийн 520.1.1, 476 дугаар зүйлийн 476.1, 126 дугаар зүйлийн 126.1-д заасныг баримтлан Н.Т, Д.Э нарын нэхэмжлэлтэй, хариуцагч Б.Г, Ц.М нарт холбогдох нэхэмжлэлийн шаардлагыг хангаж, хариуцагч нар хамтран өмчлөх

дундын эд хөрөнгөөс 568.464.964 төгрөг 75 мөнгө гаргуулах сөрөг нэхэмжлэлийг бүхэлд нь хэрэгсэхгүй болгож шийдвэрлэжээ.²⁶

Дүн шинжилгээ: Шүүх нэхэмжлэлийн шаардлагыг бүхэлд нь хангаж, сөрөг нэхэмжлэлийг хэрэгсэхгүй болгож шийдвэрлэсэн боловч, хэрэгт авагдсан нотлох баримтыг хуульд заасан журмын дагуу тухайн хэрэгт хамааралтай, ач холбогдолтой, үнэн зөв, эргэлзээгүй талаас нь үнэлж, үндсэн нэхэмжлэлийн шаардлага болон сөрөг нэхэмжлэлийн үндэслэлд бодитой дүгнэлт хийгээгүй, шүүхийн шийдвэрийн тогтоох хэсэгт нэхэмжлэлийн шаардлага тус бүрийг нарийвчлан тусгаагүй, мөн шаардлагад тусгагдсан 11 эд хөрөнгийг хэнд хэрхэн ногдуулж байгааг тодорхой заагаагүйн улмаас шүүхийн шийдвэр ойлгомжгүй, биелэгдэх боломжгүй болсон байна.

Өвлүүлэгч Г.Д нь эцэг эх, ах дүү нартайгаа хамтран ажиллаж байсан гэх үйл баримтыг тогтоосон шүүхийн шийдвэрийг нотлох баримтаар гаргаж өгсөн ч, шүүх түүнийг маргаж буй хөрөнгийг бий болоход гэрээгээр болон хуульд зааснаар хувь оролцуулсан болохоо баримтаар нотлоогүй гэж үзсэн нь үндэслэл бүхий болжээ. Харин үл хөдлөх эд хөрөнгө нь гэр бүлийн гишүүдийн хамтран өмчлөх дундын хөрөнгө, хадгаламжийн данс дах мөнгө нь гишүүний хуваарьт байх бөгөөд тэдгээрийг хууль ёсны өвлөгчид адил тэнцүү хэмжээгээр хуваан өвлөх эрхтэй. Өвлүүлэгчийн эцэг, эх нь хууль ёсны өвлөгч байхад тэдгээрийн гаргасан сөрөг нэхэмжлэлийн шаардлагыг бүхэлд нь хэрэгсэхгүй болгосон нь хуулийг буруу хэрэглэсэн гэж үзэх үндэслэлтэй. Мөн өвлөгчдөд ногдох хэсгийг зөв тогтоогоогүй байна.

²⁶ Баянгол дүүргийн иргэний хэргийн анхан шатны шүүхийн 2020 оны 02 сарын 21-ний 102/ШШ2020/00627 дугаар шийдвэр (102/2015/04926/и).
https://shuukh.mn/single_case/92020?daterange=2020-01-01%20-%202023-03-31&id=1&court_cat=1&bb=1

2.1.2. Өмчлөгчөөр тогтоолгох тухай

Тохиолдол 2: Д.Э-ний нэхэмжлэлтэй, хариуцагч Ц.Э-т холбогдох бусдын хууль бус эзэмшлээс хувийн сууцыг газрын хамт чөлөөлүүлэх тухай үндсэн, өмчлөх эрхийн Ү-200... Г-200... дугаартай гэрчилгээ, өвлөх эрхийн Х дугаартай гэрчилгээг тус тус хүчингүй болгуулж, хувийн сууц, газрын хууль ёсны өмчлөгчөөр тогтоолгох тухай сөрөг нэхэмжлэлтэй.


Хэргийн товч агуулга: Нэхэмжлэгч Д.Э, түүний өмгөөлөгч Т.Ц нар шүүхэд гаргасан нэхэмжлэл, тайлбартаа: Д.Э би 2020 оны 01 сарын 20-ны өдөр нас барсан Ц.О-ийн төрсөн хүү болно. Энэ тохиолдолд ИХ-ийн 515 дугаар зүйлийн 515.1-д “Өвлүүлэгчийн эд хөрөнгө, эрх өвлөгдөнө.”, мөн хуулийн 520 дугаар зүйлийн 520.1.1-д “... нас барагчийн төрүүлсэн хүүхэд хууль ёсны өвлөгч байна” гэж хуульчилснаар талийгаач ээжийн минь өмчлөлд байсан үл хөдлөх хөрөнгө тухайлбал, Дархан-Уул аймгийн Дархан сумд байрлалтай 40,0 м.кв талбайтай хувийн орон сууц, 1500,0 м.кв газар өвлөх эрхийн дагуу 2021 оны 04 сарын 01-ний өдөр шилжин ирсэн. Мөн ИХ-ийн 531 дүгээр зүйлийн 531.1, 531.3-т зааснаар хууль ёсны өвлөгч Д.Э надад өвлөх эрхийн гэрчилгээ олгогдсоноор үл хөдлөх хөрөнгийн өвлөгч буюу өмчлөгч болсон.

ИХ-ийн 101 дүгээр зүйлийн 101.1, 106 дугаар зүйлийн 106.1, 106.2, 106.3-д заасны дагуу шүүхэд хандаж байна. Төрсөн хүүхэд, өвлөгч, өмчлөгчийн хувьд үл хөдлөх хөрөнгөө захиран зарцуулж, чадахгүй байгаа тул дараах шаардлагыг гаргаж байна. Дархан-Уул аймаг, Дархан сумд байрлалтай 40 м.кв талбайтай хувийн орон сууц, 1500 м.кв газрыг Ц.Э түүний гэр бүлийн гишүүдийн хууль бус эзэмшлээс чөлөөлж надад олгон миний зөрчигдсэн эрхийг сэргээж өгнө үү гэв.

Хариуцагч Ц.Э, түүний өмгөөлөгч Ж.Э шүүхэд гаргасан хариу тайлбар болон шүүх хуралдаанд гаргасан тайлбартаа: Нэхэмжлэлийн шаардлагыг бүхэлд нь хүлээн зөвшөөрөхгүй байна. Болсон явдлын тухайд: 2006 онд би Х байрны 2 өрөө байраа

7,000,000 төгрөгөөр зарчхаад Х буудлын тэнд хашаа байшинг нэг хүнээс 2,000,000 төгрөгөөр авахаар ярилцаад байж байх үед миний дүү Б надад “манай найз О-д хямдхан хашаа, байшин байна тэрийг авчихгүй юу, тэр хүнтэй таныг уулзуулаад өгье гэхээр нь түүний үгэнд орж О гэгчтэй уулзаад хашаа, байшинг нь үзэхэд нэг талын хашаа нь байхгүй, байшин нь шал, хаалга, цонхгүй, хашаа нь тэр чигээрээ зэрлэгт баригдсан байсан. Би уг хашааны газар нь арай том юм уу гэж бодоод ярилцаж байгаад 1,500,000 төгрөгөөр авахаар харилцан тохиролцож худалдаж авсан. О намайг эхний ээлжид ХБ-ны 160... салбарт Д гэдэг хүний нэрээр мөнгө тушаа гэхээр нь би 2006 оны 04 сарын 25-ны өдрөөс 2006 оны 10 сарын 25-ны өдрийг хүртэл нийт 6 сарын зээлийн хүү 191,560 төгрөг төлсөн бөгөөд энэ зээл нь О өөрийн нэр дээрээ авсан зээл байсан юм байна лээ. Үлдсэн мөнгийг нь О-д өөрт нь бэлнээр цувуулж өгөөд 2007 оны 04 сард дуусгасан юм. Үл хөдлөх хөрөнгийн гэрчилгээ гаргаж өгөхөөр чинь өгнө гээд 50,000 төгрөг өгөлгүй үлдээгээд байсан юм. Хашаа байшингийн гэрчилгээ гаргуулж өгөхийг О-с удаа дараа шаардсан боловч өөдөөс согтуу дарамтлаад янз бүрээр хэлээд хойшлуулаад байдаг байсан. Би түүнийг нас барсныг нь сүүлд мэдсэн юм. Би энэ хашаа байшингийн үнийг О-д бүрэн төлсөн тул миний өмч хөрөнгө гэж үзэж байгаа учраас Д.Э-ийн нэхэмжлэлийг хүлээн зөвшөөрөхгүй байна. Иймд нэхэмжлэлийн шаардлагыг хэрэгсэхгүй болгож өгнө үү гэв.

Хариуцагч Ц.Э, түүний өмгөөлөгч Ж.Э нар шүүхэд болон шүүх хуралдаанд гаргасан сөрөг нэхэмжлэлдээ: Би энэ хашаа байшингийн үнийг О-д бүрэн төлсөн, миний өмч хөрөнгө гэж үзэж байгаа учраас Д.Э-ийн нэр дээр байгаа Дархан сумд байрших хувийн орон сууцны байшингийн өмчлөх эрхийн Ү-200... дугаартай гэрчилгээ болон гэр бүлийн хэрэгцээний 1500.0 м.кв газрын өмчлөх эрхийн Г-200... дугаартай гэрчилгээ, 62 дугаартай өвлөх эрхийн гэрчилгээг тус тус хүчингүй болгуулж, дээрх хувийн орон сууцны байшин болон гэр бүлийн зориулалттай газрын хууль ёсны өмчлөгчөөр тогтоож өгнө үү гэв.



Нэхэмжлэгч Д.Э, түүний өмгөөлөгч Т.Ц нар шүүхэд болон шүүх хуралдаанд гаргасан сөрөг нэхэмжлэлийн тайлбартаа: Сөрөг нэхэмжлэлийг бүхэлд нь хүлээн зөвшөөрөхгүй байна. Учир нь миний ээж Ц.О нь сөрөг нэхэмжлэгч Ц.Э-т тус хашааг зарж борлуулж байгаагүй. Худалдах, худалдан авах гэрээ байгуулж байгаагүй. Миний ээж Ц.О нь надад хэлэхдээ улсын бүртгэлийн Ү-200..., Г-100... тус тус дугаартай эдгээр үл хөдлөх хөрөнгийг хүнээр харуулаад байлгаж байгаа гэдгийг хэлж байсан тул сөрөг нэхэмжлэлийг хүлээн зөвшөөрөхгүй эсэргүүцэж байна гэв.

Шүүхийн шийдвэр: ИХ-ийн 520 дугаар зүйлийн 520.1.1, 535 дугаар зүйлийн 535.1, 106 дугаар зүйлийн 106.1-д тус тус зааснаар нэхэмжлэгч Д.Э-ийн өмчлөлийн Дархан-Уул аймаг, Дархан сумд байрлалтай 40,0 м.кв талбайтай хувийн орон сууц, тус хаягт байрлалтай 1500 м.кв газрыг хариуцагч Ц.Э-ийн хууль бус эзэмшлээс албадан чөлөөлж, дээрх үл хөдлөх эд хөрөнгүүдийн өмчлөх эрхийн Ү-200..., Г-200... дугаартай гэрчилгээ, Д.Э-д олгосон өвлөх эрхийн 62 дугаартай гэрчилгээг тус тус хүчингүй болгуулж, хувийн сууц, газрын хууль ёсны өмчлөгчөөр тогтоолгохыг хүссэн сөрөг нэхэмжлэлийн шаардлагыг бүхэлд нь хэрэгсэхгүй болгож шийдвэрлэсэн.²⁷

Дун шинжилгээ: ИХ-ийн 183 дугаар зүйлийн 183.1-д “Эрх шилжүүлж авч байгаа этгээдийн нэр дээр улсын бүртгэлд бүртгүүлсэн эрхийг хэлцлийн үндсэн дээр олж авч байгаа этгээд улсын бүртгэлд бичигдсэн тэмдэглэлийг буруу ташаа болохыг мэдэж байсан, эсхүл уг бүртгэлийг буруу ташаа гэж эсэргүүцсэнээс бусад тохиолдолд үнэн зөв гэж тооцно.”, ИХ-ийн 110 дугаар зүйлийн 110.1-д Үл хөдлөх эд хөрөнгө хэлцлийн үндсэн дээр нэг этгээдээс нөгөөд шилжиж байгаа бол уг хэлцлийг үл хөдлөх эд хөрөнгийн бүртгэлийн газар бүртгүүлснээр өмчлөх эрх шинэ өмчлөгчид үүсэж, өмнөх өмчлөгчийн өмчлөх эрх дуусгавар болно гэж заасан.


²⁷ Дархан-Уул аймаг дах сум дундын иргэний хэргийн анхан шатны шүүхийн 2021 оны 11 сарын 02-ны 987 дугаар шийдвэр (135/2021/00346/и).
https://shuukh.mn/single_case/107916?daterange=2021-01-01%20-%202021-12-31&id=1&court_cat=1&bb=1

ИХ-ийн 518 дугаар зүйлд заасны дагуу өвлүүлэгч нас барснаар өв нээгдэж, Д.Э нь ИХ-ийн 520 дугаар зүйлийн 520.1.1-д заасан хууль ёсны өвлөгч мөн тул талийгаачийн эд хөрөнгө, эрхийг өвлөн авах эрхтэй этгээд гэж үзнэ. Д.Э нь талийгаачийн нэр дээрх эд хөрөнгийг өвлөн авахаар Дархан-Уул аймгийн тойргийн нотариатчид хандан өвлөх эрхийн гэрчилгээ олгох хүсэлт гаргаж, баримт бүрдүүлсний дагуу түүнд өвлөх эрхийн гэрчилгээ олгосон нь үндэслэлтэй байна. Хэдийгээр ИХ-ийн 535 дугаар зүйлийн 535.1-д өв хүлээн авсан өвлөгч нь ... өвлүүлэгчийн гүйцэтгэвэл зохих үүргийг өвлөн авсан эд хөрөнгийн хэмжээгээр хүлээхээр хуульчилсан боловч хариуцагчийн үл хөдлөх эд хөрөнгийн өмчлөх эрхийн гэрчилгээг хүчингүй болгуулж, өмчлөгчөөр тогтоолгох сөрөг нэхэмжлэлийн шаардлагаа хариуцагч нотолж чадаагүй, үндэслэлгүй байх тул бүхэлд нь хэрэгсэхгүй болгож шийдвэрлэсэн нь зүйтэй байна. ИХ-ийн 106 дугаар зүйлийн 106.1-д зааснаар өмчлөгч хөрөнгөө бусдын хууль бус эзэмшлээс шаардах эрхтэй тул нэхэмжлэгчийн “эзэмшлээс чөлөөлүүлэх шаардлага”-ыг хангаж шийдвэрлэсэн нь үндэслэлтэй юм.

2.1.3. Өвлөгдөх хөрөнгөнөөс оногдох хэсгээ гаргуулах тухай

Тохиолдол 3: Ц.Б-ийн нэхэмжлэлтэй, хариуцагч Д.М, Ц.Ц, Ц.Д, Д.Г, Д.Г, Д.Ж нарт холбогдох 4 ханатай гэр, 388 тооны мал, өвөлжөө, хаваржааны иж бүрэн хашаа, 15-XX ДГА улсын дугаартай УАЗ 469 маркийн автомашины өв залгамжлагчаар тогтоолгох тухай.

Хэргийн товч агуулга: Нэхэмжлэгч Ц.Б шүүхэд гаргасан нэхэмжлэл болон шүүх хуралдаанд гаргасан тайлбартаа: Ц.Б би айлын бага охин, дээрээ дөрвөн ах, дөрвөн эгчтэй. Оршин суугаа хаяг минь С сум 2 дугаар багт байдаг хэдий ч ээждээ хамгийн ойр, байнга хамтран амьдардаг байсан хүн нь ганцхан би. Тийм учраас дээрх хөрөнгийн өв залгамжлагч болохоо хуулийн дагуу төрийн байгууллагаар шийдүүлэх хүсэлтэй байна гэжээ. Хариуцагч нарын итгэмжлэгдсэн төлөөлөгч Б.Д эд хөрөнгийг төрсөн хүүхдүүд бүгд хувааж авах эрхтэй, ганц Ц.Б-д өвлүүлэх нь учир дутагдалтай гэж маргасан байна.



Шүүхийн шийдвэр: Нэхэмжлэлийн зарим хэсгийг хангаж, ИХ-ийн 520 дугаар зүйлийн 520.1, 520.4-д зааснаар нэхэмжлэгч Ц.Б-д 4 ханатай гэр-1, УАЗ-469 маркийн 15-XX улсын дугаартай авто машин-1, ямаа-20, хонь-25, үхэр-14 өвлүүлж, үлдэх шаардлагыг хэрэгсэхгүй болгож, Д.Б-д өвөлжөө хаваржааны хашаа , ямаа-20, хонь-25, үхэр -14, Д.М-д ямаа-10, хонь-35, Ц.Ц-д ямаа-10, хонь-35, Ц.Д-д ямаа-10, хонь-35, Д.Г-т ямаа-10, хонь-35, Д.Г-т ямаа-10, хонь-35, Д.Ж-д ямаа-10, хонь-35 тус тус өвлүүлж шийдвэрлэсэн.²⁸

Дүн шинжилгээ: Анхан шатны шүүх нэхэмжлэлийн шаардлага, үндэслэлийг зөв тодорхойлж чадаагүйгээс хэргийн оролцогчдын эрх зүйн байдлыг буруу тогтоож, хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны журмыг зөрчсөн. Өөрөөр хэлбэл, хууль ёсны өвлөгчөөр тогтоолгохыг хүссэн нэхэмжлэлийн шаардлагатай маргаанд Д.М, Ц.Д, Д.Г, Д.Г, Д.Ж, Ц.Ц нарыг хариуцагчаар татсан атлаа бие даасан шаардлага гаргасан гуравдагч этгээд мэтээр дүгнэлт хийж, бие даасан шаардлагыг хэрэгсэхгүй болгохоор шийдвэрлэсэн нь ойлгомжгүй, шүүхийн шийдвэр “хууль ёсны бөгөөд үндэслэл бүхий байх” шаардлагад нийцээгүй байна.

Хэрэгт цугларсан нотлох баримтууд болон зохигчдын тайлбараас үзэхэд нэхэмжлэгч Ц.Б болон түүний ах дүү нар П.Ц-ын төрсөн хүүхдүүд болох эсэх буюу түүний хууль ёсны өвлөгч болох эсэх талаар маргаагүй, ийм нэхэмжлэлийн шаардлагыг гаргаагүй байхад шүүх шийдвэрлэсэн нь хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг ИХШХШТХ-д заасан ямар журмаар явуулсан нь тодорхойгүй, ойлгомжгүй байна. Нэхэмжлэлд дурдагдсан хариуцагч нарыг хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд хариуцагч биш гуравдагч этгээдээр оролцуулснаас үзэхэд анхан шатны шүүх хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг ердийн журмаар биш онцгой ажиллагааны журмаар явуулсан гэж үзэхээр байгаа

²⁸ Дорноговь аймаг дах сум дундын иргэний хэргийн анхан шатны шүүхийн 2022 оны 04 сарын 20-ны 136/шш2022/00162 дугаар шийдвэр (136/2021/00299/И). https://shuukh.mn/single_case/114461?daterange=2020-01-01%20-%202023-03-31&id=1&court_cat=1&bb=1

боловч иргэний хэрэг үүсгэх захирамж болон шүүхийн шийдвэрт энэ талаар заагаагүй, мөн хариуцагч нарыг бие даасан шаардлага гаргасан гуравдагч этгээдээр оролцуулахаар шийдвэрлэсэн атлаа тэдэнд нэхэмжлэлийн хувийг гардуулсан, харин тэднээс гаргасан бие даасан шаардлага нь юу болох эсэх нь тодорхойгүй зэргээс хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг онцгой ажиллагааны журмаар явуулсан гэж үзэх нөхцөл байдлыг үүсгэж эргэлзээ төрүүлсэн байна.

2.1.4. Өв хүлээн авах хугацааг сунгах

Тохиолдол 4: С.А-ийн хүсэлттэй, хууль ёсны өвлөгч болохыг тогтоолгох, өвлөх эрхийн хугацаа сэргээлгэх тухай.

Хэргийн товч агуулга: Хүсэлт гаргагч С.А шүүхэд болон шүүх хуралдаанд гаргасан тайлбартаа: Миний бие С.А нь Х аймгийн Б суманд 1966 оны 03 сарын 03-ны өдөр С-ын 2 дах хүү болон мэндэлсэн. Бид эцэг эхээс хоёулаа бөгөөд төрсөн ах Т нь 1994 он нас барсан. Аав Б.С 1990 онд, ээж М.С 2017 онд нас барсан. Миний ээж М.С нь Х аймгийн Б сумын Д багийн Х дугаар гудамжны Х тоотод 200... нэгж талбарын дугаартай 1030 м² талбайтай, өмчлөх эрхийн Г-160... улсын бүртгэлийн дугаартай, гэр бүлийн хэрэгцээний зориулалт бүхий газартай байсан. Одоо уг газрыг надаас өөр өвлөх хүн байхгүй. Тухайн үед би ээжийнхээ ажил төрлөөр ирээд уг газрыг өвлөж авах талаар Х аймгийн Б сумын нотариатчид хандахад нэг жилийн дараа өвлөх эрх нээгдэхээр гэрчилгээ бичүүлж ав гэсэн. Тэгээд хот руу яваад түүнээс хойш цар тахал гараад нутагтаа ирж чадаагүй юм. Иймд намайг ээж М.С-ийн газрын хууль ёсны өвлөгч мөн болохыг тогтоож өгнө үү гэжээ.

Шүүхийн шийдвэр: ИХ-ийн 520 дугаар зүйлийн 520.1.2, 528 дугаар зүйлийн 528.2-т заасныг баримтлан С.А-ийн өв хүлээн авах хугацааг сэргээж, ИХ-ийн 520 дугаар зүйлийн 520.1.2, 528 дугаар зүйлийн 528.2.2-т заасныг баримтлан С.А нь талийгаач М.С-ийн хууль ёсны өвлөгч бөгөөд түүний Х аймгийн Б сумын Д багийн Х



дугаар гудамжны X тоотод байрлах 1030 м² талбай бүхий өмчлөх эрхийн Г-160... улсын бүртгэлийн дугаартай, гэр бүлийн хэрэгцээний зориулалттай газрыг өвлөх эрхтэй болохыг тогтоож нэхэмжлэлийн шаардлагыг бүхэлд нь хангаж шийдвэрлэсэн.²⁹

Дүн шинжилгээ: ИХ-ийн 528 дугаар зүйлийн 528.1-д зааснаар өвлүүлэгчийг нас барах хүртэл түүнтэй хамт амьдарч байсан өвлөгч нь өв нээгдсэнээс хойш гурван сарын дотор өв хүлээн авахаас татгалзсан тухайгаа мэдэгдээгүй, түүнчлэн мөн хуулийн 528 дугаар зүйлийн 528.2-т зааснаар өв нээгдсэнээс хойш нэг жилийн дотор хуульд заасны дагуу өвлөгдсөн эд хөрөнгийг эзэмдэн авсан буюу эрхлэн удирдсан, эсхүл нотариат буюу баг, сумын Засаг даргад өв хүлээн авах буюу өвлөх эрхийн гэрчилгээ олгохыг хүсэж, өргөдөл гаргаагүй байна. Өөрөөр хэлбэл, өвлөгч нь хуульд заасан хугацаанд зохих байгууллагад хүсэлтээ гаргаагүй, хугацаа хэтрүүлж өвлөх эрхээ алдсан.

Шүүх ИХ-ийн 528 дугаар зүйлийн 528.4-д зааснаар өв хүлээн авах хугацааг сунгаж, хууль ёсны өвлөгч бөгөөд өвлөх эрхтэй болохыг тогтоож, нэхэмжлэлийн шаардлагыг хангаж шийдвэрлэсэн нь үндэслэлтэй байна. Харин нотариатч нэг жилийн дотор өв хүлээн авах өргөдөл гаргах эрхийн талаар зөвлөөгүй, бүртгэж аваагүй улмаас өв хүлээн авахаас татгалзсанд тооцогдож, эрх нь зөрчигдсөний улмаас тэрээр шүүхэд хандсан байна. Үүнээс үзэхэд нотариатчид өв нээгдсэнээс хойш нэг жилийн дотор өв хүлээн авах хүсэлт гаргах талаар өвлөгч нарт зөвлөж, өргөдлийг нь бүртгэн, эрхийг нь хангаж ажиллах шаардлагатай байна.

²⁹ Ховд аймгийн Булган сум дах сум дундын иргэний хэргийн анхан шатны шүүхийн 2021 оны 11 сарын 24-ний 154/ШШ2021/00239 дугаар шийдвэр (154/2021/00219/И). https://shuukh.mn/single_case/110270?daterange=2021-01-01%20-%202021-12-31&id=1&court_cat=1&bb=1

2.1.5. Нотариатын үйлдлийг хүчингүй болгуулах тухай

Тохиолдол 5: Нэхэмжлэгч “М” ХХК нь хариуцагч Д.О, Д.Э нарт холбогдуулан нотариатын үйлдлийг хүчингүйд тооцуулах, өв хүлээн авахаас татгалзсан болохыг тогтоолгох тухай.

Хэргийн товч агуулга: Нэхэмжлэгчийн зүгээс хоёр шаардлагыг гаргасан. Д.О нь СХД-ийн нотариатч Д.Ө-аас өвлөх эрхийн гэрчилгээ авахдаа ээж Д.Л хүнд өвчний учир нас барсан, би 2 хүүхдийнхээ хамт ээжийнхээ амьдарч байсан газар одоог хүртэл 17 жил амьдарч байгаа гэж дурддаг. Хүсэлтийн дагуу нотариатч Д.Ө нь өвлөх эрхийн гэрчилгээ олгосон байдаг. Гэтэл Д.О маргаан бүхий газар 17 жил амьдраагүй гэдэг нь хэрэгт авагдсан баримтаар нотлогдсон байна. НТХ-ийн 28 дугаар зүйлийн 28.2.1, 28.2.2, 28.3-д зааснаас үзэхэд Д.О-ын буруутай үйл ажиллагааны хохирлыг нотариатч Д.Ө хариуцахгүй байх үндэслэл харагдаж байгаа учраас 2019 оны 07 сарын 01-ний өдрийн өвлөх эрхийн гэрчилгээ олгосон нотариатын үйлдлийг нотариатчийн биш үйлчлүүлэгчийн буруутай үйл ажиллагааны улмаас хийгдсэн болохыг тогтоолгож, уг өвлөх эрхийн гэрчилгээ олгосон нотариатын үйлдлийг хүчингүйд тооцуулах тухай нэхэмжлэлийн шаардлага гаргасан. Мөн нэхэмжлэгч талаас хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад Д.О-ыг өвлөх эрхээсээ татгалзсан болохыг тогтоолгох тухай нэхэмжлэлийн шаардлагаа нэмэгдүүлсэн.

Хариуцагч Д.О шүүхэд болон шүүх хуралдаанд гаргасан тайлбартаа: Нэхэмжлэгч “М” ХХК-аас хуульд заасан миний эдлэх эрхийг үгүйсгээд байгааг зөвшөөрөхгүй байна. Би шаардлагатай бүх бичиг баримтыг бүрдүүлж, өвлөх эрхийн гэрчилгээ авсан. Би ээжийнхээ амьдарч байсан газрыг өвлөж авахдаа ямар нэгэн хууль, дүрэм зөрчөөгүй, тойргийн нотариатчид хандсан. Уг гэрчилгээг аваад Захиргааны хэргийн шүүхэд хандсан бөгөөд асуудал шийдэгдээгүй байхад “М” ХХК-аас надад холбогдуулан нэхэмжлэл гаргаж байгааг хүлээн зөвшөөрөхгүй байна. Нэхэмжлэгч талын шаардлага нь хууль зүйн үндэслэлгүй. Би өвлөх эрхээсээ татгалзах ямар ч боломжгүй тул нэхэмжлэлийн шаардлагыг бүхэлд нь хэрэгсэхгүй болгож өгнө үү гэв.

Хариуцагч Д.Ө шүүхэд ирүүлсэн тайлбар болон түүний өмгөөлөгч тайлбарлахдаа: Миний ажлын байранд үйлчлүүлэгч Д.О нь өөрийн эх Д.Л 2005 оны 02 сарын 18-ны өдөр нас барсан, түүний эзэмшиж байсан газар эзэмших эрхийг өв залгамжилж авах тухай хүсэлт гаргасан. Хүсэлтийг судлан үзэхэд өвлүүлэгч Д.Л-д СХД-ийн Засаг даргын 2003 оны 04 сарын 29-ний өдрийн 87 дугаар захирамжаар СХД-ийн 4 дүгээр хороо, Мах комбинатын зүүн талын задгайд 700 м.кв газрыг 2 жилийн хугацаагаар эзэмших эрхийн гэрчилгээ олгож, уг газрыг эзэмших эрхийн гэрчилгээний хугацаа хараахан дуусаагүй байхад эх нь нас барсан байсан. НҮХЗ-ын 2.2 болон НТХ-д заасны дагуу татгалзах хууль зүйн үндэслэл тогтоогдоогүй тул өвлөх эрхийн гэрчилгээ олгосон. Д.О-д өвийг хүлээж авах эрх нь нээлттэй байсан боловч хуульд заасан хугацаандаа үүргээ биелүүлээгүй гэж үзэж байна гэжээ.

Шүүхийн шийдвэр: ИХ-ийн 531 дүгээр зүйлийн 531.1, 531.2, 531.3, 528 дугаар зүйлийн 528.1, НТХ-ийн 43 дугаар зүйлийн 43.1, 28 дугаар зүйлийн 28.3-д зааснаар хариуцагч Д.Ө-ын 2019 оны 07 сарын 01-ний өдрийн 184 дугаартай өвлөх эрхийн гэрчилгээ олгосон үйлдэл, хариуцагч Д.О-д олгосон өвлөх эрхийн гэрчилгээг хүчингүй болгох, өв хүлээн авахаас татгалзсан болохыг тогтоолгохыг хүссэн “М” ХХК-ийн нэхэмжлэлийг бүхэлд нь хэрэгсэхгүй болгож шийдвэрлэсэн байна.³⁰

Дүн шинжилгээ: Нэхэмжлэгч тал ИХШХШТХ-ийн 25 дугаар зүйлийн 25.2, 38 дугаар зүйлийн 38.1-д зааснаар нэхэмжлэлийн үндэслэл, шаардлагаа баримтаар нотолж чадаагүй байна. ИХ-ийн 110 дугаар зүйлийн 110.1-д зааснаар өмнөх газар эзэмшигч буюу өмчлөгчийн эрх хэрхэн дуусгавар болж, шинэ өмчлөгчид шилжсэн нь холбогдох баримтаар нотлогдоогүй. Түүнчлэн НТХ-ийн 43 дугаар зүйлийн 43.2.3, 28 дугаар зүйлийн 28.3-д зааснаар үйлчлүүлэгч

³⁰ Сонгинохайрхан дүүргийн иргэний хэргийн анхан шатны шүүхийн 2021 оны 12 сарын 22-ны 184/ШШ2022/00012 дугаар шийдвэр (184/2021/00026/И).
https://shuukh.mn/single_case/108313?daterange=2021-12-01%20-%202021-12-24&id=1&court_cat=1&bb=1

Д.О-ын буруутай үйл ажиллагаанаас хууль зөрчсөн гэж үзэх үндэслэл тогтоогдохгүй, өв хүлээн авахаас татгалзсан гэж үзэх үндэслэлгүй байна гэсэн дүгнэлт хийж, нэхэмжлэлийн шаардлагыг бүхэлд нь хэрэгсэхгүй болгож шийдвэрлэсэн нь үндэслэл бүхий байна.

2.1.6. Өвлөх эрхийн гэрчилгээ олгохыг даалгах тухай


Тохиолдол 6: А.А-ийн нэхэмжлэлтэй, хууль ёсны өвлөгчөөр тогтоолгох тухай.

Хэргийн товч агуулга: Нэхэмжлэгч шүүхэд гаргасан нэхэмжлэлдээ: Миний хүү Н.Ч нь Х өдөр Сэлэнгэ аймгийн Баруунбүрэн суманд миний 1 дэх хүү болон мэндэлж, 2020 оны 03 сарын 10-ны өдөр бусдад хорлогдон амь насаа алдсан. Хүү минь нас барахын өмнө Орхон аймгийн Баян-Өндөр сумын Х тоот 31,3 м² өрөө орон сууц, Улаанбаатар хотын БЗД-ийн 14-р хорооны 8-р байрны Х тоот, Орхон аймгийн Баян-Өндөр сумын 1-р багийн Люкс Х тоот 2 өрөө бүхий орон сууц, Лексус 470 машинтай байсан бөгөөд төрсөн эх би ИХ-ийн 520 дугаар зүйлийн 520.1.1-д зааснаар хуульд заасан өвлөгч юм. Иймд дээрх орон сууцны хууль ёсны өвлөгчөөр тогтоож өгнө үү гэжээ.

Шүүхийн шийдвэр: ИХ-ийн 520 дугаар зүйлийн 520.1.1-д заасныг баримтлан 2020 оны 03 сарын 10-ны өдөр нас барсан хүү Н.Ч-ын хууль ёсны өвлөгч мөн болохыг тогтоож, ИХ-ийн 531 дүгээр зүйлийн 531.2-т зааснаар А.А-д өвлөх эрхийн гэрчилгээ олгохыг Орхон аймгийн тойргийн нотариатчид даалгаж шийдвэрлэжээ.³¹

Дүн шинжилгээ: ИХ-ийн 531 дүгээр зүйлийн 531.2-т хууль ёсны өвлөгчид өвлөх эрхийн гэрчилгээг өв нээгдсэнээс хойш нэг жил өнгөрсний дараа олгоно гэжээ. Нэхэмжлэгчийн төрсөн хүү 2020

³¹ Орхон аймаг дах сум дундын иргэний хэргийн анхан шатны шүүхийн 2021 оны 11 сарын 19-ний 142/ШШ2021/01124 дугаар шийдвэр (142/2021/00398/И).
https://shuukh.mn/single_case/108955?daterange=2021-01-01%20-%202021-12-31&id=1&court_cat=1&bb=1



оны 03 сарын 10-ны өдөр нас барсан, нэхэмжлэгч 2021 оны 03 сарын 04-ний өдөр ИХ-ийн 531 дүгээр зүйлийн 531.1-д “Хууль ёсны буюу гэрээслэлээр өвлөгч нь өвлөх эрхийн гэрчилгээ олгох хүсэлтийг өв нээгдсэн газрын нотариат, нотариатгүй газар баг, сумын Засаг даргад гаргана” гэсний дагуу Орхон аймгийн тойргийн нотариатчид хандаж, өвлөх эрхийн гэрчилгээ авах хүсэлт гаргаж, бүртгүүлсэн байна. Энэ тохиолдолд ИХ-ийн 528 дугаар зүйлийн 528.2-д заасны дагуу А.А-г өвийг хүлээн авсан гэж үзнэ. Гэвч нотариатч түүнд өвлөх эрхийн гэрчилгээ олгоогүй байна.

Нотариатч ямар шалтгаанаар өвлөх эрхийн гэрчилгээ олгоогүй нь тодорхойгүй, энэ талаар нотариатчид хандсан боловч шүүхэд ханд гэсэн хариу өгсөн гэж нэхэмжлэгч тайлбарлажээ. А.А нь өвлөх эрхийн гэрчилгээ олгохыг хүсэж нотариатчид хүсэлт гаргасан, нотариатч өвлөх эрхийн гэрчилгээ олгоогүй тул тэрээр өвлөх эрхийн гэрчилгээ олгохыг болон хууль ёсны өвлөгчөөр тогтоолгохыг шаардах эрхтэй. Иймд нэхэмжлэлийн шаардлагыг хангасан нь үндэслэлтэй байна. Харин нотариатч өвлөх эрхийн гэрчилгээ олгохоос татгалзсан үндэслэлээ тайлбарлаж өгөөгүй, өвлөх эрхийн гэрчилгээ олгоогүй нь түүний өвлөх эрхийг зөрчиж, шүүхэд хандахад хүргэжээ.

2.2. ДАВЖ ЗААЛДАХ ШАТНЫ ШҮҮХИЙН МАГАДЛАЛД ХИЙСЭН ДҮН ШИНЖИЛГЭЭ

Монгол Улсын шүүхийн шийдвэрийн цахим сангийн давж заалдах шатны магадлалаас “өвлөх” гэснийг сонгон 2020 оны 01 сарын 01-ний өдрөөс 2022 оны 10 сарын 01-ний өдрийг хүртэлх хугацаанд хайлт хийхэд 36 магадлал илэрсэн³²-ээс гомдлын агуулгаар нь ангилж, 4 магадлалыг сонгож судлав.

Эдгээр хэргийн нэхэмжлэлийн шаардлага нь өв залгамжлагчаар тогтоолгох, өвлөгдөх хөрөнгөөс өөрт оногдох хэсгээ гаргуулах, өвлүүлэгчийн өмчлөлийн үл хөдлөх хөрөнгөөс өвлөгдөх хэсгийг

³² <https://shuukh.mn/cases/1/2>

хариуцагчаас гаргуулах, хамтран өмчлөгчөөр бүртгэхийг эд хөрөнгийн эрхийн бүртгэлийн газарт даалгуулах, үл хөдлөх хөрөнгө болон газрын хууль ёсны өвлөгч болохыг тогтоолгох, гэр бүлийн гишүүдийн хамтран өмчлөх дундын эд хөрөнгө болохыг тогтоолгох, хууль ёсны өвлөгчөөр тогтоолгож, үл хөдлөх эд хөрөнгөөс өөрт болон хүүхдүүдэд оногдох хэсгийг гаргуулахтай холбоотой байв.

Сонгон авсан маргааныг ангилбал өвлөгчөөр тогтоолгох, хууль ёсны өвлөгчөөр тогтоолгож, хамтран өмчлөгчөөр бүртгэхийг үл хөдлөх эд хөрөнгийн бүртгэлийн байгууллагад даалгах тухай, хууль ёсны өвлөгчөөр тогтоолгож, үл хөдлөх эд хөрөнгөөс өөрт болон хүүхдүүдэд ногдох хэсгийг гаргуулах тухай, нотариатчаас өвлөх эрхийн гэрчилгээ олгосон нотариатын үйлдлийг хүчингүй болгож, хууль ёсны өвлөгчөөр тогтоолгох хэрэг тус тус нэг байна.

Давж заалдах шатны шүүх нь анхан шатны шүүхийн шийдвэрийг хянан үзэж, хэрэв алдаа гарсан бол түүнийг засах, зөвтгөх замаар хуулийн хэрэгжилтийг хангуулах үүрэгтэй бөгөөд түүний магадлал нь анхан шатны шүүхийн хууль хэрэглээний асуудлыг судлах үндсэн судлагдахуун болох учиртай.

Дээрх сонгон судалсан 4 магадлалын хүрээнд 1 шийдвэрийг хэвээр үлдээж, гомдлыг хангахгүй орхиж, 1 шийдвэрийг хүчингүй болгож, дахин хэлэлцүүлэхээр буцааж, 1 шийдвэрт нэмэлт, өөрчлөлт оруулж, 1 шийдвэрийг хүчингүй болгож шийдвэрлэсэн байна. Өв залгамжлалтай холбоотой иргэний хэрэг маргааныг хянан шийдвэрлэж буй практикт тодорхой ахиц, өөрчлөлт гарч байгаа ч түүнийг илүү үр дүнд хүргэх шаардлагатай юм.

Анхан шатны шүүхийн шийдвэрийн хувьд хэргийн оролцогчдын мэтгэлцээний явцад гарч байгаа маргааны зүйлд дүгнэлт хийж, няцаалт өгөхгүй байх, шүүхийн шийдвэрийн үндэслэх хэсэгт нотлох баримтыг хэрхэн үнэлсэн шалтгааныг дурдахгүй орхисноор хэргийн оролцогчдод эргэлзээ төрүүлж, гомдол гаргах нэг үндэслэл болж байгаа нь анхаарал татаж байна.

Мөн давж заалдах шатны шүүхээр хянагдсан иргэний хэрэгт нэхэмжлэлийн шаардлагыг багасгаж шийдвэрлэсэн тохиолдол

байна. Үүнд:


Баянгол дүүргийн ИХАШШ-ийн 2020 оны 02 сарын 21-ний өдрийн 627 тоот шийдвэрээр 568,464,964 төгрөг гаргуулах нэхэмжлэл гаргасныг хангаж шийдвэрлэсэн бол давж заалдах шатны шүүхийн 2020 оны 04 сарын 10-ны өдрийн 834 тоот магадлалаар 296,849,256 төгрөг гаргуулахаар нэхэмжлэлийн шаардлагыг багасгаж өөрчлөлт оруулан шийдвэрлэсэн байна. Үүнээс үзвэл нэхэмжлэгч тал нэхэмжлэлийн шаардлагыг бодитоор бус, хэт өндөр үнэлж нэхэмжилдэг болох нь ажиглагдав.

Давж заалдах шатны шүүхээр шийдвэрлэсэн хэргийн тоог хүснэгт болон графикаар үзүүлбэл:

График 7. Давж заалдах шатны шүүхийн сонгон авсан магадлалын ангилал



График 8. Судалгаанд хамрагдсан магадлалыг гаргасан Давж заалдах шатны шүүхийн харьяалал



ӨВ ЗАЛГАМЖЛАЛТАЙ ХОЛБООТОЙ ИРГЭНИЙ ХЭРЭГ МАРГААН ХЯНАН ШИЙДВЭРЛЭСЭН ШҮҮХИЙН ШИЙДВЭРИЙН СУДАЛГАА

График 9. Сонгон судлагдсан 4 магадлал он тус бүрээр




График 10. Давж заалдах шатны шүүхэд хянагдсан өв залгамжлалтай холбоотой иргэний хэргийн тоо (2020-2022 он)





График 11. Давж заалдах шатны шүүхээс анхан шатны шүүхийн шийдвэрийг хянасан байдал



ШҮҮХИЙН ШИЙДВЭРИЙН СУДАЛГАА: ЦУВРАЛ 17

2.2.1. Шийдвэрийг хүчингүй болгож, дахин хэлэлцүүлэхээр буцаасан

Тохиолдол 7: Ц.Б-н нэхэмжлэлтэй, П.Ц-н өв залгамжлагчаар тогтоолгох.

Хэргийн товч агуулга: Нэхэмжлэгч Ц.Б шүүхэд 4 ханатай гэр, 388 тооны мал, өвөлжөө, хаваржааны иж бүрэн хашаа, автомашины хууль ёсны өвлөгчөөр тогтоолгох нэхэмжлэлийн шаардлага гаргасан. Уг хэрэгт хууль ёсны өвлөгчөөр тогтоолгох бие даасан шаардлагыг нэр бүхий гуравдагч этгээд нар гаргасан. Нэхэмжлэгч Ц.Б нь шүүхэд гаргасан нэхэмжлэлдээ өв залгамжлах эрхээ нээлгүүлэх хүсэлтэй байна. 2020 оны 8 дугаар сард ээжийгээ нас барснаас хойш жилийн дараа өргөдөл, хүсэлтээ өгч эрхээ нээлгүүлсэн хэдий ч 2021 оны 01 сарын 20-нд шүүхээс цуцалсан. Би айлын бага охин, дээрээ дөрвөн ах, дөрвөн эгчтэй. Ээжтэйгээ хамгийн ойр, хамт амьдарсан нь ганцхан би. Өв залгамжлал цуцлагдсан шийдвэрээс хойш 1 жилийн хугацаа өнгөрч байхад нэг ч хүн сэргээлгэхээр нэхэмжлэл гаргаагүй, би л сэргээлгэх нэхэмжлэл гаргаж байна гэжээ.

Бие даасан шаардлага гаргасан гуравдагч этгээд Д.М тайлбартаа Ц.Б нь хамгийн бага хүүхэд учраас бүх хөрөнгийг өвлөх эрхтэй, сүүлийн хэдэн жил ганцаараа ээжийгээ харж хандсан гэдэг нь худлаа. Бид ээжийн 49 хоногийг хураагаад бүгд цугласан үедээ ярилцаад хэдэн малыг тэнцүү хувааж авах тухай ярилцаж байхад Ц.Б очоогүй, ээжтэй хамт амьдарч байсан хүн бол зээ хүү Д.Б, Д.М нар юм. Бид бүгд П.Ц гэдэг хүний мах цусны тасархай, иймд бид бүгд тэгш эрхтэй, малаа 7 тэнцүү хувааж авна, зарим нь надаар малаа маллуулж, малаа авах нь авна гэж яриад байгаа ... малыг 7 хувааснаараа авна, 4 ханатай гэрийг ээж амьд сэрүүн байхдаа Ц.Б-д өгнө гэж хэлсэн. Ийм учраас дээрх маргалдаж байгаа эд хөрөнгөд бид бүгдийг өмчлөгчөөр тогтоож өгнө үү гэжээ.

Анхан шатны шүүхийн шийдвэр: ИХ-ийн 520 дугаар зүйлийн 520.1.1-д зааснаар П.Ц-ын хууль ёсны өвлөгчөөр Ц.Б-г тогтоож, хууль ёсны өвлөгчөөр тогтоолгохыг хүссэн Д.М, Ц.Д, Д.Г,

Д.Г, Д.Ж, Ц.Ц нарын бие даасан шаардлагыг хэрэгсэхгүй болгож шийдвэрлэсэн.³³

Давж заалдах шатны шүүхийн шийдвэр: ИХАШШ-ийн 2021 оны 12 сарын 24-ний өдрийн 136/ШШ2022/00003 дугаар шийдвэрийг хүчингүй болгож, хэргийг дахин шийдвэрлүүлэхээр анхан шатны шүүхэд буцааж, бие даасан шаардлага гаргасан гуравдагч этгээдүүдийн итгэмжлэгдсэн төлөөлөгч Д.М-ны давж заалдсан гомдлыг хангаж шийдвэрлэсэн.³⁴

Дүн шинжилгээ: Давж заалдах шатны шүүх нь анхан шатны шүүхийн шийдвэрийг ИХ, ИХШХШТХ-ийн 116 дугаар зүйлийн 116.1-д заасан шаардлагад нийцээгүй, тус хуулийн 115 дугаар зүйлийн 115.2-т заасан шаардлагыг зөрчсөн гэж үзэж, хэргийг бүхэлд нь хянан нэхэмжлэлийн шаардлага, үндэслэлийг зөв тодорхойлж чадаагүйгээс, хэргийн оролцогчдын эрх зүйн байдлыг буруу тогтоож, нэхэмжлэгчийн өв залгамжлах эрхийг хэн, хэрхэн зөрчсөн, түүнийг сэргээхэд саад болж байгаа үйл баримт, өвлөгдөх эд хөрөнгийн өмчлөх эрхийг хэрэгжүүлэх боломжгүй нөхцөл байдал зэрэг хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны журам зөрчсөн тул анхан шатны шүүхийн шийдвэрийг хүчингүй болгож, дахин хэлэлцүүлэхээр буцаасан.

Хууль ёсны өвлөгчөөр тогтоолгохыг хүссэн бие даасан шаардлагыг хэрэгсэхгүй болгохоор шийдвэрлэснээс гадна талууд хууль ёсны өвлөгч болох эсэх талаар маргаагүй байхад гаргаагүй шаардлагыг шийдвэрлэсэн байна. Мөн нэхэмжлэлд дурдагдсан этгээдүүдийг хариуцагч биш гуравдагч этгээдээр оролцуулсан нь хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг ердийн бус, онцгой ажиллагааны журмаар явуулсан гэж үзэхээр байна.

³³ Дорноговь аймаг дах сум дундын иргэний хэргийн анхан шатны шүүхийн 2021 оны 12 сарын 24-ний 136/шш2022/00003 дугаар шийдвэр (136/2021/00299/И).

https://shuukh.mn/single_case/108712?start_date=&end_date=&id=1&court_cat=1&bb=1

³⁴ Дорноговь аймаг дах эрүү, иргэний хэргийн давж заалдах шатны шүүхийн 2022 оны 02 сарын 28-ны 202/МА2022/00003 дугаар магадлал (136/2021/00299/И).

https://shuukh.mn/single_case/20123?daterange=2020-01-01%20-%20

[2023-04-02&id=2&court_cat=1&bb=1](https://shuukh.mn/single_case/20123?daterange=2020-01-01%20-%202023-04-02&id=2&court_cat=1&bb=1)

2.2.2. Шийдвэрийг хэвээр үлдээж, гомдлыг хангахгүй орхисон

Тохойлдол 8: М Нэхэмжлэгч Н.Б, Ш.М, О.Ал нар нь Н.Б, О.Ан, О.Ам, О.Ал нарыг хууль ёсны өвлөгчөөр тогтоолгох, хамтран өмчлөгчөөр бүртгэхийг үл хөдлөх эд хөрөнгийн бүртгэлийн байгууллагад даалгах тухай үндсэн, хариуцагч Н.Н, О.Ар нар уг орон сууцны өмчлөгчөөр тогтоож, үл хөдлөх эд хөрөнгийн бүртгэлийн газарт бүртгэхийг даалган, нэхэмжлэгч Н.Б-гаас 44,500,000 төгрөг гаргуулах тухай сөрөг нэхэмжлэлтэй.

Хэргийн товч агуулга: Нэхэмжлэгч Ш.М-ын итгэмжлэгдсэн төлөөлөгч Н.Б, нэхэмжлэгч О.А-ийн итгэмжлэгдсэн төлөөлөгч Б.М нар шүүхэд гаргасан нэхэмжлэл болон шүүх хуралдаанд гаргасан тайлбартаа: Миний хүү Б.О 2017 оны 07 сарын 16-ны өдөр зуурдаар нас барсан. Түүний өмчилж байсан СХД-ийн 6 дугаар хороо, Содон хороолол, X дугаар байрны X тоот 2 өрөө орон сууцыг ИХ-ийн 531 дүгээр зүйлийн 531.1-д заасныг үндэслэн Б.О-ийн төрсөн эх Н.Б би өвлөх хүсэлтэй байгаа тул хууль ёсны өвлөгчөөр бүртгүүлэхээр энэхүү нэхэмжлэлийг гаргаж байна.


Хүү Б.О нь албан ёсны гэр бүлийн баталгаагүй байсан бөгөөд 2004 онд Ш.М гэх эмэгтэйтэй хамтран амьдарч, 2004 онд охин О.Ан, 2008 онд хүү О.Ам нарыг төрүүлсэн боловч салж, хүү О.Ам эцэгтэйгээ хамт амьдарч байсан. 2012 оны 9 сараас Н.Н-тэй хамтран амьдарч 2013 онд хүү О.Ар төрж, хүү Б.О нас барснаас хойш дээрх байранд Н.Н амьдарч байгаа юм. Би охин Б.Ою, хүү Б.О нартай хамтран ажиллуулж байсан Хархорин зах дах 2 павильоны орлогоос уг орон сууцыг “Тесо корпораци” ХХК-аас худалдан авах гэрээний дагуу урьдчилгаа мөнгөнд нийт 46,432,200 төгрөгийг төлсөн. Үүнээс О.Ал-ийн эх Б.Ою 16,292,800 төгрөг төлсөн тул түүнд уг хөрөнгийг бий болгоход оруулсан мөнгөний хэмжээгээр хамтран өмчлөх эрх үүссэн гэж үзэж байна. Гэтэл Б.Ою 2015 оны 11 сарын 21-ний өдөр нас барсан учраас өмчлөгчөөр бүртгүүлж чадаагүй, зөвхөн түүний дүү Б.О-гийн нэр дээр 1 хүний өмчөөр бүртгэгдсэн.

Иймд ИХ-ийн 531 дүгээр зүйлийн 531.1-д заасны дагуу хүү Б.О-ийн өмчлөлд байсан СХД- ийн 6 дугаар хороо, Содон хороолол, Х дугаар байрны Х тоот 2 өрөө орон сууцны өмчлөгчөөр эх Н.Б намайг, талийгаач хүү Б.О-гийн охин О.Ан, хүү О.Ам, мөн талийгаач охин Б.Ою-н хүү О.Ал нарыг тогтоож, өмчлөгчөөр бүртгүүлэхийг эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн байгууллагад даалгаж өгнө үү гэжээ.

Хариуцагч сөрөг нэхэмжлэлдээ: Н.Н би талийгаачтай амьдралынхаа явцад Хар хорин худалдааны төвийн хүнсний Х дугаартай павильоныг иргэн Н.А-с худалдан авсан. Бидний өдөр тутмын амьдралынхаа хэрэгцээгээ залгуулж байсан павильоныг хадам ээж бусдад зарсныг мэдээд тус лангуунд сууж байгаа хүнээс хэдээр авсан бэ? гэхэд 35,000,000 төгрөгөөр худалдан авсан гэж байсан. Мөн хуучин бэр буюу хүүгээс нь салж, өөр хүний эхнэр болсон Ш.М-д бидний RAV-4 автомашиныг 9,500,000 төгрөгөөр худалдсан юм. Иймд 44,500,000 төгрөгийг Н.Б-гаас гаргуулахаар нэхэмжилж байгаа.

Мөн Улаанбаатар хот, СХД- ийн 6 дугаар хороо Содон хорооллын Үйлдвэрчний эвлэлийн гудамж, Х тоот байрны Х тоотын 2 өрөө байр, 49,99 м.кв Ү-220 гэрчилгээтэй ГД-000 үл хөлдөх хөрөнгийн жинхэнэ өмчлөгч мөн болохыг тогтоолгох, үл хөдлөх хөрөнгийг би талийгаачийн хамт банкны зээлээр авсан, зээлийг цалингаараа төлж өнөөдрийг хүртэл 2 нялх хүүхдийн хамтаар амьдарч байгаа тул Н.Н, О.Ар нарыг Улаанбаатар хот, СХД-ийн 6 дугаар хороо, Содон хороолол, Х дугаар байрны Х тоот 2 өрөө орон сууцны өмчлөгчөөр бүртгэж, гэрчилгээнд бичилт хийхийг СХД-ийн Улсын бүртгэлийн хэлтэст даалгаж өгнө үү гэжээ.

Анхан шатны шүүхийн шийдвэр: ИХ-ийн 108 дугаар зүйлийн 108.1, 520 дугаар зүйлийн 520.1, 520.1.1-д заасныг баримтлан талийгаач Б.О-ийн хууль ёсны өвлөгчөөр эх Н.Б, хүү О.Ам, хүү О.Ар нарыг тогтоож, улсын бүртгэлийн Ү-220 дугаартай, Улаанбаатар хот, СХД, 6 дугаар хороо, Содон хороолол Х дугаар байр, Х тоот, 49.99 м.кв 2 өрөө орон сууцыг хариуцагч Н.Н-ийн өмчлөлд үлдээж,



Н.Б, О.Ам нарт ногдох хэсэг 23,496,000 (Хорин гурван сая дөрвөн зуун ерэн зургаан мянга) төгрөгийг хариуцагч Н.Н-аас гаргуулан нэхэмжлэгч Н.Б, Ш.М нарт олгож, үндсэн нэхэмжлэлээс О.Ан, О.Ал нарыг өвлөгчөөр тогтоолгох, сөрөг нэхэмжлэл болох нэхэмжлэгч Н.Б-гаас 44,500,000 (Дөчин дөрвөн сая таван зуун мянган) төгрөг гаргуулах шаардлагыг тус тус хэрэгсэхгүй болгож шийдвэрлэсэн байна.³⁵

Давж заалдах шатны шүүхийн шийдвэр: Анхан шатны шүүхийн шийдвэрийг хэвээр үлдээж, нэхэмжлэгч, тэдний өмгөөлөгч, гуравдагч этгээдийн итгэмжлэгдсэн төлөөлөгч нарын гаргасан давж заалдах гомдлыг хангахгүй орхиж шийдвэрлэсэн.³⁶

Дүн шинжилгээ: Нэхэмжлэгч Н.Б өв хүлээн авах хүсэлтээ хүү Б.О-ийг нас барснаас хойш 1 жилийн дотор буюу 2018 оны 02 сарын 27-ны өдөр нотариатад гаргасан, хүү О.Ам, О.Ар нар нь өвлүүлэгчийг нас барах хүртэл түүнтэй хамт амьдарч байсан болох нь тогтоогдсон бөгөөд өв хүлээн авахаас татгалзсан тухай нотариат, эсхүл оршин суугаа газрын Засаг даргад мэдэгдээгүй байх тул тэдгээрийг өв хүлээн авсан гэж үзнэ. Охин О.Ан нь талийгаач Б.О-тэй нас барах хүртэл нь хамт амьдарч байсан гэх байдал хэргийн баримтаар тогтоогдоогүй, нэхэмжлэгч Ш.М хүүхдүүдийнхээ өв хүлээн авах хүсэлтийг өвлүүлэгч нас барснаас хойш 1 жил өнгөрсний дараа буюу 2018 оны 08 сарын 24-ний өдөр нотариатаар гэрчлүүлсэн байна.

Мөн нэхэмжлэгч О.Ал, түүний эх Б.Оюу-гийн төлсөн 16,292,800 төгрөгийг түүний мөнгө байсан болохыг нотолсон баримтыг шүүхэд гаргаагүй бөгөөд хэргийн баримтаар тогтоогдохгүй байгааг зөв үнэлжээ. Анхан шатны шүүхийн шийдвэр ИХШХШТХ-ийн 116

³⁵ Сонгинохайрхан дүүргийн иргэний хэргийн анхан шатны шүүхийн 2020 оны 08 сарын 28-ны 184/ШШ2020/02638 дугаар шийдвэр (184/2018/01547/и).

https://shuukh.mn/single_case/97655?start_date=&end_date=&id=1&court_cat=1&bb=1

³⁶ Нийслэлийн иргэний хэргийн давж заалдах шатны шүүхийн 2021 оны 01 сарын 06-ны 210/МА2021/00075 дугаар магадлал (184/2018/01547/И).

https://shuukh.mn/single_case/17403?daterange=2020-01-01%20-%202022-10-01&id=2&court_cat=1&bb=1

дугаар зүйлийн 116.2-т заасан хууль ёсны бөгөөд үндэслэл бүхий байх гэсэн шаардлагад нийцсэн байна.


2.2.3. Шийдвэрт өөрчлөлт оруулсан

Тохиолдол 9: Тохиолдол 1-т дурдсан нэхэмжлэгч Н.Т, Д.Э нарын хариуцагч Б.Г, Ц.М нарт холбогдуулан гаргасан хууль ёсны өвлөгчөөр тогтоолгож, үл хөдлөх эд хөрөнгөөс өөрт болон хүүхдүүдэд ногдох хэсгийг гаргуулах үндсэн, хариуцагч нар 568,464,964.75 төгрөгөөс ногдох хэсгийг гаргуулах сөрөг нэхэмжлэлтэй хэрэг.

Хэргийн агуулга: Нэхэмжлэгч болон нэхэмжлэгч Д.Э-ын итгэмжлэгдсэн төлөөлөгч Н.Т, өмгөөлөгч Ц.А нар давж заалдах гомдолдоо: Шүүх нэхэмжлэлийн шаардлагыг бүхэлд нь хангаж, сөрөг нэхэмжлэлийг хэрэгсэхгүй болгож шийдвэрлэснийг шийдлийн хувьд хүлээн зөвшөөрч байгаа боловч, шүүхийн шийдвэрийн тогтоох хэсэгт нэхэмжлэлийн шаардлага тус бүрийг нарийвчлан тусгаагүй, мөн шаардлагад тусгагдсан 11 эд хөрөнгийг хэнд хэрхэн ногдуулж байгааг тодорхой заагаагүйн улмаас шүүхийн шийдвэр биелэгдэх боломжгүй, ойлгомжгүй болсон, улмаар нэхэмжлэгчийн хууль ёсны эрх, ашиг сонирхол ноцтой зөрчигдсэн тул гомдолтой байна.

ИХШХШТХ-ийн 118 дугаар зүйлийн 118.5 зөрчигдсэн гэж үзэж байна. Гэр бүлийн дундын өмчлөлийн үл хөдлөх эд хөрөнгүүд болон банкин дах хадгаламж зэрэг нь талийгаачийн нэр дээр байсан, мөн талийгаачийн эцэг эх, ах дүү нар эд хөрөнгөд маргаан үүсгэснээс шалтгаалан зохих журмын дагуу өвлөх эрхийн гэрчилгээ нээлгэж, өв залгамжлалын асуудал шийдвэрлэгдэх боломжгүй болсон.

Нэгэнт өвийн асуудлаар талийгаачийн эцэг, эх, дүү нар нь маргаж байгаа тохиолдолд нэхэмжлэгч нар нь хууль ёсны өвлөх эд хөрөнгөөс ногдох хэсгийг гаргуулахын тулд эхлээд Д.Д, Н.Т нарыг гэр бүл болсноос хойш бий болсон эд хөрөнгийг хуульд зааснаар Д.Д, Н.Т, Д.Э, Д.А, Д.Д, Д.Ж нарын гэр бүлийн хамтран өмчлөх



дундын эд хөрөнгө болохыг шүүхийн журмаар тогтоолгох тухай нэхэмжлэлийг мөн шүүхэд гаргасан, уг шаардлагыг шийдвэрлэснээр өвийн асуудлыг шийдвэрлэхэд хялбар болох ёстой байсан.

Гэтэл шүүх нэхэмжлэлийн шаардлагаас гэр бүлийн хамтран өмчлөх дундын эд хөрөнгө болохыг шүүхийн журмаар тогтоолгох тухай шаардлагын талаар шийдвэрийн “Үндэслэх” хэсэгт огт дурдаагүй, хууль ёсны өвлөгчөөр нэхэмжлэгч нарыг тогтоож байгаа мэт боловч эд хөрөнгөөс ногдох хэсгийг гаргуулах шаардлагыг шийдвэрлэсэн эсэх нь тодорхойгүй болсон. Иймээс шүүхийн шийдвэрийн тогтоох хэсэгт маргаан бүхий эд хөрөнгийн хуваарилалтыг нарийвчлан тусгуулах шаардлагатай.

Анхан шатны шүүх зөвхөн нэхэмжлэлийг хангаж шийдвэрлэлээ гэсэн байдлаар хариуцлагагүй хандсан нь нэхэмжлэгч нарыг, тэдгээрийн ар гэрийг бас дахин хохирооход хүргэж байгаа тул шүүхийн шийдвэрийг хүчингүй болгож, анхан шатны шүүхэд буцаахгүйгээр, шүүхийн шийдвэрт өөрчлөлт оруулж эцэслэн шийдвэрлэж өгөхийг хүсэж байна. Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 166 дугаар зүйлийн 166.4-д заасан эрхийнхээ дагуу шүүхийн шийдвэрийг бүхэлд нь хянан үзэж, анхан шатны шүүхийн шийдвэрт өөрчлөлт оруулж, гаргасан зөрчлийг нь зөвтгөж өгнө үү гэжээ.

Хариуцагч Б.Г-ын итгэмжлэгдсэн төлөөлөгч З.Н, хариуцагч Ц.М нар давж заалдах гомдолдоо “...Нэхэмжлэлд маргаан бүхий 11 эд хөрөнгийг нэхэмжлэгч хариуцагч Б.Г, Ц.М нарыг оролцуулан хуваан бодож тооцоолон шүүхэд нэхэмжлэл гаргасан байхад хэргийг шийдэхдээ нэхэмжлэлийн шаардлагад дурдагдсаныг тодруулан тооцоололгүйгээр хариуцагч нарыг хасаж, эд хөрөнгүүдийг хуваан шийдсэн. Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад хариуцагч нарын хүүхдүүд болох Г.Ж, Г.С, Г.Ч нь өөрсдийн итгэмжлэгдсэн төлөөлөгчөөр дамжуулан бие даасан шаардлага гаргаж хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцох хүсэлт гаргасан байхад анхан шатны шүүх “өмнө нь бие даасан шаардлага гаргаагүй гуравдагч этгээдээр оролцох хүсэлт гаргаж байсныг хүлээн авахаас татгалзаад

нэгэнт шийдсэн асуудал тул шийдэхгүй” гэх үндэслэлээр хүсэлтийг хүлээн аваагүй. Нэхэмжлэлийн шаардлагад дурдагдаж буй эд хөрөнгө болох БГД-ийн орон сууцыг анх худалдан авсан өдрөөс өнөөг хүртэл Г.Г, Г.Ж нар нь амьдарч байгаа, дансанд хуримтлагдсан мөнгөний зарим хэсэг болоод хөрөнгүүд нь эдгээр хүмүүсийн хүч, хөдөлмөр, орлогоор бүрдсэн болох нь хэрэгт авагдсан нотлох баримтаар бүрэн харагдаж, нотлогддог. Г.Г, Г.Ж. ГЧ нар нь тус хаяг дээр оршин суудаг гэх хорооны засаг даргын тодорхойлолт, уг байрыг худалдсан иргэн ГЧ-ын “Уг байрыг 2 дүүгээ суулгана гэж анх надаас худалдаж авсан” гэх агуулгатай шүүхэд гаргаж өгсөн тодорхойлолт, мөн уг байрыг худалдаж, хэдхэн хоногийн өмнө Б.Г гуайн “Монгол Шуудан” банк дах дансыг хааж 26 000 000 төгрөгийг Г.Д нь гарын үсэг зурж хүлээн авсан болохыг нотлох гүйлгээний баримт гэх зэрэг баримтууд нь бүгд уг хавтаст хэрэгт нотлох баримтын шаардлага хангагдсан хэлбэрээр авагдсан. Гэтэл эдгээр нотлох баримтуудыг үнэлээгүй, уг хүмүүсийн эрх ашиг хөндөгдөж байхад анхан шатны шүүх ИХШХШТХ-ийн 29 дүгээр зүйлийн 29.1, 29.3 дах заалтуудыг баримтлаагүй ба баримтлахаас үндэслэлгүйгээр татгалзсан гэж үзэж байна.

Хариуцагч талын зүгээс шүүхэд гаргасан сөрөг нэхэмжлэл болоод шүүхийн хэлэлцүүлгийн явцад ч Хөвсгөл аймагт байрлах газар, 2 байшинг үр хүүхдүүдээ анх тусад нь гаргаж байхдаа өгсөн учир маргах зүйлгүй харин уг газар дээр байгаа гарааш, контейнероос оногдох хэсгийг гаргуулна гэж тодорхой дурдсан атал огт татгалзаагүй эд хөрөнгийг татгалзсан болгож шийдвэртээ тусгасан байна. 2018 оны 11 дүгээр сарын 07-ны өдрийн ХУД-ийн ИХАШШ-ийн 2491 дугаар шийдвэрээр Г.Д, Г.Ч, Г.С, Г.Г, Г.Ж, Г.Л, Б.Г, Ц.М нар нь хамтын бизнесийн үйл ажиллагаа эрхэлж байсныг тогтоосон бөгөөд харин маргаан бүхий эд хөрөнгөнөөс өөрт ногдох хэсгийг гаргуулах шаардлагыг өвийн асуудалтай хамт шийдвэрлэх нь зүйтэй хэмээн үзсэний үндсэн дээр хариуцагч талын зүгээс сөрөг нэхэмжлэл гаргасан. Гэтэл шүүх үнэлээгүй, ямар ч нотлох баримт байхгүй байсан мэт дүгнэжээ.

Шүүхийн хэлэлцүүлгийн явцад талийгаач нь хамтын бизнесийн үйл ажиллагаанаас өөр ажил хөдөлмөр эрхэлж байгаагүй нь илэрхий болсон бөгөөд сөрөг нэхэмжлэлийн шаардлагыг тухайн эд хөрөнгө хэний нэр дээр байна, хэнд өвлөгдөн очсон зэрэг байдлаас үл хамааран шийдвэрлэх боломжтой, өмнө нь дурдсанчлан хангалттай нотлох баримт хэрэгт авагдсан гэж үзэж байна.

Дээрхээс үзэхэд анхан шатны шүүх хэт нэг талыг барьсан, үнэлэх ёстой нотлох баримтыг үнэлээгүй, хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны журмыг удаа дараа зөрчсөн, хуулийг буруу тайлбарлан хэрэглэж, хэргийг бүрэн үндэслэлтэйгээр, нотлох баримтад тулгуурлан шийдээгүй, шударга бус шийдвэр гаргасан гэж үзэж байна. Иймд анхан шатны шүүхийн шийдвэрийг хүчингүй болгож, дахин шийдвэрлүүлэхээр буцааж өгнө үү” гэжээ.

Анхан шатны шүүхийн шийдвэр: ИХ-ийн 520 дугаар зүйлийн 520.1.1, 476 дугаар зүйлийн 476.1, 126 дугаар зүйлийн 126.1-д заасныг баримтлан Н.Т, Д.Э нарын нэхэмжлэлтэй, хариуцагч Б.Г, Ц.М нарт холбогдох нэхэмжлэлийн шаардлагыг хангаж, хариуцагч нар хамтран өмчлөх дундын эд хөрөнгөөс 568.464.964.75 төгрөг гаргуулах сөрөг нэхэмжлэлийг бүхэлд нь хэрэгсэхгүй болгож шийдвэрлэжээ.³⁷

Давж заалдах шатны шүүхийн шийдвэр: Шийдвэрийн тогтоох хэсгийн 1 дэх заалтыг өөрчилж “ИХ-ийн 520 дугаар зүйлийн 520.1.1, 520.6-д зааснаар ХУД-ийн 15 дугаар хороо, Х байрны Х тоот, 59.67 м.кв талбайтай орон сууцыг болон Хас банкин дах ... дугаартай хадгаламжийн данс дах 35,839,196.39 төгрөг, ... дугаартай хадгаламжийн данс дах 30,000,000 төгрөг, Хаан банкин дах ... дугаартай харилцах данс дах 124,166,560.36 төгрөг, мөн Голомт банкн дах Г.Л-н хамтран эзэмшдэг ... тоот харилцах дансны 106,843,900 төгрөгийн үлдэгдэл, нийт 296,849,256 төгрөгийн мөнгөн

³⁷ Баянгол дүүргийн иргэний хэргийн анхан шатны шүүхийн 2020 оны 02 сарын 21-ний 102/ШШ2020/00627 дугаар шийдвэр (102/2015/04926/и).
https://shuukh.mn/single_case/92020?daterange=2020-01-01%20-%202023-03-31&id=1&court_cat=1&bb=1

хөрөнгийг нэхэмжлэгч Н.Т, Д.Э нар данснаас гаргуулах эрхтэй болохыг тогтоож, БГД, 2 дугаар хороолол, 4 дүгээр хороо, Төмөр замын X дугаар байрны X тоот, 18 м.кв талбай бүхий 1 өрөө байр, Хөвсгөл аймгийн Мөрөн хотын 1 дүгээр баг, X дугаар гудамжны X тоот, 0,9 га газар дээрх гарааш, контейнер болон Голомт банкны Г.Л-той хамтран эзэмшдэг ... тоот данснаас 54,421,484 төгрөгийг гаргуулж хариуцагч Б.Г, Ц.М нарт олгож сөрөг нэхэмжлэлийн зарим хэсгийг хангаж шийдвэрлэсэн.³⁸

Дүн шинжилгээ: Шүүх Г.Д-ийн нэр дээр бүртгэлтэй орон сууцууд, түүний дансанд буй мөнгөн хөрөнгүүдийг эцэг, эх, ах дүү нартайгаа хамтран ажилласнаас бий болсон буюу ИХ-ийн 477 дугаар зүйлийн 477.4-д заасан дундаа өмчлөх хөрөнгө гэж үзэх нотлох баримт хэрэгт байхгүй. Иймд анхан шатны шүүх Г.Д-ийн нэр дээр бүртгэлтэй дээрх хөрөнгүүдийг дундаа өмчлөх хөрөнгө гэж үзэхгүй талаар үндэслэл бүхий дүгнэлт хийжээ. Харин өвлүүлэгчийн төрүүлсэн эцэг, эх нь хууль ёсны өвлөгч болохыг нэхэмжлэгч үгүйсгээгүй байхад сөрөг нэхэмжлэлийг бүхэлд нь хэрэгсэхгүй болгосон нь буруу.

Өөрөөр хэлбэл, хариуцагч Б.Г, Ц.М болон түүний хүүхдүүд болох дээрх нэр бүхий этгээдүүдэд Г.Д-ийн нэр дээрх маргаж буй хөрөнгийг бий болоход гэрээгээр болон хуульд зааснаар хувь оролцуулсан болохоо баримтаар нотлоогүй тул ИХ-ийн 108 дугаар зүйлийн 108.1-ийн хөрөнгийг дундаа хэсгээр буюу хамтран өмчлөгч болсон гэж үзэх боломжгүй юм.

2.2.4. Шийдвэрийг хүчингүй болгож шийдвэрлэсэн

Тохиолдол 10: Нэхэмжлэгч Г.Я нь хариуцагч Р.Р, Л.Д нарт холбогдуулан өвлөх эрхийн гэрчилгээг хүчингүй болгуулж, БГД-ийн 20 дугаар хороо төмрийн захын зориулалттай 209 м.кв газрын

³⁸ Нийслэлийн иргэний хэргийн давж заалдах шатны шүүхийн 2020 оны 04 сарын 10-ны 834 дугаар магадлал. https://shuukh.mn/single_case/15346?daterange=2020-01-01%20-%202022-10-01&id=2&court_cat=1&bb=1




хууль ёсны өвлөгч болохыг тогтоолгох, хариуцагч Л.Д уг газрын хууль ёсны өвлөгч болохыг тогтоолгох, нэхэмжлэгч Г.Я өв хүлээн авахаас татгалзсан болохыг тогтоолгох тухай сөрөг нэхэмжлэлтэй.

Хэргийн товч агуулга: Нэхэмжлэгчийн өмгөөлөгч : Өвлүүлэгч Д.Г нь БГД, 20 дугаар хороо төмрийн захын зориулалттай 209 м.кв газрыг эзэмшдэг байсан. Д.Г нь 2018 оны 02 сарын 10-ны өдөр нас барсан. Түүний охин Г.Я Солонгос Улсад ажилладаг бөгөөд 2018 оны 10 сарын 01-ний өдөр Ш.Б, Б.С нарт, 2019 оны 01 сарын 17-ны өдөр Ш.Б, Б.Б нарт тус тус Д.Г-ийн нэр дээрх газрыг өвлөн авах тухай хүсэлтийг зохих байгууллага, Нотариатчидын танхим, нотариатчид бүртгүүлэх, хүсэлт гаргах, өвлөх эрхийн гэрчилгээ авах, өв нээхтэй холбоотой бүхий л эрхийг хэрэгжүүлэх итгэмжлэлийг 3 жилийн хугацаатай олгосон. Итгэмжлэлийн дагуу төлөөлөгчид нь дээрх газрын өв хүлээн авах хүсэлтийг СБД-ийн тойргийн нотариатч Г.Г-д 2019 оны 01 сарын 30-ны өдөр гаргасан бөгөөд гарын үсгийн бүртгэлийн дэвтрийн 17 дугаарт бүртгэж гэрчилсэн. Өвлөх эрхийн гэрчилгээ хэнд олгосон эсэх талаар лавлагаа авахаар МНТ-д хандахад БГД-ийн тойргийн нотариатч Р.Р нь өвлүүлэгчийн эх Л.Д-д өвлөх эрхийн гэрчилгээг хууль зөрчин олгосон байсан. Нотариатч хамт амьдарч байсан гэх оршин суугаа газрын тодорхойлолтыг үндэслэсэн гэж тайлбарладаг боловч хамт амьдардаг гэдгийг тодруулахгүйгээр олгосон нь түүний тайлбар, үзлэг хийсэн тэмдэглэлээр тогтоогдсон.

Мөн нэхэмжлэгчийн 2019 оны 01 сарын 30-ны өдөр СБД-ийн тойргийн нотариатч Г.Г маргаан бүхий хоёр газрыг өвлөн авахаар хүсэлт гаргасныг бүртгэж гэрчилсэн байхад шалгалгүйгээр шууд өвлөх эрхийн гэрчилгээ олгосон. Иймд өвлөх эрхийн гэрчилгээг хүчингүй болгож, Г.Я-г БГД, 20 дугаар хорооны 209 м.кв газрын хууль ёсны өвлөгчөөр тогтоож өгнө үү. Г.Я нь 2019 оны 01 сарын 30-ны өдөр буюу нэг жил болохоос арав хоногийн өмнө хүсэлт гаргасан тул сөрөг нэхэмжлэлийн шаардлага хуулийн шаардлага хангахгүй гэжээ.

Хариуцагч: Нэхэмжлэлийн шаардлагыг зөвшөөрөхгүй. Учир нь Д.Г 2013 оноос эхлэн ээж Л.Д-гийн хамт амьдарч байгаад 2018 оны 02 сарын 10-ны өдөр нас барсан. Д.Г нас барахаас өмнө 2018 оны 02 сарын 01-ний өдөр өөрийн эзэмшлийн 209 м.кв газрыг 2 хувааж, 100 м.кв газрыг иргэн С.Т, 109 м.кв газрыг ах Д.Г нарт шилжүүлж өгөхөөр Нийслэлийн газрын албанд өргөдөл гаргасан боловч зарим нэг бичиг баримт дутуугаас бүртгэлгүй буцаасан. Г.Я нь түүний өмнөх эхнэрийн охин бөгөөд Д.Г нь 2007 онд гэрлэлтээ цуцлуулсан. Д.Г-г нас барсан өдөр охинд нь мэдэгдэх гэхэд утас нь холбогдоогүй. Л.Д нь Д.Г-тэй хамт амьдардаг байсан тул нотариатч дээр очиж нэг жилийн дараа буюу 2019 оны 03 сард өвлөх эрхийн гэрчилгээ авсан. Нотариатч талийгаачийн эд хөрөнгийн талаар өв залгамжлах эрхтэй өөр этгээд байгаа талаар МНТ-аас лавлагаа авахад байхгүй гэсэн хариу ирүүлсэн тул эх Л.Д-д өвлөх эрхийн гэрчилгээ олгосон. Л.Д нь ИХ-д зааснаар хууль ёсны өвлөгч, харин Г.Я нь 2019 оны 03 сарын 06-нд өвлөх эрхийн гэрчилгээ гарах хүртэл ямар нэгэн хүсэлт гаргаж байгаагүй. Г.Я нь 2019 оны 01 сарын 17-ны өдөр өвлөх эрхийн гэрчилгээ олгох хүсэлт гаргах итгэмжлэлийг олгож явуулсан байдаг. Өөрсдийн гарын үсгийн үнэн зөвийг гэрчлүүлэх хүсэлт гаргасан болохоос биш өвлөх эрхийн гэрчилгээ авах хүсэлт гаргаагүй байна. Өв нээгдсэн газар БГД байхад итгэмжлэгдсэн төлөөлөгч нар СБД-ийн нотариатч дээр очиж гарын үсэг зуран түүнийгээ гэрчлүүлсэн байдаг. 2019 оны 01 сарын 17-ны өдөр Г.Я-аас Ш.Б, Б.Б нарт олгосон итгэмжлэл дээр гарын үсэг гэрчлүүлэх эрх олгогдоогүй.

Тиймээс СБД-ийн тойргийн нотариатч Г.Г-ээр гэрчлүүлсэн гарын үсгийн үнэн зөвийг гэрчлэх баримтыг Г.Я-гийн өмнөөс хийсэн гэж үзэх боломжгүй. Г.Я-г өв хүлээн авах буюу өвлөх эрхийн гэрчилгээ олгох хүсэлт гаргасан гэж үзэх баримт байхгүй. ИХ-ийн 528 дугаар зүйлийн 528.2-т бусад өвлөгчид нэг жилийн дотор өв нээгдсэн газрын нотариатад өв хүлээн авах буюу өвлөх эрхийн гэрчилгээ олгохыг хүсэж, өргөдөл гаргасан бол уг өвийг хүлээн авсан гэж үзнэ гэж зааснаар өв нээгдсэн газрын нотариатад гаргаагүй тул өв



хүлээн авсан гэж үзэх боломжгүй, өөрөөр хэлбэл өв хүлээн авах буюу өвлөх эрхийн гэрчилгээ олгох хүсэлт гаргаагүй тул өв хүлээн авахаас татгалзсан байна. Иймд БГД, 20 дугаар хороо төмрийн захын зориулалттай 209 м.кв газрын эзэмших эрхийн хууль ёсны өвлөгчөөр түүний ээж Л.Д-г тогтоож, Г.Я өв хүлээн авахаас татгалзсан болохыг тогтоож өгнө үү гэжээ.

Анхан шатны шүүхийн шийдвэр: НТХ-ийн 25 дугаар зүйлийн 25.1.4, ИХ-ийн 520 дугаар зүйлийн 520.1.1-д зааснаар БГД-ийн тойргийн нотариатч Р.Р-ийн 2019 оны 03 сарын 06-ны өдрийн 06 тоот өвлөх эрхийн гэрчилгээг хүчингүй болгож, Г.Я-г БГД, 20 хороо төмрийн захын газрын хууль ёсны өвлөгчөөр тогтоож, нэхэмжлэгч Г.Я-д холбогдох БГД, 20 хороо төмрийн захын газрын эзэмших эрхийн хууль ёсны өвлөгчөөр тогтоолгож, Г.Я-г өв хүлээн авахаас татгалзсан болохыг тогтоолгох хариуцагч М.О болон Л.Д-гийн сөрөг нэхэмжлэлийг бүхэлд нь хэрэгсэхгүй болгож шийдвэрлэжээ.³⁹

Давж заалдах шатны шүүхийн шийдвэр: БГД-ийн ИХАШШ-ийн 2020 оны 04 сарын 13-ны өдрийн 102/ШШ2020/01158 дугаар шийдвэрийг хүчингүй болгож, ИХ-ийн 528 дугаар зүйлийн 528.1, 528.2-т зааснаар Л.Д, Р.Р нарт холбогдох 2019 оны 03 сарын 06-ны өдрийн 06 тоот өвлөх эрхийн гэрчилгээг хүчингүй болгох, БГД-ийн 20 дугаар хороо төмрийн захын зориулалттай 209 м.кв газрын хууль ёсны өвлөгч болохыг тогтоолгох тухай Г.Я-гийн үндсэн нэхэмжлэл, Г.Я-д холбогдох БГД-ийн 20 дугаар хороо төмрийн захын зориулалттай 209 м.кв газрын хууль ёсны өвлөгч болохыг тогтоолгох, Г.Я-г өв хүлээн авахаас татгалзсан болохыг тогтоолгох тухай Л.Д, Р.Р нарын сөрөг нэхэмжлэлийг тус тус хэрэгсэхгүй болгож шийдвэрлэсэн.⁴⁰

³⁹ Баянгол дүүргийн Иргэний хэргийн анхан шатны шүүхийн 2020 оны 04 сарын 13-ны өдрийн 102/ШШ2020/01158 дугаар шийдвэр (102/2020/02038/и).
https://shuukh.mn/single_case/93019?daterange=2020-01-07%20-%202022-06-07&id=1&court_cat=1&bb=1

⁴⁰ Нийслэлийн иргэний хэргийн давж заалдах шатны шүүхийн 2020 оны 06 сарын 08-ны 1233 дугаар магадлал.
https://shuukh.mn/single_case/15569?daterange=2020-01-01%20-%202023-04-05&id=2&court_cat=1&bb=1

Дүн шинжилгээ: Анхан шатны шүүх маргаж буй үйл баримтын хууль зүйн үндэслэлийг зөв тодорхойлоогүйгээс хэрэгт цугларсан баримтыг тухайн хэрэгт хамааралтай, ач холбогдолтой, эргэлзээгүй, үнэн зөв талаас нь үнэлээгүй, улмаар хэрэглэвэл зохих хуулийг зөв тайлбарлаж хэрэглээгүй байх тул шийдвэр хууль ёсны бөгөөд үндэслэл бүхий байх ИХШХШТХ-ийн 116 дугаар зүйлийн 116.2-т заасан шаардлагыг хангаагүй гэж үзсэн байна. Өөрөөр хэлбэл, өвлүүлэгчтэй өвлөгч хамт амьдарч байсан тухай хорооны Засаг даргын тодорхойлолт болон өвлүүлэгч өвлөгч нар хамт амьдарч байсан тухай гэрчийн мэдүүлгийг нотлох баримтаар үнэлээгүй. Мөн өвлөгч өв хүлээн авахаас татгалзаагүй тул түүнийг ИХ-д зааснаар өвийг хүлээн авсан гэж үзнэ.

Б.Б, Ш.Б нар нь ИХ-ийн 528 дугаар зүйлийн 528.1-д заасан хугацаанд Г.Я-гийн өв хүлээн авах буюу өвлөх эрхийн гэрчилгээ олгуулах тухай өргөдлийг гаргасан байх боловч Нотариатын тухай хуулийн 43 дугаар зүйлийн 43.1-д зааснаар өв нээгдсэн газрын нотариатчид гаргаагүй харьяалал зөрчсөн гэж шүүх дүгнэжээ.

2.3. ХЯНАЛТЫН ШАТНЫ ШҮҮХИЙН ТОГТООЛД ХИЙСЭН ДҮН ШИНЖИЛГЭЭ

2020-2022 онд УДШ-ийн Иргэний хэргийн танхимаар өв залгамжлалтай холбоотой 8 хэргийг шийдвэрлэхдээ 2 хэргийн магадлалд өөрчлөлт оруулж, 2 хэргийн шийдвэр, магадлалыг хүчингүй болгож, дахин хэлэлцүүлэхээр анхан шатны шүүхэд буцааж, 1 хэргийн магадлалыг хүчингүй болгож, анхан шатны шүүхийн шийдвэрт өөрчлөлт оруулж, 3 хэргийн магадлалыг хэвээр үлдээж шийдвэрлэсэн байна. Үүнээс үзвэл давж заалдах шатны шүүхийн магадлалын 37,5 хувь нь хэвээр үлдэж, 62,5 хувь нь өөрчлөгдөж, хүчингүй болсон байна.


Өв залгамжлалтай холбоотой иргэний хэргийг шүүхээр хянан шийдвэрлэсэн сүүлийн 3 жилийн практикийг үзэхэд ИХАШШ-ээр хянан шийдвэрлэгдсэн ИХ-ийн “Өвлөх” гэсэн хэсгийн 515-538

дугаар зүйлд хамаарах хэрэг нь бусад заалтад хамаарах хэргээс цөөн тоотой, бага хувийг эзэлж байгаа ч хамрах хүрээ өргөн, шалгаж шийдвэрлэхэд цуглуулах баримт материал ихтэй, цаг хугацаа их шаарддаг, зохигчийн эрх, ашиг сонирхлыг ноцтой зөрчих магадлалттай байна. Харин гэрээслэлтэй холбоотой маргааны нэхэмжлэл бага байгаа нь иргэд гэрээслэл бичиж үлдээвэл өвлөгдөх хөрөнгөтэй холбоотой ямар нэгэн маргаан гарахгүй байх сайн талтай байгааг харуулж байна. Нөгөө талаас Монгол хүмүүс амьд сэрүүн байхдаа гэрээслэл үйлдэж, нотариатаар гэрчлүүлэх нь уламжлал, ёс заншил, сүсэг бишрэлтэй холбоотойгоор төдийлөн хийгдэхгүй байгаатай холбон үзэж болно.

Түүнчлэн анхан болон давж заалдах шатны шүүхийн зарим дүгнэлт хуульд нийцээгүйгээс шийдвэр, магадлал хууль ёсны бөгөөд үндэслэл бүхий байх шаардлагыг хангаагүй, ИХ-ийн 520, 528 дугаар зүйлийн холбогдох заалтыг зөрчсөн үндэслэлээр дийлэнх шийдвэр, магадлалд өөрчлөлт орж, хүчингүй болжээ.

УДШ-ээр шийдвэрлэгдсэн 8 хэргийн 87,5 хувь буюу 7 нь гэрээслэлээр өвлөх бус хуульд зааснаар өвлөх харилцаанаас үүссэн маргаан байна. Энэ төрлийн хэрэг маргааныг бууруулах нэг үндэслэл нь гэрээслэл үйлдэж, нотариатаар гэрчлүүлэх соёлыг хэвшүүлэх ажиллагаа юм.

График 12. Хяналтын шатны шүүхэд хянагдсан 4 хэрэг он тус бүрээр



2020-2022 оны хооронд өв залгамжлалтай холбоотой нийт 8 хэргийг УДШ-ээр шийдвэрлэснээс 4 хэргийг сонгон судаллаа. Үүнд:

2.3.1. Шийдвэр, магадлалыг хүчингүй болгож, дахин хэлэлцүүлэхээр анхан шатны шүүхэд буцаасан.

Тохиолдол 11: Тохиолдол 1, 9-д дурдсан Н.Т, Д.Э нарын нэхэмжлэлтэй, Б.Г, Ц.М нарт холбогдох хууль ёсны өвлөгчөөр тогтоолгох, өвлөгдөх эд хөрөнгөөс өөрт болон хүүхдүүдэд ногдох хэсгийг гаргуулах үндсэн нэхэмжлэлтэй, хариуцагч нь нэхэмжлэгчээс 568,464,964.75 төгрөг гаргуулах тухай сөрөг нэхэмжлэлтэй.

Хэргийн агуулга: Нэхэмжлэгч, нэхэмжлэгчийн итгэмжлэгдсэн төлөөлөгч Н.Т хяналтын журмаар гаргасан гомдолдоо: Магадлалын зарим хэсгийг эс зөвшөөрч гомдол гаргаж байна. Давж заалдах шатны шүүх анхан шатны шүүхийн шийдвэрт өөрчлөлт оруулахдаа нэхэмжлэлийн шаардлагын үндэслэлийг нэг бүрчлэн анхаарч үзээгүй, гэр бүлийн гишүүдийн хамтран өмчлөх дундын өмч болохыг тогтоолгох” шаардлагыг шийдвэрлээгүй орхигдуулсан гэж үзэж байна. Учир нь талийгаач болон түүний гэр бүлийн гишүүдийн хамтран өмчлөх дундын эд хөрөнгийг өөрсдийн хөрөнгө мэтээр хариуцагч нар нь нэхэмжлэл гаргаж, олон жилийн турш маргасан тул нэхэмжлэгчийн хувьд “эд хөрөнгүүдийг гэр бүлийн гишүүдийн хамтран өмчлөх дундын өмч болохыг тогтоолгох” зайлшгүй шаардлагатай байсан боловч уг шаардлагыг шийдвэрлээгүй орхигдуулсан. Уг шаардлагыг шийдвэрлэснээр гэр бүлийн хамтран өмчлөх дундын эд хөрөнгө болон өвийн хөрөнгийн ногдох хэсгийг хувааж шийдвэрлэхэд хялбар болох байсан. Давж заалдах шатны шүүх маргаан бүхий эд хөрөнгүүдийн зарим хэсэг болох талийгаачийн нэр дээрх арилжааны банкны данс дах мөнгөн хөрөнгө болон Хөвсгөл аймагт байгаа 1 ш машины гарааш, 1 ш контейнер зэргийг ямар ч үндэслэлгүйгээр шууд “талийгаачийн хуваарьт хөрөнгө байсан” гэж үзсэнийг эс зөвшөөрч байна. Нэхэмжлэгч болон талийгаач, тэдгээрийн дундаас гарсан 4 хүүхдүүдийн хамтран өмчлөх дундын эд хөрөнгөд нийт 11 төрлийн



үл хөдлөх эд хөрөнгө болон мөнгөн хөрөнгүүд бий. Эдгээрийн 4 нь буюу мөнгөн хөрөнгүүд нь талийгаач Г.Д-ийн нэр дээр бүртгэлтэй арилжааны банкны дансанд байдаг.

Түүнчлэн давж заалдах шатны шүүх анхан шатны шүүхийн шийдвэрийн тогтоох хэсэгт өөрчлөлт оруулж, эд хөрөнгийг хууль ёсны өвлөгч нарт хуваарилж шийдвэрлэхдээ Хас банкны 2 дансны мөнгөн дүнг хооронд сольж бичсэн. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагаа явагдахад энэхүү алдаа нь хүндрэл учруулж болзошгүй тул Тогтоох хэсгийн 1 дэх заалтын “Хас банкин дах 5000-3751-42 дугаартай хадгаламжийн данс дах 35,839,196 төгрөг” гэснийг “30,000,000 төгрөг” болгож, “5000-3765-44 дугаартай хадгаламжийн данс дах 30,000,000” төгрөг гэснийг 35,839,196 төгрөг” болгож өөрчилж өгнө үү. Нэхэмжлэгч нар нь өөрсдийн нэхэмжлэлийн шаардлагыг тодорхойлсон баримтаа хангалттай гаргасан, мөн хэрэгт цугларсан баримтын хэмжээнд хэргийг эцэслэн шийдвэрлэх боломжтой гэж үзэж байгаа тул шүүхийн шийдвэрийг хүчингүй болгож, анхан шатны шүүхэд буцаахгүйгээр, магадлалд дээр дурдсан үндэслэлээр өөрчлөлт оруулж эцэслэн шийдвэрлэж өгөхийг хичээнгүйлэн хүсэж байна. ИХШХШТХ-ийн 176.1.2-т заасан эрхийнхээ дагуу магадлалд өөрчлөлт оруулж, гаргасан зөрчлийг нь зөвтгөж өгнө үү гэжээ.

Хариуцагч Б.Г-ын итгэмжлэгдсэн төлөөлөгч З.Н, хариуцагч Ц.М нар хяналтын журмаар гаргасан гомдолдоо: Нийслэлийн ИХДЗШШ 2020 оны 04 дүгээр сарын 10-ны өдөр хянан хэлэлцээд 834 дугаартай магадлалыг хүлээн зөвшөөрөхгүй байх тул дараах үндэслэлээр хяналтын журмаар гомдол гаргаж байна.

Давж заалдах шатны шүүх шаардлага хангасан нотлох баримтыг үнэлээгүйгээс гадна аливаа тайлбар хийгээгүй. Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад талийгаачийн төрсөн дүү, хариуцагч нарын хүүхдүүд болох Г.Ж, Г.С, Г.Ч нар өөрийн итгэмжлэгдсэн төлөөлөгчөөрөө дамжуулан бие даасан шаардлага гаргаж хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцох хүсэлтийг анхан шатны шүүхэд гаргаж байсныг давж заалдах шатны

шүүх анхаараагүй. Анхан шатны шүүх ИХШХШТХ-ийн 29 дүгээр зүйлийн 29.1 дэх заалтыг баримтлаагүй ба баримтлахаас үндэслэлгүйгээр татгалзсан нь ИХШХШТХ, хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны журам ноцтойгоор зөрчигдсөн байхад давж заалдах шатны шүүх огт холбогдол өгөөгүй. Анхан шатны шүүх нэхэмжлэлийн шаардлага өөрчлөгдсөн болоод нэхэмжлэгч нэмэгдэж тусдаа нэхэмжлэлийн шаардлага гарган хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцсонтой холбоотойгоор улсын тэмдэгтийн хураамж төлөөгүй, чөлөөлөгдөх хүсэлт гаргаагүй байхад нэхэмжлэлийг хүлээн авсан. Сөрөг нэхэмжлэлийн хувьд маргаагүй Хөвсгөл аймагт байрлах газар, газар дээрх 2 байшин гэх эд хөрөнгөнүүдээс өвийн журмаар өөрт ногдох хэсгээ тус тус гаргуулан авах эрхтэй хэмээн үзэж байна. Гэтэл давж заалдах шатны шүүх үүнийг огт анзаараагүй буюу уг эд хөрөнгөнүүдээс өвлөгч нарт ногдох хэсгийг тооцоолон шийдээгүй. Анхан шатны шүүхийн хэлэлцүүлгийн явцад талийгаач нь хамтын бизнесийн үйл ажиллагаанаас өөр ажил хөдөлмөр эрхэлж байгаагүй нь илэрхий болсон бөгөөд ХУД-ийн шүүхийн шийдвэрээр хамтын бизнесийн үйл ажиллагаа эрхэлж байсныг тогтоосон, дансны хуулганаас талийгаачийн төрсөн дүү бөгөөд аав ээж нь мөнгө шилжүүлсэн болох нь шууд илэрхий байхад мөн хуульд хамтын бизнесийн үйл ажиллагаа эрхлэхдээ зохих гэрээг байгуулаагүй бол хувь тэнцүүлэн ногдох хэсгээ гаргуулан авна хэмээн зохицуулалт байхад давж заалдах шатны шүүх сөрөг нэхэмжлэлийг хангаагүй явдал нь шударга бус юм.

Иймд сөрөг нэхэмжлэлдээ маргаагүй 3 эд хөрөнгөнөөс өвийн журмаар өөрт ногдох хэсгээ тус тус гаргуулан, сөрөг нэхэмжлэлийн шаардлагыг бүхэлд нь ханган шийдвэрлэж, Нийслэлийн иргэний хэргийн давж заалдах шатны шүүхийн 2020 оны 04 дүгээр сарын 10-ны өдрийн 834 дугаартай магадлалд өөрчлөлт оруулж өгнө үү гэжээ.

Анхан шатны шүүхийн шийдвэр: Нэхэмжлэлийн шаардлагыг хангаж, хариуцагч нарын хамтран өмчлөх дундын эд хөрөнгөөс



568,464,964.75 төгрөг гаргуулах сөрөг нэхэмжлэлийг бүхэлд нь хэрэгсэхгүй болгож шийдвэрлэсэн.⁴¹

Давж заалдах шатны шүүхийн шийдвэр: Зохигчдын гаргасан давж заалдах гомдлыг хангаж, анхан шатны шүүхийн шийдвэрт өөрчлөлт оруулж шийдвэрлэсэн.⁴²

Хяналтын шатны шүүхийн шийдвэр: Хариуцагч Б.Г-ын итгэмжлэгдсэн төлөөлөгч З.Н, хариуцагч Ц.М нарын хяналтын журмаар гаргасан гомдлын зарим хэсгийг хангаж, БГД-ийн ИХАШШ-ийн 2020 оны 02 сарын 21-ний өдрийн 102/ШШ2020/00627 дугаар шийдвэр, Нийслэлийн ИХДЗШШ-ийн 2020 оны 04 сарын 10-ны өдрийн 834 дүгээр магадлалыг хүчингүй болгож, хэргийг дахин хэлэлцүүлэхээр анхан шатны шүүхэд буцааж шийдвэрлэсэн байна.⁴³

Дүн шинжилгээ: Хоёр шатны шүүх зохигчийн маргаж буй үндэслэлд дүгнэлт хийж, хэрэгт авагдсан нотлох баримтыг хуульд заасан журмын дагуу үнэлж чадаагүй, маргааны үйл баримтад хуулийг зөрүүтэй тайлбарлан хэрэглэснээс шийдвэр, магадлал хууль ёсны бөгөөд үндэслэл бүхий байх хуулийн шаардлагыг хангаагүй гэж дүгнэсэн байна.

Хариуцагч нараас маргаж буй эд хөрөнгө, мөнгөн хөрөнгийг гэр бүлийн хамтын үйл ажиллагааны үр дүнд бий болгосноо нотолж, энэ тухай ХУД-ийн ИХАШШ-ийн 2018.11.07-ны өдрийн 183/ШШ2018/02491 дүгээр шүүхийн хүчин төгөлдөр шийдвэрийг гаргаж өгсөн байхад анхан шатны шүүх хамтын үйл ажиллагааны үр дүнд бий болсон гэдэг нь тогтоогдоогүй гэж дүгнэн, үндсэн нэхэмжлэлийн

⁴¹ Баянгол дүүргийн Иргэний хэргийн анхан шатны шүүхийн 2020 оны 02 сарын 21-ний өдрийн 102/ШШ2020/00627 дугаар шийдвэр.

https://shuukh.mn/single_case/92020?start_date=&end_date=&id=1&court_cat=1&bb=1

⁴² Нийслэлийн Иргэний хэргийн давж заалдах шатны шүүхийн 2020 оны 04 сарын 10-ны өдрийн 834 дүгээр магадлал.

https://shuukh.mn/single_case/15346?start_date=&end_date=&id=2&court_cat=1&bb=1

⁴³ Улсын Дээд шүүхийн 2022 оны 02 сарын 22-ны 001/ХТ2022/00179 дугаар тогтоол (102/2015/04926/И).


https://shuukh.mn/single_case/9619?daterange=2022-01-01%20-%202022-08-29&id=3&court_cat=1&bb=1

шаардлагыг хангаж, сөрөг нэхэмжлэлийг хэрэгсэхгүй болгож шийдвэрлэсэн. Харин давж заалдах шатны шүүх энэ баримт нь хариуцагч нарын сөрөг нэхэмжлэлийн үндэслэлийг нотлохгүй. Г.Д-ийн хөрөнгө нь эцэг эх, ах дүү нартайгаа хамтран ажилласнаас бий болсон буюу ИХ-ийн 477 дугаар зүйлийн 477.4-д заасан дундаа өмчлөх хөрөнгө гэдгийг нотлох баримт хэрэгт байхгүй гэж дүгнэн, сөрөг нэхэмжлэлийн зарим хэсгийг хангасан өөрчлөлтийг шүүхийн шийдвэрт оруулж, данснаас тодорхой хэмжээний мөнгө гаргуулж хариуцагчид олгохоор шийдвэрлэсэн ч, хэрхэн яаж тооцсон нь ойлгомжгүй байна.

2.3.2.Магадлалыг хэвээр үлдээж, гомдлыг хангахгүй орхисон

Тохиолдол 12: Тохиолдол 10-т дурдсан иргэн Г-ийн нэхэмжлэлтэй, Р.Р, Л.Д нарт холбогдох өвлөх эрхийн гэрчилгээг хүчингүй болгох, өвлөгчөөр тогтоолгох тухай үндсэн нэхэмжлэлтэй, хариуцагч Л.Д нь өвлөгчөөр тогтоолгох, хариуцагч Р.Р нь нэхэмжлэгчийг өв хүлээн авахаас татгалзсан болохыг тогтоолгох тухай сөрөг нэхэмжлэлтэй.

Нэхэмжлэгчийн итгэмжлэгдсэн төлөөлөгч Б.Ц хяналтын журмаар гаргасан гомдолдоо “Давж заалдах шатны шүүх ИХШХШТХ-ийн 172 дугаар зүйлийн 172.2.1-д заасны дагуу шүүх хэрэглэвэл зохих хуулийг хэрэглээгүй, хуулийг буруу тайлбарлаж хэрэглэсэн нь шүүхийн шийдвэрт ноцтой нөлөөлжээ. ИХ-д өв залгамжлалыг 2 аргаар тодорхойлсон бөгөөд хуульд зааснаар өвлөгдөх талаар хууль тогтоогч зохицуулахдаа нэгдүгээр ээлжид тус хуулийн 520 дугаар зүйлийн 520.1-д зааснаар нас барагчийн буюу Л.Г-н эх, төрсөн охин нь нэгэн зэрэг өвлөх эрхтэй юм. Давж заалдах шатны шүүхийн магадлалд ИХШХШТХ-ийн 40 дүгээр зүйлийн 40.1, 40.2-т зааснаар нотлох баримтыг тал бүрээс нь бодитойгоор харьцуулан үзсэний үндсэн дээр үнэн зөв, эргэлзээгүй талаас нь үнэлэх нь хэрэгт ач холбогдолтой шийдвэрлэхэд чухал буюу гэрч Д.Г-н мэдүүлэг үнэн бодитой эсэхэд дүгнэлт хийгээгүй байна. Гэрчийн мэдүүлэг бусад баримтаар нотлогдоогүй буюу



баталгаажаагүй, үнэн зөв гэхэд эргэлзээтэй ба хариуцагчтай сонирхлын зөрчилтэй этгээдийн мэдүүлгийг бусад баримтаар нотлоогүй байхад үнэлсэн нь шийдвэрт нөлөөлжээ.

Мөн нотлох баримтууд байхад өвлөх эрхийг хүлээн авсан гэж тооцож байгаа нь хуулийг буруу тайлбарлаж хэрэглэсэн. Давж заалдах шатны шүүхийн магадлалд ...Иймд Р.Р нь ИХ-ийн 528 дугаар зүйлийн 528.1-д зааснаар өвлүүлэгчийг нас барах хүртэл хамт амьдарч байсан өвлөгч нь өв нээгдсэнээс хойш 3 сарын дотор өв хүлээн авахаас татгалзаагүй байх тул өвийг хүлээн авсан гэж дүгнэнэ... гэж дүгнэхдээ дээр дурдсан нотлох баримтыг дутуу үнэлсэн. Хариуцагч Р.Р нь нэхэмжлэгчтэй яг адил ИХ-ийн 528 дугаар зүйлийн 528.2-т заасан журмаар 1 жилийн дотор өвлөх талаар хүсэлтийг гаргах журам үйлчлэх ба хавтас хэрэгт МНТ-аас Р.Р нь маргаан бүхий хөрөнгийг 2007 оноос хойш өвийн нэгдсэн бүртгэлд өвлөх хүсэлтийг гаргаагүй гэж ирүүлсэн нь өвлөх эрхгүй гэдгийг харуулж байна. Маргаан бүхий газрын 000681331 тоот гэрчилгээнд тус газрыг Нийслэлийн СХД-ийн нутаг дэвсгэрт гэж, бодитоор БГД-ийн нутаг дэвсгэр гэж газрын байршлыг 2 өөр байдлаар заасан бөгөөд хэрэв ИХДЗШШ-ийн үзсэнээр өв нээгдэх газрыг СХД, БГД-ийн аль нь ч байж болохоор эргэлзээтэй байна. Учир нь нэхэмжлэгчийн хувьд тус газрын гэрчилгээнд байгаа байршлыг мэдэхээс СХД, БГД-ийн алийг мэдэх боломжгүй юм. Мөн НТХ-ийн 3 дугаар зүйлийн 3.1.1-д хууль дээдлэх зарчмыг нотариатч биелүүлэн ажиллах бөгөөд өв нээгдэх газарт хүсэлтийг гаргах талаар зөвлөх, эсхүл нотариатчийн хууль зөрчиж байгаа үйлдлийн үр дагавраар нэхэмжлэгчийн өвлөх эрхийг зөрчиж шийдвэрлэсэн нь Иргэний хууль тогтоомжийг буруу тайлбарлаж хэрэглэж байна. Иймд анхан шатны шүүхийн шийдвэрийг хэвээр үлдээж, давж заалдах шатны шүүхийн магадлалыг хүчингүй болгож өгнө үү” гэжээ.

Хяналтын шатны шүүхийн шийдвэр: Нийслэлийн ИХДЗШШ-ийн 2020 оны 06 сарын 08-ны өдрийн 1233 дугаар магадлалыг хэвээр үлдээж, хяналтын журмаар гаргасан

нэхэмжлэгчийн итгэмжлэгдсэн төлөөлөгч Б.Ц-ийн гомдлыг хангахгүй орхиж шийдвэрлэсэн.⁴⁴

Дүн шинжилгээ: Анхан шатны шүүх ИХ-ийн 528 дугаар зүйлийн 528.2-т нэхэмжлэгч нь өв хүлээн авах хүсэлтээ хуульд заасан хугацаанд гаргасан, нотариатын өвийн бүртгэлийн санд өв хүлээн авах хүсэлтээ бүртгүүлсэн зэргийг бодитой үнэлж хуулийг зөв тайлбарлан дүгнэлт гаргасан боловч өв нээгдсэн газар буюу БГД-ийн нотариатад хүсэлтээ гаргаагүй СБД-ийн нотариатад харьяалал зөрчин гаргасан байхад анхан шатны шүүх үүнийг зөв тодорхойлоогүй, өвлөгч өвлүүлэгчтэй хамт амьдарч байсан тухай гэрчийн мэдүүлгийг нотлох баримтаар үнэлээгүй зэрэг маргаж буй үйл баримтын хууль зүйн үндэслэлийг зөв тодорхойлоогүйгээс хэрэгт цугларсан баримтыг тухайн хэрэгт хамааралтай, ач холбогдолтой талаас нь үнэлээгүй, улмаар хэрэглэвэл зохих хуулийг зөв тайлбарлаж хэрэглээгүй гэж давж заалдах шатны шүүх анхан шатны шүүхийн шийдвэрт дүгнэлт хийсэн.

Давж заалдах шатны шүүх өөрийн эрх хэмжээний хүрээнд шийдвэрийг хүчингүй болгож, үндсэн болон сөрөг нэхэмжлэлийг бүхэлд нь хэрэгсэхгүй болгож шийдвэрлэжээ.

ИХ-ийн 528 дугаар зүйлийн 528.2-т дурдсан өв хүлээн авах хүсэлт нь 531 дүгээр зүйлийн 531.1-д заасан өвлөх эрхийн гэрчилгээ олгох хүсэлтээс ялгаатай бөгөөд өв хүлээн авах хүсэлтийг нотариатын тойрог харгалзахгүй аль ч нотариатч, нотариатчийн үүрэг гүйцэтгэгчид хандан гэрчлүүлэх боломжтой. Харин өвлөх эрхийн гэрчилгээ олгох хүсэлтийг ИХ-н 519 дүгээр зүйлийн 519.1, НТХ-ийн 43 дугаар зүйлийн 43.1-д зааснаар өв нээгдсэн газрын нотариатчид нотариатгүй газар баг, сумын Засаг даргад гаргахаар байгааг анхаарах хэрэгтэй.

⁴⁴ Улсын Дээд шүүхийн 2022 оны 05 сарын 24-ний 001/ХТ2022/00636 дугаар тогтоол (102/2019/02038/И). https://shuukh.mn/single_case/9534?daterange=2022-01-01%20-%202022-08-29&id=3&court_cat=1&bb=1

2.3.3.Магадлалыг хүчингүй болгож, анхан шатны шүүхийн шийдвэрт өөрчлөлт оруулсан

Тохиолдол 13: Нэхэмжлэгч Д.Т, Ц.Ц нар хариуцагч Л.Г, Г.С нарт холбогдуулан түрээсийн орлогоос ногдох хэсэгт 38,568,192 төгрөг гаргуулах, өргөтгөлийн өмчлөгчөөр тогтоолгох, маргаан бүхий үл хөдлөх хөрөнгийн тохижилтын төлбөр 7,000,000 төгрөг гаргуулах, Ц.Ц нь 30,000,000 төгрөгийн хэлцлээс татгалзаж, өвлөх эрхээ сэргээлгэх, орон сууцны хамтран өмчлөгчөөр тогтоолгох, орон сууц болон өргөтгөлийг чөлөөлүүлэхээр нэхэмжилснийг хариуцагч нар эс зөвшөөрч, Д.Т-д олгосон өвлөх эрхийн гэрчилгээг хүчингүй болгуулж, 1,110,237 төгрөг гаргуулах сөрөг нэхэмжлэлтэй.

Хэргийн товч агуулга: Нэхэмжлэгч Д.Т шүүхэд гаргасан нэхэмжлэл болон шүүх хуралдаанд гаргасан тайлбартаа “Маргаан бүхий байрыг манай гэр бүлийн хөрөнгөөр худалдаж авсан. Манай аав Д.Д, ээж Ц.Ц нар 1993 онд хүүхдүүдийн хамтаар гэр бүлийн Өвлөх урлахуй хувиараа эрхлэх аж ахуйг байгуулж, гурилын цех, барааны савангийн үйлдвэрлэл зэргээс компанийн хөрөнгө босгосон. 2001 оноос Архангай аймгийн Жаргалант, Дундговь аймгийн Адаацаг сумдад жолооны курс ажиллуулсан. Маргаан бүхий байрны ихэнх төлбөрийг жолооны курсээс олж, үлдсэн төлбөрийг ББСБ-аас зээлж, төлсөн. Би 2005 онд дээрх байранд өргөтгөл барьсан. Тухайн үед талийгаач эгч Хадгаламж зээлийн хоршоонд байр барьцаалж 5.000.000 төгрөг авч, Н.Д, Н.Э гэх хүмүүст алдсан. Эгчийг нас барах үед байрны гэрчилгээ Хадгаламж зээлийн хоршооны барьцаанд байсан. Сүүлд Л.Г ээж бид хоёртой тохирч, байрыг баараар ажиллуулъя гээд Н.Б-д газар өгч, нэг өрөө байр авахаар болсон. Тэр байраа надад, ээжид 30.000.000 төгрөг өгье, харин аавыг өмчлөх эрхээсээ татгалзаач гэж хэлсэн. Л.Г дээрх тохиролцоогоор амласан зүйлээ өгч чадахгүй, асуудлыг шүүхээр шийдүүл гэснээр шүүхэд нэхэмжлэл гаргасан.

Эгч маань 2005 оны 12 сарын 14-ны өдөр нас барсан. Анх байр, өргөтгөлийг жолооны курсийн сургалтын танхимаар тохижуул, 2006 оны 5, 6 сараас баарны зориулалтаар өөрчилж, засварласан.

Аавын УАЗ-469 машиныг 4.500.000 төгрөгөөр зарж, эгч Д.Ту-аас 2.500.000 төгрөг авч нийт 7.000.000 төгрөгөөр тохижилт, засварын ажлыг би 4, 5 сар зарцуулж хийсэн ч Л.Г, Ж.М нар зөвшөөрөлгүй өөрчилж, цэцэрлэг болгосон, бусдад түрээслэх, цэцэрлэгийн үйл ажиллагаа явуулах зэргээр нэлээн ашиг олсон. Тухайн үед Н.Б байраа өгөхгүй байна, хэсэг хугацаанд хүлээгээч гэсээр 2009 оны 2 сар хүрсэн. 2009 онд өв нээгдэж, Л.Г-ийн хамт нотариат орж, Үл хөдлөх хөрөнгийн улсын бүртгэлийн газарт мэдүүлэг бөглөж, 4 хүний нэр дээр гэрчилгээ авсан. 2007 оны 11 сард Л.Г ээжид 30.000.000 төгрөг өгнө гэж амласан ч өгөхгүй болохоор нь 2008 онд хэлцлийг нотариатаар баталгаажуулсан. Энэ байрыг бий болгоход миний маш их хөдөлмөр орсон, харин Л.Г ганц ч тоосго нэмэрлээгүй.

2007 оны 11 сард Л.Г надад нэг өрөө байр өгнө гэсэн учраас би маргаан бүхий байрыг хүлээлгэж өгсөн. Гэтэл байраа өгөхгүй 2009 оны 02 сар хүртэл явсан. Дараа нь Н.Б олдохоо больчихлоо, шүүхээр эрэн сурвалжлуулж шийдвэр гаргуулсан гэсэн. Байр өгөх тохиролцоо бүтэхгүй болохоор хэн хэн нь зөвшөөрч би гэрчилгээнд нэрээ оруулсан. 2011 оны 08 сарын 05-ны өдөр манай аав өвчний улмаас нас барсан. 2009 оны 02 сарын 12-ны өдрөөс өнөөдрийг хүртэлх хугацаанд байрнаас өөрт ногдох үр шим, олох байсан түрээсийн орлого 18.187.000 төгрөгийн 20 хувь 3.637.400 төгрөг, 2013 оны 08 сараас хойших цэцэрлэгийн сарын түрээсийн дундаж орлого 2.392.520 төгрөгийг 73 сард үргэлжлүүлж 174.653.960 төгрөг болно. Уг мөнгөний 20 хувь 34.930.792 төгрөг, нийт 38.568.192 төгрөгийг хариуцагч нараас гаргуулах. БГД-ийн 19 дүгээр хороо, 4 дүгээр хороолол 60 дугаар байрны X тоот 2 өрөө орон сууц, өргөтгөлийн хууль ёсны өмчлөгчөөр Ц.Ц, Д.Т нарыг тогтоох. Хууль ёсны өмчлөгч Д.Т миний зөвшөөрөлгүй маргаан бүхий орон сууц, өргөтгөлд хариуцагч Л.Г өнөөдрийг хүртэл цэцэрлэгийн үйл ажиллагаа явуулсан тул хариуцагч нарын эзэмшлээс чөлөөлүүлэх. 2008 оны 1 дүгээр сарын 21-ний өдөр Ц.Ц өвлөгчөөс татгалзсаны хариу төлбөрт Л.Г-өөс 30.000.000 төгрөг авахаар тохирч байгуулсан хэлцлээс татгалзаж өмчлөх эрхээ сэргээлгэх, нэхэмжлэгч нар нь маргаан



бүхий байр, өргөтгөлөөс өөрт ногдох үр шим, бусдад түрээслүүлсэн орлого болох 18.187.000 төгрөгийн 20 хувь болох 3.637.400 төгрөг, 2014 оны 08 сараас өнөөдрийг хүртэл 73 сар, сарын 2.392.520 төгрөг, нийт хугацаагаар үржүүлж 174.653.960 төгрөгийн 20 хувь болох 34.930.792 төгрөг, нийт 38.568.192 төгрөгийг хариуцагч Л.Г-өөс гаргуулж өгнө үү. Мөн Би 2007 онд 7.000.000 төгрөг гаргаж орон сууцыг кафе, баарны зориулалтаар тохижуулсныг надад хэлэхгүйгээр өөрчилж, Д.Т миний зөвшөөрөлгүй, гуравдагч этгээд Ж.М нь цэцэрлэгийн зориулалтаар үйл ажиллагаа явуулсан тул 7.000.000 төгрөгийг гаргуулж өгнө үү” гэв.

Нэхэмжлэгч Д.Т сөрөг нэхэмжлэлд холбогдуулан гаргасан тайлбартаа: “2007 оны 11 сард би Л.Г-т байр хүлээлгэж өгсөн. Үл хөдлөх хөрөнгийн улсын бүртгэлийн газраас манайх руу залгаж байрны өвлөх эрхийн гэрчилгээнд нэрээ оруулахгүй татгалзсан юм уу гэж асуухад бид нар өвлөх эрхээсээ татгалзаагүй гэхэд ирж уулз гэсэн. Л.Г бид нарт мэдэгдэхгүйгээр Эрүүгийн хэргийн асуудал дуусаагүй байхад Хадгаламж зээлийн хоршоонд 3.000.000 төгрөг өгч, гэрчилгээ авсан байсан. Л.Г нь Үл хөдлөх хөрөнгийн улсын бүртгэлийн газраас гэрчилгээ гаргуулахаар хандсан байсан. 3 хүний нэр дээр өвлөх эрхийн гэрчилгээ гарсныг би мэдээгүй. Харилцан тохиролцож, 2009 оны 02 сард нотариат дээр очиж, өвлөх эрхийн гэрчилгээ авсан. Нотариатаас 4 хүний нэр дээр гарах гэрчилгээний материал өгсөн. Тухайн үед Үл хөдлөх хөрөнгийн газрын ажилтан бүрдүүлсэн материал хуулийн шаардлага хангасан байна гээд авсан.

Намайг 2007 оны 11 сард Л.Г-т байр хүлээлгэж өгөхөд сөрөг нэхэмжлэлийн шаардлага болох СӨХ, орон сууцны конторын ашиглалтын зардал 1,110,237 төгрөгийн өр төлбөр байгаагүй. Сөрөг нэхэмжлэлийн шаардлагыг бүхэлд нь хүлээн зөвшөөрөхгүй гэв.”

Анхан шатны шүүхийн шийдвэр: ИХ-ийн 108 дугаар зүйлийн 108.2, 108.5, 106 дугаар зүйлийн 106.2, 528 дугаар зүйлийн 528.5 дах заалтыг баримтлан хариуцагч Л.Г, Г.С нараас 4,546,750 төгрөг гаргуулж, нэхэмжлэгч Д.Т-д олгож, Д.Т-ийн нэхэмжлэлийн

шаардлагаас түрээсийн орлогод 34,021,442 төгрөг гаргуулах, өргөтгөлийн өмчлөгчөөр тогтоолгох, үл хөдлөх хөрөнгийн тохижилтын зардал 7,000,000 төгрөг гаргуулах, орон сууц болон өргөтгөлийг чөлөөлүүлэх, Ц.Ц-гийн 30,000,000 төгрөгийн хэлцлээс татгалзаж, өвлөх эрхээ сэргээлгэх, Улаанбаатар хот, БГД-ийн 19 дүгээр хороо, 4 дүгээр хороолол, 60 дугаар байрны Х тоот хаягт байрлах, эрхийн улсын бүртгэлийн Y-220... дугаартай, 35 м.кв талбайтай, 2 өрөө орон сууцны болон өргөтгөлийн өмчлөгчөөр тогтоолгох, түрээсийн орлогоос 38,568,192 төгрөг гаргуулах, орон сууц болон өргөтгөлийг чөлөөлүүлэх тухай нэхэмжлэлийн шаардлагыг бүхэлд нь, хариуцагч Л.Г-ийн Д.Т-д холбогдох, өв залгамжлах эрхийн гэрчилгээг хүчингүй болгуулж, 1,110,237 төгрөг гаргуулах сөрөг нэхэмжлэлийг бүхэлд нь тус тус хэрэгсэхгүй болгож шийдвэрлэсэн.⁴⁵

Давж заалдах шатны шүүхийн шийдвэр: БГД-ийн ИХАШШ-ийн 2019 оны 09 сарын 23-ны өдрийн 102/ШШ2019/02502 дугаар шийдвэрийн тогтоох хэсгийн 1 дэх заалтыг ИХ-ийн 108 дугаар зүйлийн 108.2, 106 дугаар зүйлийн 106.1-д заасан үндэслэлгүй тул хариуцагч Г.С, Л.Г нарт холбогдох, түрээсийн орлогоос ногдох хэсэгт Д.Т-д 38,568,192 төгрөг гаргуулах, өргөтгөлийн өмчлөгчөөр тогтоолгох, маргаан бүхий үл хөдлөх хөрөнгийн тохижилтын төлбөр 7,000,000 төгрөг гаргуулах, Ц.Ц нь 30,000,000 төгрөгийн хэлцлээс татгалзаж, өвлөх эрхээ сэргээлгэх, орон сууцны хамтран өмчлөгчөөр тогтоолгох, түрээсийн орлогоос ногдох хэсэгт 38,568,192 төгрөг гаргуулах, өргөтгөлийн өмчлөгчөөр тогтоолгох, орон сууц болон өргөтгөлийг чөлөөлүүлэх Д.Т, Ц.Ц нарын нэхэмжлэлийг бүхэлд нь хэрэгсэхгүй болгож, Д.Т-д олгосон өв залгамжлах эрхийн гэрчилгээг хүчингүй болгуулах сөрөг нэхэмжлэлийг хангаж, сөрөг нэхэмжлэлээс үлдэх 1,110,237 төгрөг гаргуулах шаардлагыг хэрэгсэхгүй болгох гэж өөрчилж, шийдвэрийн тогтоох хэсгийн 2

⁴⁵ Баянгол дүүргийн Иргэний хэргийн анхан шатны шүүхийн 2019 оны 09 сарын 23-ны өдрийн 102/ШШ2019/02502 дугаар шийдвэр.

https://shuukh.mn/single_case/89371?start_date=&end_date=&id=1&court_cat=1&bb=1



дах заалтад “...хариуцагч нараас 87,698 төгрөгийг гаргуулан Д.Т-д олгосугай.” гэснийг хасаж, “Д.Т, Ц.Ц нараас 358,565 төгрөгийг гаргуулан Л.Г, Г.С нарт олгосугай.” гэсэн заалт нэмж өөрчлөн, шийдвэрийн бусад хэсгийг хэвээр үлдээж шийдвэрлэжээ.⁴⁶

Хяналтын шатны шүүхийн шийдвэр: Нэхэмжлэгч нарын хяналтын журмаар гаргасан гомдлыг шүүх хянаад Нийслэлийн ИХДЗШШ-ийн 2020 оны 01 сарын 08-ны өдрийн 62 дугаар магадлалыг хүчингүй болгож, БГД-ийн ИХАШШ-ийн 2019 оны 09 сарын 23-ны өдрийн 102/ШШ2019/02502 дугаар шийдвэрийн Тогтоох хэсгийн 1 дэх заалтын 106 дугаар зүйлийн 106.2 гэснийг 106 дугаар зүйлийн 106.1 гэж өөрчлөн, шийдвэрийн бусад заалтыг хэвээр үлдээж, нэхэмжлэгч нарын хяналтын гомдлын зарим хэсгийг хангаж шийдвэрлэжээ.⁴⁷

Дүн шинжилгээ: Давж заалдах шатны шүүх сөрөг нэхэмжлэлийг бүхэлд нь хэрэгсэхгүй болгосон нь үндэслэлгүй бөгөөд өвлөх эрхийн гэрчилгээнд нэхэмжлэгч Д.Т-ийн нэрийг нэмж оруулсан үндэслэлийг нотариатч тайлбарлаагүй, хариуцагч Л.Г нь нэхэмжлэгч нарын шахалт шаардлагаар өвлөх эрхийн гэрчилгээнд Д.Т-ийн нэр нэмэгдэж бичигдсэн гэснийг нэхэмжлэгч нар няцааж нотлоогүй гэж дүгнэн шүүхийн шийдвэрт өөрчлөлт оруулсан нь ИХШХШТХ-ийн 6 дугаар зүйлийн 6.1, 40 дүгээр зүйлийн 40.2-т заасныг зөрчсөн гэх үндэслэлээр магадлалыг хүчингүй болгосон байна.

Харин анхан шатны шүүх хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг ИХШХШТХ-д заасан журмын дагуу явуулж, хэрэгт авагдсан нотлох баримтыг тухайн хэрэгт хамааралтай, ач холбогдолтой, үнэн зөв, эргэлзээгүй талаас нь үнэлж, маргаанд ИХ-ийн холбогдох

⁴⁶ Нийслэлийн Иргэний хэргийн давж заалдах шатны шүүхийн 2020 оны 01 сарын 08-ны өдрийн 62 дугаар магадлал. https://shuukh.mn/single_case/14216?daterange=2020-01-08%20-%202020-01-08&id=2&court_cat=1&bb=1


⁴⁷ Улсын Дээд шүүхийн 2021 оны 10 сарын 19-ний 001/ХТ2021/01256 дугаар тогтоол (102/2014/03183/И). https://shuukh.mn/single_case/8744?daterange=2021-01-01%20-%202021-12-31&id=3&court_cat=1&bb=1

зохицуулалтыг зөв тайлбарлан хэрэглэсэн байна гэж үзэж анхан шатны шүүхийн шийдвэрт өөрчлөлт оруулж, магадлалыг хүчингүй болгон нэхэмжлэгч нарын хяналтын журмаар гаргасан гомдлын зарим хэсгийг ханган шийдвэрлэжээ.

2.3.4. Магадлалд өөрчлөлт оруулсан

Тохиолдол 14: Нэхэмжлэгч Д.Э, Б.Э, Б.Б нар хариуцагч Ч.А, Л.Х, Д.Э нарт холбогдуулан 2005 оны 01 дүгээр сарын 17-ны өдрийн 01 дугаартай гэрээслэл гэрчилсэн нотариатын үйлдлийг хүчингүй болгуулж, гэрээслэлийг хүчин төгөлдөр бусад тооцуулах, Ч.А, Л.Х нарт өвлөх эрхийн гэрчилгээ олгосон 2010 оны 4 сарын 30-ны өдрийн 12 дугаар болон 2016 оны 11 сарын 14-ний өдрийн 74 дугаар өвлөх эрхийн гэрчилгээ олгосон нотариатын үйлдэл болон тус 12, 74 дугаартай гэрчилгээнүүдийг хүчингүй болгуулах, Ч.А, Л.Х нарт холбогдуулан Д.Э, Б.Э, Б.Б нар Л.Б-гийн хууль ёсны өвлөгч болохыг тогтоолгож, орон сууцны Л.Б-д ногдох 20 хувийг өвлөх эрхтэй болохыг тогтоолгох, Л.Х, Л.С нар нь С.Л-гийн хууль ёсны өвлөгч болохыг тогтоолгож, орон сууцны С.Л-д ногдох 20 хувийг өвлөх эрхтэй болохыг тогтоолгох, Ч.А, Л.Х нарын хууль бус эзэмшлээс орон сууцыг гаргуулж, нэхэмжлэгч нарт хүлээлгэн өгөхийг даалгуулах, орон сууцыг 2015 оны 8 сараас 2017 оны 11 сар хүртэл хугацаанд нийт 28 сар бусдад хөлслүүлж олсон ашгийн 80 хувь буюу 3,360,000 төгрөгийг гаргуулах үндсэн нэхэмжлэлтэй, хариуцагч Ч.А-ын орон сууцны хамтран өмчлөгчөөр тогтоолгох сөрөг нэхэмжлэлтэй.

Хэргийн товч агуулга: Нэхэмжлэгч Б.Б-гийн төлөөлөгч Б.Э шүүхэд гаргасан нэхэмжлэл болон шүүх хуралдаанд гаргасан тайлбартаа: Миний аав 2004 оны 10 сарын 25-ны өдөр гэнэтийн ослоор Хөх нуурт загас барьж байгаад живсэн. Удалгүй өвөө минь 2005 оны 02 сарын 11-ны өдөр буюу 83 настайдаа өөд болсон. Бид анх шүүхэд нэхэмжлэл гаргахдаа 2005 оны 01 сарын 17-ны өдөр өвөө Л нь Дорнод аймгийн нотариатын газарт хүү Л.Б-гийн оногдох хувийг зээ хүү Ао-д эзэмшүүлэх хүсэлтэй гэсэн утга бүхий хүсэлт



гаргасныг Дорнод аймгийн нотариатч Б.Б хүлээн авч 01 дугаартай гэрээслэл гэгч баримтыг үйлдэж гарын үсгийн үнэн зөвийг гэрчилсэн байсныг хариуцагч талаас нотлох баримтаар гаргаж өгөх үед мэдсэн. Нотариатч Б.Б нь дээрх 01 дугаартай гэрээслэл гэх бичгийг үндэслэн Ч.Ао-д 2010 оны 4 сарын 30-ны өдөр 12 дугаартай өвлөх эрхийн гэрчилгээ, Л.Х-д 2016 оны 11 сарын 14-ний өдөр 74 дугаартай өвлөх эрхийн гэрчилгээг тус тус олгосон байсан. Бидний зүгээс өвөө Л маань 2005 оны 01 сарын 17-ны өдөр гарын үсэг зурсан гэх дээрх хүсэлтийг өөрийн гараар бичээгүй, өвөөгийн гарын үсэг биш, цаашлаад түүний хүсэл зориг мөн байсан гэдэгт маш их эргэлзэж нэхэмжлэл гаргасан гэжээ.

Хариуцагч Л.Х шүүхэд болон шүүх хуралдаанд гаргасан тайлбартаа: Би улсын бүртгэлийн газарт бичиг баримтаа бүртгүүлэх гэж Дорнод аймагт ирээд 4, 5 хонож байтал эгчийн минь бие муудсан. Миний эгч Д 2016 оны 06 сарын 24-ний өдөр нас барсан учир улсын бүртгэлийн газарт бичгээ бүртгүүлж чадахгүй явсан. Эгчийн минь ажил явдал өнгөрөөд 3 хоногийн үйл хийж байх үед Д.Э, Б.Б, Б.Э нар хотоос ирсэн гээд миний хүү А-той уулзсан байсан. Миний хүү нэхэмжлэгч талын нэхэмжлэлийг надад авчирч үзүүлсэн. Дүү, аав хоёрыг минь нас барахад оршуулгын ажилд нь оролцоогүй, эгчийн минь ажил явдал өнгөрөөд 3 хонож байхад байрны талаар нэхэмжлэл гаргасанд гомдолтой, мөн 1971 онд нас барсан гэсэн ээжийн минь гэрчилгээ энэ байрны асуудалтай ямар холбоотойг би ойлгохгүй байна. Би дүүгээ нас барснаас хойш Д.Э, Б.Б, Б.Э нартай ганц ч уулзаагүй. Дүүгээ эхнэрээсээ салахад нь би гэрт нь нэг нэгээр тавилга зөөж тохижуулж өгсөн. Иймд нэхэмжлэгч талд аавынхаа байрыг өгөхгүй. Нэхэмжлэлийн шаардлагыг бүхэлд нь хүлээн зөвшөөрөхгүй байна гэв.

Хариуцагч Ч.А шүүх хуралдаанд гаргасан тайлбартаа: Өвөөгөө нас барах хүртэл би хажууд байсан. Д.Э, Б.Б, Б.Э нарыг өвөө дээр ирснийг нэг ч удаа хараагүй. Э нь өвөөг эргэж ирсэн гэж хуулийн өмнө худлаа мэдүүлэг өгч байгаад гайхаж байна. Миний бие болон манай эхнэр, дүү энэ бүгдийг гэрчилнэ. Нэхэмжлэлийн шаардлагыг бүхэлд нь хүлээн зөвшөөрөхгүй байна гэв.

Анхан шатны шүүхийн шийдвэр: ИХ-ийн 9 дүгээр зүйлийн 9.4.7, 1997 оны НТХ-ийн 23 дугаар зүйлийн 23.2, 2011 оны НТХ-ийн 43 дугаар зүйлийн 43.1-д зааснаар 2005 оны 01 сарын 17-ны өдрийн 01 дугаартай гэрээслэлийг гэрчилсэн нотариатын үйлдлийг хүчингүй болгон, мөн 2010 оны 04 сарын 30-ны өдрийн 12 дугаартай өвлөх эрхийн гэрчилгээ олгосон нотариатын үйлдэл болон 12 дугаартай өвлөх эрхийн гэрчилгээг хүчингүй болгож, нэхэмжлэлээс 2016 оны 11 сарын 14-ний өдрийн 74 дугаартай өвлөх эрхийн гэрчилгээг олгосон нотариатын үйлдэл болон 74 дугаартай өвлөх эрхийн гэрчилгээг тус тус хүчингүй болгуулах тухай нэхэмжлэлийн шаардлагыг хэрэгсэхгүй болгож шийдвэрлэсэн.⁴⁸

Давж заалдах шатны шүүхийн шийдвэр: Дорнод аймаг дах Сум дундын ИХАШШ-ийн 2019 оны 03 сарын 14-ний өдрийн 138/ШШ2019/00205 дугаар шийдвэрийг хэвээр үлдээж, хариуцагчийн өмгөөлөгч Х.Д-ийн давж заалдах гомдлыг хангахгүй орхиж шийдвэрлэсэн байна.⁴⁹


Хяналтын шатны шүүхийн шийдвэр: Дорнод аймгийн Эрүү, Иргэний хэргийн давж заалдах шатны шүүхийн 2019 оны 05 сарын 29-ний өдрийн 201/МА2019/00011 дугаар магадлалын тогтоох хэсгийн 1 дэх заалт, Дорнод аймаг дах сум дундын ИХАШШ-ийн 2019 оны 03 сарын 14-ний өдрийн 138/ШШ2019/00205 дугаар шийдвэрийн тогтоох хэсгийн 1 дэх заалтыг “ИХ-ийн 9 дүгээр зүйлийн 9.4.7, НТХ-ийн 23 дугаар зүйлийн 23.2, 32 дугаар зүйлийн 32.3 (1997 оны), НТХ-ийн 43 дугаар зүйлийн 43.1-д (2011 оны) зааснаар Д.Э, Б.Э, Б.Б нарын Л.Х, Ч.А, Д.Э нарт холбогдуулан гаргасан С.Лх-гийн 2005 оны 01 сарын 17-ны өдрийн 01 тоот гэрээслэлийг гэрчилсэн болон Ч.А, Л.Х нарт өвлөх эрхийн гэрчилгээ олгосон нотариатын

⁴⁸ Дорнод аймаг дах Сум дундын иргэний хэргийн анхан шатны шүүхийн 2019 оны 03 сарын 14-ний өдрийн 138/ШШ2019/00205 дугаар шийдвэр.

https://shuukh.mn/single_case/83576?start_date=&end_date=&id=1&court_cat=1&bb=1

⁴⁹ Дорнод аймгийн Эрүү, Иргэний хэргийн давж заалдах шатны шүүхийн 2019 оны 05 сарын 29-ний өдрийн 201/МА2019/00011 дугаар магадлал.

https://shuukh.mn/single_case/12171?daterange=2019-01-01%20-%202020-11-07&id=2&court_cat=1&bb=1



үйлдлүүдийг тус тус хүчингүй болгож, С.Лх-гийн гэрээслэл, Ч.Ао-д олгосон 2010 оны 04 сарын 30-ны өдрийн 12 дугаартай өвлөх эрхийн гэрчилгээ, Л.Х-д олгосон 2016 оны 11 сарын 14-ний өдрийн 74 дугаартай өвлөх эрхийн гэрчилгээг тус тус хүчин төгөлдөр бус болохыг тогтоосугай.” гэж,

Тогтоох хэсгийн 2 дах заалтыг “ИХ-ийн 520 дугаар зүйлийн 520.1.1, 528 дугаар зүйлийн 528.3-д зааснаар Дорнод аймгийн Хэрлэн сумын 9 дүгээр баг 1 дүгээр байрны 66 тоот орон сууцны Л.Бо-д оногдох 20 хувийг нэхэмжлэгч Д.Э, Б.Э, Б.Б нар өвлөх эрхтэй болохыг тогтоолгох нэхэмжлэлийг хэрэгсэхгүй болгосугай.” гэж,

Тогтоох хэсгийн 3 дах заалтыг “ИХ-ийн 532 дугаар зүйлийн 532.1-д зааснаар Дорнод аймгийн Хэрлэн сумын 9 дүгээр баг 1 дүгээр байрны Х тоот орон сууцыг хариуцагч Л.Х-гийн эзэмшилд үлдээж, Л.Х-гээс 18,874,200 төгрөг гаргуулж, нэхэмжлэгч Д.Э, Б.Э, Б.Б нарт олгож, хариуцагч Ч.А-ын орон сууцны хамтран өмчлөгчөөр тогтоолгох тухай сөрөг нэхэмжлэлийг хэрэгсэхгүй болгосугай.” гэж,

Тогтоох хэсгийн 4 дэх заалтыг “ИХ-ийн 106 дугаар зүйлийн 106.1, 492 дугаар зүйлийн 492.1.1-д зааснаар хариуцагч Ч.А, Л.Х нарын хууль бус эзэмшлээс Дорнод аймгийн Хэрлэн сумын 9 дүгээр баг 1 дүгээр байрны Х тоот орон сууцыг чөлөөлүүлж, нэхэмжлэгч нарт хүлээлгэн өгөхийг хариуцагч нарт даалгах болон хариуцагч нараас 3,360,000 төгрөг гаргуулахыг хүссэн нэхэмжлэгч Д.Э, Б.Э, Б.Б нарын нэхэмжлэлийн шаардлагыг тус тус хэрэгсэхгүй болгосугай.” гэж шийдвэрлэжээ.⁵⁰

Дүн шинжилгээ: Анхан болон давж заалдах шатны шүүх орон сууцны Л.Б-д ногдох 20 хувийг Д.Э, Б.Э, Б.Б нар өвлөх эрхтэй гэж дүгнэхдээ зөвхөн хаягийн бүртгэлийг үндэслэж, тэднийг уг байранд нас барагчтай хамт амьдарч байсан гэж үзсэн нь үндэслэл муутай болохоос гадна, Л.Б-г нас барах үед түүнтэй түүний эцэг С.Л

⁵⁰ Улсын Дээд шүүхийн 2020 оны 10 сарын 08-ны 001/ХТ2020/00666 дугаар тогтоол (138/2016/01280/И). https://shuukh.mn/single_case/7191?daterange=2020-01-01%20-%202020-12-31&id=3&court_cat=1&bb=1

хамт амьдарч байсан нөхцөл байдал, өвлөх эрхийн талаар дүгнэлт хийгээгүй орхигдуулжээ. Маргааны зүйл болж буй үл хөдлөх эд хөрөнгө 5 өмчлөгчтэй байсан ба тэдгээрийн хоёр нь нас барсан, гурван өмчлөгч нь энэ хэргийн нэхэмжлэгч болж, хариуцагч Л.Х 40 хувийн өв залгамжлалаар өмчлөх эрхтэй болсон, зохигч орон сууцыг хэн эзэмших талаар маргаж буй тул эзэмших этгээдийг тодорхойлох шаардлагатай. С.Л-г нас барсан 2005 оноос хойш орон сууцыг Ч.А, Л.Х нар эзэмшиж, ашиглаж байгааг харгалзан орон сууцыг Л.Х-д, орон сууцны үнэлгээг үндэслэн Л.Х-гээс нийт 18,874,200 төгрөг гаргуулж нэхэмжлэгч нарт олгох нь ИХ-ийн 520 дугаар зүйлийн 520.6, 532 дугаар зүйлийн 532.1-д заасныг зөрчихгүй.

Түүнчлэн хариуцагч Ч.А нь нас барагч С.Л-гийн зээ хүү мөн боловч гэрээслэл хүчин төгөлдөр бус байгаагаас өвөг эцгийн орон сууцны ногдох хэсгээс өвлөх үндэслэлгүй, хуульд зааснаар тэргүүн ээлжид нас барагчийн охин Л.Х өвлөх эрхтэй гэж үзсэн учир орон сууцны хамтран өмчлөгчөөр тогтоолгох хариуцагч Ч.А-ын сөрөг нэхэмжлэлийг хэрэгсэхгүй болгохдоо шүүх ИХ-ийн холбогдох зохицуулалтыг зөв тайлбарлан хэрэглэсэн байна.

Анхан шатны шүүх үндсэн ба сөрөг нэхэмжлэлийн агуулгыг зөв, оновчтой тодорхойлоогүйг давж заалдах шатны шүүх зөвтгөөгүй, шийдвэрийг хэвээр үлдээсэн нь хуульд нийцээгүй тул уг алдааг залруулах нь зүйтэй байна гэж хяналтын шатны шүүх дүгнэж шийдвэр, магадлалд өөрчлөлт оруулж шийдвэрлэжээ.

ДҮГНЭЛТ

2020 оны 01 сарын 01-нээс 2022 оны 10 сарын 01-ний өдрийн хооронд өв залгамжлалтай холбоотой иргэний хэрэг маргааныг хянан шийдвэрлэсэн анхан, давж заалдах, хяналтын шатны шүүхийн шийдвэрт дүн шинжилгээ хийж, судалгааны үр дүнг үндэслэн дор дурдсан дүгнэлт, саналыг боловсруулав. Үүнд:

1. Хүн амьдралынхаа туршид тодорхой хэмжээний хөрөнгө бий болгож, өсгөн үржүүлж, нас барахаасаа өмнө хэн нэгэнд түүнийгээ гэрээслэн үлдээх эсхүл хууль ёсны өвлөгчид нь өвлөн авдаг. Иргэний эрх зүйн онолын хувьд өв залгамжлал нь түүний нэг салбар эрх зүй, эрх залгамжлалын нэг төрөл бөгөөд хүний өмчлөх эрх үүсэх нэг үндэслэл болно. Өв залгамжлалын эрх зүй нь иргэний эд хөрөнгө, эрхийн харилцааг зохицуулж буй агуулгаараа үндсэн хуулийн төдийгүй иргэний эрх зүйд томоохон байр суурь эзэлдэг. Өв залгамжлалын онцлог нь өвлүүлэгч нас барснаар үүсэж, түүний хөрөнгө болон эрхийг өвлөгчид шилжүүлэх харилцааг зохицуулж, өв хөрөнгө, эрх шилжсэнээр дуусгавар болдог. Монгол Улсын хууль тогтоомжид иргэний өв залгамжлуулах эрхийг баталгаатай эдлэхээр хуульчилж, түүнийг хуульд зааснаар буюу гэрээслэлээр гүйцэтгэхээр зохицуулсан. Өвлүүлэгчийн аливаа хөрөнгийг түүний хууль ёсны өвлөгчид өвлөн авах эрхтэй байдаг бол гэрээслэлээр хууль ёсны өвлөгчөөс гадна хууль ёсны бус өвлөгчид өв хүлээн авах эрхтэй байдаг. Өөрөөр хэлбэл, хууль ёсны өв залгамжлалыг өөрчлөх нэг арга зам нь гэрээслэл юм.

2. Өв залгамжлалыг баталгаажуулах эрх хэмжээ нотариатчид олгогдсон бөгөөд түүний олгосон өвлөх эрхийн гэрчилгээг үндэслэн

өв залгамжлалыг гүйцэтгэдэг. Нотариатчийн үйл ажиллагаа хуульд нийцсэн байх нь өв залгамжлал бүрэн хэрэгжих нөхцөлийг бүрдүүлж, өвийн маргаан гарахаас урьдчилан сэргийлнэ.

Шүүхийн шийдвэр нь өвлөх эрхийн гэрчилгээ хуульд нийцсэн эсэхийг хянан магадалж буй ажиллагаа юм. Өв залгамжлалын эрх зүйн харилцааг ИХ-иас гадна НТХ, Нотариатын үйлдэл хийх заавраар нарийвчлан зохицуулдаг. Эдгээр хэм хэмжээний уялдаа холбоог хангах, нэг мөр зөв ойлгож, хэрэгжүүлэх асуудал учир дутагдалтай байна. Үүнийг нотариатч өвлөх эрхийн гэрчилгээ олгосон практик, түүнтэй холбоотой иргэний хэрэг маргааныг шийдвэрлэсэн шүүхийн шийдвэрээс үзэж болно. Дээрх хугацаанд Монгол Улсын шүүхийн шийдвэрийн цахим сан (shuukh.mn)-гийн маргааны төрөл гэсэн хэсгээс “өвлөх” гэж хайлт хийхэд 54 шийдвэр илэрч байгаа нь энэ хугацаанд олгосон нийт 43652⁵¹ өвлөх эрхийн гэрчилгээний 0,12 хувийг эзэлж байна. Үүнээс үзвэл өвлөх эрхийн гэрчилгээ олгох нотариатчийн үйл ажиллагаа зарчмын хувьд хуульд нийцэж байгааг илэрхийлнэ.

Мөн шүүхээс дийлэнх тохиолдолд өвлөх эрхийн гэрчилгээг хүчин төгөлдөр хэвээр үлдээж шийдвэрлэсэн байгаа нь өвлөх эрхийн гэрчилгээ хууль ёсны дагуу олгогдсоныг илтгэх ч арга зүйн хувьд харилцан адилгүй байна.

Иргэний хэрэг маргаанд өв залгамжлалтай холбоотой хэрэг маш бага хувь эзэлж байгаа ч олон өвлөгчтэй, нотлох баримт, цаг хугацаа, ажиллагаа их шаарддаг, өвлөгдөх эд хөрөнгийн үнэ цэн өндөр, түүний үнэлгээ маргаан дагуулдаг зэрэг нь цаашид хэрэг маргааны тоог нэмэгдүүлэх хандлагатай байна.

3. Хяналтын шатны шүүхээс хэргийг дахин хэлэлцүүлэхээр буцаах, магадлалд өөрчлөлт оруулах зэрэг нь анхан болон давж заалдах шатны шүүхээс хууль тогтоомжийг зөрүүтэй буюу эрх зүйн өөр үр дагавар үүсгэж хэрэглэснийг илтгэж, түүнийг хяналтын журмаар хянан хэлэлцэх нөхцөлийг бүрдүүлж байна.

⁵¹ Монголын Нотариатчдын танхимын 2020, 2021, 2022 оны жилийн эцсийн тайлан.



Дээрх сан (<https://shuukh.mn>)-гийн маргааны төрөл гэсэн хэсгээс “өвлөх” гэж хайлт хийхэд өв залгамжлалтай холбоотой нийт 36 магадлал илэрснээс 4 магадлалд дүн шинжилгээ хийж үзэхэд 1 хэргийн шийдвэрийг хүчингүй болгож, дахин хэлэлцүүлэхээр буцааж, 1 шийдвэрийг хэвээр үлдээж, гомдлыг хангахгүй орхиж, 1 шийдвэрт өөрчлөлт оруулж, 1 шийдвэрийг хүчингүй болгож шийдвэрлэжээ. Үүнээс үзвэл зарим тохиолдолд шүүгчид хуулийг буруу тайлбарлаж, хууль хэрэглээний алдаа гаргасан гэж үзэж болохоор байна.

4. Гэрээслэлтэй холбоотой маргаан бага байгаа нь нэг талаас иргэд гэрээслэлийн талаарх ойлголт хангалтгүй, эрх зүйн соёл төлөвшөөгүй, нөгөө талаас монголчуудын уламжлал, шашин, шүтлэгтэй холбоотой гэж үзэж болох юм. Судалгааны хугацаанд нотариатчаар 89 гэрээслэл гэрчлүүлсэн байна.⁵² Эл байдалд эрх зүйн хөгжил, иргэд хувийн өмчтэй болсон цаг хугацаа, хөрөнгийн үнэ цэнэ хамааралтай ч, гэрээслэлийн ач холбогдлыг олон нийтэд сурталчлан таниулж өвийн маргаанаас урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх замаар эрх зүйн соёлыг төлөвшүүлэх ажил хангалтгүй байгааг илэрхийлнэ.

5. Иргэний хуулийн 528 дугаар зүйлийн 528.2-т “Энэ хуулийн 528.1-д зааснаас бусад өвлөгчид нь өв нээгдсэнээс хойш нэг жилийн дотор хуульд заасны дагуу өвлөгдсөн эд хөрөнгийг эзэмдэн авсан буюу эрхлэн удирдсан, эсхүл нотариат буюу баг, сумын Засаг даргад өв хүлээн авах буюу өвлөх эрхийн гэрчилгээ олгохыг хүсэж, өргөдөл гаргасан байвал уг өвийг хүлээн авсан гэж үзнэ.” гэж зааснаас үзвэл мөн хуулийн 520 дугаар зүйлд заасан хууль ёсны өвлөгчид тооцогдох бүх өвлөгчид өв хүлээн авах хүсэлт гаргах эрхтэй гэж ойлгож болохоор байна. Үүнийг үндэслэн бусад өвлөгчид 1 жилийн дотор өв хүлээн авах өргөдөл гаргавал нотариатч, баг, сумын Засаг дарга түүнийг заавал хүлээн авч, тэдгээрийн өв хүлээн авах эрхийг хангах ёстой. Өвлөх эрхийн гэрчилгээг нэг жил өнгөрсний дараа

⁵² Монголын Нотариатчдын танхимын 2020, 2021, 2022 оны жилийн эцсийн тайлан.


олгодог Иргэний хуулийн зохицуулалтыг иргэд нэг жилийн дараа нотариатад хандах юм байна хэмээн буруу ойлгож, дээрх хугацаа өнгөрсний дараа ханддаг. Тэр үед тухайн этгээд хуулиар өв хүлээн авахаас татгалзсанд тооцогдсон байх нь шүүхэд маргаан үүсгэх нөхцөлийг бүрдүүлж байгааг анхаарах шаардлагатай байна.

6. Олон улсын туршлагаар ихэнх орнууд хууль ёсны өвлөгчийн асуудалд анхаарал хандуулж өвлөгчдийн эрэмбийг тогтоож байгааг цаашид нарийвчлан судлах шаардлагатай байна. Өвлүүлэгчийг асран тэтгэхэд зонхилох хувь нэмэр оруулсан хууль ёсны өвлөгч бус этгээдийг өвлөгчөөр тооцохоос гадна өвлүүлэгчтэй хамт амьдарч асарсан, түүнийг асран тэтгэхэд гол үүрэг гүйцэтгэсэн, амьдралын нөхцөл онцгой бэрхшээлтэй хүнд, хөдөлмөрийн чадваргүй өвлөгчийг илүү анхааран үздэг сайн туршлага байна.

Шүүхээр шийдвэрлэгдсэн хэргүүдээс үзэхэд хууль ёсны өвлөгчид нь өвлөгч болохоо тогтоолгохоор шүүхэд хандаж байгаа нь хууль ёсны өвлөгчдийг нэр зааж хуульчилсан ч, өвлүүлэгчтэй хамт амьдарч байсан болон хамт амьдраагүй гэж зохицуулсантай холбоотой. Практикт тэдгээрийг тогтоож буй тухайн засаг захиргааны нэгжийн өрхийн ам бүлийн тодорхойлолт учир дутагдалтай байгаа нь хууль ёсны өвлөгчдийг тогтооход бэрхшээл үүсгэдэг.

Шүүх нэхэмжлэлийн шаардлагыг зөв тодорхойлоогүй, шийдвэрлэвэл зохих асуудлыг шийдвэрлээгүй, хууль хэрэглээний алдаа гаргаж, анхан, давж заалдах болон хяналтын шатны шүүх хуулийг өөрөөр тайлбарлан хэрэглэж байгаа нь хэргийг хуульд заасны дагуу үнэн зөв шийдвэрлэхэд шууд нөлөө үзүүлж, гурван шатны шүүхээр хянуулах нөхцөлийг бүрдүүлж байна.

Эцэст нь дүгнэхэд өв залгамжлалтай холбоотой иргэний хэрэг маргааныг хянан шийдвэрлэж буй анхан шатны шүүхийн практик нэг мөр тогтоогүй байгаа тул давж заалдах шатны шүүх шийдвэрийг хянан үзэх, хэрэв алдаатай гарсан бол түүнийг зөвтгөх замаар хууль хэрэглээний нэгдмэл байдлыг ханган ажиллаж байгаа ч



хяналтын шатны шүүхийн шийдвэрээс үзэхэд хууль хэрэглээний алдаа байсаар байгааг анхааралдаа авч, хуулийг нэг мөр зөв ойлгож, хэрэглэх практик тогтоох шаардлага байсаар байна.

Хүснэгт 1. Өвлөх эрхийн гэрчилгээ олгосон болон гэрээслэлээр гэрчилсэн үйлдлийн тоо

Он	Өвлөх эрхийн гэрчилгээний тоо	Гэрээслэлээр гэрчилсэн үйлдлийн тоо
2020	10429	23
2021	18235	78
2022	14988	28
Нийт	43652	129

САНАЛ

1. УДШ-ээс Монгол Улсын шүүхийн тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.4-д заасны дагуу өв залгамжлалтай холбоотой харилцааг зохицуулсан хэм хэмжээг нэг мөр ойлгож хэрэглэх практик тогтоох, хуульчлагдсан нэр томъёог зөв хэрэглэх, Монгол хэлний зөв бичих дүрмийг анхаарч, утга найруулгыг засан сайжруулах шаардлагатай байна. Тухайлбал, Өвлүүлэгч бус талийгаач, нас барагч, өв хүлээн авах хугацааг сунгах бус өвлөх хугацааг сэргээх, оногдох хэсэг бус ногдох хэсэг, өвлүүлэгч нас барснаар өв нээгдсэн байтал өвлөх эрхийн гэрчилгээ олгосноор өв нээгдсэн мэт тайлбарлаж хэрэглэх нь үгийн утга болоод өгүүлбэрийн агуулгад нөлөөлөхүйц байгаа нь зохисгүй юм.

Мөн хуулийн 25.8.4-д заасны дагуу өвийн маргааныг хянан шийдвэрлэсэн шүүхийн шийдвэрт үндэслэн хуулийг нэг мөр, зөв ойлгож хэрэглэх албан ёсны тайлбар гаргах;

2. Өвлүүлэгчийг асран тэтгэсэн этгээдийг хууль ёсны өвлөгчийн адил тооцох, өвлүүлэгчийг асрахад тухайн өвлөгч гол үүрэг гүйцэтгэсэн, өвлөгчийн амьдралын нөхцөл байдал онцгой хүнд, хөдөлмөрийн чадваргүй байдал зэргийг харгалзан үзэж өвлөгдөх

- эд хөрөнгийг хуваарилах эрх зүйн зохицуулалтыг Монгол Улсын Иргэний хуулийн 520 дугаар зүйлд нэмэлт, өөрчлөлт оруулах замаар хуульчлах;
3. Хууль ёсны өвлөгчид өвийн хөрөнгийг хуваарилах хэлцэл байгуулж, нотариатаар гэрчлүүлэн түүнийг үндэслэн өвийг хуваах нь маргаан гарахгүй байх нөхцөлийг бүрдүүлдэг. Нотариатч энэ талаар өвлөгч нарт зөвлөж, олон нийтэд сурталчлан таниулах;
 4. Гэрээслэл үйлдэх замаар өвлөгдөх хөрөнгийг хуваарилах нь өвийн хөрөнгөтэй холбоотой маргаан гарахаас урьдчилан сэргийлэх нэг арга зам болохыг сурталчлах;
 5. Нотариатчаас өвлөх эрхийн гэрчилгээ олгох үйлдлийг нэг мөр болгох зорилгоор шүүхийн байгууллагатай хамтарсан сургалт зохион байгуулж, нэгдсэн ойлголтод хүрэх;
 6. Нотариатын тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.3-д заасны дагуу Иргэний хуулийн 520 дугаар зүйлийн 520.1.1, 520.1.2, 520.2-т заасан өвлөгчид өв хүлээн авах, эсхүл татгалзах хүсэлтээ хуульд заасан хугацаанд гаргахыг зөвлөх, түүнийг гэрчлэх замаар өвлөгчдийн эрхийг хангах;
 7. Өмчлөгч өөрийн хүсэл зоригийн дагуу эд хөрөнгөө бусдад гэрээслэх, өвлөгчид өвлүүлэгчийн үүргийг өвлөн авсан хөрөнгийн хэмжээнд хүлээх зэрэг өв залгамжлалтай холбоотой хууль тогтоомжийг олон нийтэд сурталчлан таниулж, өвийн маргаанаас урьдчилан сэргийлэх ажлыг зохион байгуулах.

АШИГЛАСАН ЭХ СУРВАЛЖ

Эрх зүйн баримт бичиг

1. Монгол Улсын Үндсэн хууль, 1992.
2. Монгол Улсын Иргэний хууль, 2002.
3. Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль, 2002.
4. Нотариатын тухай хууль, 2011.
5. Нотариатын үйлдэл хийх заавар, 2011.
6. Монгол Улсын олон улсын гэрээ, иргэний хэрэг хянан шийдвэрлэх тухай конвенц, 1999.
7. Монгол Улсын Дээд Шүүхийн 2008 оны 02 сарын 28-ны 09 дугаар “Монгол Улсын олон улсын гэрээ болон олон улсын эрх зүйн нийтээр хүлээн зөвшөөрсөн хэм хэмжээ, зарчмыг шүүхийн практикт хэрэглэх тухай тогтоол.

Ном, бүтээл

1. А.Оюунчимэг, Нотариатын үйлдэл (мэргэжлийн аргачилсан зөвлөмж), 2007.
2. Б.Амарсанаа, З.Сүхбаатар, Б.Батбаяр, БНХАУ-ын Иргэний хууль, анхны хэвлэл, 2021.
3. Б.Алтангэрэл, Ж.Амарсанаа, Ч.Баттөмөр, Ц.Сарантуяа, Б.Чимид, Олон улсын гэрээний тухай Монгол Улсын хуулийн дэлгэрэнгүй тайлбар, 2011.
4. Б.Буянхишиг, ХБНГУ-ын Иргэний хууль (кодификацийн бүрэн эх) анхны хэвлэл, 2017.
5. Б.Улаанбаатар, Монгол Улс дах гэрээслэл: асуудал, шинэчлэлт, 2017.

6. Б.Урангоо, Япон Улсын Иргэний хуулийн орчуулга, 2018.
7. Г.Эрдэнэбаяр, Ч.Баянжаргал, Хууль ёсны өвлөх эрх зүй, 2009.
8. М.Ванчигмаа, Гэрээслэлээр өвлөх эрх, 2005.
9. Майкл Х.Роффэр, Дэлхийн эрх зүйн түүх, 2020.
10. Монсудар хэвлэлийн газар, Монгол хэлний хураангуй тайлбар толь, 2009.
11. Өв залгамжлал, гэрээслэлтэй холбоотой маргааныг шүүхээр хянан шийдвэрлэсэн байдал, Түүвэр эмхэтгэл, Монголын Нотариатчдын танхим Сонгинохайрхан дүүргийн салбар, 2015.
12. С.Нарангэрэл, Монгол Улсын хууль зүйн нэвтэрхий толь бичиг, 2021.
13. Ц.Оюунаа, Олон улсын хувийн эрх зүй, Сурах бичиг, Анхны хэвлэл, 2015.
14. Ц.Оюунаа, Өв залгамжлалын эрх зүй-Олон улсын хувийн эрх зүйн хүрээн дэх судалгаа, 2017.
15. Ц.Оюунаа, Олон улсын хувийн эрх зүй, сурах бичиг анхны хэвлэл, 2017.
16. Ц.Оюунаа, Өв залгамжлалын эрх зүй, Олон улсын хувийн эрх зүйн хүрээн дэх судалгаа, 2018.
17. Ц.Оюунаа, Эртний Ромын хувийн эрх зүй дэх өвлөх эрх, түүхэн тойм, 2016.
18. Ц.Оюунаа, Эртний Ромын хувийн эрх зүй дэх өвлөлийн асуудал-Ромын эрх зүйн түүхэн сурвалж III хэвлэл, 2022.
19. Ч.Баянжаргал, Нотариатын эрх зүйн асуудал, харьцуулсан судалгаа (Докторын судалгааны ажил), 2021.
20. Хууль зүйн Үндэсний хүрээлэн, Холбооны Бүгд Найрамдах Герман Улсын Үндсэн хууль, 2020.
21. Я.Цэвэл, Монгол хэлний товч тайлбар толь, 2021.
22. ШУА, Д.Төмөртоогоо, Монгол хэлний үгийн гаралын тайлбар толь, 2018.
23. Шүүхийн ерөнхий зөвлөл, “Шүүхийн судалгаа, мэдээлэл, сургалтын хүрээлэн, Шүүхийн шийдвэрт дүн шинжилгээ хийх аргачлал”, 2015.



Гадаад хэл дээрх бүтээл

1. Дигести Юстиниана: пер с лат./отв.ред Л.Л.Кофанов, Т. 7. Полу том 2, М. Статут 2005.
2. Ред. И.Б.Новицкий, И.С.Перетерский, Римское частное право, М. Юристь. 1997.

Цахим хуудас

1. <https://shuukh.mn>
2. <https://legalinfo.mn>
3. Бүгд Найрамдах Франц Улсын Иргэний хууль, 1803
https://www.legifrance.gouv.fr/codes/section_lc/LEGIT-EXT000006070721/LEGISCTA000006136269/#LEGISCTA000006136269

Шүүхийн шийдвэр

1. <https://shuukh.mn/cases/1/1>
2. https://shuukh.mn/single_case/92020?daterange=2020-01-01%20-%202023-03-31&id=1&court_cat=1&bb=1
3. https://shuukh.mn/single_case/107916?daterange=2021-01-01%20-%202021-12-31&id=1&court_cat=1&bb=1
4. https://shuukh.mn/single_case/114461?daterange=2020-01-01%20-%202023-03-31&id=1&court_cat=1&bb=1
5. https://shuukh.mn/single_case/110270?daterange=2021-01-01%20-%202021-12-31&id=1&court_cat=1&bb=1
6. https://shuukh.mn/single_case/108313?daterange=2021-12-01%20-%202021-12-24&id=1&court_cat=1&bb=1
7. https://shuukh.mn/single_case/108955?daterange=2021-01-01%20-%202021-12-31&id=1&court_cat=1&bb=1

8. https://shuukh.mn/single_case/108712?start_date=&end_date=&id=1&court_cat=1&bb=1
9. https://shuukh.mn/single_case/20123?daterange=2020-01-01%20-%202023-04-02&id=2&court_cat=1&bb=1
10. https://shuukh.mn/single_case/97655?start_date=&end_date=&id=1&court_cat=1&bb=1
11. https://shuukh.mn/single_case/17403?daterange=2020-01-01%20-%202022-10-01&id=2&court_cat=1&bb=1
12. https://shuukh.mn/single_case/92020?start_date=&end_date=&id=1&court_cat=1&bb=1
13. https://shuukh.mn/single_case/15346?daterange=2020-01-01%20-%202022-10-01&id=2&court_cat=1&bb=1
14. https://shuukh.mn/single_case/93019?daterange=2020-01-07%20-%202022-06-07&id=1&court_cat=1&bb=1
15. https://shuukh.mn/single_case/15569?daterange=2020-01-01%20-%202023-04-05&id=2&court_cat=1&bb=1
16. https://shuukh.mn/single_case/92020?start_date=&end_date=&id=1&court_cat=1&bb=1
17. https://shuukh.mn/single_case/15346?start_date=&end_date=&id=2&court_cat=1&bb=1
18. https://shuukh.mn/single_case/9619?daterange=2022-01-01%20-%202022-08-29&id=3&court_cat=1&bb=1
19. https://shuukh.mn/single_case/93019?daterange=2020-04-13%20-%202020-04-20&id=1&court_cat=1&bb=1
20. https://shuukh.mn/single_case/15569?start_date=&end_date=&id=2&court_cat=1&bb=1
21. https://shuukh.mn/single_case/9534?daterange=2022-01-01%20-%202022-08-29&id=3&court_cat=1&bb=1



22. https://shuukh.mn/single_case/89371?start_date=&end_date=&id=1&court_cat=1&bb=1
23. https://shuukh.mn/single_case/14216?daterange=2020-01-08%20-%202020-01-08&id=2&court_cat=1&bb=1
24. https://shuukh.mn/single_case/8744?daterange=2021-01-01%20-%202021-12-31&id=3&court_cat=1&bb=1
25. https://shuukh.mn/single_case/83576?start_date=&end_date=&id=1&court_cat=1&bb=1
26. https://shuukh.mn/single_case/12171?daterange=2019-01-01%20-%202020-11-07&id=2&court_cat=1&bb=1
27. https://shuukh.mn/single_case/7191?daterange=2020-01-01%20-%202020-12-31&id=3&court_cat=1&bb=1

ШҮҮХИЙН ШИЙДВЭРИЙН СУДАЛГАА ХАРИУЦСАН РЕДАКЦЫН ЗӨВЛӨЛИЙН ТАНИЛЦУУЛГА

ДАШНЯМЫН ЗОЛЖАРГАЛ (LL.M.)
GREEN CLIMATE FUND, АХЛАХ ХУУЛЬЧ



Д.Золжаргал нь Монголын санхүү, хөрөнгийн зах зээлийн чадварлаг мэргэжилтнүүдийн нэг бөгөөд компанийн эрх зүй, эрчим хүч, эрдэс баялгийн салбараар мэргэшсэн хуульч юм. ОУ-ын байгууллагад уригдан ажиллахаасаа өмнө Монголын томоохон арилжааны банк, бүс нутагт хүлээн зөвшөөрөгдсөн тэргүүлэх хуулийн фирм байгуулж ажилласан туршлагатай.

МУИС-ийн ХЗС-ийн Олон улсын эрх зүйн бакалавр, 2004 онд АНУ-ын Оклахомагийн их сургуулийг Бизнесийн удирдлагын магистр, Харвардын их сургуулийн Хуулийн сургуулийг Хууль зүйн магистр зэрэгтэй тус тус дүүргэсэн.

СҮХЭЭГИЙН БИЛГҮҮН (LL.M.)
ХУУЛЬ ЭРХ ЗҮЙН ХӨГЖЛИЙН ХҮРЭЭЛЭНГИЙН СУДЛААЧ



С.Билгүүн нь хууль зүйн судалгаа, сургалт, шүүхийн захиргааны чиглэлээр ажилладаг.

Монгол Улсын Их Сургуулийн Хууль зүйн сургуульд суралцаж, “Монгол Улсад эрх зүйн зайлшгүй процессыг төлөвшүүлэх нь” сэдвээр, Япон улсын Кьюсюгийн их сургуульд суралцаж “Монгол Улс дах нийтийн ашиг сонирхлыг шүүхэд төлөөлөн хамгаалах тогтолцоог бэхжүүлэх нь” сэдвээр хууль зүйн магистрын зэрэг тус тус хамгаалсан.

Харьцуулсан эрх зүй, хүний эрхийн чиглэлээр судалгаа хийдэг.

**НАРАНЧУЛУУНЫ ОТГОНЧИМЭГ (LL.M.)
ШҮҮХИЙН ЕРӨНХИЙ ЗӨВЛӨЛИЙН ГИШҮҮН**



Н.Отгончимэг нь Захиргааны эрх зүйн чиглэлээр мэргэшсэн хуульч, судлаач бөгөөд УИХ-ын тамгын газар, Олон улсын хөгжлийн хөтөлбөрүүдэд зөвлөх хийх зэргээр мэргэжлээрээ 22 жил ажилласан туршлагатай хуульч юм. 2021 оноос УДШ-ийн дэргэд байгуулагдсан Шүүхийн сургалт, судалгаа, мэдээллийн хүрээлэнгийн захирлаар ажиллаж байна.

МУИС-ын ХЗС-ийг Магистрын зэрэгтэй, Лондоны Kings college-ийг Хууль зүйн Магистр зэрэгтэй төгссөн.

**ГАНЧУЛУУНЫ ОЮУНБОЛД (LL.M.),
МХХ-НЫ ЭРҮҮГИЙН ЭРХ ЗҮЙН ХОРООНЫ ТЭРГҮҮН**



Г.Оюунболд нь криминологи, эрүүгийн болон эрүүгийн байцаан шийтгэх эрх зүй, шүүхийн шийдвэр биелүүлэх эрх зүйн чиглэлээр мэргэшиж судалдаг практикийн болон судалгааны байгууллагад 18 жил ажилласан туршлагатай.

Цагдаагийн академид эрх зүйн бакалаврын төгсөж “Эрүүгийн байцаан шийтгэх хугацаа” сэдвээр хууль зүйн ухааны магистр зэрэг хамгаалсан. Хүмүүнлэгийн ухааны их сургуульд Менежментийн бакалаврын зэрэгтэй мэргэжлийн англи хэлний ангид суралцан төгссөн.

**АЛТАНГЭРЭЛИЙН БЯМБАЖАРГАЛ (S.J.D.),
МУ-ЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ХУУЛЬ ЗҮЙН БОДЛОГЫН ЗӨВЛӨХ**



МУИС-ийн ХЗС-д төрийн захиргаа, Монгол улсын Үндсэн хуулийн эрх зүй, ҮХ-ийн процессын эрх зүй, харьцуулсан эрх зүйн хичээл заадаг. ХЗС-ийн эрдэмтэн нарийн бичгийн даргын хувиар эрдэм шинжилгээний ажил, бүтээл туурвил, Эрх зүй улирал тутмын сэтгүүлийг эрхлэн гаргах ажлыг хариуцан ажиллаж байв. 2021 оноос МУ-ын Ерөнхийлөгчийн Хууль зүйн бодлогын зөвлөхөөр томилогдон ажиллаж байна.

МУИС-ийн ХЗС-ийг дүүргэж, БНСУ-ын Күүкмений сургуульд Хууль зүйн докторын зэрэг хамгаалсан.

ISBN 991991366-9



9 789919 913663